



НЭЭЛТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТАМГЫН
ГАЗАР

ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ,
ХЭЛЭЛЦЭХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ

ИРГЭДИЙН ОРОЛЦОО

/Олон улсын семинар/

Улаанбаатар хот
Төрийн ордон
2007.01.15-01.16

DDC
328.2
X-578

Í ÝÝËÒÒÝÉ Í ÈÉÄÝÌ ÔÎ ÐÓÌ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48,
Утас: 976-11-313207
Факс: 976-11-314857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

© Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл
ННФ-ын хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

ISBN 978-99929-5-922-3

БИТ ПРЕСС ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форум, УИХ-ын Тамгын газартай хамтран “Хууль боловсруулах, хэлэлцэх явцдахь иргэдийн оролцоо” олон улсын семинарыг 2007 оны нэгдүгээр сарын 15-16-нд зохион байгуулж явууллаа. Семинарын зорилго нь хууль боловсруулах, батлах үйл явцын ил тод, нээлттэй байдлыг хангах, түүнд иргэний нийгмийн төлөөлөл болох төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох явдал байв. Энэхүү семинарын үйл ажиллагаанд Польш, Эстони, Чех, Румын, словак улсын шинжээч, судлаач, багш, мэргэжилтнүүд уригдан оролцож уг асуудлаархи өөрийн орны болон олон улсын жишиг туршлага сургамжаасаа хуваалцлаа. Гиймээс бусад орны энэ талаар хэрэгжүүлж явуулсан бодлого, туршлагатай танилцаж, өөрийн орны нөхцөлд хэрэглэж болох загварыг тодорхойлоход уг семинарын бас нэг ач холбогдол чиглэгдсэн болно.

Семинарын илтгэл, түүнтэй холбогдуулж гарсан асуулт-хариулт, санал шүүмжлэлийн дэлгэрэнгүй тэмдэглэлийг сийрүүлж хавсаргалаа. Мөн семинарын илтгэлтэй УИХ-ын вэб хуудас www.parl.gov.mn болон Нээлттэй Нийгэм Форумын вэб хуудас www.forum.mn хаягаар орж танилцаж болно.

Семинарын илтгэлийг хөтөлбөрийн дагуу дараалуулан эмхтгэв. Харин илтгэлтэй холбогдуулж гаргасан санал шүүмжлэл, асуулт-хариултын дэлгэрэнгүйг эмхтгэлийн төгсгөлд хавсаргасан болно.

Нээлттэй Нийгэм Форум
УИХ-ын Тамгын газар

“ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ, ХЭЛЭЛЦЭХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО” ОЛОН УЛСЫН СЕМИНАРЫН ХӨТӨЛБӨР

2007 оны 1 дүгээр сарын 15-16

1-р сарын 15, Даваа гариг

- 09.30-10.00 Оролцогчдыг бүртгэх
10.00-10.10 Нээлт
Д.Лүндээжанцан, УИХ-ын дэд дарга

*Үдээс өмнөх хуралдаан: Даргалагч Х.Тэмүүжин, МУИС-ийн
ХЗДС-ийн багш, ННФ-ын удирдах
зөвлөлийн гишүүн*

*Үндсэн хуралдаан - Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь
оролцооны ерөнхий асуудлууд*

- 10.10-10.30 “Хууль тогтоох үйл явц дахь оролцооны тулгамдсан асуудлууд”
З.Энхболд, УИХ-ын гишүүн
10.30-10.50 “Хуулийн төсөл боловсруулах, батлах үйл явцад иргэдийн оролцоог
хангах нь: Европын зарчмууд болон практик асуудлууд”
Катерина Хадзи-Мичева, Европын ашгийн бус хуулийн төвийн
хуулийн зөвлөх
10.50-11.20 Асуулт хариулт, хэлэлцүүлэг

Хуралдаан 1- Иргэдийн оролцооны зохицуулалт

- 11.40-12.00 “Монгол дахь иргэдийн оролцооны эрх зүйн орчин болон
институтчилэл” Ч.Тамир, МУИС-ийн багш, бодлогын судлаач
12.00-12.20 “Польш улсын хууль хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо”
Гржегорч Маковски, Варшавын их сургуулийн багш
12.20-12.50 Асуулт хариулт, хэлэлцүүлэг

*Үдээс хойшхи хуралдаан: Даргалагч Ж.Нарантуяа, УИХ-ын Тамгын
Газрын нэгдүгээр нарийн бичгийн дарга*

Хуралдаан 1 - Иргэдийн оролцооны зохицуулалт /үргэлжлэл/

- 14.30-14.50 “Румын улсын иргэдийн оролцооны зохицуулалт”
Андреа Чифан, Румын Улсын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн
нөлөөллийн хөтөлбөрийн зохицуулагч
- 14.50-15.10 “Естони улсын үндэсний бодлого боловсруулах үйл явцад иргэдийн
оролцоо: ололт болон дутагдалтай талууд”
Жон Ендер, PRAXIS бодлогын судалгааны төвийн төрийн
захиргааны хөтөлбөрийн судлаач
- 15.10-15.30 Асуулт хариулт, хэлэлцүүлэг

Хуралдаан 2 - ТББ-ын оролцооны зохицуулалт

- 15.30-15.50 “Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь ТББ-ын оролцоо”
Ж.Баярцэцэг, Нээлттэй Нийгэм Форумын менежер
- 15.50-16.10 “Румын улсын ТББ-ын оролцооны эрх зүйн зохицуулалт”
Кристина Ренерт, Румыны Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн төрийн
захиргааны шинэчлэлийн хөтөлбөрийн зохицуулагч
- 16.10-16.30 “Словак улсын ТББ-ын оролцооны зохицуулалт”
Милан Ветрак, Европын Хууль зөвлөгөө байгууллагын захирал,
Трнава сургуулийн багш
- 16.50-17.10 Асуулт хариулт, хэлэлцүүлэг

Хуралдаан 3 - Парламент дахь лоббигийн зохицуулалт

- 17.10-17.30 “Парламент дахь лоббигийн эрх зүйн зохицуулалт”
Виктория Млинарчикова, Словакийн Нээлттэй Нийгэм
Хүрээлэнгийн ажилтан
- 17.30-17.50 “Монгол дахь лобби үйл ажиллагааны өнөөгийн байдал”
Ц.Оюунбаатар, “Консенсус” төвийн захирал
- 17.50-18.10 Асуулт хариулт, хэлэлцүүлэг

1-р сарын 16, Мягмар гариг

Хуралдаан даргалагч Ж.Баярцэцэг, Нээлттэй Нийгэм Форумын менежер

Хуралдаан 4 - Засгийн Газрын түвшин дэх оролцоо

- 10.00-10.20 “Яамдын түвшинд хуулийн төсөл боловсруулахад иргэд, ТББ-ыг оролцуулах нь”
Ц.Цолмон /ХЗДХЯ-ны хууль зүйн бодлогын газрын дарга/
- 10.20-10.40 “Чех улсын хууль боловсруулах үйл явц дахь иргэдийн оролцоо”
Микал Стика, Авилгалын эсрэг эрх зүйн зөвлөгөө өгөх төвийн захирал, Чех улсын Транспаренсал Интернэшнл салбар
- 10.40-11.10 Асуулт хариулт, хэлэлцүүлэг

Хуралдаан 5 - Мэдээллийн эрх чөлөөний хуулийн оролцооны зохицуулалт

- 11.30-11.50 “Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар оролцоог зохицуулах нь”
Сү.Батболд УИХ-ын гишүүн, Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн санаачлагч
- 11.50-12.10 “Словак улсын Мэдээллийн Эрх чөлөөний тухай хуулийн оролцооны зохицуулалт”
Виктория Млинарчикова, Словакийн нээлттэй нийгэм хүрээлэнгийн ажилтан Милан Ветрак, Европын хууль зөвлөгөө байгууллагын захирал, Трнава сургуулийн багш
- 12.10-12.40 Асуулт хариулт, хэлэлцүүлэг
- 12.40-12.50 Хурлыг хаах

“ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ, ХЭЛЭЛЦЭХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН СЕМИНАРЫГ НЭЭЖ ХЭЛСЭН ҮГ

*Д. ЛҮНДЭЭЖАНЦАН
/Улсын Их Хурлын дэд дарга/*

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын Тамгын газар, Монголын Нээлттэй Нийгэм Форумын хамтран зохион байгуулж буй “Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо” сэдэвт олон улсын семинарын ажиллагаа нээснийг мэдэгдье.

Монголын төр засаг өөрийн үйл ажиллагаандаа ардчилсан засаглалын үйл ажиллагааны тулгын чулуу, тулгуур зарчим болсон ил тод, нээлттэй байдлыг хэрэгжүүлэх, энэ үндсэн дээр төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, улмаар шийдвэр гаргах түвшинд иргэд, олон нийтийн оролцоог хангаж ажиллахад зохих ач холбогдол өгдөг. Ялангуяа хууль тогтоох төрийн дээд байгууллага парламентын түвшинд олон нийтэд нээлттэй байх асуудал бол манай үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг болж байдаг юм. Тиймээс ч 2002 онд Улсын Их Хурлын тогтоолоор баталсан Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөний таван гол зорилтын нэг нь парламентын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг бүх талаар хангах асуудал юм.

Монголын парламентын хууль хэлэлцэн батлах чуулганы ажиллагаа сонирхсон иргэд, олон нийтэд нээлттэй байдаг. Хууль тогтоох төрийн бодлогын хувьд төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар хууль эрх зүйн тодорхой орчныг бүрдүүлэхэд анхаарлаа чиглүүлж ирснийг юуны түрүүнд тэмдэглэх хэрэгтэй. Эдүгээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол улсын 30 шахам хууль тогтоомжид төрийн үйл ажиллагааны ил тод байдлын эрх зүйн үндсийг тодорхойлсон нийтлэг болон нарийвчилсан зохицуулалтын хэм хэмжээ зохих тусгалаа олсон гэж болно.

Одоо бид хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх үе шатанд иргэдийн санал бодлыг аль болох өргөн тусгах, тэдний идэвхтэй оролцоог хангах асуудлыг анхааран ажиллаж байна. Энэ талаар тус семинарт илтгэл тавьж хэлэлцүүлэх манай гишүүд илүү дэлгэрэнгүй ярих юм.

Энэхүү семинарт урилгаар оролцож байгаа гадаадын шинжээч, судлаач, багш, мэргэжилтнүүд уг асуудлаархи өөрийн орны болон олон улсын жишгийн туршлага

сургамжаа сэтгэл харамгүй хуваалцана гэдэгт бид итгэж байна. Семинарын ажиллагаанд Польш, Эстони, Чех, Румын, Словак улсын төлөөлөгчид хүрэлцэн ирж оролцож байгааг дурьдахад нэн таатай байна.

Түүнчлэн манай семинарын ажиллагаанд Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцож байгаад талархаж байна.

Мөн манай УИХ-ын гишүүд, УИХ-ын тамгын газрын удирдлага, ажилтнууд болон зарим төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, төрийн бус байгууллагын төлөөлөгчид оролцож байна.

Монголын Нээлттэй Нийгэм Форумас санаачлан төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал, нийгмийн баялгийн тэгш хуваарилалтын зарчим, оролцооны механизмыг боловсронгуй болгох асуудлаар бодлогын цуврал судалгаа хийж, тэдгээрийн үндсэн дээр дээрх асуудлын талаарх төр, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, идэвхи, оролцоог хангах, төрийн бодлогын олон нийтийн үндэслэлийг сайжруулах, нийгмийн хяналт, шахалт, нөлөөллийг буй болгох талаар бүтээлч хувь нэмэр оруулах олон ажил зохион явуулдгийг монголын төр, олон нийт сайн мэддэг, бас үнэлдэг билээ.

“Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо” сэдэвт энэхүү семинар ч гэсэн бас дээрх олон ажлын үргэлжлэл гэж ойлгож байна. Энэ удаад бид хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь оролцооны ерөнхий асуудлын хүрээнд иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоог хангах механизм, эрх зүйн орчин, нөхцлийг хэрхэн бүрдүүлэх, олон нийтийн эрх ашгийг хөндсөн тулгамдсан асуудлаар шийдвэр гаргахад оролцооны зохицуулалт ямар байх, олон нийтийн нөлөөлөл, лоббийн асуудал, мэдээллийн эрх чөлөөг хүртэх эрхээр хангагдах байдал зэрэг олон сонирхолтой асуудлаар харилцан ярилцах болно. Ингэснээр та бид төр, олон нийтийн харилцан итгэлцэл, түншлэлийг бэхжүүлэх, парламентаас батлан гаргаж буй хууль, тогтоомжийн үндэслэл, үр нөлөөг дээшлүүлэхэд зохих хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Үүнд энэ семинарын гол ач холбогдол орших болно.

Та бүхэнд амжилт хүсье.

**2007 ОНЫ НЭГДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДРИЙН ҮДЭЭС ӨМНӨХ ХУРАЛДААН:
“ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ, ХЭЛЭЛЦЭХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ
ОРОЛЦООНЫ ЕРӨНХИЙ АСУУДЛУУД”**

**ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН
ОРОЛЦООНЫ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД**

З.ЭНХБОЛД
/Улсын Их Хурлын гишүүн/

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Миний бие энэхүү семинарт тавьж буй товчхон илтгэлээрээ хууль тогтоох үйл явцад иргэдийн оролцоо ямар байгаа, төр, засгаас бодлого шийдвэр гаргахдаа тэдний санаа бодлыг яаж тусгаж байгаа болон бодлого шийдвэрээ иргэддээ ямар арга механизмаар хүргэж байгаа, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах эрх зүйн орчин ямар хэмжээнд бүрдсэн, тэдгээрийг боловсронгуй болгох ямар чиглэл, боломж байгаа зэрэг асуудлыг хөндөж Та бүхэнтэй санал солилцох гэсэн юм.

Хууль тогтоох үйл явц дахь иргэдийн идэвхтэй оролцоо нь нэг талаас, төрийн үйл ажиллагааны ил тод байдлын илэрхийлэл, нөгөө талаас иргэдийн улс төрийн идэвхийг хөхүүлэн дэмжих нэг гол хөшүүрэг болдог. Тиймээс хэлэлцэж буй хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн саналыг аль болох өргөн тусгах, төслийн талаархи нээлттэй хэлэлцүүлгийг сайн зохион байгуулж байх нь хуулийн төсөл нийтийн эрх ашигт илүү ойр дөт болж, ингэснээр амьдрал практикт хэрэгжих үндэслэл сайтай байх нь ойлгомжтой.

Монгол улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”, мөн хуулийн хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж тус тус заасан.

Хууль тогтоох үйл явцад иргэдийг оролцуулах хэд хэдэн арга зам байдаг бөгөөд тэдгээрийн талаар товч дурдвал:

1. Ард нийтийн санал асуулга явуулах

Монголын парламент шууд оролцооны чухал хэлбэр болсон ард нийтийн санал асуулгын тухай хуулийг 1995 онд баталсан.

Энэхүү хуульд ард нийтийн санал асуулгыг улс орны амин чухал асуудлаар буюу төрийн дотоод, гадаад бодлогыг тодорхойлохтой холбогдсон тодорхой асуудлаар ард нийтийн сонголт хийлгэх шаардлага гарсан тохиолдолд, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар явуулахаар заасан.

Уг хууль батлагдсанаас хойш даруй 10 гаруй жил өнгөрч байгаа ч ард нийтийн санал асуулга нэг ч удаа явагдаагүй байна. Харин Монголын түүхэнд нэг л удаа 1945 оны 10 дугаар сарын 20-нд БНМАУ-ын тусгаар тогтнолын төлөө явагдсан ард нийтийн асуулга байдаг бөгөөд түүнд бараг нийтээрээ оролцож, тусгаар тогтнолоо бүрэн дэмжсэн санал өгсөн билээ.

Ард нийтийн санал асуулга явуулах иргэдийн оролцооны энэ арга нь манай улсад төдийгүй бусад улсад ч түгээмэл хэрэглэгддэггүй байна.

2. Олон нийтийн хэлэлцүүлэг

Хууль тогтоох үйл явцад иргэд оролцохдоо хуулийн төслийг боловсруулахаас эхлээд хуулийг батлах хүртэлх бүхий л үе шатанд нь оролцох бололцоотой бөгөөд сүүлийн жилүүдэд парламент хууль тогтоох үйл явцын боломжтой бүх шатанд олон нийтийн оролцоог хангах талаар нэлээд анхаарч ажиллаж байгаа билээ.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бүх хууль тогтоомжийн төслийг Парламентын вэб хуудсанд тавьж олон нийтэд мэдээлэх ажил хийгдэж байгаа боловч иргэд тэр бүр интернетэд орж хууль тогтоомжийн төслүүдтэй танилцах боломжоор бүрэн хангагдаагүй байна.

Тиймээс өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан хэлэлцэх нь зүйтэй гэж шийдвэрлэсний дараа анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө өдөр тутмын хэвлэлд нийтлүүлж олон нийтээс санал авах ажлыг Байнгын хороод зохион байгуулж байна.

Түүнээс гадна төслийн талаар эрдэмтэд, шинжээчид, сонирхлын бүлэг, мэргэжлийн байгууллагын саналыг сонсох, мэдээлэл авах зорилгоор нээлттэй хуралдааныг зохион байгуулж явуулдаг.

Парламентын түвшинд олон нийтийн хэлэлцүүлгийн хэлбэр болох нээлттэй сонголт, нээлттэй хуралдааныг явуулдаг бол мэдээллийн хэрэгслээр нээлттэй хэлэлцүүлэг явуулах болсон.

Сүүлийн үед олон нийтийн анхаарлыг татсаар ирсэн Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Ашигт малтмалын тухай хууль, Татварын хуулиуд, Авилгын эсрэг хуулийн төслийн талаар хурал, семинар зохион байгуулах, төслийг интернэтийн сүлжээнд тавих, олон нийтийн санал асуулга явуулах, иргэд, иргэний

нийгмийн төлөөллийг ажлын хэсэгт оруулан хамтран ажиллах зэрэг янз янзын арга хэлбэрээр олон нийтийн саналыг тусгаж ажилласан.

Иргэдийн оролцооны бас нэгэн нөлөөтэй суваг нь парламентад шуудангаар болон электрон хэлбэрээр санал хүсэлт ирүүлдэг иргэдийн захидал юм. Захидлын тооны өсөлт, бууралтын статистик үзүүлэлтийг харахад нэгэн бүрэн эрхийн хугацаагаа эхэлж буй Парламентад хандах иргэдийн хандлага эхэндээ эрс нэмэгддэг байдал харагдаж байна. Жишээ нь: 2000 онд 1899 захидал авч байсан бол 2001 онд энэ тоо 3420 болж, 2004 онд 3313 захидал авч байсан бол 2005 онд 6113 болжээ. Энэ нь иргэд шинэ парламентад илүү итгэл найдвар тавьж өөрсдийн санал бодлоо илэрхийлж байдгийн нэг жишээ юм. 2006 онд нийт 3811 захидал хүлээн авснаас төр, засгийн бодлого шийдвэрт тусгах, хуулийн төсөлд өгөх саналын байдал сар бүрд харилцан адилгүй боловч ихэнхдээ 4-10 гаруйхан хувьтай байдаг. Харин аль нэг гишүүнд хандсан захидлын тоо нийт захидлын 80-90 гаруй хувийг эзэлж байгааг анхаарахгүй өнгөрч боломгүй байна. Мөн оны эхний 10 сарын байдлаар Иргэдийн хүлээн авах байранд өөрийн биеэр ирж санал хүсэлтээ илэрхийлсэн хүн 781 байна.

Энд нэг зүйлийг анхаарах хэрэгтэй. Иргэдээс ирж буй өргөдөл, захидлын дийлэнх нь Улсын Их Хурлын гишүүд болон төрийн байгууллага, албан тушаалтнуудын эрх мэдэл, чиг үүрэгт нь хамаарахгүй хувь хүмүүс өөрсдийнхээ амьдралын аар саар асуудлаа шийдвэрлүүлэх агуулгатай байгаа юм. Энэ бол иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, эрх зүйн соёлд сургах асуудал хойшлуулушгүй зорилт болоод байгааг харуулж байна.

Иргэдийн оролцооны бас нэг түгээмэл хэлбэр нь иргэд Улсын Их Хурлын гишүүдтэй биечлэн уулзаж санал хүсэлтээ амаар болон бичгээр илэрхийлэх хэлбэр юм.

Сонгогчдыг өөрсдийн сонгосон төрийн түшээдтэй уулзах бололцоогоор хангах үүднээс Төрийн ордонд Улсын Их Хурлын гишүүд иргэдтэй уулзах тусгай ерөө ажиллуулж байгаагаас гадна Хөдөлмөрчдийг хүлээн авах байраар үйлчилж байна.

УИХ-ын гишүүн, иргэн хоёрыг холбоход гишүүдийн туслах, туслах-бие төлөөлөгчдийн үүрэг өндөр гэдгийг ч энд тэмдэглэх нь зүйтэй болов уу.

“Ардчилсан парламентын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Монгол улсын ихэнхи аймаг, нийслэлийн дүүргүүдэд Парламентын мэдээлэл, сурталчилгааны төвийг байгуулж, төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлахын зэрэгцээ УИХ-ын чуулганаар хэлэлцэх гэж буй хуулийн төсөл болон батлагдсан хуулийн хэрэгжилтийн талаар иргэдийн санаа бодлыг авч эхэлж байгаа нь цаашдаа үр дүнгээ өгнө гэж бодож байна.

Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах төвүүдийг түшиглэн орон нутгийн удирдлагын бие даасан байдлыг хангах, төвлөрлийг сааруулах чиглэлээр холбогдох хуулиудад өөрчлөлт оруулахтай холбогдуулан нийт, аймаг, нийслэл, дүүргүүдэд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж явуулсан.

Сурталчлах төвүүдэд хэлэлцүүлгийн явцад холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн 1152 санал гарснаас Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд өөрчлөлт оруулахаар 420, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулинд өөрчлөлт оруулахаар 225, Ашигт малтмалын тухай хуулинд өөрчлөлт оруулахаар 109, Татварын багц хуулинд өөрчлөлт оруулахаар 89, Төрийн албаны тухай хуулинд өөрчлөлт оруулахаар 30, “Орон нутгийн ИТХ-ын сонгуулийн тухай”, Боловсролын тухай, Нийгмийн даатгалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай зэрэг бусад шаардлагатай хуулиудад өөрчлөлт оруулахаар нийт 279 санал тус тус гарч байсан байна.

“Улс төрийн намуудын тухай”, “Олон нийтийн радио телевизийн тухай” хуулийн төсөл, “УИХ-ын сонгуулийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хүргүүлж, хэлэлцүүлэг явуулсан бөгөөд “Нийгмийн даатгалын тухай” болон “Ашигт малтмалын тухай” хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдээр иргэдийн саналыг нь авч холбогдох Байнгын хороо, хуулийн ажлын хэсэгт хүргүүлжээ.

Эдгээрээс харахад хууль тогтоох явцад иргэдийн оролцоог хангах талаар хийж байгаа ажлын үр дүн ямар нэг хэмжээгээр гарч байна гэж үзэж байна.

Хууль, төрийн байгууллагын бусад шийдвэрийг олон нийтэд сурталчлан мэдээлэх, хэрэгжилтийг нээлттэй зохион байгуулах нь төрийн байгууллагуудын ил тод байдлын нэг үзүүлэлт мөн билээ. Энэ талаар эрх зүйн тодорхой зохицуулалтууд хийгдсээр байгаа.

Хууль болон төрийн байгууллагуудын шийдвэрийг нийгэм, олон нийтэд сурталчлан мэдээлэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд онцгой үүрэгтэй. Үндсэн хуулиас эхлээд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, Олон нийтийн радио телевизийн тухай хуулиудаар хэвлэлийн эрх чөлөөний эрх зүйн суурь үндэс бүрдсэн. Харин эдгээр хуулийг хэрэгжүүлэх явц төдийлөн сайн байгаа гэж дүгнэхээргүй байна.

Хууль тогтоох явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, түүнчлэн төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах эрх зүйн суурь орчин бүрдсэн гэж үзэж болох боловч тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй байна. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, зарим шаардлагатай хуулийг шинээр батлах зэргээр эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Цаашид анхаарах, авч хэрэгжүүлэх ажлын талаар хэдэн зүйл хэлье.

Нэгдүгээрт, Улсын их хурлаар хэлэлцэх хуулийн төслийг иргэд, олон нийтэд аль болох хүртээмжтэй, хялбар аргаар, шуурхай хүргэх асуудлыг эн тэргүүнд анхаарах шаардлагатай байна. Үүний тулд Улсын Их Хурлын вэб хуудсаар дамжуулан хуулийн төслийн онлайн хэлэлцүүлгийг зохион байгуулж иргэдийн санал хүсэлтийг авах ажлыг илүү өргөн далайцтай болговол зохино. Словак улсын туршлагаас харахад хууль тогтоох үйл явц дахь иргэдийн оролцоог хангах асуудалд интернетийн сүлжээг оновчтой ашиглаж, холбоотой бүхий л мэдээллийг олох түмэнд цаг тухайд нь шуурхай хүргэж чаддаг байна. Тиймээс Улсын Их

Хурлын вэб хуудсаар иргэдэд хүргэж байгаа мэдээллийг илүү боловсронгуй, шуурхай, системтэй болгоход анхаарах ёстой байна. Орон нутгийн хөгжлийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал ихтэй манай орны хувьд интернетийн сүлжээг ашиглан хуулийн төслийн хэлэлцүүлэг хийх нь цаг хугацаа, орон зайг хэмнэсэн хамгийн оновчтой хувилбар байж болох учраас шаардагдах төсөв, хөрөнгийг эн тэргүүнд шийдвэрлүүлэх шаардлагатай юм.

Хоёрдугаарт, Өнөөгийн байдлаар бүх аймгийн төв, зарим сум өндөр хурдтай холбооны дамжуулах сувгаар холбогдсон байгааг ашиглан орон нутгийн төр, захиргааны байгууллагууд нөөц бололцоогоо дайчлан үнэгүй интернет төвүүдийг байгуулж ажиллуулах замаар хуулийн төслийг иргэдэд шуурхай хүргэх, тэдний санал бодлыг авах ажлыг зохион байгуулах боломжтой гэж үзэж байна. Ер нь энэ ажлыг зөвхөн орон нутаг гэж явцуурахгүйгээр нийслэл хотод ч мөн адил зохион байгуулах шаардлага, хэрэгцээ их байна. Үүнд томоохон компани, банк зэрэг байгууллагын дэмжлэг туслалцаа ч ихээхэн хэрэгтэй байгаа юм.

Гуравдугаарт, Интернетээр хийх хуулийн төслийн хэлэлцүүлгийг илүү үр бүтээлтэй болгохын тулд Улсын Их Хурлын тамгын газрын мэдээлэл технологийн сүлжээг улам боловсронгуй болгох, шинэчлэх, орон тоог нэмэгдүүлэх шаардлага зохих ёсоор гарна.

Дөрөвдүгээрт, Улсын Их Хурлын байнгын хороодоор хийж байгаа хуулийн төслийн нээлттэй хуралдаан, хэлэлцүүлгийг эрх зүйн нэгдсэн зохицуулалт хийгээд зохион байгуулалтын тодорхой журамд оруулах хэрэгтэй байна.

Эдгээрийг үндэслэн хууль боловсруулах, хэлэлцэх үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ажиллахад төр болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэд бүх талаар хамтран ажиллана гэдэгт найдаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа. Семинарын цаашдын үйл ажиллагаанд амжилт хүсье.

ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦАД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ: ЕВРОПЫН ЗАРЧМУУД БА ПРАКТИК АСУУДЛУУД

КАТЕРИНА ХАДЗИ-МИЦЕВА
/Европын ашгийн бус хуулийн төв/

Илтгэлийнхээ үндсэн хэсэг рүү орж Европ дахь хууль боловсруулах, тогтоох үйл явцад олон нийтийн оролцоог хангах практик ба олон нийтийн оролцоог зохицуулдаг зарчмуудыг хэлэлцэхээс өмнө нэгэн түүх яримаар байна. Миний найз Энэтхэгт галт тэргээр аялж байхад нь тохиолдсон явдал юм. Тэрээр галт тэргэнд зорчиж явтал цай кофе зардаг хүн ойртож иржээ. Түүнээс “Цай авъя” гэхэд нь тэр хүн “Уучлаарай, бидэнд халуун ус байхгүй ээ” хэмээн хариулжээ. “За тэгвэл кофе авч болох уу?” гэж найзыг маань асуухад тэр дахин “Уучлаарай, халуун ус байхгүй” гэж хариулаад “Цай кофе аваарай” гэж зорчигчдод санал болгосоор цааш одсон юм. Энэ түүх нь бид хуулиндаа маш олон сайхан амлалт, ганган хээнцэр зүйлс оруулдаг ч амьдралд хэрэгжих арга механизмыг нь иргэдэд тэр болгон хангаж өгдөггүй учир хууль хэрэгждэггүй, цаашлаад иргэд, төрийн бус байгууллагууд, ер нь хүн бүр хуулийн ашиг шимийг амьдралдаа хүртэж чаддаггүй гэдгийг надад байнга сануулдаг юм. Тиймээс Монголын Их хурлын гишүүд төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийг хууль тогтоох болон боловсруулахад оролцох үйл явцыг тодорхой дүрэмтэй болгосноор илүү хүртээмжтэй болгоход чиглэсэн энэ санаачлагыг маш их дэмжиж байгаагаа илэрхийлье.

Үргэлжлүүлэхээсээ өмнө та бүгдийн анхаарлыг “Иргэдийн оролцоо яагаад бидэнд хэрэгцээтэй вэ?” гэсэн асуултад хандуулмаар байна. Олон газраар явж, хамтран зүтгэгчидтэйгээ уулзахад “Бид төрийн бус байгууллага учир энэ үйл явцад оролцох, түүний нэгэн хэсэг байх эрхтэй. Тиймээс Парламент эсвэл Засгийн газар бидэнд оролцох боломжийг олгох үүрэгтэй” гэж байнга ярилцдаг. Миний бодлоор эцэстээ үр дүн л чухал. Хууль гаргаад, бодлого хэрэгжүүлэхэд бидний санаа зовж, чухал хэмээн тооцдог зүйл нь тэр хууль, тэр бодлого бидэнд хэрхэн тусч байна, бидний амьдралыг сайжруулж байна уу, үгүй юу гэдэг асуудал байдаг. Яг энэ мөчид оролцоо гэж зүйлийн утга учир илэрдэг. Би идеалист хүн учир бид бүгд л энэ нийгмээ сайжруулж, дээшлүүлэхийн тулд хүчин чармайлт гарган ажилладаг хэмээн итгэдэг учраас оролцоог хангасан үйл явц нь бидний амьдралд үнэхээр нөлөөлөхүйц үр дүнг бий болгоход туслана гэж найддаг. Тиймээс ч илтгэлийнхээ эхэнд “Манай Засгийн газар нь бидний амьдралд жинхэнээр нөлөөлөхүйц бодлого боловсруулж, түүнийг хэрэгжүүлэн үр дүнд хүргэхийг эрмэлзэж байна” гэсэн Их

Британий нэгдсэн вант улсын шинэчлэгч Засгийн газраас гаргасан илтгэлээс авсан ишлэлийг оруулъя гэж бодсон юм.

Оролцоо нь бидэнд чухал хэрэгцээтэй бодлого боловсруулахад туслах уу? Эн тэргүүнд бүх хүн, иргэд, төрийн бус байгууллага, шинжээч мэргэжилтэн, олон улсын төлөөллийн оролцоог хангаснаар бүхэл нийгмийн хэрэгцээг тусгасан бодлого боловсруулахыг бид хангадаг. Өөрөөр хэлбэл, иргэдийн хэрэгцээ сонирхлыг шийдэх, хангах талаар тэдний саналыг бид авч ажилдаа тусгаад, дээр нь өөрсдийн нарийн мэдлэг, туршлагаар баяжуулан нэгтгэсэн үйл явц болох юм.

Оролцоог бид Засгийн газраас эсвэл Парламентаас удирдан явуулдаг үйл явц гэж ойлгодог. Энэ нь тийм биш. Учир нь төрийн бус байгууллага, энгийн иргэд бусад сонирхсон бүлгүүд ямарваа асуудлыг шийдэх талаар өөрсдийн саналаа төсөл хэлбэрээр боловсруулж болдог. Иргэд хамтран шаардлагатай мэдлэг туршлага, нөөц бололцоогоо нэгтгээд амьдралд хэрэгжихүйц санал боловсруулдаг.

Бид яагаад оролцоог хүсдэг талаар өөр нэг шалтгааныг тодруулахдаа “Оролцоогоор бид дэвшилтэт, урагш тэмүүлсэн бодлого боловсруулж чадна” гэсэн Их Британийн Засгийн газрын бодлогын баримт бичгээс иш татаж болно. Энэ нь асуудлыг шийдвэрлэхдээ бид зөвхөн өөрсдийн жижиг хүрээнд ажилласнаар хүрч чадах шийдвэрээс илүү бүтээлч шийдвэрийг оролцооны ачаар олж харж чадна гэсэн үг юм. Үндсэндээ боломжтой гэж бодож байсан зүйлээсээ цааш даван гарч, бусад орнуудын туулсан замнал туршлагаас суралцан илүү сайжруулсан шийдвэрт хүрч чадна гэсэн үг. Эцэст нь оролцоо яагаад маш чухал болох талаар хэлэхэд оролцоог хангаснаар тэр хууль эсвэл бодлого амьдралд нь нөлөөлөх хүмүүсийг энэхүү үйл явцаар сургаж, тэдгээр хүмүүс хууль эсвэл бодлогыг ойлгох, хэрэгжүүлэх, хэрэглэх үйлдлийг нь хангаж байна гэсэн үг гэж би боддог.

Тэгэхээр оролцооны үйл явцыг зохицуулдаг ямар ямар зарчмууд Европт байдаг вэ? Энд би Европын холбооны засаглалын цагаан илтгэл, Европын холбооноос гаргасан хэд хэдэн мэдэгдэл, Унгар, Их Британи, Финлянд зэрэг Европын холбооны гишүүн улсуудын хууль тогтоомжоос авсан олон зарчмыг нэгтгэсэн байгаа. Та бүхэнд жагсаалт нь байгаа тул нэг бүрчлэн тайлбарлах шаардлагагүй гэж бодож байна. Гэхдээ өөрийн ажлын туршлагаас маш чухал гэж бодсон хэдийг тайлбарлах нь хэрэгтэй болов уу.

Юуны өмнө **чин хүсэл эрмэлзэл байх ёстой**. Хууль боловсруулах, бодлого боловсруулах гэдэг нь маш хариуцлагатай ажил. Тиймээс зөвхөн хууль санаачилсан хүнээр зогсохгүй, оролцож буй бүх хүн чин хүсэл эрмэлзэлтэй байх ёстой гэж би боддог. Хууль боловсруулах багтах үйл явцын бүх шатлалд сонирхсон этгээдүүдтэй зөвлөлдөж байхыг Засгийн газар хангах ёстой. Нөгөөтэйгүүр, сонирхсон этгээдүүд ч мөн чин хүсэл эрмэлзлээ илэрхийлэн хариу өгөх, бүхий л үйл явцын турш идэвхитэй байх, нөөц бололцоогоор хангах хариуцлагыг хүлээдэг байх ёстой. Учир нь маш олон тохиолдолд Засгийн газар нь үйл явцыг нээлттэй болгосон ч төрийн бус байгууллагууд хангалттай хэмжээгээр саналаа өгөхгүй, эсвэл хуралд ирэхээ мартдаг. Тийм тохиодолд Засгийн газар нь мэдээж “Бидний хийж буй зүйлийг сонирхохгүй байна. Оролцох замыг чинь нээчихээд байхад оролцохгүй байна” гэж хэлэх эрхтэй болно. Тиймээс энэ хариуцлага нь аль аль талд ноогддог гэдгийг ухамсарлах хэрэгтэй байдаг.

Өөр нэгэн асуудал бол **олон нийтэд хүртээмжтэй хэлбэрээр мэдээлэх**. Өмнөх илтгэгч Их Хурлын эрхэм гишүүн хууль тогтоомжийг олон нийтэд хүртээлтэй болгох нь маш чухал болох талаар дурьдсан байгаа. Миний бодлоор Европын олон улс зөвхөн мэдээллийг хүртээлтэй болгоод зогсохгүй, мэдээлэл хүртээлтэй болсон талаар хүмүүст мэдээлэхдээ их амжилттай ажилласан гэж үздэг. Мэдээллийг зөвхөн вэбсайтад байрлуулаад зогсохгүй, түүнийг яаж авах, олох, ойлгох талаар өргөн үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү зорилгыг хангахын тулд ямар техник, арга барилыг ашиглаж байгаа талаар бас бодолцох нь чухал юм. Жишээ нь, мэдээллийг вэбсайтад тавилаа гэж бодоход интернетийн гарцгүй, огт ашигладаггүй хүмүүсийг яах вэ гэсэн асуудал гарна. Их Британийн Засгийн газар бүх яам тамгын газрууддаа өөрсдийн бүх мэдээллийг вэбсайтад байрлуулаад зогсохгүй тэр мэдээллээ хэвлэн, мэдээлэл тэр болгон амар хүртэж чаддаггүй нийгмийн бүлгүүдэд хүргэх, тэдэнд тараах тусгай кампанит ажил үечлэн зохион байгуулах үүрэг даалгавар өгсөн байдаг.

Дараагийн чухал асуудал нь **эргэх холбоо** юм. Миний дурьдаж буй зүйлс нь ажлынхаа туршлагаас харахад хэрэгжилт дээрээ бэрхшээлтэй тулгардаг учир эдгээрийг онцлон тайлбарлаж байгааг дахин анхаарна уу. Тэгэхээр эргэх холбоо гэж юу вэ? Та хууль санаачлагч буюу Засгийн газар эсвэл Парламент байлаа гэхэд олон нийтээс авсан саналыг хууль боловсруулах үйл явцад хэрхэн ашигласан талаар эргэн хариу өгөх, тайлбар хийх хариуцлагыг үүрдэг. Энэ тал дээр Их Британийн маш сайхан жишээ байдаг. Хэрэв та хууль санаачлагч бол ямар саналыг хуулийн төсөл эсвэл бодлогын төсөлдөө тусгасан, ямар саналыг ямар учир шалтгаанаар тусгаагүй гэх мэт олон нийтийн оролцооны талаар нарийвчилсан тайлан бүхий хуулийн эсвэл бодлогын төслийг гардуулах ёстой байдаг. Бүх хүмүүст үүнийг нээлттэй болгодог. Ингэснээр иргэд болон хууль тогтоогчид ямар санал ямар үндэслэлээр буцаагдсан, тусгагдсан гэх мэт мэдээллийг харах боломжтой байдаг. Унгараас харин нэг сөрөг жишээ байна. Унгарт мэдээллийн эрх чөлөөний тухай хууль болон Цахим мэдээллийн эрх чөлөөний тухай хууль байдаг. Эдгээр хуулийн дагуу Засгийн газар нь иргэд олон нийтээс авсан саналууд дээр хариу олгох ёстой боловч Засгийн газар вэбсайт дээрээ “Бид санал авсан, уншсан, хэлэлцсэн” гэсэн л тайлбар тавьдаг. Тэгээд л тэр. Ийм мэдэгдэл тавьснаараа Засгийн Газар олон нийтээс авсан саналыг хэрхэн ашигласан, эс ашигласан талаар хуулийн дагуу хариуцан тайлагнах үүргээ биелүүлжээ гэж үздэг. Энэ муу жишээг та бүхэн сайжруулж чадна гэдэгт би итгэж байна.

Дурьдалгүй өнгөрч болохгүй өөр нэгэн зүйл бол Европын хэд хэдэн Засгийн газрууд олон нийттэй хийх зөвлөлдөөн болон оролцооны үйл явц ямар байдлаар явагдах ёстой талаар тусгай журам батласан байдаг. Хууль боловсруулж эхлэхээс өмнө оролцооны үйл явцын төлөвлөгөөг гарган, хуулийн төслийг хамаарах албан тушаалтан, төсөл боловсруулах багийн бүрэлдэхүүн, цаг хугацааны төлөвлөгөө гэх мэт бүтцийг тодорхой болгосон байдаг. Эдгээр зүйлс нээлттэй байхад тэр хуулийн төслийн талаар хэнд хэзээ хандах асуудал өөрөө шийдэгддэг.

Оролцоо ямар ямар хэсгүүдээс бүрдэх вэ? Европын холбооны түвшинд, оролцоо гэдэг нь мэдээлэл, зөвлөлдөөн, идэвхитэй оролцоо гэж тодорхойлогддог. Энэ гурвыг товч тайлбарлая. Мэдээлэл гэдэг нь хууль санаачлагч Засгийн газар эсвэл Парламент нь хууль боловсруулах үйл явц эхлэх талаар мэдээллийг олон

нийтэд хүртээлтэй болгоно гэсэн үг. Зөвлөлдөөн ба идэвхитэй оролцоо гэдэг нь зарим талаараа давхардсан үйл явц байдаг. Гэхдээ идэвхитэй оролцоо гэдэг нь зөвлөлдөөнөөсөө илүү өргөн хүрээтэй, түүнийг дотроо багтаасан ойлголт юм. Хууль боловсруулах тогтоох явцын хүрээнд энгийнээр ойлгоход зөвлөлдөөн гэдэг нь хууль санаачлагч дүрэм журмыг тодорхойлдог үйл явц буюу санаачлагч нь цаг хугацааг тодорхойлж, иргэдолоннийтээс саналавч, авсан саналуудыг боловсруулан, хуулийн эсвэл бодлогын төслийг боловсруулдаг үйл явц юм. Харин идэвхитэй оролцоо гэдэг нь “Хэлэлцэх цаг хугацааг уртасгах хэрэгцээ” гэж хэлж болох юм. Энэ нь хууль санаачлагч болон бусад иргэд олон нийт нь эрх тэгш хамтран зүтгэгчид ба тэд цуг суух цаг гарган, асуудлыг шийдвэрлэн, хамтдаа энэ үйл явцад оролцож байна гэсэн үг юм. Тэд хамтдаа энэхүү үйл явц, үр дүнг хариуцаж байна гэсэн үг. Тэгэхээр идэвхитэй оролцоо гэдэг нь оролцооны нэлээд хөгжингүй хэлбэр юм. Жишээ нь нэгэн хуулийн төсөл боловсруулахаар Парламентын гишүүд, Засгийн газрын албан тушаалтнууд, төрийн бус байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан эхнээсээ хамтран ажиллаж, бүхий л үйл явц ямар үе шатаар дамжих, авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг хамт тодорхойлон, төслийг олон нийтэд хүргэн, авсан саналууд дээр хамтран ажиллаж, төслөө хамтран эцэслэж байвал тэр бол идэвхтэй оролцоо.

Европын жишгийн дагуу оролцооны эдгээр бүх хэлбэр хууль боловсруулах тогтоох бүхий л үйл явцын турш байх ёстой. Энэ нь хууль болон бодлого боловсруулах үйл явц, хэрэгжилт, мөн хэрхэн оролцооны үйл явц болж өнгөрснийг үнэлэх үйл явцад байх ёстой гэсэн үг юм. Тийм ч учраас олон Засгийн Газрууд “Бид хууль тогтоох болон хэрэгжүүлэхэд оролцоог байлгах ёстой” гэж хэлээд зогсохгүй тэр оролцоо болон зөвлөлдөөн нь хэрхэн явагдсан дээр үнэлгээ авах ёстой гэж хэлж байгаа. Тэрхүү үнэлгээний явц ч мөн оролцооны зарчимд үндэслэнэ гэж мэдэгдэж байгаа. Энэ нь юу гэсэн үг вэ? Үйл явц дууссаны дараа бид суугаад хэдэн байгууллагатай зөвлөлдсөн, хэн хэн оролцсон, тэдний санал юу байсан гэх мэт мэдээллийг оруулсан тайлан бичиж түүнийгээ нийтэд хүртээлтэй болгоно гэсэн үг. Хоёрдугаарт, оролцсон байгууллага хүмүүсээс тэр үйл явц сайн болсон эсэх талаар асуун, ирээдүйд ямар ямар зүйлс дээр анхаарах хэрэгтэйг тэднээс санал авна гэсэн үг. Гуравдугаарт, идэвхитэй оролцооны тухайд хараат бус шинжээчдэд үйл явцыг дүгнэх, үнэлэх бололцоог хангаж, зөвлөлдөөн үнэхээр үр дүнтэй болсон эсэх талаар тэдний үнэлгээг авна гэсэн үг.

Цахим мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн үйл явцын үед Унгарын төрийн бус байгууллагууд өөрсдийн санаачлагыг бүрдүүлэн хуулийн хэрэгжилтийг хянаж байсан. Энэхүү хуулийн дагуу яамдаас санаачилсан хуулийн төслүүдийг хүртэл вэбсайт дээрээ байрлуулах үүргийг яамд хүлээдэг. Тэдгээр төрийн бус байгууллагууд яамдын вэбсайтууд руу орж, жилийн турш юу юу болж байгаа талаар хяналт тавьж, хуулийг дагаж мөрдөж байгаа эсэхээр нь тэдгээр яамдад улаан, шар, ногоон дарцаг гэсэн үнэлгээ өгч байсан. Тэрхүү мониторингийн үйл ажиллагааны дүнд хууль батлагдсанаас хойш эхний жилд зөвхөн хоёр гуравхан яамд л хуулийг мөрдөж байгаа нь илэрсэн. Тэгэхээр хууль нь байж л байдаг, батлагдчихсан мөртлөө мэдээллийг бүх хүмүүст нээлттэй болгох дээр Засгийн Газрын яамд үүргээ хэрэгжүүлэхгүй ажиллаж байгаа нь харагдсан.

Бүхэл үйл явцын хувьд, эдгээр оролцооны хэлбэрийг хүлээн зөвшөөрч байгаа эсэх, Засгийн Газрын баталсан бодлого хэрэгжиж байгаа эсэх дээр оролцооны хэлбэрүүд нь мөн чухал байдаг. Олон засгийн газрууд төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах стратеги боловсруулан батласан байдаг ба хэтийн төлөвтөө төрийн бус байгууллагууд үйл явцад оролцохыг, тэдэнтэй зөвлөлдөхийг хангана хэмээн амласан байдаг. Эдгээр төрийн бус байгууллагуудын эрхийг хэрэгжүүлэх тал дээр ч хууль дүрэм журам батлан, институцуудыг бий болгосон байдаг. Жишээ нь мэдээллийн хамгаалалтын омбудсмэны тогтолцоог үүсгэж болдог, цаашлаад нөлөөллийн буюу лоббийн үйл ажиллагааны хууль баталсан байдаг, мөн мэдээллийн эрх чөлөөний тухай, эсвэл хууль тогтоох үйл явцын тухай хуультай болсон байдаг.

Үйл явцыг оролцооны болгох талаар хэд хэдэн арга барил боловсруулсан байдаг. Жишээ нь, зөвлөлдөх төрийн бус байгууллагуудын жагсаалт мэдээллийн сан бий болгох, хууль боловсруулах үйл явцад оролцох талаар мэдээлэл бүхий регистрац бий болгох, дугуй ширээний ярилцлага зохион байгуулах гэх мэтээр оролцооны арга хэлбэрүүдийг бий болгон ашиглаж болдог.

Эдгээр оролцооны хэлбэрүүд болох мэдээлэл, зөвлөлдөөн, идэвхитэй оролцоог хангах бодлого, хууль, институцуудын талаар нэлээд ярьсан тул хууль тогтоох, боловсруулах, батлах үйл явцад нэн чухал хэдэн зүйлийг ярья гэж бодлоо.

Мэдээллийн хувьд Унгарын Мэдээллийг хамгаалах ба мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн жишээг авч үзье. Энэхүү хуулийн дагуу олон нийтийн эрх ашигт хамааралтай бүх л хууль болон хуулийн төслийг яамд болон Засгийн газар өөрсдийн вебсайт дээр байрлуулах үүргийг хүлээдэг. Үүнд асуудал үүсдэг, учир нь шүүх болон Засгийн Газар нь “Олон нийтийн эрх ашигт хамаарах” гэдгийг өөрсдийнхөөрөө тодорхойлох эрхтэй байдаг. Нэгэн жишээ дурьдахад Унгарын нэгэн Парламентын гишүүн нэгэн хуулийн эсрэг өргөдөл өгсөн байсныг төрийн бус байгууллагууд авахыг хүсэхэд шүүх тэрхүү эсэргүүцсэн өргөдлийг олон нийтийн эрх ашигт хамааралгүй учир Парламент тэр өргөдлийг төрийн бус байгууллагуудад нээх шаардлагагүй гэсэн дүгнэлт өгсөн. Тэгэхээр одоо хүртэл Унгарт хаагдмал хийгдэж буй зүйлс их байна. Тийм сэтгэлгээгээрээ мэдээллийн эрх чөлөөг тодорхойлсон зүйлүүд гарсаар байгаа. Энэ нь цаашид шийдвэрлэх ёстой асуудлуудын нэг юм.

Зөвлөлдөөний хувьд энэ нь оролцооны үйл явцад илүү хамааралтай гэж би үздэг ба Унгарын эерэг жишээнүүд бий. Унгарт Парламент эсвэл Засгийн Газрын түвшинд хууль боловсруулах тогтоох үйл явцад оролцож болдог. Парламентын хууль тогтоох боловсруулах үйл явцад оролцох журам нь яамдын журамтай харьцуулахад тийм ч нарийвчилсан биш боловч амьдрал дээр яамдын үйл явцад оролцохоос илүү Парламентын үйл явцад оролцох нь амар байдаг. Тэгэхээр урьд нь хэлж байсанчлан хэчнээн хууль нь байлаа ч, хэчнээн хууль нь сайн байлаа ч түүнийг хэрэгжүүлбэ гэсэн чин эрмэлзэл байхгүй бол үр дүн гарахгүй гэсэн үг. Жишээ нь, Унгарт Парламентын түвшинд бүх хуулийн төслүүдийг олон нийтэд мэдэгдэхийн тулд вэбсайт дээр байрлуулах ёстой. Мөн Парламентын байнгын хороодын хуралдаанууд олон нийтэд нээлттэй байх ёстой байдаг ба оролцохыг хүсвэл Парламентад нэрээ бүртгүүлэх ёстой болдог. Оролцохыг хүссэн хүмүүсийн

нэрийн жагсаалт Парламентын нарийн бичгийн даргад байдаг. Гэхдээ энэ нь бас л асуудалтай. Хороодын хуралдаан болоход тэд оролцох байгууллагуудын тоог тав, хамгийн дээд тал нь арван төрийн бус байгууллагаар хязгаарладаг. Тиймээс танай байгууллагын мэргэшсэн асуудлаар хуралдаан болох талаар сураг сонсонгуутаа бүртгүүлэхгүй бол та оролцож чадахгүй гэсэн үг. Словакид нөхцөл өөр байдаг талаар би сонссон. Парламентын хорооны хуралдаанд бүртгэлтэй төрийн бус байгууллага суух, хэлэлцэх асуудал дэвшүүлэх, өөрсдийн саналаа илэрхийлэх эрхтэй байдаг. Ихэнхдээ тэрхүү хорооны дарга болон бусад гишүүд төрийн бус байгууллагуудын төлөөлөгчдийг урилгаар оролцуулдаг энэ механизмыг өргөнөөр хэрэглэдэг. Яамдын түвшинд зөвлөлдөөн болоход оролцуулах ёстой байгууллагуудын жагсаалт тэдэнд байдаг. Яамд зөвлөлдөөнд оролцох төрийн бус байгууллагуудыг зөвхөн өөрсдөө хамтран ажиллах дуртай байгууллагуудаар хязгаарлан урьдаг учир оролцоход маш хэцүү асуудал үүсдэг. Өөр нэгэн асуудал нь яамдын үйл явцын тогтолцоо нь их бүрхэг байдагт оршдог. Жишээ нь, нэг яам хууль санаачиллаа, та тэр үйл явцад оролцохыг хүслээ гэхэд тэр төслийг хариуцсан хүнийг нь олж холбоо тогтоох маш хэцүү байдаг. Яам руу утасдаад нэг хэлтсээс нөгөө рүү шилжүүлсээр маш их хугацаа зарж байж хариуцсан хүнийг олох жишээтэй. Мэдээж энэ байдлаа сайжруулах тал дээр Унгарын яамд ажиллаж байгаа нь гарцаагүй.

2000 онд Их Британи зөвлөлдөөний зургаан шалгуур зарчмыг батлан гаргаж, дараа нь эдгээрийг шинэчлэн сайжруулж өөрчилсөн байгаа. Энэ нь Ерөнхий Сайд яамдууддаа хандан зөвлөлдөөнийг хэрхэн явуулах талаар гаргасан зарчмууд юм. Тони Блэри Засгийн Газрынхаа гишүүддээ хандахдаа эдгээр зарчмуудыг даган мөрдөх хууль, бодлого боловсруулах ёстойг цохон тэмдэглэж, хэрэв эдгээр шалгуур зарчмуудыг мөрдөлгүй хууль, бодлогын төслийн бичиг баримтыг өргөвөл санаачлагч нь ямар учир шалтгаанаар шалгуур зарчмуудыг даган мөрдөөгүй, шалгуур зарчмыг даган мөрдөөгүй ч тэрхүү төслийн бичиг баримт нь ямар байдлаар хангалттай болох талаар нарийн тайлбартай ирүүлэх ёстойг хэлсэн байна. Үүнийг Их Британий Засгийн газрын вэбсайтаас олж үзэж болно. Энэ нь шалгуур зарчмуудыг үнэлж, хэрэгжүүлэх маш том хүчин зүйл болж байгаа нь гарцаагүй.

Эдгээр зарчмуудыг Их Британийн зөвлөлдөөн зохион байгуулах журам гэж нэрлэдэг. Үүнд:

1. Үйл явцын турш зөвлөлдөөнийг өргөнөөр зохион байгуулах, бичгээр оролцох үйл ажиллагааг доод тал нь нэг удаа хийх, энэ боломжийг хүмүүст хангахын тулд доод тал нь 12 долоо хоног зориулах.
2. Төсөл ойлгомжтой байх, ашиг сонирхол нь хөндөгдсөн хүмүүст өгөх хариу тодорхой байх, хариу өгөх хугацаа тодорхой байх.
3. Бүх хүмүүст хүртээлтэй байдлаар товч, тодорхой зөвлөлдөөн явуулах.
4. Зөвлөлдөөний үйл явц бодлогод хэрхэн нөлөөлсөн, авсан саналуудад хэрхэн хариу өгсөн талаар тайлагнах.

5. Яам зөвлөлдөөнийг үр дүнтэй зохион байгуулсан эсэх тухай хянах (томилогдсон зөвлөлдөөнийг зохицуулагч үнэлнэ).

6. Зөвлөлдөөн нь зохицуулалтын сайн практикийг дагаж мөрдсөн эсэх (зохицуулалтын нөлөөллийн үнэлгээг оролцуулна).

Энэхүү журам нь зөвлөлдөөнийг тодорхой цаг хугацаанд зохион байгуулах ёстойг заасан бөгөөд энэ нь арван хоёр долоо хоног дотор багтаахаар зохицуулжээ. Хууль эсвэл бодлогыг боловсруулах үйл явц нь боломжтой бол хэд хэдэн зөвлөлдөөнөөр хэлэлцэгдэх ёстой. Боллоцгоогүй бол нэг зөвлөлдөөн явуулахдаа арван хоёр доошгүй долоо хоногийг зориулах ёстой хэмээн заасан байна. Мөн нарийвчилсан журмыг үзвэл хууль эсвэл бодлогыг боловсруулах, иргэдтэй зөвлөлдөх үйл явц нь олон нийтийн амралтын үеэр зохион байгуулагдаж байвал зөвлөлдөөний эцсийн хугацааг сунган, төрийн бус байгууллагуудад оролцох боломжийг нь нээлттэй олгох талаар заасан байдаг. Хэрэв эцсийн хугацааг богиносгох шаардлагатай бол богиносгох болсон учир шалтгааныг тодорхой байдлаар өгүүлсэн тайланг төслийн баримттай хамт гаргах ёстой. Үнэлгээ өгөх хүмүүс зохистой шалтгаанаар богиносгосон эсэхийг тодорхойлдог. Энэ хугацааг чухалчлан тэмдэглэж байгаа нь төрийн бус байгууллагууд болон иргэд хуулийн болон бодлогын төсөлд үндэслэл бүхий санал боловсруулан өгөх нөхцлийг хангаж өгч байгаа арга хэлбэр юм.

Их Британий журмаас өөр нэгэн сайн сургамж авах зүйл бол зөвлөлдөөний зохицуулагч гэсэн институцийг бий болгосон явдал байгаа. Яам болгон өөрийн зөвлөлдөөний зохицуулагчтай байж тэр нь үйл явцыг ажиглан, зөвлөлдөөн хэрхэн явагдсан талаар илтгэл бичдэг байгаа.

Гурав дахь жишээ нь **идэвхитэй оролцоо** юм. Өмнө нь хэлсэнчлэн, жишээ нь төрийн бус байгууллагууд нийлээд сайн дураар ажиллах талаар хууль боловсруулах хэрэгтэй байна гэж үзжээ. Тэгвэл энэхүү идэвхитэй оролцооны зарчмаар тэд энэхүү шийдвэрийнхээ дагуу зөвлөлдөөн зохион байгуулж, үйл явцыг хариуцан, хуулийн төслийг боловсруулан батлуулах үйл ажиллагаан дээр Засгийн Газартай хамтран ажиллана гэсэн үг. Хоёр тал бие биеэ гүйцэлдүүлэн үйл ажиллагаагаа зохицуулан ажиллаж чадвал илүү идэвхитэй санаачлага болж чадна.

Эцэст нь үлдэж байгаа хэдэн минутаа оролцоог хангах үйл явц, хэрэгжилтэд үүсдэг асуудал бэрхшээлийн талаар ярьж, эдгээрийг шийдвэрлэх арга замуудыг хэлэлцье гэж бодлоо. Хүмүүс “Бид оролцох эрхтэй, бид үйл явцад нөлөөлөх эрхтэй, бидэнтэй зөвлөлдөх ёстой” гэж хэлдэг ч үнэндээ хамгийн том асуудал нь тэр оролцох ёстой үйл явцаа сонирхдоггүй, эсвэл үндэслэл бүхий сайн санал өгч чаддаггүй, тэр нь цаашлаад бидний оролцож байгаа байдлын чанарыг тодорхойлж, саналыг үнэлэх итгэл үнэмшил суларч байгаа юм. Энэ нь эргээд Засгийн Газар эсвэл Парламентаас бидний оролцох эрхийг хязгаарлах шалтаг болдог. Монгол уруу ирэх замдаа сониноос Их Британийн Засгийн газар Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиндаа хязгаарлалт оруулах талаар мэдээ уншлаа. Английн Засгийн Газар үүнийг зарим иргэд энэхүү хуулийг хэтрүүлэн ашиглаж байгаа ба мэдээллийг нэгтгэх, мэдээллийг боловсруулахад боловсон хүчин, цаг, санхүү мөнгө хэрэгтэй учир хуулиндаа хязгаарлалт хийх шаардлагатай хэмээн тайлбарласан байсан. Зарим Британийн иргэд орон нутгийнхаа удирдлагаас тэрхүү дүүрэг дэх гэрлээгүй

цагдаагийн ажилтнуудын жагсаалтыг хүсдэг, тийм мэдээллийг хуулийн дагуу өгөх шаардлагатай байдаг гэсэн жишээ татсан байсан юм. Энэ мэдээлэл нь Мэдээлэл хамгаалах хуулийн хүрээнд багтаагүй ангилалд байдаг юм байна. Тэгэхээр бас л үйл явцад мэргэжлийн түвшинд оролцохыг хүсэж байвал өөрийн үйл ажиллагааг итгэл үнэмшилтэй болгох ёстой юм.

Идэвхитэй оролцооны тухайд ширээн дээр өөд өөдөөсөө харж суугаад хамтран ажиллахыг хичээж байгаа бол ялангуяа төрийн бус байгууллагууд нь өөрсдийн санал юунд үндэслэгдсэн, яагаад хамааралтай талаар баттай мэдээлэл, баримттай оролцох нь их хэрэгтэй байдаг. Үүнийг Их Британийн Засгийн Газар ч төрийн бус байгууллагуудад зөвлөдөг. Төрийн бус байгууллагууд нийгмийн тодорхой бүлгүүдийг төлөөлдгийн хувьд “Ийм байдлаар асуудлыг шийдэх нь зөв хэмээн бодож байна” гэж хэлээд суух биш яагаад дэвшүүлсэн шийдвэр чинь сайн болох талаар нотлох баримттай байвал тэрхүү төрийн бус байгууллагын санал ч илүү жинтэй болно.

Бас өөр нэг зүйл нь **харилцаа холбоо** юм. Засгийн Газар “Бид хуулийн төслийг хүмүүст хүртээлтэй болгочихлоо” гэдэг. Гэтэл тэр хүмүүсийн саналаа өгөх ёстой хууль нь хэр ойлгомжтой байдаг вэ? Энэ түүхийг би хэн нэгнээс сонссон юм. Английн нэгэн хотын захирагч нь орон нутгийн бодлогыг боловсруулах явцдаа иргэдээс санал хүсэлтийг нь авах хэрэгтэй гээд орон нутгийн бодлого боловсруулагчдыг боловсруулж байгаа баримтуудаа олон нийтэд хүртээлтэй болгох тухай санал тавьжээ. Тэд боловсруулсан бодлогоо бичээд, хэвлээд, хүмүүст тарааж. Харин хотын захирагч тэрийг нь аваад гудамжинд гараад санамсаргүйгээр хэдэн хүн сонгон албан газартаа авчраад тэр баримтыг уншин ойлгоогүй бүх зүйлээ улаанаар тэмдэглэхийг хүсчээ. Хотын захирагч дараа нь бодлого боловсруулагчдыг өрөөндөө хуралдуулахад тэд орж ирээд ханан дээрх улаан цааснуудыг хараад иргэд тэдний боловсруулж байгаа баримтуудыг ойлгодоггүйг харсан байна. Бага багаар хууль тогтоогчид өөрсдийгөө иргэд ойлгохоор илэрхийлж сурсаар, улаанаар тэмдэглэгдсэн хэсгүүд ч багасчээ. Та бүхний иргэддээ өгч байгаа мэдээлэл тодорхой ойлгомжтой байх нь маш чухал гэж би боддог. Хүмүүсээс санаа оноо авахыг хүсэж байвал саналаа өгөх хүмүүс тэр баримтыг ойлгож байгааг хангах нь нэн чухал.

Эцэст нь хэлэхэд, миний харснаар маш олон оролцооны үйл явц амжилтад хүрдэггүй нь эхнээсээ иргэдийг оролцуулах чин хүсэл эрмэлзэл байдаггүйгээс гадна үр дүнгийн төлөө хүлээх хариуцлагын тогтолцоо байдаггүйтэй холбоотой гэдгийг хэлмээр байна. Олон тохиолдолд зөвлөлдөөн, оролцоо байгаа ч иргэдийн саналаа өгсөн төслийн эцсийн хувилбараас тэс өөр хууль Парламентаар батлагдах нь цөөнгүй. Тиймээс хууль санаачилж буй Засгийн Газар эсвэл Парламентын гишүүд тэдний санаачилсан хууль нь иргэдийн оролцооны үйл явцыг тусгасан байхыг хангах хариуцлага хүлээх ёстой гэж боддог. Нөгөөтэйгүүр төрийн бус байгууллагууд ч мөн хуулийн төслийг боловсруулах үйл явц дууссаны дараа зөв зүйтэй шийдвэрийг зөвлөсөөр байх ёстой гэж боддог. Хэрэв тэд ингэхгүй л бол тэдгээр хуулийн төсөлд өөрчлөлт орох боломж их шүү. Энэ үгээр илтгэлээ өндөрлөө.

АСУУЛТ- ХАРИУЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Р. БУРМАА /Сонгогчдын Боловсрол Төв/

3. Энхболд гишүүний илтгэлд хэрэгжүүлэх боломжтой хэд хэдэн санал дэвшүүлээ. Илтгэлд дурьдсан нэг тоон үзүүлэлтийн талаар тодруулах гэсэн юм. Жилд хэдэн хуулийн төсөл, тогтоол шийдвэр УИХ-аар батлагдаж байна? Түүний хэдэн хувь нь олон нийтийн хэлэлцүүлгээр орж байна? Мөн хэдэн хувийн хуулийн төсөл олон нийтэд хэвлэгдэж хүрч байна? Вэб хуудсанд бүгд тавигддаг уу? Би хуулийн төслийн хэлэлцүүлгийг үзэх гэтэл 7 дугаар сарын 8-наас хойш мэдээлэл байхгүй байж байгаад 12 сарын сүүлээр ирцийн мэдээллүүд тавигдаж байгаа харагдсан. Тэгэхээр энэ талаар тодорхой журам байдаг юм уу? Ямар хугацаанд шинэчлэгдэж байдаг юм бэ? Өөр нэг асуулт бол Байнгын хороон дээр хэдэн хуулийн төслөөр хэлэлцүүлэг хийсэн бэ? Нийт батлагдсан хуулийн хувьтай нь харьцуулж сонирхож байна.

3. ЭНХБОЛД /УИХ-ын гишүүн/

Би сая Тамгын газраас лавлагаа авлаа. Нэг чуулганаар 100 орчим шинэ хууль, шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль хэлэлцэн баталдаг юм байна. Вэб хуудсыг гайгүй ажиллаж байгаа гэж би бодож байгаа. Яг үнэнээ хэлэхэд цаасаар гар дээр ирчихдэг учраас би орж үзээгүй л дээ. Тийм алдаа гарсан байхыг үгүйсгэхгүй. Яагаад гэвэл манай техникийн хэлтэс маш цөөхөн хүнтэй, хүн нь хүрэлцдэггүй юм. Дөнгөж сая би Д. Лүндээжанцан даргатай яриад сууж байна л даа. Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын тушаалаар вэб хуудсыг шинэчлэх журам гэж байдаг бол тэрийг илүү тодорхой болгоод мэдээллээ өдөрт нь оруулж байдаг, ороогүй байвал хариуцлага тооцож байдаг болгох, орон тоог нэмэх тухай ярьж байна. Тэгэхээр энд нэг тийм алдаа гарсан байж магадгүй.

Нийт хэлэлцэж байгаа хуулийн тоог нээлттэй хэлэлцүүлэг хийж байгаа хуулийн төслийн тоотой харьцуулахад үнэхээр чамлалттай байгаа юм. Ашигт малтмалын тухай хуулийн төслөөр хийснийг санаж байна. Яагаад гэхээр хамгийн анхных нь байсан. Дүрэм, журмыг нь би өөрөө боловсруулж байсан учраас сайн санаж байна. Түүнээс хойш бусад Байнгын хороо нээлттэй хэлэлцүүлэг хийснийг би санахгүй байна. Одоо Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хороо Улаанбаатарын утааны асуудлаар 2 дугаар сард хийхээр товлосон байна билээ. Бүх хуулиар нээлттэй хэлэлцүүлэг хийх шаардлагагүй байх. Олон нийтийн санаа, сонирхлыг татсан ийм асуудлаар зайлшгүй хийх ёстой гэж бодож байна. Нэг хуульд хоёр үг засах асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг явуулья гэж хэлэхэд ирэх хүний тоо цөөхөн байна гэж би хувьдаа бодож байна. Тиймээс хуулийн төслүүд нь олон нийтийн

анхаарлыг хэр татаж байна, бүх хүний эрх ашгийг хөндөж байна уу гэдэг чухал юм. Тухайлбал, Татварын тухай хууль бол бүх хүний эрх ашигтай холбоотой учраас зайлшгүй олон нийтийн хэлэлцүүлэг хийх шаардлагатай. Байнгын хорооны хэлэлцүүлэг биш олон нийтийн хэлэлцүүлэг бол одоо явж байгаа шүү дээ. Татварын хуулиудаар Шинжлэх ухаан, мэдээллийн төвийн танхимд цуврал ярилцлага явагдсныг би санаж байна. Телевизийн ярилцлага нэлээд их явсан. Тэгэхээр 200 хууль хэлэлцсэн байна, түүнээс хоёрхон хуулийн төслийг нийтэд хэлэлцүүлсэн байна гэж хэлэхээсээ илүү тухайн хуулиуд нийт иргэдийн эрх ашгийг хэр хөндөж байсан гэдгээс тоо баримтаа гаргавал зүгээр байх.

Р. УНДРАЛ /Ардчилалын Боловсрол Төв/

Бурмаагийн тавьсан асуулттай бас холбоотой юм. Эргэх холбооны талаар. Иргэд, ТББ-ууд өөр өөрсдийнхөө салбар чиглэлээр дамжуулаад хууль, тогтоол, дүрэмд өөрсдийн санал бодлоо илгээдэг. Гэтэл УИХ болон түүний Тамгын газарт иргэд, ТББ-уудаас өргөж байгаа саналуудын бүртгэл байдаг уу? Дэвшүүлсэн саналд хариу өгөх талаар ямар ч юм хийдэггүй. Ихэнх тохиолдолд эдгээр саналыг хүлээж авдаггүй, хүлээж аваагүй бол яагаад хүлээж аваагүй гэсэн тухай эргээд хариу өгөх ч юмуу, ямар шалтгаанаар авдаггүй вэ гэсэн тийм бүртгэл, тооцоо юм байдаг уу? Жишээлбэл, 2005 оноос эхлээд ТББ-уудын эвсэл байгуулаад Татварын багц хуулинд өөрчлөлт оруулъя гээд чадах ядахаараа УИХ-ын гишүүдтэй, Төсвийн байнгын хорооны гишүүдтэй уулзалт хийж байсан боловч амжилтад хүрээгүй л дээ.

З. ЭНХБОЛД /УИХ-ын гишүүн/

Би нөгөө 1 хувийн татварын асуудлыг санаж байна. Хэлэлцээгүй биш хэлэлцсэн. Манай татварын хуулийн шинэчлэлийн үзэл баримтлал бол өөр байгаа юм. Бүх татвар улсын төсөвт хураагддаг. Буцаагаад тэндээсээ хуваарилагддаг байхаар явахгүй бол нэг хувийн татвар гэдэг цоорхой гаргаад түүгээр төсвийн орлого бүрдэхгүй байх тал их байна гэж гишүүдийн олонх нь үзэж байсан учраас энэ батлагдаагүй. Манай монголын өөрийнх нь онцлог байгаа юм. Татварын хуулийг буруугаар хэрэглэх явдал гарчихсан учраас гишүүд эмээгээд байсан. Тухайлбал, боловсролд оруулдаг хөрөнгийг татвараас чөлөөлнө гэсэн чинь тэрбум төгрөгөөр сургуулийн засвар хийж татвараас чөлөөлүүлчихээд буцаагаад тэр сургуульд орсон хүүхдүүдээс төлбөр авдаг ийм практик гарч ирсэн учир тэр цоорхойг хаасан юм шүү дээ. Түүнтэй адил тэр нэг хувийг зөвшөөрчих юм бол хэдэн төгрөгийн орлого улсын төсөвт хураагдахгүй байх вэ гэдэг тийм айдас байгаа юм. Тэгээд Рааш гишүүн бид нар бас Словакт очоод харсан. Нэг хувийн татвартай улс юм байна билээ. Тэгээд шинэ гарсан парламент нь түүнийгээ хумиж байна билээ. Яагаад ингэж байгаа юм бэ гэхээр үүнийг буруугаар ашиглах явдал их гараад байдаг, түүнтэй татварын алба үр ашигтай тэмцэж чадахгүй байна. Тийм учраас үүнийг тодорхой зорилготой, хэмжээ нь бага байхаар нэмж засах хэрэгтэй гэж байсан. Тэгэхээр татварын албаны зөв ажиллагаа, ил тод, компаниуд өөрсдөө ухамсартайгаар хэрэглэдэг хуулийн соёл төлөвшсөн үед л ярина уу гэхээс биш одоо өнөөдөр шиг татвараас зугтаадаг үйл явцтай байгаа үед бол болохгүй. Иймд УИХ-д хэлэлцэгдээгүй юм шиг харагдаж байгаа боловч үйл явцыг нь би өөрт чинь ярьж өгч байна шүү дээ. Шалтгаан нь бол энэ юм. Ер нь бүх саналыг авах бололцоогүй

байдаг. Ямар саналыг яагаад аваагүй гэдэг нь ил тод байхаас бус бүх саналыг ав гэж тулгаж болохгүй. Тэгэхээр иргэдийн оролцоо, ТББ-уудын оролцооны тухай ярихдаа энийг бас жаахан зааг ялгаатай ойлговол зүгээр юм шиг байгаа юм.

Ж. НАРАНТУЯА /УИХ-ын Тамгын газрын нэгдүгээр нарийн бичгийн дарга/

Хоёр зүйл тодруулж хэлье. Манай УИХ-ын вэб хуудас их хурлаар хэлэлцсэн бүх л бичиг баримтыг байршуулдаг. Хэлэлцүүлгийн үйл явцыг ч гэсэн ялгаагүй, Байнгын хорооны хуралдаан, чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл, санал хураалтын дүн зэргийг бүгдийг үзэж болно. 7 дугаар сараас 11 дүгээр сар хүртэл шинэчлээгүй байж магадгүй. Хоёр үндсэн шалтгаантай. Нэгдүгээрт, чуулганы завсарлагааны үеэр УИХ-ын гишүүд гол төлөв орон нутагт, тойргийн сонгогчидтойгоо уулздаг болохоор манай вэб хуудаст тусгагдаад байх мэдээлэл харьцангуй бага байдаг байх. Хоёрдугаарт, манайд бас техникийн тодорхой саатал гарсан. Үүнд та бүхнээс уучлалт хүсч байна. Бид цаашдаа парламентынхаа вэб хуудсыг цаг тухайд нь шинэчлэн ажиллана. Манайд байнгын хорооны ажлын алба гэж шинээр байгуулагдсан. Энэ албаны хийх үйл ажиллагааны үндсэн гол чиглэл нь иргэд, байгууллагаас ирж байгаа санал, хүсэлт, гомдлыг нэгтгэж дүгнэдэг, түүнд ямар нэгэн байдлаар анализ хийдэг, эргээд хариу мэдэгддэг байх ёстой. Үнэхээр түүрүүнд Катерина хэлж байснаар аливаа нэгэн үйл ажиллагаа бол заавал эргэх холбоотой байдаг. Иргэн байгууллагад өргөдөл, санал өгдөг. Тэр санал нь ямар шатанд явж байгаа, яагаад хуулийн төсөлд тусгах боломжгүй вэ гэдгийг бид нар цаашдаа анхаарч ажиллана. ТББ-ууд, иргэд үүнд эргээд хяналт тавьж, танай энэ үйл ажиллагаа чинь доголдож байна шүү гэж хэлж байх ёстой. Үүн дээр бид байнга хамтарч ажиллана гэдэгт найдаж байна.

Д. ЛАМЖАВ /Иргэн/

Би нэг жишээ хэлье. Авилгалын тухай хууль хэлэлцэнэ гээд хуулийн төсөл нь сонинд нийтлэгдсэн. Хэлэлцэх хоног нь ч гэсэн дөхсөн байсан. Хуулийн төсөл нь манай улс нэгдэн орсон Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцийн үзэл санаатай холбогдолгүй шахам байсан. Тэгээд бачимдахдаа би бүр хуулийн төсөл бичсэн. Дараа нь түүнийгээ УИХ-д хүргэх ажил болсон л доо. Бүх гишүүдийн электрон шуудангийн хаягаар явуулсан. Дараа нь бүгдэд нь цаасаар хүргэсэн. Тэгээд тэр юу болсон тухай би юу ч мэдээгүй. Ямар нэгэн хариу байгаагүй. Сүүлд нь би Цэцэд хандсан өөр нэг асуудлаар явахдаа Авилгалын эсрэг хуулийн хувийн хэрэгтэй танилцаж үзсэн. Иргэдээс ирүүлсэн санал шүүмжлэл хуулийн хувийн хэрэгт авагдах тухай холбогдох хуулиудад байдаг. Тэгээд тэр хувийн хэрэгт миний юм байна уу гээд харахаар байхгүй байх жишээтэй. Иймд энэ оролцооны асуудал дээр УИХ, ялангуяа Тамгын газар хандлагаа өөрчлөхгүй бол юм бүтэхээ больжээ. Хандлагаа маш өөр байдлаар тавих ёстой. Оролцоог сайжруулахын тулд түүрүүн гадаадын нэг илтгэгч зөвхөн интернетийн асуудал бол хангалтгүй, түүнийг ашиглаж чаддаггүй хүмүүс байдаг гэж хэлсэн. Би түүнийг бүрэн дэмжихийн хамт интернет бол маш хүчтэй зэвсэг учраас түүнийг бас ашиглах хэрэгтэй гэж хэлмээр байна. Манай УИХ бол интернетийн сүлжээг хариуцан ажиллаж байгаа хэдэн хүүхдийг хуучин тогтолцооны үеийн бичээчийн түвшинд авч үздэг байхгүй юу. Тэнд ухаантай хүмүүс ажилладаг юм шүү дээ. Тэд программ бичнэ. Өчнөөн олон арван хүний хийх ёстой ажлыг ганцхан хүн хийгээд зохицуулаад өгчихнө. Тэгэхээр

одоо энэ байдалдаа хандлагаа өөрчлөх ёстой. Тэгэхгүйгээр ажил урагшаа явахгүй нь ээ. Өнөөдөр энд яригдаж байгаа асуудлын хувьд гэвэл хуулиудад “болно”, “шаардлагатай бол болно” гэсэн заалт байгаа. Тэр шаардлагыг нь хэн тодорхойлох вэ? Болно гэдэг чинь бас болохгүй байж ч болно гэсэн үг болж байгаа. Энэ мэт ерөөсөө дэг байхгүй байгаа. Үүний төлөө л юм ярихаас аргагүй. Эрх зүйн орчин нь ерөөсөө бүрдээгүй байгаа. Энхболд гишүүний илтгэлд гарсан УИХ-д иргэдээс хандсан тухай диаграмм дээр хувийн асуудлаа шийдүүлэх гэж ханддаг хүсэлт нь нэг их өндөр багана болчихсон харагдсан. Энэ юуг харуулж байна гэхээр УИХ-аас олон нийттэй харьцах асуудалдаа механизмаа бүрдүүлж чадаагүйн баталгаа. Тийм учраас иргэдийг хүмүүжүүлэх асуудал ярихаасаа өмнө Их хурлыг хүмүүжүүлэх асуудлыг ярих нь хамгаас чухал байна.

Ц. ОЮУНБААТАР /Консенсус төв/

Гурван асуулт асууя. Хууль тогтоох байгууллага маань цөөхөн ч хүнтэй, бас сонгуулийн систем маань ч гэсэн алдаа оноотой. Хуулийн үндсэн зорилго нь ард түмний санаа бодолд тулгуурладаг байх ёстой.

Нэгдүгээрт, иргэд, ТББ-уудыг хууль боловсруулах, хэлэлцэх үйл явцад татаж оролцуулах асуудалд зарчмын өөрчлөлт хийх боломж байна уу, үгүй юу? Өнөөдрийн парламент ч, ирээдүйн парламент ч гэсэн энэ асуудалд томоохон өөрчлөлт хийх, эрх зүйн зохицуулалтыг нь бүрдүүлэх чиглэлээр юу хийх гэж байна гэдэг нь сонин байна.

Хоёрдугаарт, хууль боловсруулах шатанд иргэд, олон нийтээс ирдэг олон тооны өргөдөл, санал, хүсэлт байдаг. Хэдэн зуу, мянгаараа яригдаж байна. Эдгээрээс авсан нь хэд байгаа юм бэ? Заавал авах ёсгүй. Үндсэн хууль хэлэлцэж байхад их сайн авч байсан. Урьд нь ч хийж байсан. Бүр түрүүнд социалист тогтолцооны үед ч үүнийг бас муугүй хийж байсан шүү дээ. Өнөөдөр бид зарчмын том юм юу хийчихэв? Зөвхөн иргэдээс биш мэргэжлийн багш, судлаачид, эрдэмтдийн саналыг яаж авах бололцоотой байна вэ? Түрүүчийн УИХ дээр энэ тухай асуудлыг их олон хөндөж тавьдаг байсан. Энэ тал дээр шинэчлэлт хийж чадвал манай парламентад ихээхэн өөрчлөлт гарна. Ялангуяа нэг намд нөлөөтэй байж их хуралд очно, эсвэл их мөнгөтэй байж их хуралд очно. Өөрөөр ямар ч сайн судлаач, мэргэжилтэн, багш хууль тогтоох үйл явцад нөлөөлөгч, хууль тогтоогч болж чадахгүй. Өнөөгийн байдал ийм байна. Дараагийн 2008 оны сонгуулийн хуульд ч нэг иймэрхүү янзтай явж байгаа. Ийм учраас би иргэд, олон нийтээс дэвшүүлсэн саналыг хүлээж авах, боловсруулах, бүртгэх, эргэж мэдэгдэх нь нэг хуулийг хэлэлцүүлэхээс илүү нийгэмд үр өгөөжтэй байж магадгүй юмаа гэж бодож байна.

Гуравдугаарт, ер нь УИХ-д хуулийн болон бусад асуудлаар хандаж байгаа санал хүсэлтийг Үндсэн хуулийн 16.12-т байдаг “Иргэд өргөдөл гомдол, санал хүсэлтээ УИХ-д хандаж гаргана” гэсэн заалтад хамааруулдаг уу? Тэгдэг бол заавал хариу өгөх ёстой. Одоо бол хэн хүнгүй л аваад хав дарчихдаг зуршилтай байгаа. Д. Бямбасүрэн гуайн гаргасан нэг практик байгаа шүү дээ. Ганбаярыг Ерөнхий прокурор байхад нь миний өргөдөлд хариу өгөөгүй гэж Үндсэн хуулийн цэцээр дүгнэлт гаргуулсан. Өнөөдөр ийм боломж нээлттэй байна уу, үгүй юу? Энэ нь УИХ-ын гишүүдэд хамаарч байна уу, үгүй юу? Хүмүүс УИХ-ын гишүүдэд

өдий төдий өргөдөл, гомдлоо гаргадаг. Түүнийх нь хариу нь байдаггүй. Гэтэл энэ Үндсэн хууль зөрчиж байгаа үйл явц болчихоод байна. Иймд энэ гурван асуултад анхаарч шийдэх гарц байна уу гэдгийг сонирхож байна.

3. ЭНХБОЛД /УИХ-ын гишүүн/

Ц. Оюунбаатарын санаа зовдогтой би бас санал нэг байна. УИХ-ын болон Тамгын газрын үйл ажиллагааг иргэд, олон түмэнд нээлттэй болгох асуудлыг дэмждэг. Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль үүнд чухал алхам болох хууль гэж үздэг. Энэ хууль төрийн байгууллагуудыг олон нийтийн хүссэн мэдээллийг гаргаж өгөх талаар үүрэгжүүлж байгаа хууль юм. Энэ нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд нэлээд том алхам болно гэж үзэж байгаа. Яагаад гэхээр УИХ-ын гишүүд, сайд нар, төрийн албан хаагчдын гар дээр байдаг мэдээлэл иргэдийн гар дээр байдаг мэдээллээс ялгаатай. Өнөөдөр УИХ-ын гишүүний хувьд тухайн хуулийн төсөлтэй холбоотой маш олон судалгаа, мэдээлэл байгаа. Энэ бүх мэдээлэл иргэдэд байх юм бол тэдний саналаа хэлэх боломж бас их өөр болох юм. Гэтэл хоёр өөр хүнд хоёр өөр мэдээлэл өгчихөөд “чи оролцсонгүй” гэж хэлэх нь буруу юм. Адил мэдээлэлтэй хүн асуудалд тэгш оролцоотой байх талаар ярих ёстой. УИХ-ын вэб хуудсыг өөрчилж гээд байгаа нь ердөө л энэ юм. Хоёр гуравхан зүйл хийхэд л чанарын өөрчлөлт гарах гээд байгаа юм. **Нэгдүгээрт**, үүнийг бид өнөөдөр хийх ёстой. Гишүүдэд тараагдсан тэр зузаан материал шиг мэдээллийг интернетэд байрлуулсан байх, асуудал Байнгын хороогоор ороод юу нь өөрчлөгдөв гэдэг нь ил тод байх юм бол иргэдийн, ТББ-ын оролцоо их үр дүнтэй болох юмаа гэж бодож байгаа.

Хоёрдугаарт, зайлшгүй нэн даруй засах шаардлагатай практик бол чуулганы хуралдаан, Байнгын хороон дээр хэлэлцэх асуудлаа жагсаагаад доор нь “бусад” гээд нэг хүүдий үлдээчихдэг юм. Тэгээд түүндээ ийм асуудал хэлэлцье гээд оруулж ирдэг. Гэхдээ тэр нь өөрөө манай УИХ-ын ажлыг чанаргүй, түүхий хууль гаргах бололцоог нээгээд байна гэж би хувьдаа үздэг. Бусад гэдгээр орох зайлшгүй шаардлагатай байгаа дайн байлдаан, бусад зүйл нь нээлттэй байгаад байна. Тиймээс хандлагаа өөрчлөхгүй бол болохгүй нь ээ гэсэн Ламжав гуайн саналтай нэг байна. Хичнээн олон хүнээс санал асууна, төдийчинээ олон санал гарах ёстой. Хүлээж авсан санал хүсэлт нь илүү бүтээлч байхаар явах юм бол гарч байгаа хуулиудын чанар сайжирна. Энэ өөрчлөлтүүдийг хийчихвэл түрүүчийн парламентуудаас илүү амьд болох юм. Би хувийн туршлагаасаа хэлэхэд УИХ-ын хавар, намрын чуулганы дараа илүү их овсгоотой байх нь чухал юм. Чуулганаар хэлэлцэх асуудлын талаар гишүүнд тараасан холбогдох мэдээллийг хувилаад баг, сумын дарга нарт үлдээдэг. Тэгээд саналаа бичгээр өгөөрэй гэдгийг би бүр уламжлал болгосон. Тэглээ гээд түүний дагуу ирдэг санал бас ховор байдаг. Ламжав гуай шиг тийм их санал гаргадаг хүн бас цөөн л дөө. Яагаад гэвэл харилцан адилгүй мэдээлэлтэй байдаг учраас тэр байх. Тэгэхээр үүний тулд бас зарим хуулийг өөрчлөх, тухайлбал Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа юм.

С. ГАНБААТАР /Эрүүл нийгэм-иргэний хөдөлгөөний тэргүүн/

Манай хамгийн гол бэрхшээл бол иргэдийг мэдлэгтэй, мэдээлэлтэй байх боломжийг нь сайн олгоогүйн улмаас иргэд оролцох гэхээр тэтгэвэр нэмэх үү, доод

цалин нэмэх үү гэхээс цааш юмгүй байдаг. Интернетээр ард иргэдийг мэдлэгжүүлэх, мэдээлэлжүүлэх гэхээр интернет нь тийм ч их өргөн нийтийг хамарсан биш байдаг. Энэ бэрхшээлүүдийг бусад улс орон, бас шилжилтийн орнуудад шийдвэрлэж байгаа дэвшилтэт арга замууд юу байна? Ялангуяа мэдлэгжүүлэх, мэдээлэлжүүлэх тал дээр?

3. Энхболд гишүүнээс асуухад УИХ-ын чуулганы хуралдаанд иргэний хөдөлгөөнүүд суугаад ажиглах боломж нь ямаршуу байдаг юм болоо? Ард нийтийн санал асуулга өнгөрсөн 16 жилийн туршид явагдсан тохиолдол байна уу? Ховор байдаг юм бол тэр боломж нь яагаад хаагддаг юм болоо?

3. ЭНХБОЛД /УИХ-ЫН ГИШҮҮН/

Миний илтгэлд бас гарсан байгаа. 1995 онд Ард нийтийн санал асуулгын тухай хууль гаргаад ерөөсөө ашиглаагүй юм байна билээ. Энэ хуулийг ашиглахад санхүүгийн бэрхшээл илүү их байх шиг байгаа юм. Яагаад гэвэл Монгол улсын насанд хүрсэн бүх иргэдээс асууна гэхээр сонгууль явуулах хэмжээний зардал гардаг. Бусад улсын туршлагыг харахад сонгуультайгаа хамт явуулдаг арга байдаг. Манайд дөрвөн жилд нэг удаа УИХ-ын сонгууль болдог. Сондгой жилд нь Ерөнхийлөгчийн сонгууль болдог. Тэгэхээр 5 жилийн давтамжид 3 удаа сонгуультай хамт ард нийтийн саналыг ямар нэгэн илүү зардалгүйгээр авах боломж байгаа юм. Харин үүнийг ашиглахгүй байгаагийн учир юу юм бэ гэхээр ач холбогдол өгөхгүй л байгаа байх. Энэ бол хамгийн хүчтэй зэвсэг л дээ. Санал асуулга гэхээр 1945 онд тусгаар тогтнолын асуудлыг шийдсэнтэй хүмүүс адилтгаж ойлгоод байдаг. Тэрнээс өөр юм шийдэх гэхээр хүмүүс “За энэ ч дээ дэндүү бага юм шийдэх гээд байна уу” гэж боддог юм шиг байгаа юм.

Ер нь иргэдийн эрх ашгийг хөндөж байгаа асуудлаар ялангуяа татварын өсөлтийн асуудлаар зайлшгүй хийдэг арга хэмжээ юм билээ. Татварыг төдий чинээгээр нэмэгдүүлэх нь зүйтэй юу, үгүй юу? Чиний татварын мөнгөөр ийм юм барих нь зөв үү, буруу юу? гэх зэргээр асуудаг юм байна билээ. Намайг Денверт сурч байхад татварын мөнгөөр тэр хотод шорон барих нь зүйтэй юу, үгүй юу гэдэг асуудлаар санал асуулга явуулж байсан. Үүнийг тухайн дүүргийн оршин суугчид эсэргүүцээд хотынхоо нийт оршин суугчдын санал асуулгаар шийдэж байсан л даа. Тэгэхдээ тэнд жилдээ хэдэн сонгууль зэрэг явж байгаа юм. Тиймээс нэг удаагийн сонгуультайгаа зэрэг явуулаад шийдэж байсан.

Санал асуулга явуулахдаа шорон барих зайлшгүй шаардлагатай байгаагаа цагдаагийн байгууллага бодитой үндэслэлтэй сайн тайлбарлаж, нөгөө талаас нь эсэргүүцэгчид манай энд шорон баривал оргодлууд гэр орон ухах зэрэг аюултай учраас зөвшөөрөх боломжгүй гэдгээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан маш сайн хэлэлцүүлэг хийж байсан. Үүний үр дүнд ард нийтийн санал асуулгаар шорон барих нь зүйтэй гээд энэ ажилд иргэдээс нэмэлт 50 долларын татвар авахыг зөвшөөрч шийдэж байсан.

Тэгэхээр түрүүнд Катеринагийн ярьж байснаар интернетээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслийг сайн ашигладаг байх ёстой. Энэ үүднээс Улаанбаатарт гардаг бүх телевизийг ямар нэгэн үнэ төлбөргүйгээр орон нутагт гаргадаг болгох

хөрөнгө оруулалтыг хоёр, гурван тэрбум төгрөгөөр хийлээ л дээ. Одоо ингээд цагаан сар гэхэд дуусах юм билээ. Аймгийн төвүүд болон том сумдад Улаанбаатарт гардаг телевизийн 10 сувгийг нэгэн зэрэг хүлээн авч үзнэ. Сумын төвд 4 сувгийг үзэх боломж гарна. Ингэхээр ХМХ мэдээллийг иргэдэд хүргэх, харин эргэх холбоог нь интернетээр дамжуулан авч байх боломжтой юм. Бүх сумын Тамгын газар интернеттэй, түүнд УИХ, Засгийн газрын бүхий л үйл ажиллагаа нээлттэй байдаг, тэгээд оронгуутаа өөрийнхөө и-мэйл хаягаар сонгосон гишүүндээ юм уу сайдад асуулт тавьж хандаж болохыг би энэ илтгэлдээ яриад байгаа юм. Тэгэхээр айл болгоныг гэртээ интернеттэй бай гэж хэлж байгаа үг бас бишээ. Ямар ч дүүргийн Тамгын газраар ороход жижүүрийнх нь дэргэд үнэгүй интернет байж байдаг, тэгээд хоёр талдаа урсгалтай сүлжээгээр иргэд саналаа илэрхийлэх боломжоор хангаад өгсөн байх нь төрийн үүрэг гэж бодож байгаа.

С. ДЭМБЭРЭЛ /Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга/

Хуулийг боловсруулж хэлэлцэхэд оролцоог хангах асуудлыг номинал, бодитой гэсэн байдлаар хоёр хувааж яримаар юм шиг байна. Өнөөдрийн энэ хурал дээр яригдаж байгаа байдлыг харахад гол төлөв нэрлэсэн буюу номинал оролцоог хэлээд байх юм. Энэ ч одоо бүр моод болчихсон. Интернет, нэг цэгийн үйлчилгээ, хотлайн гээд л. Тэгээд нэг иймэрхүү хурал хийдэг. Энэ маань тэгэхээр нэрлэсэн оролцоо гэсэн үг юм. Жишээ нь сая нэг хүн тэр ТББ-ын тухай хууль юу болж байна гэж асууж байна л даа. Тэгэхээр З. Энхболд гишүүн юу гэж хариулж байна вэ гэхээр “үгүй ээ тэр чинь ийм байгаа юм” гэх жишээтэй. Эсвэл Ламжав гуайн асуусан шиг “Би ингээд ингээд саналаа явуулсан чинь таг болчихсон” гээд. Нэг хууль байдаг юм. Үүнийг гэхдээ УИХ-ын гишүүн бүр уншаагүй байх, уншдаггүй ч байх гэж би боддог юм. Тэр нь хууль боловсруулах... гэсэн нэг их урт нэртэй. Тэр хуульд яг гол цаад талынх нь үзэл санаа юунаас хамаарч байна гэхээр сайн гишүүн, сайн Ерөнхийлөгч, сайн УИХ-ын дарга, сайн сайд байвал энэ оролцоо нэмэгддэг гэсэн тийм утгатай. Өөрөөр хэлбэл хүмүүсийг гишүүн, сайд болчихоор бусдаасаа илүү сайн болчихдог гэсэн нуугдмал үзэл санаа тэр хуульд явж байдаг. Жишээлбэл, “УИХ-ын гишүүн тодорхой ийм ийм саналуудыг үндэслэлтэй гэж үзвэл оруулна” гэж заасан байдаг. Тэгэхээр үндэслэлтэй гэдэгт 6 шалгуур байдаг гэж түрүүний нэг эмэгтэй ярьсан шүү дээ.

Манайд бол тэр үндэслэлтэй гэдгийгээ хууль зүйн талаас нь оруулчихсан тийм заалтууд байхгүй ээ. Тиймээс эндээс гарах хамгийн энгийн нэг практик дүгнэлт, зөвлөмж гэвэл тэр хүний ярьсан Тони Блейрийн хэлсэн зургаан зүйлийг хуульдаа тусгаж өгөх шаардлагатай юм. Ламжав гуайн хэлсэн тэр хандлагаа өөрчлөх гэсэнд дүгнэлт хийх хэрэгтэй. Тэгэхгүйгээр орой болгон телевизээр Улаанбаатар хотын утаа униар ийм байна, тийм байна гэж яриад л ямар ч үр дүн гарахгүй. Тэгэхээр энэ нэрлэсэн оролцооны хэлбэр гомдол гаргах, өргөдөл бичих маягаар эсвэл ууртай, эсвэл жагсах байдлаар явагдаад байх болно. Тийм учраас тэр системийг нь өөрчилж байж иймэрхүү хурлаас үр дүн гаргахгүй бол болохгүй. Энэ семинарын үр дүн ч ялгаагүй. Их хурлын гишүүд хурлын материалтай танилцаад л үүний дагуу хийгдэх ажил байхгүй байх жишээтэй. Яг үнэндээ хэлэхэд монголын маань бодит байдал ийм л байгаа. Хууль тогтоох үйл явцад хүмүүсийн санал бодлыг авдаг механизм маань ийм л байгаа. Гэтэл цаана чинь бусад орны сайн жишээнүүд

зөндөө байна. Энийг нэг их ухаантай зан гаргалгүйгээр шууд аваад хуулиндаа хийгээд тэр шалгууруудыг тавьчихад энэ улс бас нэг арай гайгүй болно байх гэж боддог юм. За баярлалаа.

Д. АЛТАЙ /Ардчилсан социалист эмэгтэйчүүдийн холбоо/

Би судлаачийн хувьд хоёр санал хэлье. Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцооны асуудал бол сүүлийн жилүүдэд маш их яригдаж байгаа. 2000 оноос хойш сайн засаглалыг төлөвшүүлэх, парламентын ил тод, нээлттэй байдлыг хангах гээд Нээлттэй Нийгэм Форумас ч гэсэн энэ чиглэлээр олон бүтээлч судалгаанууд хийгдэж байгаа гэж бодож байгаа. Өнгөрсөн оны 5 сард яг энэ асуудлаар болсон хэлэлцүүлэгт Тамир судлаач, бусад залуу судлаачид оролцож байсан. Өнөөдөр Европын хуучин социалист байсан орнуудын судлаач, экспертүүдийг оролцуулсан семинар болж харилцан туршлага солилцон манай парламентыг цаашид хөгжүүлэх чиглэлээр үр бүтээлтэй семинар болж байна. Энэ талаар УИХ-ын Тамгын газар, Нээлттэй Нийгэм Форумд бас талархал илэрхийлэх ёстой байхаа. Иргэдийн оролцооны тухай асуудал дээр илтгэл тавьсан, санал гаргасан хүмүүс аль аль тал дээр үнэхээр дутагдалтай, доголдож байгаа асуудлыг зөв зүйтэй ярьж байна.

Өмнөх парламентад би өөрөө байсны хувьд 2004 онд УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа нээлттэй хэлэлцүүлэг, нээлттэй сонголт хоёрыг оруулах гэж санал гаргаад тэр маань эцэстээ хоёулаа нийлээд нээлттэй хуралдаан гэсэн нэг хэлбэр болоод хуульд орсон юм. Ер нь 2004 оны сонгуулиас хойш иргэний нийгмийн хөдөлгөөн маш их идэвхжиж байна. ТББ их төлөвшиж, хөгжиж байна. Парламент доторхи хүчний харьцаа, олон намын төлөөлөл бас их өөрчлөгдөж байна. Ийм нөхцөлд бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад ТББ, иргэд, судлаачдын оролцоог илүү өндөр байлгах нийгмийн хэрэгцээ, шаардлага өнөөдөр тулгараад байна. Тодорхой хуулийн төсөл өгөхөд ямарч хариу байхгүй, таг болчихдог гээд зарим хүн нэлээд бухимдалтай ярьж байна шүү дээ. Ядаж Их Хурлын Тамгын газар их мэдрэмжтэй хандаж ямарч хүмүүсийн санал хүсэлтэд ийм болсон шүү гээд интернетээр хариу өгч байх соёлтой харьцаа хэрэгтэй байна. Тэгэхгүй бол энэ иргэдийн хөдөлгөөн, ТББ-ууд чинь бидний саналыг ерөөсөө авдаггүй, оруулдаггүй гээд дандаа л сөрөг байдлаар жагсаал цуглаан хийх замаар конфронтацийн байдал үүсч буй болоод байна. Тийм учраас үүнийг улс төрийн соёлтой аргаар шийдэхийн тулд юу хиймээр юм бэ гэдэг дээр УИХ, УИХ-ын Тамгын газар, бодлого боловсруулж шийдвэр гаргаж байгаа хүмүүс маань өөрсдөө үг хэл яриагаараа зөв зүйтэй нотолмоор байна.

1994-1996 онд би УИХ-ын дэргэдэх судалгааны төвд секторын эрхлэгч хийж байсан. Өнгөрсөн 4 жилд бодлогын шинжилгээний хүрээлэн байгуулах асуудал УИХ-аар ороод байгуулахаар болсон ч төсөв, хөрөнгө мөнгийг нь шийдэж өгөөгүй юм. Тэгээд олон улсын байгууллагад хандах, гадны байгууллагаас хөрөнгө олох маягаар явсан. Тэр маань болоогүй. Аливаа орны парламент дэргэдээ мэдээлэл, судалгааны том төвтэй байдаг. Өнөөдөр манай парламент цаашдаа мэргэшсэн парламент болъё гэж байгаа бол бодлогын шинжилгээний төвтэй байх шаардлагатай. Тэгээд бие даасан, хараат бус судлаачидтай, тэр нь нэг их олон хүн байх шаардлагагүй шүү дээ. 15-20 хүн байхад л хангалттай. Аль нэг улс төрийн намын хараат бус, зөвхөн төрд үйлчилдэг ийм эрдэм шинжилгээний хүрээлэн хэрэгтэй байна.

Өнөөдөр манай парламент хамгийн их шүүмжлүүлээд байгаа зүйл нь нэгдүгээрт, иргэдийн оролцоо байгаа. Дараагийн асуудал нь гарч байгаа хуулийн чанарын асуудал юм. Амьдралд сайн нийцэхгүй байна, байн байн нэмэлт, өөрчлөлт оруулж байна гээд маш их шүүмжлүүлж байгаа явдал. Иймд аливаа хуулийн бодлого, төсөлд эрх зүй, нийгэм, эдийн засгийн экспертиз хийдэг дэлхий дахины туршлага байгаа шүү дээ. Үүнийг өнөөгийн Тамгын газар, Байнгын хороодын алба хийж хүч хүрэхгүй ээ. Тиймээс сайн чанартай хууль гаргая гэж байгаа бол эрх зүй, эдийн засгийн шинжилгээ хийж байдаг бодлогын шинжээчүүдтэй байх ёстой гэдгийг хэлэх байна. Баярлалаа.

Х. ТЭМҮҮЖИН /Хурал даргалагч, МУИС-ийн ХЗДС-ийн доктор/

Энэ хэсгийн хуралдаан үүгээр өндөрлөж байна. Би энэ сэдвийг судалж байхад гадны хоёр гурван шинжээчийн хийсэн судалгаа надад их сонирхолтой санагдаж байсан юм. Энэ юу вэ гэхээр донор орнуудын эрх зүйн шинэчлэлийн туслалцаа нь өөрөө өөрчлөгдөх ёстой посткоммунист төртэй их түншилдэг учраас тэр төрийг зөвхөн төсөв хэрэгжүүлдэг хэсэг хүмүүсийн хоорондын хэлцлийн үр дүн болж хувиргадаг. Энэ нь өөрөө иргэдийн оролцооны дүнд сайн хууль батлаад байдаг юм байна гэсэн практик тогтоогоод өгдөг учраас посткоммунист орнууд ихэнх тохиолдолд иргэдээсээ санал авахаас илүүтэйгээр нөгөө эрх зүйн шинэчлэл хийхэд туслалцаа үзүүлж байгаа доноруудын үгээр ажилладаг төр болж хувирдаг. Энэ нь өөрөө иргэдийн оролцоогүй хууль батлах явцыг бий болгоод, нөхцөл нь ямар байгааг үл анзаарсан хөрсөн дээр ургамлыг хурдан ургуулах оролдлогууд хийдэг, эцэстээ энэ нь өвчилсөн хуулиудыг бий болгодог гэсэн үнэлгээ байсан юм. Үнэхээр ажиглаж байхад манайд хуультай холбоотой маш олон төсөл хэрэгждэг боловч эцсийн дүндээ төртэй түншлээд төрийн арга хэрэгслийн тусламжтайгаар хуулийг богино хугацаанд хурдан батлах гэж оролддог. Энэ оролдлого нь эцсийн дүндээ иргэдийн оролцоогүй, тэдний санаа бодлыг тусгаагүй хууль байсан учраас хэрэгжих явцаа үл ойлгогдох нөхцлийг бий болгодог гадна хуулийг хүлээн зөвшөөрдөг орчинг өөрийг нь бий болгодог гэдэг. Энэ байдал манайд их түгээмэл харагддаг гэдгийг би анзаарсан. Тэгээд судалгааны явцад манайд хэрэгжиж байгаа эрх зүйн шинэчлэлтэй холбоотой төслүүд үнэхээр бүгд яамны хажууд, төртэй түншилсэн байдаг.

Тэр шинжээчийн бичсэнээр “дуулгавартай хууль тогтоогч нартай хамгийн түрүүнд ажилладаг” гэж... Эндээс ургуулаад бодоход нэгдүгээрт, манай хууль тогтоох үйл явцад иргэдийн дуу хоолойноос илүүтэйгээр яагаад доноруудын дуу хоолой хүчтэй байдаг юм бол? Хоёрдугаарт, иргэдийн хэлэлцүүлэг яагаад ийм хуурмаг байдаг юм болоо гэж бодсон. Жишээ нь, манайд сонгуулийн хуулийн төслийг иргэдээр хэлэлцүүлэх явц жил гаруй үргэлжилсэн боловч яг УИХ-аар аваад хэлэлцэхдээ тэс өөр хууль гаргаж ирээд хэлэлцсэн. Гэхдээ төслийн өмнө урьд нь олон нийтийн санаа бодлыг авч хэлэлцүүлэг хийсэн гэсэн бичигтэй байсан. Тэгэхээр манайд бас ийм хуурмаг хэлэлцүүлгүүд явах аюул байдаг юм байна. Үүнийг яаж зохицуулах юм бол гэж анхаарч байсан.

Ингээд бидний дараагийн бүлэг хуралдаан бол “Иргэдийн оролцооны зохицуулалт” гэсэн сэдэвтэй юм. Та бүхнийг идэвхтэй оролцохыг хүсч байна.

ХУРАЛДААН 1- ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ЗОХИЦУУЛАЛТ

“МОНГОЛ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БОЛОН ИНСТИТУТЧИЛЭЛ”

Ч.ТАМИР

/МУИС-ийн багш, бодлогын судлаач/

Монголын Парламентад бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн идэвхтэй оролцоог дээшлүүлэх асуудал улам бүр хурцаар тавигдах боллоо. Чухамдаа цаашид Монгол улс ардчиллын замаар хурдацтай хөгжих эсэх нь иргэдийг улс орны хөгжлийн бодлогын болон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцогч болгож, улмаар хөгжлийн бодлого стратеги хэр зэрэг уялдахаас ихээхэн хамаарах юм. Өөрөөр хэлбэл Монголын ард түмний хөгжил цэцэглэлт¹, төр засгийн нээлттэй байдал, төр иргэн хоёрын хооронд түншлэлийн харилцааг бэхжүүлэхээс ихээхэн шалтгаалах ба бодлого боловсруулах үйл явцад иргэдийн идэвхтэй оролцоог хангах боломжийг бүрдүүлж өгснөөр иргэдийн төрд итгэх итгэл дээшлэх юм. Энэ бол ямар ч орны төр засгийн анхаарлын төвд байдаг асуудал бөгөөд манай парламентад ч гэсэн иргэдийн зүгээс үзүүлэх итгэл ус агаар мэт дутагдаж байгаа, Засгийн газрын хувьд ч гэсэн ч гэсэн иргэдтэй холбох ил тод, тайлагнах механизм хөгжлийн шатандаа байгаа ба ерөнхийдөө сул хэвээр байна².

Сүүлийн хоёр жилийн хугацаанд буюу 2004 оны Парламентын сонгуулийн дараагаас эхлэн нийгэм улс төрийн амьдрал ихээхэн идэвхжиж, зөвхөн 2005 оны эхний улирлын байдлаар 40 гаруй иргэний хөдөлгөөн³, холбоод шинээр үүссэн бөгөөд авилгал, ядуурал зэрэг нийгмийн асуудалтай хурц тэмцэхийг шаардаж байна. Тиймээс Парламентыг ил тод, нээлттэй болгох, иргэдийн оролцоог дээшлүүлэх явдал чухлаар тавигдаж байна. Хэдийгээр энэ зорилго нь манайд сүүлийн 10 гаруй жилийн туршид ихээхэн яригдаж байгаа, олон хүнд хуучин сэдэв мэт сэтгэгдэл төрөхийг үгүйсгэхгүй боловч үүсээд байгаа өнөөгийн нийгэм, улс төрийн хямрал түүнийг шийдвэрлэхэд эрхгүй чухал, нөгөө талаас бидний Үндсэн хуульд заасан хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулах зорилт, ардчиллын замаар замнахад учирч байгаа саад бэрхшээл, мөн барууны орнуудад иргэдийн оролцоотой ардчиллын асуудлыг сүүлийн үед шинэ эрч хүчээр хэлэлцэх болсон зэргийг харгалзвал эл сэдэв шинэ юм. Монгол

1 Эдвин Рекош. Нээлттэй хэлэлцүүлгийн үндэс. 2005.

2 Дэлхийн Банкнаас гаргасан баримт бичиг (Mongolia-Country assistance 2004)

3 Ч.Тамир. Улс төрийн системийн задрал. ӨС., 2006-3-24

улс нь постсоциалист орны хувьд аливаа шилжилтийг хийхдээ нийгэм эдийн засгийн⁴ хувьд амжилт олохыг эрмэлзэхийн хэрээр өөрийн дотоод ардчиллыг бэхжүүлж, засаглалын үр нөлөөг сайжруулах, нээлттэй, ил тод, хариуцлагатай Парламентыг төлөвшүүлэхэд анхаарах ёстой. Чухамдаа 1990 оноос постсоциалист орнуудад ардчилсан гэж хэлж болохуйц тогтолцоо бүрэлдэж эхэлсэн боловч нэлээд олон улс эргээд авторитар дэглэм рүү шилжсэнийг судлаачид тэмдэглэдэг⁵. Харьцангуй утгаараа газар зүйн хувьд нэг орон зайд хамаарах, хуучин зөвлөлтийн маш хүчтэй нөлөөнд байсан *Казахстан, Киргизстан, Туркменистан зэрэг оронд коммунизмын сүйрлийн дараах эхний арван жилийн эцэст дарангуйлагч дэглэм бүрэн тогтжээ*⁶. Чухамдаа цөөн биш судлаач эдгээр оронтой Монголыг харьцуулан дарангуйллын засаглалыг тойрсон, ардчиллын зүгт бодитой алхам хийсэн гэсэн нэгэн утгатай дүгнэлтийг өгч байгаа боловч энэ нь тайвшрах зүйл огт биш юм. Монгол орны туулж өнгөрүүлсэн 15 жилийн түүхийн алдаа оноог дэнслэн харахад засгийн эрхийг улс төрийн нэг хүчнээс нөгөөд тайван замаар буюу сонгуулиар шилжүүлж чадсан нь дээрх өөдрөг дүгнэлт хийх үндэслэл болдог. Хэрвээ улс төрийн дэглэмийг ардчилсан ба авторитар гэсэн зарим тохиолдолд хэт явцуу гэж хэлж болохуйц хоёр л сонголтын үүднээс үнэлвэл Монгол орон гарцаа байхгүй эхний жагсаалтад багтана. Гэвч Монголын *ардчилал балчир байна*⁷, *ардчиллын төлөө эргэлт буцалтгүй*⁸ замнаж байгаа гэсэн дүгнэлт нь манай улсад цаашид ардчилал лав бэхжиж, улам итгэлтэйгээр урагшлана гэсэн баталгаа ч бас биш. Тиймээс цаашид Монгол орон хэр зэрэг хурдацтай хөгжих нь бид өөрийн дотоод ардчиллыг хангасан тогтолцоог бий болгохоос хамаарна. Өөрөөр хэлбэл сонгуулиас гадна ардчиллын бусад шалгуур, үзүүлэлтийг бид ярих эрхтэй, тийм хэрэгцээ шаардлага ч нийгэмд үүсээд байна.

Иргэд Парламентад хандаж захидал бичих нь ихэссээр байна.

Судалгаанаас үзэхэд иргэдийн Парламентад хандаж захидал бичих явдал ихэсчээ. Үүнийг Парламентад боловсрогдож байгаа аливаа бодлогын үйл ажиллагаанд оролцох сонирхол ихэсч байна гэж дүгнэж болно. Парламентын Тамгын газарт (цаашид ТГ гэх) иргэдийн ирүүлэх захидал⁹ динамик үзүүлэлттэй байгаа боловч ерөнхий хандлага нь тогтмол өсчээ.

Категори	1992	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005
Ирсэн нийт захидал	1213	1575	2258	1406	776	1899	3420	2835	3040	3313	6112 ¹⁰

4 Сүүлийн жилүүдэд төр засгийн баримталж байгаа бодлогын гол баримт бичиг бол Эдийн засгийн өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг.
 5 М.Стивен Фиш. Төв (өвөр) азийн гажуудал: Монголын ардчиллын харьцуулсан төлөв байдал. /Ардчиллын чанар: Судалгааны өгүүллийн эмхтгэл. 2005/
 6 Мөн тэнд 218 х.
 7 Монголын хүний хөгжлийн илтгэл. 1997.
 8 Ийм дүгнэлтийг АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш Монголд айлчлахдаа хэлсэн.
 9 Иргэдээс УИХ-д хандаж ирүүлсэн захидлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар зохицуулдаг. Энэ хуулийн дагуу захидлыг өргөдөл, гомдол гэж хоёр ангилна. Улс нийгмийн ач холбогдолтой болон бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлтийг өргөдөл гэнэ. Өргөдөл нь хүсэлт, санал, мэдэгдэл, мэдээлэл, шаардлагын зэрэг шинжтэй байж болдог
 10 Шинэ парламент ажиллаж эхлэх эхний нэг жилийн хугацаанд идгэдээс ирдэг саналын тоо ихэсдэг учир энэ тоо дараагийн жилүүдэд бага зэрэг багасч болзошгүй

Тухайлбал Парламент анх байгуулагдаад байсан 1992 онд 1213 хүн захидал ирүүлж байсан бол 1996 онд 1575 болж бараг 25 хувиар, 2001 оноос эхлэн энэ тоо 3420-д хүрсэн бөгөөд 2003, 2004 онуудад бага зэрэг буурснаа 2005 ондогцом өсч 6112 хүн захидал илгээжээ. Экспертийн судалгаанаас үзэхэд УИХ-ын сонгууль явагдсаны дараа жил иргэдийн захидал бичих нь ихэсдэг үүнийг намууд ба улс төрчдийн амлалт мөн иргэдийн шинэ төр засгаасаа амлалтаа биелүүлэхийг хүсч хүлээж байдагтай холбон тайлбарлаж болно. Статистикаас ч гэсэн сүүлийн 3 сонгуулийн дараах жилд тухайлбал 1997, 2001, 2005 онуудад захидал ирэх нь хамгийн өндөр хувьтай байна. Ямар боловч статистикийн мэдээн дээр тулгуурлан цаашид иргэдийн парламентад хандах нь улам бүр ихсэх болов уу гэсэн таамаглалыг дэвшүүлж болох юм.

Иргэний оролцоо ба иргэний хөдөлгөөний эрчимжилт

Сүүлийн хоёр жилд иргэний хөдөлгөөн, эвсэл холбоо олноор байгуулагдах боллоо. Чухамдаа 1990 онд Монголд социализм нуран унаж ардчилсан хөдөлгөөн өрнөхөд 60 орчим хөдөлгөөн, холбоо бүртгэгдсэн байдаг бол 2004 оны парламентын сонгуулийн дараагаас өдгөө хүртэл нийт 40 гаруй хөдөлгөөн¹², холбоод шинээр үүсч, идэвхжиж эхэллээ. Экспертийн судалгаа, фокус судалгаанд оролцогчид¹³ эдгээр хөдөлгөөн, холбоо байгуулагдах болсон үндсэн шалтгааныг бодлого боловсруулах үйл явцад иргэд оролцох боломжгүй байгаатай холбож үзсэн. Ингэхдээ ихэнхи эксперт намуудын дотоод хямрал, цаашилбал төр нь иргэнийхээ ашиг сонирхлыг төлөөлж чадахгүй байгаагийн илрэл¹⁴ гэж тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл, *ард түмнийг төлөөлөх парламентын чиг үүрэг нь түүний үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжид сайтар тусгагдаагүй ба тайлагнаж буй байдал нь олон нийтээс хүсч хүлээсэн тэр хэмжээнд хүрэхгүй байна. Парламентын гишүүд нь сонгогчидтойгоо харилцах туршлага дутмаг байдаг нь нийтлэг, нөгөөтэйгүүр иргэд нь гишүүнийхээ чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээ, хязгаар, болон хариуцлагын талаар бүрэн мэдээлэл, ойлголтгүйгээс болж төлөөллийн асуудал улам хурцадмал болдог*¹⁵.

Энэ нөхцөл байдал нь 2006 оны 1 дүгээр сард Засгийн газрыг огцруулж, нэг бус парламентын гишүүн Парламентийг хугацаанаас нь өмнө татан буулгах, ээлжит бус сонгууль¹⁶ явуулах санал дэвшүүлэхэд хүргэсэн. Нэг хэсэг нь эдгээр хөдөлгөөн, холбооны үүсэл, идэвхжилийг улс төрд өөрийн байр суурийг олж авах гэсэн хүмүүсийн хүсэл зориг, амбицтай холбон тайлбарлаж байхад, ардчилсан нийгэмд байдаг хэвийн зүйл гэсэн өөдрөг үзэл бодлын дуу хоолой ч сонсогдоно. Зарим хүмүүсийн зүгээс нэлээд дэмжлэг олж байгаа сүүлчийн тайлбарыг ойлгож болох ч асуудлыг бас л хэт хялбарчилсан, гадаад өнгөн хэсгийг харсан, нийгмийн учир шалтгааныг нь анхаараагүй гэсэн шүүмжлэл зүй ёсоор хүлээх ёстой. Тиймээс аль ч байр сууринаас хандсан энэ бүхэн нь Парламентад бодлого боловсруулах төвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь

11 Хорьдугаар зууны Монгол. 1995, ШУА Түүхийн хүрээлэн. 103 х

12 Тус хөтөлбөрийн хүрээнд Ч.Тамирын явуулсан фокус бүлгийн (цаашид ФБС гэх.) болон экспертийн (цаашид ЭС гэх.) судалгаанаас.

13 Ч.Тамир. Улс төрийн системийн задрал. ӨС., 2006-3-24

14 Экспертийн судалгаа.

15 (World Governance Survey in Mongolia. www.odi.org.uk/WGA_Governance/Docs/)

16 УИХ-ын Э.Бат-Үүл, Х.Гүндалай зэрэг нэлээд хэдэн гишүүд Парламентыг тарааж ээлжит бус сонгууль явуулахыг санал болгосон.

чухал гэсэн дүгнэлтэнд хүргэж байгаа бөгөөд уг дүгнэлт нь нийгмийн бодит хэрэгцээ, шаардлагаас үүдэлтэй байгааг анхаарах нь чухал юм.

Олон түмний итгэл

Одоогоос 5 жилийн өмнө гарсан НҮБ-ын баримт бичигт уламжлалт ёсоор төвлөрсөн байдалтай байгаа монголын улс төрийн тогтолцоо, өнгөрсөн үеийн Парламентын билэгдлийн шинжтэй үүрэг роль, мөн өнөө үеийн УИХ-ын гишүүдэд ил тод байдал үгүй болж, үйл ажиллагаагаа олон нийтийн өмнө хариуцдаггүй байдлаас үүдэн УИХ-ын гишүүдийн талаар тааламжгүй ойлголтыг төрүүлж парламентад итгэх олон түмний итгэлийг бууруулсан байна¹⁷ гэсэн. Парламентад үзүүлэх олон түмний итгэл өнгөрсөн хугацаанд сайжраагүй, харин жил тутамд улам муудаж байгааг олон нийтийн санал асуулгын дүнгээс харж болно¹⁸.

Итгэх төвшин	2003-8 сар	2003-12 сар	2005-3 сар	2005-11 сар
Ерөнхийлөгч	Итгэдэг	46.4	45.6	44.8
	Дунд зэрэг	29.4	40.4	42.3
	Итгэдэггүй	8.2	6.4	9.7
УИХ	Итгэдэг	24.4	21.9	19.8
	Дунд зэрэг	40.4	49.2	53.9
	Итгэдэггүй	19.5	20.1	22.3
Засгийн газар	Итгэдэг	27.7	24.2	19.4
	Дунд зэрэг	37.7	45.7	49.4
	Итгэдэггүй	16.0	18.7	26.4

Хүснэгтээс харахад төрийн институцэд итгэх итгэл муудсан байна. Ингэж олон түмний итгэл сулрах нь ардчилсан засаглалтай аль ч оронд түгээмэл ажиглагддаг зүйл мөн боловч системийн онолын үүднээс авч үзвэл төрийн институцэд итгэдэг иргэдийн тоо 25 хувиас багассан тохиолдолд систем хэвийн оршин тогтнох боломжгүй болно гэж үздэг.

НҮБ-ын судалгаанд оролцсон иргэдийн 41,3 хувь нь¹⁹ улсын төсөв боловсруулах, хэрэгжүүлэх, хянаж шалгахад оролцохыг хүсдэг гэдгийг харуулсан. Дээрхийг нэгтгэн дүгнэхэд нэгд, иргэд төр засагтаа итгэх эсэх нь төрийн үйл хэрэгт иргэдийн оролцооны төвшнөөс шууд хамааралтай, хоёрт, иргэд өөрсдийн дуу хоолойг төрд хүргэхэд ихээхэн анхаарах болсон байна.

17 НҮБ-ын Ардчилсан засаглалын Парламентын чадавхийг дээшлүүлэх төслийн баримт бичиг (2001 оны 3 сар)

18 МУИС-ийн Социологийн тэнхмийн дэргэдэх Социологийн академи судалгааны төвийн Улс төрийн институцийн мониторинг

19 Улс, орон нутгийн төсвийг төлөвлөн боловсруулах, гүйцэтгэлд нь хяналт тавихад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломж ба арга хэлбэр. 2003 он. УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр,

Засаглалын ил тод байдал, иргэний эрх

Бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог дээшлүүлэх нь засаглалын ил тод байдал, иргэний эрхийн хэрэгжилтээс шууд хамаардаг. 2005 оны Фридом хаусийн судалгаагаар Монгол улс төрийн ба иргэний эрх 2 оноог авч эрх чөлөөтэй гэсэн ангилалд багтсан. Үүнийг хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ болон Төв Азийн орнуудтай харьцуулахад 1-3 пунктээр дээгүүр байгаа боловч постсоциалист Чех, Польш, Унгар, Словени, Словак, Прибалтикийн орнуудаас хоцорч байна²⁰. Ерөнхий үзүүлэлт ийм байгаа боловч ажилгүйдэл, ядуурал ихтэй, авилгал²¹ цэцэглэсэн зэрэг сөрөг талыг тооцвол цаашид бодлого боловсруулах иргэдийг оролцоог дээшлүүлэх асуудал мань улам бүр бартаа нугачааг туулна гэдэг нь тодорхой байна.

Тунхагласан бодлого ба бодит байдал

Дурдах ёстой дараагийн нэг шалтгаан бол тунхагласан бодлого ба бодит байдлын зөрүү юм. 1996 оноос хойш баталсан бодлогын олон баримт бичигт иргэдийн оролцоог дээшлүүлэхийн чухлыг тэмдэглэжээ. Тухайлбал 1996 онд баталсан Монгол улсын хөгжлийн үзэл баримтлалд²² хууль тогтоох, байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгож, төрийн үйл хэрэгт олон түмний шууд болон төлөөллийн байгууллагаар дамжуулан оролцох арга хэлбэрийг төгөлдөржүүлнэ. Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх нөхцлийг бүрдүүлэх замаар нийгмийн янз бүрийн давхарга, бүлгүүдийн сонирхлыг төрийн бодлогод тусгах бололцоог хангана гэж заажээ. Мөн улс төр, эдийн засгийн шийдвэр гаргах төвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлнэ²³, ардчиллын үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ, засаглалын үйл явцад олон нийтийг өргөн оролцуулна²⁴, засгийн бүх эрх ард түмний мэдэлд байж ард түмэн шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэх зарчмуудыг хангах механизмыг төгөлдөржүүлнэ²⁵, төрийн мэдээллийг нээлттэй болгох, иргэд төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, санал асуулга, нийгмийн судалгаанд мэдээлэл, холбооны технологийг өргөн хэрэглэх²⁶ гэх зэрэг заалт бий. 2000 онд баталсан Засгийн газрын Сайн Засаглал үндэсний хөтөлбөрт *Засгийн газар, яамдын хувьд тэрчлэн төрийн бодлого боловсруулах явц ба үйлчлүүлэгчдийн хооронд болон нийгмийн санал бодол ба түүнийг бүрдүүлэгчдийн хооронд зөвшилцөл бий болгох нь нэн чухал*²⁷ гэжээ. Мөн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт иргэдийн оролцооны асуудлыг анхаарлын гадна үлдээсэнгүй. Тухайлбал 1996-2000 оны Засгийн газар өөрийн чиг үүргийг зах зээлийн эдийн

20 Фридом Хаусийн судалгаа. 2005 онд Монгол орон улс төрийн ба иргэний эрх 2, эрх чөлөөтэй гэсэн ангилалд багтсан. <http://www.freedomhouse.org>

21 2005 онд Трансперанси Интернэйшнл байгууллагын судалгаагаар Монгол орон авилгалын зэрэглэлээр ноднингийн байраа бараг хадгалсан. Ингэж 85-р байрт орсон ч өмнөх жилүүдээс авилгалын хэмжээ, далайц улам ихэсч байгаа нь нууц биш юм. Монголын хувьд 2.4-3.6 болсон.

22 1996 онд баталсан Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал. Төрийн оновчтой зохицуулалт, ардчиллын бэхжилт-хөгжлийн баталгаа гэсэн VI хэсэг.

23 1996 онд батлагдсан Төрөөс баримтлах хүн амын бодлого. 86-р зүйл.

24 1996 онд батлагдсан Монгол улсын төрөөс засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого.

25 1998 онд баталсан Монгол улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр. 7-р зүйл.

26 2000 онд баталсан Монгол улсын мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэл үзэл баримтлал.

27 2000 онд баталсан ЗГ-н Хүний аюулгүй байдлыг хангах Сайн Засаглал хөтөлбөр.

засаг бүхий ардчилсан нийгэм дэх шаардлагын дагуу тогтоож, түүний үйл ажиллагааг иргэдэд үйлчлэх, тэдний санал, өргөдөл гомдлыг барагдуулах, ашиг сонирхлыг нь хамгаалах нийгмийн эрүүл орчин бий болгоход чиглүүлнэ гэж зааж байв. 2000-2004 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөрт иргэдийн шууд оролцоог дэмжсэн заалт байхгүй боловч төрийн бус байгууллагыг дэмжиж, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд болон ялангуяа нийгмийн салбарт оролцоог нь өргөжүүлнэ гэжээ. Харин 2004 онд байгуулагдсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргасан бөгөөд *төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах явцыг нээлттэй болгож*²⁸, *дээрхи асуудлыг аль болох ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа тал болон иргэдийн санаа бодолд тулгуурлан шийддэг жишиг тогтооно* гэсэн зорилтыг дэвшүүлсэн. Дээр өгүүлснээс дүгнэхэд бодлогын баримт бичигт иргэдийн оролцооны талаар тодорхой зорилго дэвшүүлсэн боловч гагцхүү эдгээр зорилтын хэрэгжилт амьдрал дээр ихээхэн хангалтгүй байгааг харж болохоор байна.

Дүгнэлт, санал, зөвлөмж

Парламентад бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог дээшлүүлэх зорилго нь иргэдийн оролцоонд нөлөөлж байгаа урт хугацааны хүчин зүйлс буюу ажилгүйдэл, ядуурал, газарзүйн алслагдмал байдал зэрэг объектив хүчин зүйлээс гадна төрөө дээдлэх монголчуудын уламжлалт үзэл, иргэдийн улс төрийн соёл, төр засгийн байгууллагын хаалттай байдал, хууль боловсруулах үйл явцын талаар иргэдийн мэдлэг, боловсрол хангалтгүй байдаг, хуучны төвлөрсөн сэтгэлгээний инерци зэрэг олон хүчин зүйл давхацсан, нийгэм улс төрийн нэн төвөгтэй амаргүй цаг үед явагдаж байгаагаараа онцлог юм. Гэвч эл зорилго нь бэрхшээлтэй боловч зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай зорилго бөгөөд эл асуудлаар хоёрдмол байр суурь нь иргэдийн төрд итгэх итгэл, төрийн бодлого хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлнэ. Ардчилал гүнзгийрч, иргэний нийгэм хөгжиж, зах зээл, харилцаа холбоо өргөжихийн хэрээр Монголчууд бидэнд оролцооны олон шинэ боломжийг нээж өгч байгаа бөгөөд үүнийг хэрхэн ашиглахаас хөгжил дэвшил хамаарах болно.

Хууль зүйн зохицуулалтын хүрээнд:

- Үндсэн хуулийн иргэдийн оролцооны тухай заалтыг бусад гол хуулиудад тусгаж хэрэгжүүлж эхлээд төдийлөн удаагүй байна. Гэсэн хэдий ч эдгээр хуульд өнгөрсөн богино хугацаанд нэлээд хэдэн удаа өөрчлөлт оруулж амжсан нь эл асуудал чухал байгааг эргэлзээгүй харуулна. Ийм өөрчлөлт болгон улам боловсронгуй болгоход чиглэж байгаа нь эргэлзээгүй боловч зарим тохиолдолд хуулийг шинэчлэхдээ өмнөхөөсөө ухрах хандлага гарч байжээ. Үүнд жишээ болговол 2006 онд баталсан УИХ-ын тухай хууль ба хуралдааны дэгт олон нийтийн оролцоотой холбоотой заалтыг хуучинтай харьцуулахад улам бүрхэгдсэн, зарим тохиолдолд хэрэгжихгүй байгаа гэсэн шалтгаанаар улам сайжруулах биш харин шууд хасах арга хэлбэрийг сонгож авсан явдал гарсан байна. Иргэдийн шууд

28 2004-2006 оны ЗГ-ын мөрийн хөтөлбөр. Төрийн удирдлага, иргэний оролцоо гэсэн 1-р хэсгийн 1-1-1-д

оролцоог зохицуулсан ард нийтийн санал асуулгын хууль батлагдсанаасаа хойш 11 жилийн нүүр үзэхэд нэг ч удаа хэрэглэгдсэнгүй.

- Хуулийн шинжилгээнээс харахад иргэдийн оролцоог зохицуулсан гол хуулийн заалтууд давхцсан, ихэнхдээ тунхаг төдий, өөр хоорондоо уялдаа холбоо багатай байна. Тухайлбал санал авч болно гэсэн хуулийн заалт нь өнгөц харахад илүү өргөн боломжийг олгож буй мэт боловч бодит байдал дээр түүнийг хэрэгжүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлж байгаа нь судалгаагаар нотлогдож²⁹ байна. Тийм учраас *шаардлагатай гэж үзвэл, нэн чухал харилцаа, олон нийтээс санал авч болно, үндэслэлтэй гэж үзвэл* гэх зэрэг нэн тодорхойгүй хэллэгийг жишээ болгож болно. Мөн үндсэн хууль ба холбогдох бусад хууль тогтоомжид заасан уламжлах гэдэг үгийг эрх бүхий этгээд нь тайлбар хийх шаардлагатай гэдэг нь харагдлаа.

- Иргэдийн оролцоог зохицуулсан хуулийн заалтад хэрэгжүүлэх механизмыг нарийвчлан гаргаагүй учраас хэн, хэзээ, яаж, ямар санхүүжилтаар хэрэгжүүлэх нь гол төлөв тодорхойгүй, журам гаргана гэж заасан ч журам нь гараагүй, гарсан ч тухайн хуулийн мөн чанарын эсрэг агуулгатай байх, олон зүйлийг нарийвчлан заагаагүй байдал харагдаж байна. Үүнийг дагаад хэрэгжих механизм нь ч бүрэлдээгүй байна, баталсан сайхан хуулийг хэрэгжүүлэгч субъектууд ихэвчлэн өөрийн үзэмжээр шийдвэр гаргаж хэвшжээ.

- Голлох хоёр хууль Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах хууль, Хууль бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг шинээр эмхтгэн найруулах шаардлагатай гэсэн дүгнэлтийг гаргаж байна. Нэн тэргүүнд хийх ажилд иргэдийн өргөдөл гомдолд хариу өгөх хугацааг ажлын 5 хоног болгон багасгах, иргэдийн өргөх бичиг, шаардах бичиг, мэдэгдэл зэргийг хуульд тусгах зэргийг дурдаж болохоор байна.

- Сонгогдсон гишүүн буюу төлөөлөгчдийн байгууллага иргэн хоёрын хоорондын холбоог бэхжүүлэх, сонгогчдын өмнө хүлээх хариуцлагын механизмыг бий болгох, сонгуулиас бусад үед сонгогчид төрөл бүрийн арга механизмаар төлөөлөгчдийн байгууллагад нөлөөлөх зэрэг асуудал орхигдсоныг цаашид анхаарах хэрэгтэй байна. Тиймээс үндсэн хуульд заасан иргэдийн шууд оролцоог хангах, тухайлбал органик хуулийг санаачлах, зарим нэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага нийгэмд гарч байна.

- Хэдийгээр бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог дээшлүүлэх асуудлыг хууль, эрх зүйн орчны хүрээнд нэлээд олон заалтаар нарийвчлан зохицуулах гэж оролдсон ч өнөөгийн шатанд эдгээр хуулийн зарим заалтыг нэгтгэн нэгэн бүхэл зүйл болгон уялдуулах, боловсронгуй болгох, тайлбар хийх, тодотгох, нарийвчлах шаардлагатай байгаа юм.

- Бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог дээшлүүлэх бүхий л боломжийг эрж хайж эрх зүйн орчин болон институтчиллын нөхцөл байдалд шинэчлэлийг давхар хийх шаардлагатай, гэхдээ бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл явцад иргэдийн оролцоог дээшлүүлэхэд онцгой анхаарч боловсронгуй болгоход чиглэгдэх арга замыг хайх шаардлагатай.

²⁹ Иргэдийн дунд явуулсан фокус, мөн экспертийн судалгаанаас энэ нь тод харагдсан.

Бодлогын баримт бичгүүдийн талаар:

- Хөгжлийн агуулгатай бодлогын голлох баримт бичигт иргэдийн оролцоог бодлого боловсруулах төвшинд дээшлүүлнэ гэдгийг тунхагласан нь эл асуудал байнга төр засгийн анхааралд байдаг гэсэн сэтгэгдлийг төрүүлэхээр байна. Эдгээр баримт бичгүүд үр өгөөжөө өгч байгаа нь эргэлзээгүй боловч бодит ажил гэхээсээ илүүтэй хүсэл мөрөөдлийг илтгэж байна гэсэн шүүмжлэлд өртөх юм.

- Шилжилтийн он жилийн эхэнд гарсан ихэнх бодлогын баримт бичигт иргэдийн оролцоог ТББ-ын хөгжилтэй илүүтэй их холбон үзэж түүгээр хэмжих гэсэн оролдлогыг дэмжиж байсан бөгөөд иргэдийн шууд идэвхтэй оролцооны талаар төдийлэн дурдаагүй байна.

- Улс төрийн хүчнүүдийн хувьд цаасан дээрх баримт бичиг, мөрийн хөтөлбөрт иргэдийн оролцоонд ихээхэн анхаарал хандуулж байсан мэт боловч бодит байдал дээр ийм хүсэл зориг ихэнх тохиолдолд бага байгаа, байсан ч үүнийг хэрэгжүүлэх механизм, гарц, зарим талаараа экспертиз хийх чадвар дутагдаж байгаатай холбоотой. Гэвч энэ хандлага сүүлийн хоёр жилд өөрчлөгдөж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

- Иргэдийн оролцоог ерөнхийд нь ихээхэн ярьж, бичиж, тунхаглаж байгаа боловч яг тухайлсан, нарийвчилсан судалгаа төдийлөн хийгдээгүй байна. Хэрвээ орон нутгийн төвшин дэх зарим нэгэн судалгаа, олон улсын байгууллагын гарын авлагын шинжтэй материалыг эс тооцвол ийм дүгнэлтийг баттай хийж болно.

Институтийн талаар:

- Өнөөдрийн байдлаар иргэдийн оролцоотой холбогдон ажиллаж байгаа субъектуудыг өөр хооронд нь уялдаатай ажиллуулж чадвал багагүй хүч болох юм. Ингэхийн тулд Тамгын газарт олон нийтийн харилцааны хэлтсийг бие даасан байдалтайгаар байгуулах гэсэн зорилтыг нэн түрүүнд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Парламентад бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог дээшлүүлэх зорилт нь Байнгын хороог бэхжүүлэхээс ихээхэн хамаарна гэдэг нь харагдлаа. Тиймээс Байнгын хорооны үйл ажиллагааг хуульд заасан шигээ хийх бие даан ажиллах бэхжүүлэх хэрэгтэй. Олон тохиолдолд байнгын хорооны үйл ажиллагаа даргаас шалтгаалахаар хууль, журамд заасан мөртлөө түүнийг ганцхан жилийн хугацаагаар сонгодог нь бэхжилтэд ихээхэн сөргөөр нөлөөлж байна.

- Бодлогын судалгааны институтийг байгуулахгүйгээр энэхүү зорилтыг шийдвэрлэхэд төвөгтэй байх болно.

ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО: ПОЛЬШИЙН ЖИШЭЭ, ҮНДСЭН ИНСТИТУЦУУДЫН ТОЙМ

Г.МАКОВСКИ

/Варшавын их сургуулийн багш, доктор/

Польш Улс бүрэн эрхт байдлаа олж авсан 1989 оноос хойш иргэд хууль тогтоох үйл явцад оролцох өргөн бололцоотой болсон юм. Энэхүү илтгэл нь Польшийн иргэн бүрт нээлттэй үндсэн механизмуудын талаар өгүүлэх болно.

Хууль тогтоох үйл явц болон иргэд

Бүгд Найрамдах Польш Улсын 1997 оны Үндсэн хууль санал асуулга болон олон нийтийн санаачилга гэсэн хоёр үндсэн замаар хууль тогтоох үйл явцад шууд оролцох боломжийг польш иргэдэд олгосон. Санал асуулга явуулах ерөнхий журмыг Польшийн Үндсэн хуулийн 62, 125, 90, 235 дугаар зүйлд зааж өгсөн. Бүх нийтийн санал асуулгын тухай 2003 оны гуравдугаар сарын 14-ний хууль, Орон нутгийн санал асуулгын тухай 2000 оны есдүгээр сарын 15-ны хуулиар бүх нийтийн болон орон нутгийн санал асуулга явуулах нарийвчилсан журмыг тус тус тогтоож өгсөн.

Бүх нийтийн санал асуулгыг Үндсэн хуулийн холбогдолтой хууль тогтоомжийн дагуу улс орны амин чухал асуудлуудаар зохион байгуулж болно. Ийм санал асуулгаар шийдсэн асуудал иргэдийн 50-иас дээш хувь нь оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр болно. Санал асуулга явуулах тухай шийдвэрийг Парламентын тогтоолоор, эсвэл Польшийн Ерөнхийлөгчийн шийдвэрээр гаргана. Өнөөг хүртэл Польшид бүх нийтийн санал асуулгыг гурван удаа зохион байгуулсан байна. Үүнд, нийтийн франчайзын асуудлаар 1996.02.16-нд, үндсэн хуулийн шинэчлэлийн асуудлаар 1997.05.25-нд, Польш улс Европын Холбоонд /ЕХ/ нэгдэх асуудлаар 2003.06.08-нд тус тус болжээ. Үүнээс үзэхэд, Польшийн улс төрийн амьдралд энэхүү механизмыг байнга хэрэглэдэггүй, иргэд ийм замаар хууль тогтоох ажиллагаанд оролцох боломж бага байгаа нь харагдаж байна.

Санал асуулга явуулах аргыг хэрэглэхэд техникийн шинж чанартай бэрхшээл их байдаг нь маргаангүй. Ийм механизмыг зөв ажиллуулахын тулд асуулгын асуултуудыг маш тодорхой томъёолох ёстой. Гэтэл энэ нь туйлын өргөн хүрээтэй хууль эрхийн акт (тухайлбал, ЕХ-ны үндсэн хуулийн төсөл) зэрэг асуудлын хувьд боломж муутай байдаг. Түүнээс гадна, улс төрийн шалтгаанууд ч бас бий. Нийт

иргэдэд юу чухал вэ гэдэг асуултад хариулахад ер нь хүнд шүү дээ. Хэдийгээр сүүлийн үед чухал чухал асуудлууд байнга гарч ирж байгаа боловч, Польшийн улс төрчид санал асуулгын арга замыг ашиглах боломжийг авч үзэх сонирхолгүй байна. Тэд иргэдийн гарт шийдвэр гаргах эрхийг өгөх замаар улс орны ирээдүйг өөрчлөх өөрсдийн үзэл бодлоо орхигдуулахыг хүсэхгүй байгаа гэдэг нь тодорхой харагдаж байна.

Санал асуулгад оролцох нийгмийн сонирхол мөн л харьцангуй бага байгаа нь харамсалтай. Оролцогчдын тоо франчайзын асуудлаар болсон анхны санал асуулгаар 32%, үндсэн хуулийн шинэчлэлийн асуудлаарх санал асуулгаар 43% байлаа. ЕХ-нд элсэх асуудлаарх санал асуулгад оролцогчдын тоо бага байсныг харгалзан хугацааг хоёр хоногоор сунгаж байлаа. Гэтэл ийм онцгой арга хэмжээ аваад байхад энэхүү чухал асуудлаар иргэдийн дөнгөж 58% нь л саналаа өгсөн.

Энэ бүхнийг нэгтгэж дүгнэвэл, нэг талаас улс төрчид санал асуулгын замаар иргэдийг хууль тогтоох үйл явцад оролцуулахыг нэг их сонирхохгүй байна. Бүдүүн тоймоор яривал, тэд энэ институцийг хэт их ашиглахгүй байгаа юм. Нөгөө талаар, иргэд ч хууль тогтоох үйл явцад оролцох онцын сонирхолгүй байна. Санал асуулгад оролцох, санал асуулга явуулах шийдвэр гаргах нь үнэндээ ритуал шинж чанартай байгаа бөгөөд зөвхөн үндсэн хуулийн шаардлагаар (ЕХ-нд элсэх асуудлын хувьд ийм байсан) тодорхойлогдож байх шиг байна.

Олон нийтийн санаачилга нь ч мөн адил өргөн хэрэглэгдэх институц болоогүй байна. Энэ механизмын үйл ажиллагааг Польшийн Үндсэн хуулийн 118 дугаар зүйл ангиар зохицуулсан байдаг ба энэ зүйл ангид дор хаяхад 100 мянган хүний дэмжлэг авсан хуулийн төслийг иргэд Парламентад өргөн барих эрхтэй гэж заасан. Цөөн тооны нөхцөл байдлыг эс тооцвол, иргэдийн өргөн барьсан хуулийн төсөл нь засгийн газрын болон парламентын гишүүдийн хуулийн төсөлтэй ижил статустайгаар хэлэлцэгдэх ёстой. Ийм механизм ашиглаж байгаа иргэд Төсвийн тухай хуулийн хүрээнд нөлөөлж болохгүй, Үндсэн хуулийг өөрчлөхийг оролдож болохгүй. Иргэдийн оруулсан хуулийн төсөл нь парламентын ажлын хүрээнд ямар нэг эрх ямба эдлэхгүй. Иргэдийн өргөн барьсан хуулийн төслийг Сеймийн дарга хүлээн авснаас хойш гурван сарын дотор авч хэлэлцэх ёстой. Бас нэг онцлог нь гэвэл, иргэдийн оруулсан санал нь тасалбар болгох тухай парламентын бичигдээгүй журам (энэ журмаар Парламентын бүрэн эрхийн хугацаа дуусмагц тухайн үед хэлэлцэгдэж байсан хуулийн төслүүдийг хэлэлцэх ажиллагаа ямар түвшинд байгаагаас үл хамааран дуусгавар болдог)-д хамаарахгүй.

Олон нийтийн санаачилгыг зохицуулсан хууль хүчин төгөлдөр болсон 1999 оноос хойш 2005 оны эхний хагас жил гэхэд иргэд ердөө л 55 төсөл санаачилж оруулжээ. Эдгээрээс зөвхөн 19 нь л эхний хэлэлцүүлгийг давсан байна. Хууль хэлэлцэх эхний шатанд буцаагдсан төсөл байхгүй ч гэсэн ганц ч төсөл тэр шатнаас цааш явсангүй³⁰. Парламентын одоогийн 5 дахь бүрэн эрхийн хугацаанд парламентын гишүүд 416 хуулийн төсөл авч хэлэлцэж байгаагаас ердөө л 9 нь иргэдээс өргөн барьсан төсөл байна (2006 оны 12 дугаар сарын 29-ний байдлаар)³¹.

30 Польш дахь олон нийтийн санаачилгын тухай тодорхой мэдээллийг Rytel Anna, The Popular Initiative in Poland, Democracy International, 2005, <http://www.democracy-international.org> –аас олж үзнэ үү.

31 Эх сурвалж: <http://www.sejm.gov.pl>

Олон нийтийн санаачилга ч тэр, санал асуулга ч тэр аль алиныг нь иргэд сонирхохгүй байгаа нь тодорхой. Гэхдээ энэ нь иргэний нийгэм эрх зүйн соёл ядмаг, сул дорой байгаагаас үүдэлтэй асуудал юм. Польшууд өөрсдийн эрх зүйн орчинг сайжруулахын төлөө энэхүү институцийг ашиглах шаардлагыг харахгүй, эсвэл тийм мэдлэг байхгүй, эсвэл зүгээр л сонирхдоггүй юм шиг байгаа юм. Мөн иргэдийн өргөн барьсан төслүүдийн дийлэнх нь аль нэг салбар дахь нийгмийн байдлыг сайжруулах нийтлэг оролдлогыг илэрхийлээгүй, харин тодорхой бүлэг хүмүүсийн тодорхой ашиг сонирхлыг хөндсөн байдагт анхаарлаа хандуулах нь зүйтэй. Иргэдийн санаачилсан төслүүдийн дийлэнх нь нийгмийн томоохон бүлэг хүмүүсийн аж байдлыг сайжруулахын төлөө үйл ажиллагаатай нийтлэг биш байдаг.

Санал асуулга болон олон нийтийн санаачилга нь нийт улс үндэстний эрх зүйн суурь орчны хүрээнд иргэдээс шууд нөлөө үзүүлэх боломж олгодог тусгай механизм юм. Түүнээс гадна, хууль тогтоох үйл явцад оролцох боломжийг иргэдэд олгодог өөр хэд хэдэн институц, шийдэл байдаг. Эдгээрээс заримыг нь энд би товчхон танилцуулья.

Польшийн Үндсэн хуулиар гишүүд нь нийтийн сонгуулиар сонгогдсон олон нийтийн хамтын бүхий л байгууллагын (парламент, парламентын комисс буюу орон нутгийн сонгуульг байгууллага) хуралдаанд оролцох эрхийг иргэн бүрт олгосон байдаг. Гэхдээ практик амьдрал дээр техникийн шалтгаантай зарим нэг хязгаарлалт байхаас өөр аргагүй. Хэдий тийм боловч, иргэд парламентын комиссуудын хуралдаанд оролцох замаар үндсэн хуулиар олгосон эрхээ эдлэх боломжтой. Ийм тохиолдолд иргэн хуралд оролцох хүсэлтээ тухайн хороо, комиссын даргад тавих ёстой. Парламентын хороодын хуралд ажиглагчаар оролцох, хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр үг хэлэх бололцоо бий.

Парламентын хороодын ажилд оролцох бас нэг хэлбэр нь иргэдийг экспертээр урих явдал юм. Тэднийг парламентын экспертээр ийнхүү ажиллуулах нь асуудал үүсгэдэг гэдэгт анхаарал хандуулах хэрэгтэй. Учир нь тэдний үйл ажиллагааг хууль бус хэлбэрээр илэрч болох лобби хийх явдлаас ялгаж салгах бараг боломжгүй байдаг. Лобби хийдэг экспертүүдтэй холбогдсон асуудлыг шийдэх гэсэн сүүлийн үеийн оролдлого нь хууль тогтоох үйл явцад лобби хийх үйл ажиллагааны тухай хууль гаргасан явдал юм. Энэ хуулийн ачаар иргэдэд хууль тогтоох ажилд нөлөө үзүүлэх бас нэг боломж олгосон шинэ институц болох олон нийтийн хэлэлцүүлэг бий болсон.

Хууль тогтоох үйл явцад лобби хийх үйл ажиллагааны тухай хуулийн заалт ёсоор иргэн бүр аль нэг хуулийн төсөл түүний сонирхлыг хөндөж байгаа талаар хууль тогтоогчдод мэдээлэх эрхтэй боллоо. Төрийн холбогдох байгууллага, тухайлбал яам, эсвэл парламент тийм мэдээлэл авснаа нотлох, хэрэв олон нийтийн хэлэлцүүлэг явуулах шийдвэр гарсан бол тэр мэдээллийг авч үзэх үүрэг хүлээсэн байна. Энэ институцийн талаар тодорхой ярихын өмнө лобби хийх журамтай холбогдсон зарим чухал асуудлыг авч үзэх нь зүйтэй юм. Учир нь энэ нь хууль тогтоох үйл явцад оролцох боломжийг иргэдэд олгож байгаа институц юм.

Хууль тогтоох ажиллагаанд нөлөө үзүүлж болохуйц бүхий л үйл явдлыг хамарч байгаа ерөнхий лобби үйл ажиллагаа болон мэргэжлийн лобби үйл ажиллагаа

хоёрыг уг хууль ялгаж тодорхойлсон. Хуульд зааснаар, мэргэжлийн лобби үйл ажиллагаа гэдэг нь хэрэв хууль тогтоох үйл явцад нөлөөлж, тэндээсээ ашиг болох эрмэлзэлтэй бол тэр иргэн (эсвэл хуулийн этгээд) «мэргэжлийн лоббист» гэж бүртгүүлсэн байхыг хэлнэ.

Мэргэжлийн лоббист нь бүртгүүлснийхээ дараа парламентад нэвтрэх тусгай үнэмлэх авах бөгөөд яамд руу саадгүй нэвтрэх эрхтэй байна. Яамд болон парламент бүхий л чухал мэдээллийг гарган өгч, холбогдох шаардлагатай дотоод журмаа өөрсдөө хариуцах үүрэг хүлээсэн. Бүртгүүлэлгүй мэргэжлийн лобби үйл ажиллагаа явуулсан тохиолдолд маш өндөр торгууль хүлээлгэхээр заасан.

Лоббист нь дээрхээс өөр тусгай эрх ямба эдлэхгүй. Тэгвэл, хууль эрх зүйн үүднээс аваад үзвэл мэргэжлийн лобби үйл ажиллагаа явуулах нь тийм ч хэцүү бишийн зэрэгцээ тусгайлсан ашиг тус авчирдаггүй. Лобби үйл ажиллагаа явуулах тухай Польшийн хуулинд лоббистууд үйл ажиллагаагаа илүү тунгалаг болгох, авилгалд аль болох бага автах талаар тусгайлан зохицуулсан зүйл үгүй. Үүний улмаас хууль тогтоогчийн зорилго биеллээ олж чадаагүй. Учир нь лобби үйл ажиллагаа, эксперт болон яамд, парламентад явуулж буй хууль тогтоох ажиллагаанд оролцох сонирхолтой бусад хүмүүсийн үйл ажиллагааг ялгаж ойлгоход бэрхшээлтэй хэвээр байна.

Энэ бол лобби үйл ажиллагааны тухай хуулийн хамгийн сул талын нэг мөн. Энэ талаар би сүүлд дахин ярих болно. Далимд нь дурдахад, бүртгэлтэй мэргэжлийн лоббистуудыг парламентад «сорогчид» гэдэг бөгөөд лоббистуудын зүүх ёстой улаан өнгийн таних тэмдгийн ачаар хэн нь хэнээсээ зайлсхийж явах талаар хүн бүр мэддэг болсон гэж парламентчид шоолцгоодог юм. Гадаад хэргийн яаманд бүртгүүлсэн 77 лоббист болон лобби үйл ажиллагаа явуулдаг компани байдаг бол³² Парламентын бүртгэлд дөнгөж 9 лоббист бүртгүүлсэн³³ байдгийг нэмж хэлмээр байна.

Тухайн хууль нь лобби үйл ажиллагааг зохицуулахын зэрэгцээ олон нийтийн хэлэлцүүлэг гэсэн институцийг бий болгосон. Олон нийтийн хэлэлцүүлгийн институцийг энэ хуулийн үндсэн дээр албан ёсны болгосон хэдий ч энэ нь харьцангуй шинэ институц юм. Лобби үйл ажиллагааны тухай хуулийг 2006 оны гуравдугаар сард батлахын өмнө Эрүүл мэндийн яам 2004 онд хар тамхинд донтохтой тэмцэх тухай хуулийн төслийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж байсан. Тэр үед улстөрчид зохих ойлголт, мэдлэгтэй болсны ачаар албан ёсны хууль эрхийн актгүй ч гэсэн уг механизмыг ашиглах боломжтой болсон юм. Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан тэрхүү хэлэлцүүлэг нь хууль гарснаас хойш, хуулийн бүх заалтыг ашиглаад зохион байгуулсан олон нийтийн бүх хэлэлцүүлгээс ч илүү барууны стандартад дөхөж очсоныг тэмдэглэх хэрэгтэй.

Олон нийтийн хэлэлцүүлэг нь мэдээж онцлогтой, үнэ цэнтэй механизм юм. Энэ нь хууль тогтоох ажиллагаанд иргэдийн үзүүлэх нөлөөг хангаад зогсохгүй, иргэний яриа хэлцээний институц болж, иргэдийн идэвхийг өрнүүлэн, иргэд болон

32 Эх сурвалж: <http://www2.mswia.gov.pl/portal.php?serwis=bip&dzial=14&id=74&poz=2>

33 Эх сурвалж: <http://www.sejm.gov.pl>

хууль тогтоох байгууллага дахь тэдний төлөөллийн хоорондын зайг ойртуулах боломж олгосон. Ийм учир шалтгаанаар Польшид бүхий л институцийг хууль эрх зүйн актаар баталгаажуулсан нь сайн хэрэг. Харамсалтай нь, энэ бүхнийг хийсэн арга зам нь учир дутагдалтай байсан бөгөөд сургамжтай ч болсон. Анализ хийж үзвэл олон нийтийн хэлэлцүүлгийн механизм бий болгохдоо Польшийн сургамжаас юуг нь авах эсэх талаар олон зөвлөмж гаргаж болох юм.

Эхний асуудал нь ерөнхий шинж чанартай гэж хэлбэ л дээ. Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах институцийг яагаад лобби үйл ажиллагааны тухай хуулиар зохицуулах болсныг ойлгоход хүнд. Лобби хийх, олон нийтийн хэлэлцүүлэг явуулах нь хоорондоо зарим утгаар холбоотойг ойлгож болно л доо. Гэхдээ олон нийтийн хэлэлцүүлэг нь олон нийтийн яриа хэлцээний механизмын хувьд лобби үйл ажиллагаа гэхээсээ сурталчлан таниулах зорилгод л үйлчилдэг. Олон нийтийн хэлэлцүүлэг нь лобби хийхээс үндсээрээ ялгаатай бөгөөд энэ асуудлыг өөр замаар, хууль эрхийн өөр актаар зохицуулах ёстой байсан юм.

Харамсалтай нь асуудлын гол нь лоббиг хэрхэн тодорхойлж байгаад оршиж байна. Энэ тодорхойлолт нь хэтэрхий өргөн, нийгмийн ашиг сонирхлыг төлөөлөх болон ашиг сонирхол, байгууллага, компанийн явцуу бүлгийн төлөө лоббидох асуудлыг тодорхойлоогүй. Хууль тогтоогчид лобби үйл ажиллагааны тухай өргөн хүрээтэй тодорхойлолтыг авч хэрэглэхээр шийдсэн нь иргэдийн бүлгүүд, төрийн бус байгууллагуудын сурталчлан таниулах ажилд хортой болсон юм.

Лобби үйл ажиллагааны тухай хууль нь Парламентад өргөн барьсан хуулийн төслүүд, тогтоолын төслүүдээр олон нийтийн хэлэлцүүлэг явуулах боломж олгодог. Энэ хуулийг хэрэгжүүлэх журам нь тун ч ойлгомжгүй. Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах процедур, зохион байгуулалтын талаар ямар ч заалт байхгүй. Зөвхөн, оролцох боломжтой талуудыг бүртгэнэ гэсэн л нэг заалт байдаг. Хуулиар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах ажлыг төрийн аль нэг байгууллагад хариуцуулж заагаагүй. Энэ институцийг ашиглах эсэх нь ер нь л сайн дурын хэрэг болсон. Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах шийдвэр гаргахдаа эрх баригчдаас баримтлах заавар байхгүй (хууль хэрэгжүүлэх журманд ч гэсэн). Олон нийтийн хэлэлцүүлгийг амин чухал юм уу эсвэл маргаантай хууль тогтоомжоор явуулна гэдгийг мэдээж тааж болно л доо. Харин чухам юу чухал юм бэ гэдэг асуудал л санаа зовоосон хэвээр байх болно. Нэгтгэж хэлбэл, олон нийтийн хэлэлцүүлгийн институцийг эрх зүйн орчноо сайжруулах гэсэн иргэдийн гар дээрх үр ашигтай зэвсэг болгох явдлыг хангаж чадах тийм зохицуулалт Лобби үйл ажиллагааны тухай хуульд орхигдсон байна. Харин чиг бүр эсрэгээр, олон нийтийн хэлэлцүүлгийг үр дүнгүй болгохуйц тийм зарим нөхцөл байдал харагдаж байна. Жишээлбэл, Лобби үйл ажиллагааны тухай хуулийн заалтаар бол олон нийтийн хэлэлцүүлгийг техникийн шалтгаанаар болон байр савны тохиромжгүй байдал гэсэн шалтгаар цуцалж болох нь.

Польшийн хууль тогтоогчид олон нийтийн хэлэлцүүлгийн институцид тоомжиргүй хандсан байна гэдэг нь ойлгомжтой. Лобби үйл ажиллагааны тухай хуулийг хэрэгжүүлэх талаар Польшийн Засгийн газар, Сеймээс гаргасан хоёр дахь шатны хууль тогтоомжийн утга агуулга ч үүнийг нотолно. Тухайлбал, Сеймийн хувьдолон нийтийн хэлэлцүүлгийг зөвхөн Парламентын гишүүний саналаар, зөвхөн

төсөл хэлэлцэж эхлэх шатанд зохион байгуулж болно. Польшийн Парламентын дээд танхим бөгөөд хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд оролцдог Сенатыг Лобби үйл ажиллагааны тухай хуулийн зохицуулалтад огт хамруулаагүй байна. Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах санал гаргасан Парламентын гишүүнд хэрхэн хандах, тэгж хандсанаар хууль тогтоох үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх гэлээ гэсэн зэмлэл хэрхэн хүртэхгүй байх нь мөн ойлгомжгүй байна. Лобби үйл ажиллагааны тодорхойлолт хэт өргөн учраас олон нийтийн хэлэлцүүлэг явуулах санал гаргахыг Парламентын гишүүнээс хүсэх нь хууль тогтоох үйл явцад нөлөөлөх гэсэн ажил гэж ойлгогдож болохоор байна. Энэ бол бас л чухал асуудал. Хууль тогтоох үйл явц дахь авилгалтай тэмцэхэд хэрэгтэй арга хэрэгсэл болно гэж хүлээж байсан нөгөө хууль нь өөрөө авилга бий болгох бололцоо өгч байгаа нь парадокс юм. Хууль тогтоогчид энэхүү институцийн үр дүнтэй ажиллах явдлыг хангаагүйгээр үл барам, бүр эсрэгээр уг механизмыг хэрэгцээгүй болгоход хүргэх хэд хэдэн шийдлийг тухайн хууль тогтоомжид оруулсан байна.

Өнөөдрийн хувьд, олон нийтийн хэлэлцүүлэг нь айхтар чухал зүйл биш болоод байна. Энэ нь одоогийн практик амьдралаас харамсалтай нь харагдаад байгаа юм. Хууль тогтоох үйл явц дахь лобби үйл ажиллагааны тухай хууль батлагдсан 2006 оны гуравдугаар сараас хойш олон нийтийн хэлэлцүүлгийг Сеймд (аль ч яам энэ институцийг ашиглаагүй) зохион байгуулах оролдлого зөвхөн гурван удаа хийсэн. Үүнээс хоёр нь ач холбогдол багатай хууль тогтоомжтой холбоотой байлаа. Гурав дахь хэлэлцүүлгийг ихээхэн маргаантай сэдэв болох орон нутгийн засаг захиргааны сонгуулийн хуулиар хийх гэж байсан боловч будлиантай байдлаар цуцалсан юм. Энэ тохиолдол олон нийтийн хэлэлцүүлгийн институцийн нэр хүндэд муугаар нөлөөлж, тун аюултай хэрэг явдал болсон. Хэлэлцүүлгийг иргэний яриа хэлцээний зорилгоор бус, харин ч хууль тогтоох үйл явцад саад хийхэд ашиглах гэж оролдсон юм. Гэсэн хэдий ч, энэхүү институцийн нийтлэг үр нөлөөг тооцоолоход бэрхшээлтэй хэвээр байна. Олон нийтийн хэлэлцүүлгийг институц болгох гэсэн өнөөгийн түүхийг хэрэгцээтэй механизмыг ажиллаж эхлээгүй байхад нь хэрхэн устгахын үлгэр жишээ гэж үзэж болохоор байна. Хэрвээ буруу практик цаашид үргэлжилсээр байвал олон нийтийн хэлэлцүүлэг огт хэрэгцээгүй болох нь дамжиггүй.


Буруу зохицуулалт бүхий олон нийтийн хэлэлцүүлгийн энэхүү сөрөг талыг бага зэрэг саармагжуулсан нэг шийдлийг Лобби үйл ажиллагааны тухай хуульд тусгасан. Үүгээр засгийн газрын болоод тодорхой яамдын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжуудын талаар иргэдэд баримжаа олгох боломжтой болсон. Хууль хүчин төгөлдөр болсноос хойш, сайд нарын зөвлөл болон яам бүр хууль эрхийн баримт бичгүүдийн төслийг нийтэд ил болгох үүрэг хүлээсэн. Төслийн товч танилцуулга, төслийн ажлыг зохицуулж байгаа албан тушаалтнуудын тухай мэдээлэл үүнд багтах ёстой. Энэ бол одоо үйл ажиллагаагаа явуулж байгаа мэдээллийн системүүд болон Олон нийтийн мэдээллийн бюллетень, Олон нийтийн мэдээллийг нээлттэй байлгах тухай хууль зэрэг холбогдох стандартуудад нэмэлт болсон чухал заалт юм. Харамсалтай нь, хууль хүчин төгөлдөр болоод хагас жил болж байхад зарим яам хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй л байна. Яамд төлөвлөгөөгөө нийтэд ил болгохгүй байх, эсвэл хагас дутуу мэдээлэх явдал байсаар байна.

Санал асуулга, олон нийтийн санаачилга, хууль тогтоох байгууллагуудад нэвтрэх эрх, олон нийтийн хэлэлцүүлэг, хууль тогтоох үйл явц дахь лобби үйл ажиллагааны тухай хууль эдгээр нь хууль тогтоох ажилд иргэдийг оролцуулах боломж олгосон үндсэн механизмууд юм. Орон нутгийн түвшинд ч гэсэн иргэдэд санал асуулга явуулах институц, орон нутгийн төр захиргааны байгууллагад нэвтрэх эрх байгаа бөгөөд орон нутгийн хууль тогтоомжид нөлөөлөх боломжтой гэдгийг нэмж хэлэхийг хүсч байна.

Хэрэв Польшийн иргэн хууль тогтоох үйл явцад оролцъё гэвэл сайн муу ч гэсэн бүхий л шаардлагатай институц зохицуулалт үнэн хэрэгтээ байгаа юм л даа. Эдгээр институцийн аль нь ч төгс төгөлдөр биш. Гэхдээ миний бодлоор тэдгээр нь санасан хэмжээнд хүрч ажиллаж чадахгүй байгаагийн шалтгаан нь өөр юманд байна. Энэ механизмуудын чадварын гол асуудал нь тэдний учир дутагдалтайд байгаа юм биш, харин ардчилсан төрийн аливаа институцийг ашиглах хүсэл эрмэлзэл нийгэмд ерөнхийдээ байхгүй байгаад оршиж байна. Польшийн нийгэм нь идэвх сонирхол муутай учир тэр нь эдгээр механизмын ач холбогдолд муугаар нөлөөлөөд байгаа юм. Энэ дүгнэлтийг нотлох хатуу баримт бараг байхгүй боловч асуудлын учир шалтгааныг тогтоох шууд бус баримт материал олон байна. Улс төрийн үйл ажиллагаа болон сонгуульд оролцох зэрэг урсгал үйл ажиллагааг Польшийн иргэд хэрхэн сонирхдог вэ гэдгийг тоо баримтаар авч үзье.

Орон нутгийн сонгуулийн өмнөхөн хийсэн судалгааны үр дүнг Статистикийн төв газар (СТГ)-аас 2006 оны есдүгээр сард гаргасан бөгөөд үүнээс үзэхэд польш иргэдийн зөвхөн тал шахам хувь нь л уг сонгуульд оролцох сонирхолтой байсан байна³⁴.

График 1. Орон нутгийн сонгуульд оролцох иргэдийн сонирхол 2006 оны байдлаар




эх сурвалж: СТГ, 2006 оны есдүгээр сар

Дундаж иргэнд хамгийн ойр байдаг орон нутгийн түвшинд олон асуудлыг шийддэг гэдэг утгаар иргэд орон нутгийн сонгуульд илүү идэвхтэй оролцмоор. Өнгөрсөн орон нутгийн сонгуульд санал өгсөн иргэдийн тоо хэмжээ урьдчилсан

34 СТГ, Орон нутгийн сонгуульд оролцох иргэдийн сонирхол. Судалгааны бюллетень, Варшав, 2006 оны есдүгээр сар

судалгаанд гарснаас хамаагүй хол давсан (45,91%) байлаа. Гэсэн хэдий ч энэ бол хангалттай үзүүлэлт биш (Баруун европын орнуудад энэ тоо дунджаар 65%³⁵ байдаг) юм. Цаашилбал, энэ үзүүлэлт хангалтгүй байгаа нь польш иргэд сонгууль болон ардчиллын бусад институцэд ритуал маягаар ханддагаас үүдэлтэй. Судалгааны бусдажлууд үүнийг мөн нотолж байгаа юм. Жишээ нь, польш иргэдийн ердөөл 50% нь тэдний оршин суугаа орон нутгийн засаг захиргааны албан тушаалтнууд ажлын цагаар ажил дээрээ байдаг эсэхийг сонирхдог байна (график №2-ыг үзнэ үү)³⁶.


График 2. Орон нутгийн засаг захиргааны ажилтнууд үндсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг иргэд сонирхдог байдал



эх сурвалж: *Diagnoza 2005*

СТГ-аас явуулсан санал асуулгаар «Та болон тань шиг хүмүүс танай хот, тосгонд болж өрнөж байгаа ажил хэрэгт нөлөөлж чаддаг уу?» (график №3-ыг үзнэ үү) гэсэн асуултад хариулсан хүмүүсийн 50 гаруй хувь нь орон нутгийн аж амьдралд нөлөөлөх эрх мэдэл бараг байхгүй гэж хариулсан байна.

График 3. Хот, тосгоны аж амьдралд нөлөө үзүүлж байгаа гэсэн ойлголт



эх сурвалж: *СТГ, 2004 оны зургадугаар сар*


35 Орон нутгийн сонгууль дахь сонгогчдын оролцоо. Сонгогчдыг бүртгэх, санал өгөх түвшинд үзүүлж буй нөлөөнүүд. Судалгааны илтгэл, Лондон, 2002 оны тавдугаар сар

36 Эх сурвалж: <http://www.diagnoza.com/>

Польш иргэд ардчиллын институцүүдээр дамжуулан эргэн тойрондоо болж буй үйл явдлын чиг хандлагад нөлөө үзүүлэх боломжгүй гэж үздэг учир аргаа барсан байдалтай байгаа нь нэг талаас харагдаж байна. Нөгөө талаас, хууль тогтоох үйл явцад оролцох зэргээр орчин тойрондоо нөлөө үзүүлэх боломжийн тухай тэд сонирхдоггүй нь өөрсдийн сонгосон төлөөллөө үүргээ найдвартай биелүүлж байна уу, үгүй юу гэдэгт ч санаа зовдоггүй байдлаас харагдаж байна.

Иргэдийг хууль тогтоох ажилд оролцуулах механизмууд сул дорой байгаад нэрмээс болж байж магадгүй нэг хүчин зүйл нь төрийн суурь институцүүдэд ерөнхийдээ итгэдэггүй байдгаас бас үүдэлтэй. 2006 оны хоёрдугаар сард СТГ-аас хийсэн судалгаагаар төрийн хамгийн чухал институцүүдэд хэрхэн итгэдэг вэ гэдэг асуултыг польшуудад тавьсан (график №4-ийг үзнэ үү). Уг графикаас харахад эдгээр институцүүд иргэдийн итгэлийг хүлээдэггүй байна. 2006 оны хоёрдугаар сард асуулгад оролцогсдын тал шахам хувь нь л шинээр байгуулагдсан засгийн газарт итгэж байна гэж хариулсан байна. Оролцогсдын гуравны хоёрын итгэл хүлээсэн өөртөө засаглах институц үл итгэхээсээ илүү итгэл хүлээсэн төрийн цорын ганц байгууламж байсан. 2005 оны намар сонгогдсон шинэ парламент оролцогсдын гуравны нэг, шүүхийн байгууллагууд, төрийн албан хаагчид 40 шахам хувийн итгэл хүлээсэн байлаа³⁷.

График 4. Төрийн хамгийн чухал институцүүдэд үзүүлэх итгэл



эх сурвалж: СТГ, 2006 оны II сар

2006 оны IX сард СТГ-аас хийсэн судалгаагаар польш иргэдийн дөрөвний гурав нь Сеймийн үйл ажиллагаанд, гуравны хоёр нь Ерөнхийлөгчийн ажлын албаны үйл ажиллагаанд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлсэн (график №5³⁸ -ыг


37 СТГ, Хувийн амьдрал, төрийн ажил, иргэний нийгэмд итгэх итгэл. Судалгааны бюллетень, Варшав, 2006 оны хоёрдугаар сар

38 СТГ, Ерөнхийлөгчийн ажлын алба, Парламентын үйл ажиллагааны тухай иргэдийн санал. Судалгааны бюллетень, Варшав, 2006 оны IX сар


үзнэ үү) байна. Төрийн үндсэн институцүүдэд үл итгэх, шүүмжлэлтэй хандах ийм нөхцөл байдалд иргэд хууль тогтоох үйл явцад оролцоно, ийм замаар ямар нэг юмыг өөрчлөнө гэдэгт итгэнэ гэж хүлээх хэцүү.

График 5. Ерөнхийлөгчийн ажлын алба, Парламентын үйл ажиллагаанд өгөх үнэлэлт

Сеймийн талаарх олон нийтийн санал



ЕАА-ны талаархи олон нийтийн санал



эх сурвалж: СТГ, 2006 оны IX сар

Ардчилсан институцүүдэд урам хугарах, үл итгэх байдал нь ардчиллын талаар хийсэн ерөнхий үнэлэлт дүгнэлтэд илэрхийллээ олсон байна. СТГ-аас хийсэн хамгийн сүүлийн судалгаануудын нэгэнд *Та манай улсад ардчилал үйлчилж байгаа байдалд сэтгэл хангалуун байдаг уу* гэсэн асуулт тавихад 40% нь тийм гэж хариулсан бол 46% нь сэтгэл дундуур байдаг гэсэн байна.

Системийн өөрчлөлт хийснээс хойш олон жил болоод байхад бидний байгуулсан институцүүдийг үнэлэх үнэлэмж ихээхэн зөрчилтэй байна (харин нөгөө талаар, асуултад хариулагсдын 72% нь ардчилал ерөнхийдөө Польшийн нийгмийн улс төрийн уламжлал, соёлд нийцэж байгааг хүлээн зөвшөөрсөн нь сэтгэл тайвшруулж болох юм).

Хууль тогтоох үйл явц дахь ТББ-ууд

Өмнө авч үзсэн институцүүд иргэд зохион байгуулалтад орсон эсэхээс үл хамааран тэдэнд үйлчлэхэд нээлттэй байгаа. Дээр иш татсан тоо баримтаас үзэхэд, иргэдийн зүгээс хууль тогтоох ажилд оролцох оролцоонд зарим нэг хязгаарлалт байна. Энэ нь байгаа механизмуудын учир дутагдалтай холбоотой төдийгүй, Польшийн нийгмээс төртэй харьцах харьцаа ерөнхийдөө идэвхгүй, энэ чиглэлээр ямар нэгэн үйл ажиллагаа явуулахаас болгоомжилдог байдалтай бас холбоотой. Энэ утгаар, иргэний нийгмийн зохион байгуулалттай хэсэг болох төрийн бус байгууллагууд хууль тогтоох ажилд хэрхэн оролцдог вэ гэж асууж болох юм. Эл асуултад тодорхой хариулахын өмнө Польш дахь төрийн бус секторын тухай танилцуулах нь зүйтэй.

KLON/JAWOR Ассоциациас хийсэн сүүлийн судалгаа болон албан ёсны статистик тоо баримтаар бол Польшид 55 016 ассоциаци холбоо, 8 212 сан (ТББ-ын гол төрлүүд) байна. Бүртгэлд орсон байна гэдэг нь эдгээр ТББ идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг гэсэн үг биш гэдгийг санах хэрэгтэй. Бүртгэгдсэн ч гэсэн үйл ажиллагаа явуулдаггүй байгууллагуудын тоог гаргахад хэцүү. Ерөнхийдөө бол Польшид 20 000 гаруй ТББ идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг гэсэн тооцоо байдаг. ТББ-уудын гуравны нэг нь нийт үндэсний, эсвэл бүс нутгийн холбоод, хамтын ажиллагааны гэрээ, эвлэл хэлбэрээр ажилладаг. 2004 оны тоо баримтаар ТББ-ууд янз бүрийн статустай 7,5 сая гишүүнтэй байжээ. Польшийн ТББ-уудын үйл ажиллагааны үндсэн салбарууд нь спорт, нөхөн сэргээлт, хобби, аялал жуулчлал бөгөөд дараа нь соёл, урлаг, боловсрол, нийгмийн үйлчилгээний салбарууд орж байна. ТББ-уудын орлогын гуравны нэг нь орон нутгийн болон төв засгийн газраас санхүүждэг төрийн сангуудаас гарч байна. Ердийн ТББ-ын жилийн дундаж орлого 10 000 злот (3 400 орчим ам. доллар) хүрэхтэй үгүйтэй байна. ТББ-уудын дөрөвний гурав гаруйд нь хадгаламж байхгүй. KLON/JAWOR-ын судалгаанаас үзэхэд, Польшийн ТББ-уудын гол асуудал нь тэдний санхүүгийн байдал муутай холбоотой бөгөөд миний үзэж байгаагаар бас сайн дурын хамтын ажиллагаанд хамрагдахад бэлэн хүмүүс байхгүй байгаагаас ч хамаарч байна.

Польшийн төрийн бус секторын дүр зураг ардчиллын тухай үнэлэлт дүгнэлттэй адилхан зөрчилтэй харагддаг. Нэг талаас, Польш дахь ТББ-уудын тоо олон юм шиг боловч 40 шахам сая хүнтэй том орны хувьд энэ тоо чамлалттай байна. ТББ-ууд хөрөнгө мөнгө муу боловч олон хүнд тусламж үзүүлж, төрийн засаг захиргааны чухал түнш болсон. Польшийн ТББ-ууд олон холбоо, эвлэлд нэгдсэн боловч нийт салбарыг төлөөлөн ажиллах толгой байгууллага байхгүй. Ийм байдал наад зах нь хоёр хүчин зүйлээс үүдэлтэй. Нэгд, Европын Холбоонд элсэх үйл явц Европын интеграцийн үзэл санааг шургуу дэмждэг олон бүлэг хүмүүсийн идэвхийг сэргээсэн. Хоёрт, Европын интеграцийн үйл явц, иргэдтэй яриа хэлцээ явуулахыг шаардсан барууны орнуудын шахалт ТББ-уудын эрэлт хэрэгцээг (моод болсон гэж хэлж болно) нэмэгдүүлсэн. Ерээд оны сүүлчээр ТББ-ууд хандивлагчдын тусламж дэмжлэг (гол төлөв америкчуудын) багассанаас хүнд байдалд ороод байсан ч гэсэн үйлдвэрчний эвлэл болон сүм хийд (төрийн засаг захиргааны нийгмийн уламжлалт түншүүд)-ийн дээр нэмэгдэн эрх баригчдын хүсэн хүлээсэн түнш болсон.

ТББ-уудын секторын хөгжлийн ийм ерөнхий нааштай нөхцөл байдалд Олон нийтийн ашиг тус, сайн дурын үйл ажиллагааны тухай хууль 2003 онд батлагдсан. Хэдийгээр энэ хууль бүх шаардлагыг хангаагүй боловч ТББ-уудад төрийн байгууллагуудтай яриа хэлцээ явуулах шинэ эрх мэдэл, арга хэрэгсэл өгч чадсан юм. Юуны өмнө, ТББ-уудын тухай тодорхойлолт өгч, тэдний үйл ажиллагааг зохицуулсан тусгай хуулийг хэрэгжүүлснээр ТББ-ууд Польшийн бодит амьдралд өөрийн гэсэн нэр, байр суурь олж авсан. Улсын сектор тэднийг хамтын ажиллагааны бодит, үнэ цэнтэй түнш хэмээн илүү их хүлээн зөвшөөрөх болсон. Шинэ хууль тогтоомжид ТББ-уудаас хууль тогтоох үйл явцад нөлөө үзүүлэх илүү өргөн боломж өгсөн зарим онцлог шийдлийг мөн зааж өгсөн. Орон нутгийн засаг захиргаанд ТББ-уудтай хамтран ажиллах шинэ үүрэг ногдуулсан. Өөртөө засаг захиргаанууд ТББ-уудтай харилцан хамтран ажиллах тусгай хөтөлбөрийг ТББ-уудтай зөвлөлдөн жил бүр хамтран боловсруулж ажиллах үүрэг хүлээсэн. Үүнээс гадна, Олон нийтийн ашиг тус, сайн дурын үйл ажиллагааны тухай хуулинд Олон нийтийн ашиг тусын төлөө үйл ажиллагааны асуудал эрхэлсэн Зөвлөл байгуулах талаар заасан. Энэ Зөвлөлийн нэг үүрэг нь олон нийтийн ашиг тус, сайн дурын үйл ажиллагааны асуудлаар засгийн газраас гаргах хууль тогтоомжийн төсөлд санал өгөх явдал юм.

Зөвлөл нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн бөгөөд ТББ-уудын асуудал хариуцдаг сайд тэргүүлэн ажилладаг байгууллага юм. Удирдах зөвлөл нь 20 гишүүнтэй. Эдгээр гишүүд нь гуравдагч талын төлөөлөл биш. Учир нь сайд тэднийг ТББ-уудтай зөвшилцөн гаргасан жагсаалтад орсон нэр дэвшигч дотроос томилдог. Зөвлөлийн бүрэлдэхүүнд мөн засаг захиргааны төв байгууллагын төлөөлөл (5 гишүүн) болон орон нутгийн засаг захиргааны төлөөлөл (5 гишүүн) ордог. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд энэ байгууллага бүх ТББ-ын эрх ашигт нийцсэн хууль тогтоомж гаргуулахын төлөө үр дүнтэй тэмцэж чадсан. Польшийн ТББ-уудад төртэй шууд харьцах төлөөллийн альтернатив механизм байхгүй нөхцөлд энэ Зөвлөл нь бүр ч их ач холбогдолтой болж байна. Зөвлөл байгууллагуудын холбоод болон засгийн газартай нэгэн зэрэг хамтран ажиллаж байгаа учир төрийн бус нийт секторын эрх ашгийг хамгаалах үр дүнтэй механизм болж чадаж байна. Зөвлөлийн үйл ажиллагаанд ямар ч саад тогтор учирдаггүй гэвэл мэдээж тийм биш (яамд хууль тогтоомжийн төслөө танилцуулдаггүй, яаралтай баримт бичгийг Зөвлөлд гаргаж өгдөггүй гэх мэт). Зөвлөлийн нэр хүнд, байр суурь аажим аажмаар бэхэжсээр байгаа. Хамгийн гол нь Зөвлөл байгуулсан явдал 2003 оны өмнөх үетэй харьцуулбал урагш хийсэн томоохон алхам юм.

Зөвлөл өөрийн хүлээсэн үүргийн нэг болох хууль тогтоох үйл явцад нөлөө үзүүлэх механизмын хувьд үр дүнтэй ажилласны нэг жишээ бол Компанийн орлогын татварын тухай хуульд сүүлд оруулсан өөрчлөлт дээр харагдаж байна. Засгийн газар ТББ-уудыг дэмждэг компани, байгууллагад татварын хөнгөлөлт үзүүлэх явдлыг зогсоох тухай хуулийн төсөл санаачилж парламентад оруулсан байлаа. Энэ үед Зөвлөл өөрийн төлөөлөгчөө Парламентын Төрийн санхүүгийн хорооны хуралд оролцуулж чадсан бөгөөд тэрбээр хуулийн төслөө буцааж авах шаардлагатайг парламентын гишүүд болон засгийн газрын албаны хүмүүст итгүүлж чадсан байна. Хэрэв тэгж чадаагүй бол төрийн бус нийт сектор санхүүгийн

чухал эх үүсвэрээ алдах байлаа (зөвхөн 2005 онд ТББ-ууд энэ эх сурвалжаас 300 гаруй сая злот буюу 100 гаруй сая ам. доллар олж авсан байна).

ТББ-ууд Олон нийтийн ашиг тус, сайн дурын үйл ажиллагааны асуудал эрхэлсэн Зөвлөлийн ачаар өөрсдийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг бий болоход байнга нөлөөлж чадна гэж хэлэхэд хэцүү. Хэдийгээр «систем» гэж хэлчихээр тогтолцоо байхгүй байгаа боловч нааштай практик тогтож байгаа нь ирээдүйд ердийн үзэгдэл болох байх гэж найдаж байна.

Олон нийтийн ашиг тус, сайн дурын үйл ажиллагааны тухай хууль нь ТББ-уудыг хууль тогтоох ажилд оролцуулах шинэ институцүүд бий болгоод зогссонгүй, бусад шинэ механизм үүсэхэд тойруу замаар нөлөө үзүүлсэн байна. Янз бүрийн улстөрийн намуудыг төлөөлсөн депутатууд, сенаторуудын идэвх зүтгэлээр парламент 2005 онд ТББ-уудын асуудлаар Сенатын спикер толгойлсон тусгай Бүлэг байгуулсан. Тус бүлэгт орсон Парламентын гишүүд ТББ-уудад өөрсдийн эрх ашгийг хууль эрх зүйн актаар хамгаалуулахын төлөө ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ гэж мэдэгдсэн байна. Сенатын спикерийн нэр хүнд, хувийн оролцооны ачаар парламентын тус бүлэг идэвхтэй ажиллаж байгаа бөгөөд ажлын тодорхой үр дүн гарч эхлээд байна. Парламентын зүгээс ТББ-уудтай хамтран ажилласны ачаар хууль санаачлагчдаас өөрсдийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах болсон тохиолдол хоёр ч чухал хуулийн төсөл дээр гарсан (Олон нийтийн сангийн тухай болон Нэмэгдсэн өртгийн татварын тухай). Хуулийн төслийг өөрчлөх буюу хууль тогтоох асуудлаар ТББ-уудтай хамтран ажиллах явдал нэмэгдсэн. Тус Бүлэг нь нэр хүндтэй бөгөөд төрийн бус секторын төлөөлөгчид хүчин төгөлдөр үйлчилж байгаа болон төслөөрөө байгаа хууль тогтоомжийн талаар санал бодлоо илэрхийлэхэд тохиромжтой (парламентийн ордонд байрладаг учраас) форум юм.

Дээр дурдсан институцүүд байгаа хэдий боловч, ТББ-ууд хууль тогтоогчид шахалт үзүүлэх хүчтэй, үр дүнтэй эх сурвалж болж чадаагүй л байна. Өөрсдийн эрх ашгийг хөндсөн хууль тогтоомжийн утга агуулгад ч нөлөө үзүүлж чадахгүй байх явдал гарсаар байна. Хэдий тийм боловч, Олон нийтийн ашиг тус, сайн дурын үйл ажиллагааны тухай хууль, Олон нийтийн ашиг тусын төлөө үйл ажиллагааны асуудал эрхэлсэн Зөвлөл, ТББ-уудын асуудал эрхэлсэн Парламентын бүлэг нь ТББ-уудаас хууль тогтоох үйл явцад оролцох боломжийг ихээхэн тэлж чадсан. ТББ-ууд нэр хүндтэй болж, хүсэл эрмэлзэл, санал бодлоо хүргэх харилцаа холбооны шинэ сувгуудтай болсон. Нэг асуудал байгаа нь ТББ-ууд улс төрчидтэй түншийн харилцаа тогтоох ажлаа үнэхээр удаан хийж байгаад оршиж байна. Үүний үр дүнд тэдний зүгээс хууль тогтоох үйл явцад оролцох чадамж хязгаарлагдмал хэвээр байна. Бас нэг асуудал бий. ТББ-уудын төлөөлөгчдийн хууль тогтоох үйл явцад оролцож байгаагаас харахад тэд төрийн бус секторын ашиг сонирхлоос өөр юм бодохгүй байна. Тухайлбал, татварын хөнгөлөлт үзүүлэх хуулийн өөрчлөлтийг зөвхөн өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой утгаар ойлгодог. Үнэн хэрэгтээ, энэ бол сурталчлан таниулах гэхээсээ илүү лобби хийсэн үйл ажиллагаа юм. ТББ-уудын үүнээс өөр нийтлэг үйл ажиллагааг олж харахад хэцүү байсаар байна.

Иймэрхүү санаачилгын нэг жишээ нь Олон нийтийн институцийн хүчин чармайлт юм. Тус институт хэдэн жилийн турш шинээр сонгогдсон Парламентын гишүүдтэй ажиллаж, тахир дутуу иргэд, өндөр настны сонгуульд оролцох явдлыг

хөнгөвчлөх, ингэснээр сонгуулийн ирцийг сайжруулах талаар сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж итгүүлэхийг оролдож ирлээ. Энэ нь шуудангаар санал өгөх, интернэтээр санал өгөх, эсвэл төлөөлөгчөөр дамжуулан, эсвэл хөдөлгөөнт хайрцаг ажиллуулах замаар санал авах, санал өгөх хугацааг сунгах (одоо оройны 8 цагт санал авах байр хаагддаг) зэрэг саналууд юм. Харамсалтай нь Парламентын гишүүд эдгээр саналыг амьдралд хэрэгжүүлэхийг хичээхгүй байна. Олон нийтийн институтэд хамаатуулж болох нэг амжилт бол Европын холбоонд Польш улсыг элсүүлэх санал асуулгын хугацааг сунгаж чадсан явдал байсан. Гэхдээ энэ асуудлаарх сурталчлан таниулах ажлын нааштай үр дүн нь Европын холбоонд элсэхийн төлөө улстөрийн хүчнүүдийн тусгай сонирхолтой холбоотойг үгүйсгэх аргагүй (санал асуулга хүчингүй боллоо гэж зарлах нь гүн гүнзгий үр дагавар авчрах байсан юм).

= = =

Эцэст нь дүгнэж хэлэхэд, иргэд болон ТББ-ууд хууль тогтоох үйл ажиллагаанд оролцье гэвэл тэдний ашиглаж болох харьцангуй зөв арга хэрэгсэл Польш улсад байна гэж хэлэх байна. Эдгээр арга хэрэгслийн аль нь ч төгс төгөлдөр биш л дээ. Ялангуяа, олон нийтийн хэлэлцүүлгийг буруу аргаар зохицуулсан хууль тогтоомжтой. Гэсэн ч, бүх л дутуу дулимаг зүйлээс үл хамаарах боловч энэ механизмыг үр дүнтэй болгох шийдвэрлэх хүчин зүйл нь дадал заншил юм. Хэрэв иргэд, ТББ-ууд олон нийтийн хэлэлцүүлгийн механизмыг ашиглавал, хууль тогтоох явцад энэ механизмыг ашиглахыг шаардвал, нөгөө талаас улс төрчид энэ институцэд иргэний яриа хэлцээний арга хэрэгсэл гэж хандвал, техникийн чанартай дутуу дулимаг зүйлүүд чухал үүрэгтэй биш байх юм. Сайн дадал заншил төгс төгөлдөр бус хуулийг ч үр нөлөөтэй болгох ба үүний адил муу хууль тогтоомж нь сайн дадал заншлыг ч устгах боломжтой. Энэ зарчим дээр дурдсан бүх тохиолдолд үйлчилж байгаа юм. Иргэдийг хууль тогтоох үйл явцад оролцуулах механизмууд үр нөлөөгүй байгаагийн гол шалтгаан нь иргэний оролцоо, практик үйл ажиллагаа, сайн дадал заншил дутмаг байгаад оршиж байна. Нөгөө талаар, иргэд олон нийтийн амьдралд (ялангуяа улс төрийн хүрээнд) оролцож, хүсэл эрмэлзлээ биелүүлэхийг хүсэхгүй байгаа нөхцөл байдалд дээрх дутуу дулимаг зүйлийг нөхөн бий болгож чадахгүй. Нэгэн нэртэй социологичийн хэлснийг утгачлан ашиглаж тайлбарлавал, институцүүдийг хүн бий болгосон, одоо институцүүд шинэ хүн бий болгоно гэж хүлээх тийм нөхцөлд бид байна. Бидний байгуулсан ардчилсан интситуцүүд иргэдийг бий болгодоггүйд асуудал байгаа юм. Байдлыг сайжруулах түлхүүр нь иргэдэд анхан шатнаас нь эхлээд иргэний боловсрол олгох явдал мөн. Үүнийг олон жилийн турш огоорч ирлээ.

АСУУЛТ- ХАРИУЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Ч. ОТГОНБАЯР /Хөдөөгийн эмэгтэйчүүдийн холбоо/

Асуулт алга, санал бодлоо хэлье. Үндсэн хуульд зааснаар хууль боловсруулах, хэлэлцэх үйл явцад иргэд үндсэн хоёр хэлбэрээр оролцдог. Нэгд шууд, хоёрт сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулж оролцдог. Иргэдийн шууд оролцооны тухайд гэвэл санал хүсэлтээ ярих, уулзалтад үгээ хэлэх асуудлыг яриад байгаа юм. Гэтэл энэ үйл ажиллагаанд иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсрол, чадвар их хэрэгтэй юм. Уулзалтад ярьж байгаа хүн бүрийн үгийг аваад байна гэвэл бас хэцүү байдаг. Бас эвлэлдэн нэгдсэн төрийн бус байгууллага, хөдөлгөөнүүдээрээ дамжуулж иргэд өөрсдийнхөө санаа бодлыг илэрхийлж байдаг. Энэ тохиолдолд харин ТББ, хөдөлгөөнүүд иргэдийн санаа бодлыг илүү багцалсан, илүү чиглүүлсэн байдаг учраас тэдний гаргаж байгаа санал илүү боловсронгуй байдаг. Сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан иргэд санаа бодлоо оруулахдаа ихэвчлэн гишүүн нь тойрогт ажиллах үед л өөрсдийн санаа бодлыг хэлдэг. Тамгын газарт болон Байнгын хороонд ирж байгаа нь харьцангуй тогтсон, төлөвшсөн тийм эрх зүйн мэдлэгтэй, боловсролтой, бас туршлагатай хүмүүсийн санаа бодол хуулийн төслийг хэлэлцэх явцад орж ирдэг. Тийм учраас энэ хоёрыг хооронд нь ялгаж үзэх хэрэгтэй. Тамгын газрын тухайд гэвэл энэ ирүүлсэн санал дээр илүү тогтоцтой ажиллаж, энэ чиглэлээр эргэж хариу өгөх нь зүйтэй юм. Иргэдийн шууд оролцооны талаар хуульчлан баталсан эрх зүйн оролцооны орчин боловсронгуй биш байна. Энэ талаар цаашдаа боловсронгуй болгох шаардлагатай. Нэгэнт парламент гэдэг бол хуулийг боловсруулж, хэлэлцэж, баталж байгаа үйл ажиллагаа учраас энэ нь маш тогтвортой, амьдралд хэрэгжихүйц, нийцэхүйц, чанартай хууль батлан гаргах шаардлагатай. Иймд үнэхээр Парламентын аппаратыг өргөжүүлэх, чадваржуулах хэрэгтэй. Түүрүүнд Д.Алтай ярьсан судалгаа, мэдээллийн хүрээлэн байгуулах саналыг дэмжиж байна. Баярлалаа.

Р. БУРМАА /Сонгогчдын боловсрол төв/

Польшийн илтгэгчээс асуух зүйл байна. ТББ-дын асуудлаар Сенатын спикер толгойлсон тусгай бүлэг Парламентын ордондоо байрлаж форум хэлбэрээр ажилладаг гэж ярьсан. Энэ механизм нь хэрхэн яаж ажилладаг вэ, хуульчлагдсан байдаг уу? Зардал төсөв нь Парламентын төсөвт багтдаг уу?

МАКОВСКИ

Парламентын төсөвт багтдаггүй. Сайн дурын үндсэн дээр ажилладаг ТББ юм.

Д. ЛАМЖАВ /Иргэн/

Хоёр зүйл хэлмээр байна. Аливаа ийм чухал семинар уулзалт нь үр дүнтэй байх асуудал чухал юм. Нэгдүгээрт, холбогдох хуулийн төслийг боловсруулах асуудал байгаа юм. Манайд ийм практик бий. ТББ-дын хуулийн төслийг иргэний нийгмийн байгууллагууд санаачилж, боловсруулж парламентаар батлуулсан. Тэгэхээр үүнийг цааш нь явуулах ёстой юм. Хоёрдугаарт, Польшийн туршлага бол үнэхээр гашуун туршлага байна. Хэрэгжээгүй. Сайн парламент бас тийм байж болох юм. Эсвэл тэр хуульд ямар нэг дутагдал байсан байх. Тэгэхээр энд хэлэлцэх сэдвийг хэн тодорхойлж байна вэ гэдгээс их хамаарч байгаа байх гэж бодож байна. Тохиолдлын шинжтэй сонсдог биш дэгийн дагуу сонсдог байх. Хүн ирэхгүй байвал яахав, хүн ирвэл нэг хүнийг ч гэсэн сонсдог тийм дэгтэй болох ёстой. Манайд бол бослого гарч цонхоо хага цохиулж байж сонсох жишээтэй. Байнгын хорооны хэлэлцүүлэгт ийм ийм санал ирсэн гэдгийг заавал мэдээлдэг, сонсдог байх ёстой л доо. Манай УИХ бол байнгын ажиллагаатай биш болчихоод байгааг айхтар их шүүмжилж байгаа. Нэг жилийн талд нь чуулган нь хуралдаж, талд нь гадаадад зугаалж, наадам хэсч явдаг ийм ажилтай болсон. Тэгээд тэр тал хугацааны 7 хоногт хоёрхон удаа нэгдсэн хуралдаан хийж байгаа гэхээр ерөнхийдөө байнгын ажиллагаатай парламентгүй болчихоод байгаа юм. Бас гишүүд залхуураад бүх эрхээ даргадаа шилжүүлчихсэн байгаа. Нэг хуулийн төслөөр хоёр гурван санал авмар болж байгаад хэлэлцэхдээ дарга нь “Би жаахан засч байгаад болмоор бол та нарт буцааж тараана, болохгүй бол тэр чигт нь явуулчихна шүү” гэдэг болсон. Тэгээд хуульд баахан редакци хийдэг. Манай парламент болохгүй байгаа юм. Тиймээс хүмүүжүүлж авахгүй бол болохгүй. Энэ асуудлыг иргэний нийгмийн оролцоотой хийхээс өөр аргагүй байдалтай байгаа.

Ж. НАРАНТУЯА /УИХ-ын Тамгийн Газар/

Өнөөдөр УИХ-ын Тамгын газар, Нээлттэй Нийгэм Форум санаачлаад энэхүү семинарыг зохион байгуулж байна. Тэгэхээр төрийн байгууллага, ТББ-дын эрхэм зорилго бол нэг байгаа юм. Иймд энэ зорилгоо хэрэгжүүлэхэд яаж хамтран ажиллах вэ, ямар арга зам байна вэ? гэдгийг хамтран ярилцаж байна. Бодлогын хувьд бид нэгдмэл байна. Хэрэгжүүлж байгаа арга туршлагын хувьд нэгдсэн нэг зөвшилдөөнд хүрэх ёстой юм байна. Тиймээс манай парламент юу хийх гэж байна вэ гэвэл нэгдүгээрт, бид нар Хууль зүйн яамтай хамтраад Хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд зарчмын нэлээн өөрчлөлт оруулах гэж байгаа. Нэгэнтээ хууль боловсруулах шатанд иргэдийн саналыг авах юм бол мэдээж тэр хууль илүү чанартай гарна. Дараа нь хэлэлцүүлэх шатанд Байнгын хорооны түвшинд нийтийн сонсгол хийх ёстой. Нээлттэй хэлэлцүүлэг гэдэг маань олон шатаар иргэдийн саналыг авах тухай асуудал юм. Тэгэхээр энэ бүгдийг нэгтгэсэн нэг зохицуулалт байх уу, эсвэл тус тусдаа байх уу гэдэг талаар бодож байна. Хуулийн төсөлд иргэдийн саналыг авахдаа баг, хорооны түвшинд иргэдийн санал хүсэлт, дуу хоолойг сонсдог үйл ажиллагаа илүү өргөн байх ёстой юм болов уу. Харин парламентын түвшинд арай өөр арга механизм байх болов уу гэж бодож байна. Ингээд та нарыг бидний хийхээр төлөвлөж байгаа ажлын талаар өөрсдийн санал дүгнэлтийг хэлэх болов уу гэж найдаж байна. Баярлалаа.

УНДРАЛ /Ардчилалын Боловсрол Төв/

Хамгийн гол нь энэ семинараас гарах үр дүн нь юу вэ? ННФ-аас олон чухал асуудлаар семинар зохион байгуулж байгаа нь сайшаалтай. Гэхдээ эргээд тодорхой ажил болдоггүй, энэ нь юунд байна гэхээр эдгээр семинарт УИХ-ын гишүүд ерөөсөө оролцдоггүй. Энэ семинарын нээлт дээр хүртэл УИХ-ын дэд дарга Д.Лүндээжанцан гуай үг хэлээд нүүрээ харуулчихаад гараад явчихлаа. Болж өгвөл хэдэн тооны гишүүдийг оролцуулж болдоггүй юм уу? ТББ-ууд лоббидож байгаа асуудлаараа хэлэлцүүлэг хийхдээ урьдаг боловч гишүүд ирдэггүй. Тэгээд үр дүн гардаггүй байхгүй юу. Тийм учраас энэ удаагийн олон улсын семинарын ганц авууштай гарах үр дүн нь юу вэ гэхээр төв ба дорнод европын орнуудын туршлагаас бид нар авах, суралцах явдал байна. Иймд эндээс тодорхой саналууд гаргаад УИХ-ын Тамгын газарт оруулмаар байна. Тухайлбал, Ард нийтийн санал асуулгын тухай хуульд өөрчлөлт оруулахад Польшийн туршлагаар хэрвээ 100 мянган иргэн санаачилга гаргавал ард нийтийн санал асуулга явуулж болдог юм байна гэдгийг нэг санал болгоод оруулах жишээтэй. Эсвэл ТББ-уудтай хамтран ажиллах Парламентын бүлэг байгуулах тухай ч гэдэг юмуу. Энэ мэтээр хуралдаан болгоноос ганц хоёр заалт, тодорхой саналыг бэлтгэж оруулмаар байна.

2007 ОНЫ НЭГДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДРИЙН ҮДЭЭС ХОЙШХИ ХУРАЛДААН

Хуралдаан даргалагч УИХ-ын Тамгын Газрын нэгдүгээр нарийн бичгийн дарга Ж.Нарантуяа

Хурал даргалагч

Та бүхний өдрийн амгаланг айлтгая. Семинарынхаа ажиллагааг үргэлжлүүлье. Одоо “Румын улсын иргэдийн оролцооны зохицуулалт”–Румын улсын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн нөлөөллийн хөтөлбөрийн зохицуулагч Андреа Чифан.

РУМЫН ДАХЬ ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

АНДРЕА ЧИФАН

/Румын улсын Нээлттэй Нийгмийн Хүрээлэн/

2003 оны 52 дугаар Хууль буюу Ил тод байдлын тухай хуулийн талаар мэдээлэл өгөн хууль боловсруулах, батлах үйл явц дахь иргэдийн оролцооны талаар яримаар байна. Ил тод байдлын тухай хууль нь төрийн болон хувийн хэвшлийн секторын хооронд аль аль талуудын үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрүүдийн талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэхийг хангах зорилгоор батлагдсан хууль юм. Ингэснээр иргэд төрийн байгууллагуудын норматив санаачлагын талаар мэдээлэл хүртэн, ирээдүйд батлагдах хууль журмын талаар өөрсдийн санал хүсэлтээ өгснөөр шийдвэр гаргах үйл явцад идэвхитэй оролцох боломжтой болох ба хэрэв энэ үйл явц амжилтгүй байвал эцсийн арга хэмжээ болох сонгогдсон албан тушаалтнуудыг шийтгэх боломжтой болно гэсэн үг юм.

Төрийн захиргааны хувьд энэхүү хуулийн үр ашиг их, эдгээрийг товч дурьдвал төрийн захиргаа нь ирээдүйд батлагдах дүрэм журмаар зохицуулсан үйл ажиллагааны талаар үнэгүй мэдээлэл олж авах, санаачилсан дүрэм журмыг батлах хэрэгцээ шаардлагын тухай тайлбар авах, хэрэгжилтийн үед үүсэж болох бэрхшээлийн талаар урьдчилан мэдэх, иргэдийн итгэл үнэмшлийг олж авах гэх мэт зүйлс байдаг.

Иргэдийн хувьд энэ хуулийн дагуу хүртэх үр ашиг нь төрийн захиргааны байгууллагаас санал болгосон төсөлтэй танилцах, өөрсдийн үзэл бодол, саналаа

илэрхийлэх, мөн өөрсдийн ирээдүйн үйл ажиллагаагаа тэрхүү хуулийн төслийн шаардлагын дагуу зохицуулах цаг хугацаатай байх гэх мэт зүйлс бий.

Эдгээр үзүүлэнгээс та бүхэн харж байгаа байх, Румынд иргэний нийгэм төрийн шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх, оролцох хэд хэдэн зохицуулагдсан арга замууд байдаг. Иргэдийг хууль батлах, боловсруулах үйл явцад оролцуулах, иргэдтэй зөвлөлдөх тухай хэд хэдэн хуулиуд байдаг бөгөөд эдгээрээс хамгийн чухал нь 2003 онд батлагдсан 52 дугаар хууль юм. Тус хууль нь хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын санаачилсан олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнд Румыний Засгийн газрын дэмжлэгтэйгээр үүссэн юм. Бусад хууль тогтоомжийн талаар миний хамтран зүтгэгч ярих болно.

52 дугаар хуулийн хоёрдугаар зүйлийн дагуу Ил тод хуулийн гол зарчмууд нь орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагуудын хэлэлцэхээр төлөвлөж буй олон нийтийн ашиг сонирхолд хамааралтай асуудлууд, нийтээр дагаж мөрдөх дүрэм журмын төслийн талаар иргэдэд албан, урьдчилсан байдлаар мэдээлэх, мөн захиргааны шийдвэр гаргах, норматив баримт бичгийн төсөл боловсруулахдаа иргэдтэй зөвлөлдөх гэсэн зарчмуудаас бүрддэг.

Хуулийн дөрөвдүгээр зүйлд заасны дагуу ил тод байдлын зүйл заалтад хамаатай төрийн захиргааны байгууллагын тоонд яамд, Засгийн газар болон тэдний харъяан дахь төрийн захиргааны байгууллагууд, тэдгээрийн салбар төрийн үйлчилгээний байгууллагууд, бие даасан захиргааны байгууллагууд ордог. Орон нутгийн төрийн захиргааны хувьд мужийн зөвлөл, орон нутгийн зөвлөл, хотын дарга, орон нутгийн болон мужийн бусад институци, үйлчилгээний байгууллагууд орно.

Орон нутгийн засаг захиргаа, төрийн захиргааны байгууллагууд болон яамдын санаачилсан хуулийн төслүүд дээр иргэдтэй зөвлөлдөнө. Одоогийн байдлаар хуулийн төслийг парламентад хэлэлцэх үед парламентаас тогтоосон журмын дагуу олон нийт буюу ихэнхдээ хуралдаанд байлцаж буй төрийн бус байгууллагуудтай зөвлөлдөх буюу эс зөвлөлдөж болно. Хэдийгээр ийм төрлийн зөвлөлдөх саналыг анх хувийн хэвшлийн байгууллагууд гаргасан ч сүүлийн гурван жилийн хугацаанд төрийн бус байгууллагууд энэхүү журмыг хамгийн их хэрэглэж үр ашгийг хүртсэн нь сонирхолтой байж болох юм.

Нийтээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгийг боловсруулах болон шийдвэр гаргах явцад иргэд, холбоодыг оролцуулах тухай хуулийн дагуу бий болсон журмууд нь төрийн байгууллагын өөрийн вэбсайтаа байрлуулан нийтлэх, эсвэл тухайн хуулийн төслийг боловсруулж буй тухай зарыг өөрийн албан газрын байранд өлгөж мэдээлэх үүрэгтэйг нь зааж байгаа юм. Зарыг иргэдэд хүртээлтэй газар, өрөө тасалгаанд байрлуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тухай бүрт мэдээлэх ёстой. Зарыг дээр дурьдсан арга замаар тухайн асуудлын мөн чанараас шалтгаалан ялгавартай хугацаанд нийтэд мэдээлнэ. Норматив эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулж буй тохиолдолд гуч хоногийн өмнө, ямарваа нэгэн шийдвэр гаргах үйл явцад иргэдийг оролцохыг хүссэн зар байгаа бол гурав хоногийн өмнө зарлагдсан байна. Чухал нь тэрхүү зард тухайн хуулийн төслийн үндэслэл, хуулийн төсөл боловсруулах болсонтой холбогдох мэдээлэл, сонирхсон хүмүүс, байгууллагууд саналаа илгээх хаяг, хэлбэр, цаг хугацаа зэргийг тусгасан

байна. Дээрх мэдээллийг авахыг хүсэж өргөдөл гаргасан хувь хүн, төрийн бус байгууллага, төрийн захиргааны байгууллага хэнд ч болов холбогдох төрийн захиргааны байгууллагаас тухайн баримт бичгийн төслийг илгээнэ. Шаардлагатай бол баримт бичгийн төслийг нийтээр хэлэлцүүлэх уулзалтыг хэрхэн зохион байгуулах талаар тухайн төрийн байгууллага холбогдох байгууллагуудад бичгээр мэдэгдэх үүрэг хүлээнэ. Олон нийтийн уулзалтын үеэр хүлээн авсан мөн тухайн төрийн байгууллагад бичгээр ирүүлсэн санал, зөвлөмжүүдэд дүн шинжилгээ хийж, авч үзэх ёстой. Гэхдээ иргэд, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудаас ирүүлсэн саналыг тухайн хууль, дүрэм журамд тусгах эсэхийг төрийн захиргааны байгууллага өөрөө шийднэ.

Төрийн байгууллагуудаас зохион байгуулах хурал, зөвлөлдөөнд иргэдийг оролцуулах үйл явцыг хуулийн дагуу нэгдмэл хэлбэрт оруулсан байдаг. Хурал, уулзалт болохоос гурав хоногийн өмнө хурал болох огноо, цаг хугацаа, хэлэлцэх асуудлыг заасан зарыг холбогдох төрийн захиргааны байгууллага олон нийтэд мэдээлэх ёстой. Хурлыг даргалагч оролцогчдод санал бодлоо илэрхийлэх боломж олгох ба холбогдох төрийн байгууллага хэлэлцсэн асуудлын талаар санал хураасан бол санал хураалтын дүнг тусгасан хурлын тэмдэглэлийг хөтлөх үүрэг хүлээнэ. Энэхүү заалт нь сонгуульт албан тушаалтнууд өөрсдийн саналаа иргэдэд нээлттэй болгох, түүнийхээ хариуцлагыг хүлээх ёстой гэсэн иргэний нийгмийн зүгээс ирдэг байнгын шахалтын үр дүнд бий болсон ба эдгээр механизм байхгүй байсан бол иргэд өөрсдийнхөө сонгосон төлөөлөгчдийн хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар үнэлгээ өгөх боломжгүй болно.

52 дугаар хуулийн дагуу шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг хангах талаар төрийн захиргааны байгууллагууд хэд хэдэн төрлийн мэдээлэл багтаасан жил тутмын тайланг нийтлэх үүрэг хүлээдэг. Цаг гарвал энэхүү заалтын хэрэгжилтийн талаар би сүүлд нь хэдэн үг хэлнэ.

Энэхүү тайланд:

- Нийт хэчнээн тооны зөвлөмж хүлээн авсан болох
- Хуулийн төсөл, гаргасан шийдвэртээ нийт хэчнээн зөвлөмжийг тусгасан болох
- Хуулийн төслийн талаар хэдэн удаа олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан болох
- Хуулийн заалтыг биелүүлээгүйгээс болж шүүхэд дуудагдсан тохиолдлуудын нөхцөл байдлын талаар
- Иргэд, тэдний хуулийн дагуу байгуулагдсан түншлэлүүдтэй хамтран ажиллаж буй байдлаа дүгнэсэн өөрийн дүгнэлт
- Нийтэд хаалттай хийсэн хурлын тоо, шалтгаан, үндэслэл.

52 дугаар хууль нь орон нутгийн захиргаа, яамдад хамааралтай. Тус хуулийн дагуу иргэд, тэдний байгууллагаас ирүүлсэн санал, дүгнэлтийг хүлээн авах эсвэл татгалзах нь тухайн төрийн байгууллагын өөрийнх нь эрх мэдлийн асуудал юм. Энэхүү хууль нь харин Парламентын үйл ажиллагааг зохицуулдаггүй. Тиймээс хэрэв Парламентын гишүүн хууль

санаачилсан, эсвэл түүнийг дэмжиж байгаа бол тухайн хуулийнхаа төслийг заавал иргэдтэй зөвлөлдөх үүрэг хүлээхгүй ч, энэ нь тухайн гишүүний хүсэл эрмэлзлээс хамаардаг. Олон нийтээр хэлэлцүүлэхийг сонгоогүй тохиолдолд санал нь Парламентын ердийн журмын дагуу хэлэлцэгдэнэ. Парламентад иргэд, олон нийттэй зөвлөлдөх тогтвортой бүтэц бий болгосноор Парламентын гишүүд иргэний нийгмийн байгууллагуудаас судалгаа, шинжилгээний материал хүлээн авч судлах замаар өөрсдөдөө дутагдалтай байгаа мэдлэг, мэдээллийг олжавах, бодлого боловсруулах тогтолцоог сайжруулах, иргэдийн санаачилгыг хөхиүлэн дэмжих боломжийг бүрдүүлэх юм. Ийм бололцоог бий болгосноор бодлого боловсруулах үйл явцыг тогтвортойгоор сайжруулах төдийгүй оролцоонд суурилсан ардчилсан тогтолцоог хөгжүүлэх улс төрийн хүсэл эрмэлзлэлийг батлан харуулах болно.

Хэдийгээр эрх зүйн түвшинд иргэдийг шийдвэр гаргах үйл явцад оролцуулах нөхцөл 2003 оны 52 дугаар хуулийн дагуу бүрдсэн ч иргэний нийгмийн байгууллагуудтай зөвлөлдөх үйл явцыг хэрэгжүүлэх арга барил нь хэлбэр төдий, үл ойлгогдох, тодорхойгүй, итгэл үнэмшил төрүүлэхүйц бус байна. Төрийн захиргааны байгууллагууд ёс төдий, уялдаа холбоогүй, тэр ч бүү хэл хагас дутуу мэдээлэл өгөх замаар энэхүү хуулийг хэрэгжүүлдэг. Хувийн хэвшлийн байгууллагуудын хувьд хэдийгээр энэхүү хуулийг санаачилсан ч олон нийттэй зөвлөлдөх үйл явцад сайтар нэгдэн нийлж оролцож чадахгүй байна. Олон нийтийн зөвлөлгөөнийг хуулийн үг үсгийг хэрэгжүүлэх зорилгоор зохион байгуулах нь элбэг байдаг. Харин иргэдээс ирүүлсэн санал, зөвлөмжөөс ашигтай тустай зүйлийг нь тэр бүр авч хэрэглэж чадахгүйгээр барахгүй тэдний өгсөн мэдлэг, туршлагыг үл хайхарч байгаа билээ.

Дүгнэж хэлэхэд Ил тод байдлын тухай хууль нь шинэ, магад төрийн захиргааны хувьд хамгийн чухал арга хэрэгслийг бий болгосон ба иргэд үүнийг ашиглаж үгээ хэлэх боломж олсон. Тэгэхээр оролцоогүй бол өөрөө хохирно гэсэн үг. Хэрэв асуулт байвал би нэмэлт мэдээлэл өгөхөд бэлэн.

ҮНДЭСНИЙ БОДЛОГО ТОДОРХОЙЛОХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО: ТЭРГҮҮН ТУРШЛАГА БА СУЛ ТАЛУУД

ЖОН ЭНДЕР

*/PRAXIS бодлогын судалгааны төвийн
төрийн захиргааны хөтөлбөрийн судлаач/*

Эстони нь жижиг улс. Зарим талаар шилжилтийн орон хэвээр байгаа бөгөөд энэ хоёр шинж нь Эстоний тусгай сонирхлын болон зорилтот бүлгүүдийн оролцооны практикт нөлөөлж байна. Иргэний нийгэм нь бүрэн хөгжиж амжаагүй байгаа ба зөвлөлгөөнд зориулах цаг, нөөц хязгаарлагдмал байдаг. Үүний зэрэгцээ төрийн албан хаагчид болон парламентын гишүүд иргэдтэй зөвлөлдөх, тэдний оролцоог хангах тал дээр удаан хугацааны туршлага хуримтлуулж амжаагүй байгаа.

Эстоний хууль, эрх зүйн актууд нь олон улсын стандартад нийцэхүйц хэмжээнд сонирхлын бүлгүүдийг оролцуулах ерөнхий хүрээг хангаж өгсөн байдаг. Эдгээр асуудлыг илүү нарийвчлан зохицуулах нь тэр болгон сайн үр дүнд хүргэдэггүй. Тэрхүү хүрээг агуулгаар баяжуулахад илүү ач холбогдол өгдөг. Жишээ нь сонирхогч талуудын оролцоог хангах удирдамж (2005), ТББ-уудыг илүү сайн түнш байх чадавхийг нь дээшлүүлэх, яамдын сайн засаглалын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, зохицуулалтыг сайжруулах, тэргүүний туршлагыг илрүүлэх гэх мэт.

Төрийн хэрэг эрхлэх газар, Эстоний хуулийн төвийн сан болон зарим яамдын иргэдийн оролцоог өөрсдийн зорилгын хүрээнд нэмэгдүүлэхийн тулд бий болгосон электроник хэлэлцүүлгийн талбарууд байдаг. Гэвч эдгээр нь зохицуулалтыг сайжруулахын тулд шаардлагатай хэлэлцүүлгийн багахан хэсгийг л хангадаг. Ихэнх зөвлөлдөөн нь утсаар эсвэл цахилгаан шуудангаар албан бус хэлбэрээр хийгддэг. Албан ёсны зөвлөлдөөнийг ихэвчлэн дугуй ширээний ярилцлага хэлбэрээр хийдэг. Сонин, телевиз зэрэг нь мөн хүн амын нэлээд хэсгийн эрх ашгийг хөндсөн асуудлаарх шийдвэрийн хэлэлцүүлгийг өрнүүлэхэд үүрэг гүйцэтгэдэг.

Ер нь сүүлийн үед хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үндсэн дээр Эстонид олон нийтийн хэлэлцүүлэг, зөвлөлдөөнийг явуулах аргад нилээд нөлөө үзүүлсэн. Жишээ нь, Засгийн газар зөвлөгөөнийг заавал явуулж байх зарчмыг дүрэм журмууддаа тусгаж, зөвлөлдөөнийг явуулах удирдамжийг батлан, иргэний нийгмийн хөгжлийн концепц дээр саналаа нэгтгэсэн. Гэвч энэ нь зөвхөн хүрээг бий болгож байгаа хэрэг бөгөөд хамгийн гол нь түүнийг хэрэгжүүлэх явдал юм.

Эстонид хэрэглэж буй ухагдахуунууд


Олон нийтийн оролцоо³⁹ :

1) Зорилгодоо хүрэхийн тулд гишүүд, зорилтот бүлгүүдээ идэвхжүүлж, тэднийг оролцуулахад чиглэсэн ТББ-ын үйл ажиллагаа

2) Иргэд, тэдний төлөөллийн байгууллагуудад амьдралд нь нөлөөлөх шийдвэрүүдийг гаргахад оролцох боломжоор хангахад чиглэсэн төрийн үйл ажиллагаа

3) Чанартай, үр дүнтэй бодлого боловсруулахын тулд тухай салбарын шинжээчдээс мэдээлэл цуглуулахад чиглэсэн төрийн үйл ажиллагаа

Оролцооны түвшин⁴⁰ :



Олон нийтийн оролцоог хангах хүрээ⁴¹

Үндсэн хуулийн 56 дугаар зүйл иргэдийг оролцуулах талаар нэг их дурдаагүй. Иргэд парламентыг сонгох эрхтэй гэхдээ бүх нийтийн санал асуулгыг зөвхөн парламент санаачлах эрхтэй. Эстони тусгаар тогтнолоо олсноос хойш зөвхөн ганц бүх нийтийн санал асуулга явагдсан. Тэр нь Эстони 2003 онд Европын холбоонд элсүүлэх шийдвэрийг талаар байсан. Сонирхлын бүлгүүд хууль санаачлах эрхгүй. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах эрх нь зөвхөн Рижикогугийн гишүүд, факц болон хороо, мөн Засгийн газар, Ерөнхийлөгч нарт байдаг. Сонирхлын бүлгүүд хэлэлцэх асуудлын жагсаалтыг тодорхойлох, түүнийг хянах эрхгүй байдаг. Гэтэл энэ нь оролцооны ардчиллын нэгэн чухал шалгуур болдог (Dahl, Barber). Тиймээс сонирхлын бүлгүүд зөвхөн тэднийг урьсан нөхцөлд болон сонирхлын бүлгүүдийг оролцуулах хуулийн шаардлагыг биелүүлэх тохиолдолд хуулийн төслийг боловсруулах явцад оролцох боломжтой байдаг.

Хуулийн төслийг боловсруулах тухай Парламентын журмын 53 дугаар зүйлд зааснаар хуулийн дагалдах тайлбарта ямар хүмүүст (засгийн газрын ямар байгууллага, ямар орон нутгийн захиргаа, ТББ, шинжээчид гэх мэт) хуулийн төслийн саналыг авахаар хүргүүлсэн, ямар хүмүүсийн саналыг хууль боловсруулахад анхааралдаа авсныг тайлагнах ёстой. Хуулийн дагуу үүрэг хүлээх иргэд, нийгмийн бүлэг, иргэний нэгдлүүдийн санал, бодлыг авсан байх ёстой. Мөн тухайн сонирхлын бүлгүүдийн

39 Lagerspetz, M. (2004). "Estonian Civil Society Dictionary"
40 OECD 2001, PRAXIS 2004
41 PRAXIS 2004, "Engaging Interest Groups in Decision-Making Processes", www.praxis.ee

төлөөлж буй иргэдийн саналыг авахыг болон тухайн салбарт дээд байгууллага байгаа бол түүний саналыг авахыг зөвлөдөг. Хуулийн төслийг боловсруулах тухай Засгийн газрын дүрмийн 38 дугаар зүйлд төслийг хүргүүлсэн байгууллагуудыг болон тэдэнтэй зөвлөлдсөн үр дүнгийн тухай тодорхой тайлагнасан байх ёстой гэж заасан байдаг. Хүлээж авсан бүх саналыг хүснэгтэд тусгаж, тэднээс заримыг нь ямар учраас хуулийн төсөлд тусгаагүй болсон шалтгаанаа тодорхой тайлбарласан байх ёстой. Мөн уг дүрэмд хэрэв хуулийн төслийг ТББ-д явуулсан бол ямар учраас тухайн ТББ-г сонгосон тухайгаа тайлбарлах ёстой гэж заасан байдаг.

Гурван талт хэлэлцүүлэг болон байгаль орчны тухай хуулийн тухай бодлогын хүрээнд сонирхлын бүлгүүдийн оролцоог зохицуулсан заалтууд хамгийн их байдаг.

1996 онд оролцооны ардчиллыг хөгжүүлэх тухай гурван талт гэрээг байгуулсан. Энэ гэрээний дагуу Засгийн газар хуулийн бүх төслийг Парламентад өргөн барихаас өмнө ажил олгогчдын болон ажилчдын бүх төв байгууллагууд (Эстоний үйлдвэрчний эвлэлүүдийн конфедерац, Эстоний ажил олгогчдын холбоодын конфедерац, ЕЕС) руу тэдний санал, бодлыг авахаар хүргүүлдэг. Мөн Эстоний үйлдвэрчний эвлэлүүдийн конфедерац, Эстоний ажил олгогчдын холбоодын конфедерац, ЕЕС гэх мэт байгууллагуудаар дамжуулан ажилчид ба ажил олгогчдын төлөөлөл оролцсон хэд хэдэн зөвлөл, зөвлөлдөх хороо байдаг. Эстоний гурван талт гэрээний санаачлагчид болон тэдгээр хэлэлцээрт илүү идэвхтэй оролцсон түншүүд бол ихэвчлэн үйлдвэрчний эвлэлүүд байдаг. Тиймээс нийгмийн санал солилцоо нь Эстонид зөвхөн Засгийн газрын хувьд сонирхлын бүлгүүдийг оролцуулах явдлаар хязгаарлагддаггүй, харин нийгмийн түншүүдийн хувьд ч мөн бодлого боловсруулах явцад идэвхтэй оролцох боломжийг хангаж өгч байдаг.

Оролцооны тухай ихэнх хууль нь Эстонид байгаль орчны салбарт байдаг. Хамгийн нөлөөтэй нь Эрхүсын конвенц. Энэ конвенц бүх сонирхогч талууд байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд оролцох эрхтэй гэж заасан байдаг (6-8 дугаар зүйлүүд). Үүнээс гадна Байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээ, байгаль орчны аудитын тухай хууль болон байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээний мэдэгдэлд тавигддаг шаардлага (Байгаль орчны сайдын 2001 оны 1 дүгээр сарын 31 тушаал №4) нь байгаль орчны асуудлаарх оролцоог зохицуулж байдаг. Байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээний хөтөлбөр, мэдэгдлийг танилцуулахад сонирхсон хүн болгоныг санал, бодлоо илэрхийлэх боломжоор хангасан олон нийтийн хэлэлцүүлгийг явуулах ёстой байдаг (17 дугаар зүйл). Хэрэв ийнхүү тавигдсан санал, бодлыг хөтөлбөр, мэдэгдэлдээ тусгаагүй бол ямар учраас тусгаагүйгээ байгаль орчны үнэлгээнийхээ эцсийн тайланд тайлбарласан байх ёстой.

Гэрээ хэлэлцээр болон бусад санаачлага

Нийгмийн болон байгаль орчны бодлогоос гадна Европын холбооны бүтцийн сантай холбогдуулж боловсруулсан “2004-2006 оны үндэсний хөгжлийн төлөвлөгөө”-ний хүрээнд иргэдийн оролцооны зарчмыг өргөн хэрэглэсэн. Сангийн яам, уг төлөвлөгөөний менежментийг хариуцсан этгээдийн хувьд нийгэм, эдийн

засгийн олон байгууллага, бүлэг болон бусад түншүүдийг оролцуулах үүрэгтэй байсан. Нийтдээ 103 нийгэм-эдийн засгийн түншүүд энэ хүрээнд оролцсон бөгөөд оролцооны тэргүүн туршлагыг дагасан.

Эстоний иргэний нийгмийн хөгжлийн тухай үзэл баримтлал (ЭИНХТҮБ) нь оролцоог дээшлүүлэхэд чиглэсэн хамгийн чухал болон хамгийн өндөр зорилго тавьсан бичиг баримт. 1999 онд, ЭИНХТҮБ-ыг батлахаас өмнө, 10 улс төрийн нам болон иргэний нийгмийн 10 дээвэр /дээд/ байгууллага сайн санаа, чин эрмэлзлэлийнхээ илэрхийлэл болгож хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан. Энэхүү санамж бичигт улс төрийн намууд болон ТББ-ууд Эстонид оролцооны ардчиллыг хөгжүүлэхийн төлөө хамтран ажиллана гэж амласан бөгөөд тэгш эрхийн зарчимд үндэслэсэн түншлэлийг чухалчлан дурдсан. ЭИНХТҮБ-ыг Рижикогу 2002 оны 12 дугаар сарын 12-нд баталсан. Энэ баримт бичиг нь төрийн захиргааны байгууллага болон иргэний нийгмийн байгууллагуудын олон нийтийн (төрийн) бодлого боловсруулан хэрэгжүүлэх, Эстоний иргэний нийгмийг хөгжүүлэх, оролцооны ардчиллыг төлөвшүүлэх, шийдвэр гаргах явцад иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулах зэрэгт гүйцэтгэх харилцан бие биенийгээ нөхөн дэмжсэн үүрэг, функцийг тодорхойлсон. 2003 оны намар ЭИНХТҮБ-ыг хэрэгжүүлэх хамтарсан хороог төр, иргэний нийгмийн байгууллагууд байгуулсан. Уг хорооны нэг ажлын хэсэг хууль тогтоох явцад иргэдийн оролцоог хангах асуудлаар ажилладаг.

2005 оны сүүлээр төрийн байгууллагуудад зориулсан Оролцоог хангах сайн туршлага нэртэй баримт бичгийг ЭИНХТҮБ-д үндэслэн боловсруулсан. 2006–2007 онуудад Төрийн хэрэг эрхлэх газар түүнийгээ олон нийтэд танилцуулсан. Уг баримт бичигт “Хэрхэн оролцуулах вэ? Хэнийг оролцуулах вэ? Оролцоо нь ямар зарчимд суурилсан байх вэ? Зөвлөлдөх үйл явц эхэлж буй гэдгийг хэнд мэдээлэх вэ? Хэрхэн мэдээлэх вэ?” гэх зэрэг асуултад хариулсан байдаг. Энэ баримт бичиг нь дараах зарчимд суурилсан:

- Оролцооны зорилго тодорхой байх
- Хамрагдах ёстой бүх сонирхогч талууд, сонирхлын бүлгүүдтэй зөвлөлдсөн байх
- Оролцоог шийдвэр гаргах үйл явцын эхний үеэс эхлэн хангах
- Оролцооны тодорхой төлөвлөгөөтэй байх
- Харилцаа холбоо жигд, тасралтгүй байх
- Оролцооны дунд үеийн дүгнэлт, үнэлгээг хийж байх
- Үр дүнг мэдээлж байх
- Оролцоо, түүний үр дүнг үнэлж байх

Олон нийтийн оролцооны электроник аргууд

Хүлээн зөвшөөрүүлэхээр тараагдсан бүх хуулийн төслийг *eLaw* (<http://eoi.gus.just.ee>) хэмээх хуулийн төслийг хүлээн зөвшөөрөх электроник системээр дамжуулан нийтэд мэдээлдэг. *eLaw*-гийн зорилго нь аажмаар цаасан дээр хууль боловсруулах явдлыг үгүй болгож хууль тогтоох бүх үйл явцыг дижитал аргаар хийх тогтолцоонд оруулах явдал юм. Өнөөдрийн байдлаар хуулийн төсөл, (төлөвлөсөн хууль, түүнийг хүлээн зөвшөөрөх хугацаа, цагийн хуваарь, төсөл дээр ажиллаж буй ажлын хэсгийн бүрэлдэхүүн, тэдэнтэй холбоо барих мэдээлэл, санал, бодол, асуулт, хайх хэрэгсэл гэх мэт) тэдгээрийн тухай мэдээллийг авах

таатай электроник орчин бүрэлдсэн байгаа. Энэ нь хуулийн төслийг хүлээн зөвшөөрөх, батлах үйл явцыг илүү ил тод, нээлттэй болгож байгаа юм. *eLaw* бол юуны өмнө хуулийн төслийг боловсруулж, түүнийг дэмжин зөвшөөрдөг төрийн албан хаагчдад чиглэсэн. Сонирхлын бүлгүүд мэдээллийг хүмүүсийн нэр, хуулийн төслийн санаачлагч, огноо, баримт бичгийн төрөл, түүний нэг хэсэг зэргээр хайх болон бусад яамдын саналыг унших боломжтой.

“Өнөөдөр би шийднэ” (ӨБШ) гэдэг нь одоогийн байдлаар оролцооны үйл явцыг нэмэгдүүлэхэд илүү чиглэж байгаа. Зөвлөлдөх, мэдээлэх асуудлыг одоохондоо орхигдуулж байгаа. ӨБШ-ийн гол бэрхшээлтэй зүйлс нь бол ашиг тусгүй маш олон санаа, жинхэнэ шийдвэр хангалттай олон биш, иргэд ба төрийн албан хаагч, сонгогдсон төлөөлөгчид хоорондын санал солилцоо хангалтгүй, идэвхтэй оролцогчдын тоо цөөрч буй байдал, хуулийн төсөл, түүний үүдэл санааны тухай суурь мэдээлэл хангалтгүй, албан ёсны шаардлагатай холбоотой шалтгаанаар дэвшүүлсэн санаануудыг буцаах зэрэг явдал юм. Шинжээчид хуулийн төслийн суурь мэдээллийг өгөх, түүний үндэслэлийг тайлбарлах болон иргэд дэвшүүлсэн санааныхаа тухай тэр даруй хариу авах боломжгүй. ӨБШ нь иргэдэд шийдвэрт нөлөөлөх боломжийг олгох оролцооны орчинг бүрдүүлэхээс илүү ярилцлагын талбар болсон.

Тэмисын гарц нь илүү оролцоонд чиглэсэн боловч хуулийн төслийн тухай мэдээллийг өгдгөөрөө хэрэглэгчдэд мэдээлэх функцийг нэлээн сайн биелүүлдэг. Энэ форумын гол давуу тал нь мэдээллийг системтэйгээр цуглуулж түгээдэг, бэрхшээлтэй асуудлыг энгийн, ойлгомжтой хэлбэрээр тодорхойлдог, шийдвэр гаргагчид болон хуулийг санаачлагч, хуульч, бусад шинжээчид хэлэлцүүлэгт оролцдог, санаанууд нь илүү бодит байдаг, сонирхлын бүлгүүдийг сайтар тодорхойлж оролцуулахыг хичээдэг зэрэг явдал юм. Тэмис Парламентад өргөн барьсан хуулийн төслүүд дээр мөн хэлэлцүүлэг зохиодог. Тэмисын гол дутагдал гэвэл түүний хэрэглэгчдийн тоо цөөн байдаг болон яамдаас иргэдийн санаанд эргээд санал бодлоо өгөх явдал хязгаарлагдмал байдаг юм.

Ерөнхийдөө Эстонид электроник оролцооны оролдлогууд буурч байгаа. Үүнийг хөгжүүлэхийн тулд улс төрийн зориг эрмэлзлэл болон нөөц баялаг шаардлагатай. Гэвч үүнийг хөгжүүлэхэд шууд үүрэг хүлээсэн этгээд гэж байхгүй. Он-лайн хэлэлцүүлэг, зөвлөлтөөний төвлөрсөн веб сайт одоогоор байхгүй. Яамдын веб сайтуудын тухай мэдээлэл тархай бутархай, хэлэлцүүлгийн хэрэгслүүд нь дутагдалтай. Тиймээс өнөөдрийн байдлаар Эстонид он-лайн зөвлөлтөөн жинхэнэ утгаар бол явагддаггүй. Электроник оролцоог хангахад хэлэлцүүлж байгаа бодлогын асуудлыг шийдвэрлэх альтернатив арга замын тухай мэдээллийг хуулийн төсөл юм уу бодлогын баримт бичиг хэлбэрээр өгөх чадвартай хэрэглэгчдэд ээлтэй, сайн чанарын хэрэгслүүд шаардлагатай. Мөн хуулийн төслийг танилцуулахдаа суурь мэдээлэл, гол өөрчлөлт, асуудлын тойм, иргэд, сонирхлын бүлгүүд зэргээс чухам ямар хэсэг дээр нь хувь нэмэр оруулахыг хүсч байгаагаа тодорхой заасан зэрэг мэдээллийг өгөх хэрэгтэй.

Төрийн албан хаагчийн төгс түнш⁴²:

- Шинэ бодлого, хуулийн төсөл дээр санал, бодлоо идэвхтэй илэрхийлдэг
- Дүн шинжилгээнд үндэслэсэн мэдээлэл өгөх чадвартай
- Тухайн салбарт үзүүлэх нөлөөг үнэлэх чадвартай
- Итгэл даах чадвартай
- Гишүүдийнхээ эрх ашгийг төлөөлж чаддаг
- Бусад ТББ-тай хамтран ажиллаж чаддаг
- Хувийн эрх ашгаас гадна нийтийн эрх ашгийг харж чаддаг
- Төлөөлөл сайтай
- Бусад улс орны туршлагын тухай мэдээллээр хангах чадвартай

ТББ-ын төгс түнш:

- Зөвлөлдөөний тэргүүн туршлагыг (зөвлөмжүүдийг) дагадаг
- Тухайн асуудлаар тодорхой мэдээлэл өгөх чадвартай
- ТББ-ыг тэгш эрх бүхий түнш хэмээн ойлгодог
- ТББ-ын бүхий л асуултад хариулдаг
- Итгэл даах чадвартай
- Төрийн бусад байгууллага болон бусад ТББ-тай ажиллаж чаддаг
- Тухайн бэрхшээлтэй асуудлыг өргөн хүрээнд харж чаддаг
- ТББ-ын санал, бодлыг анхааран авч эргээд тэдгээрийн тухай мэдээлдэг.

42 Elo Tuppits, Ministry of Economic and Communication Affairs

АСУУЛТ -ХАРИУЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

УНДРАЛ /Ардчиллын Боловсролын Төв/

Эстоний илтгэгчээс нэг асуулт асууя. Миний мэдэхээр Эстони улс нь 2004 онд Иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлалын асуудал гэсэн баримт бичиг боловсруулаад парламентаараа батлуулсан гэсэн. Энэ баримт бичгийг боловсруулахад иргэдийн оролцоо ямар байсан бэ? Мөн энэ баримт бичиг хэрхэн үйлчилж байдаг вэ?

ЖОН ЭНДЕР

Тиймээ. Парламент, ТББ-ууд хэрхэн хамтарч ажиллах тухай суурь баримт бичиг юм. Арай ерөнхий болсон. Энэ баримт бичгийн дагуу төр, ТББ-уудын хамтарсан зөвлөл байгуулсан. Зарим үр дүнд хүрсэн. Канад, Дани, Британид бас иймэрхүү баримт бичиг байдаг. Латви, Хорватад ийм хууль боловсруулж байгаа.

ЧИНЧУЛУУН /Монголын эмэгтэйчүүдийн сан/

Манайд ТББ-ууд тодорхой асуудлаар хуулийн санаачилга гаргадаг боловч хууль тогтоогчдын зүгээс хоолонд оруулах, гадаадад явуулах зэргээр шан харамж шаардах явдал нэлээд тулгардаг. Польшид лоббийн тухай хууль байдаг гэсэн. Өөр ямар парктик байна вэ?

ПОЛЬШИЙН ТӨЛӨӨЛӨГЧ

Энэ бол онолын хувьд ерөнхийдөө авилгалын асуудал байна. Манай лоббийн тухай хуульд мэргэжлийн, энгийн гэсэн хоёр хэлбэрээр лобби явуулахыг заасан байдаг. Мэргэжлийн лоббийн үйл ажиллагаанд тодорхой шан харамж байдаг байх. Харин энгийн лобби бол нөлөөллийн чанартай байдаг. Тиймээс ТББ-ууд ямар нэг үнэ төлбөргүй, нөлөөллийн лобби хийх ёстой юм.

Х. ОЮУНЦЭЦЭГ /Хуульч эмэгтэйчүүдийн холбоо/

Парламентаар хуулийн төсөл хэлэлцэх явцад иргэний нийгмийн хөдөлгөөнүүд, ТББ-ууд албан ёсоор өөрсдийнхөө байр суурийг илэрхийлэх боломжийг хуульчилсан ямар улс орон байна вэ?

ПОЛЬШИЙН ТӨЛӨӨЛӨГЧ

Төр, ТББ-дын зөвлөлдөх зөвлөл гэж байдаг. Энэ зөвлөлд Хуулийн яам, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөгчид ордог бөгөөд аливаа хуулийн төслийн

талаар урьдчилан санал солилцож зөвлөлддөг. Энэ тухай уг хуулийн төслийг хэлэлцэх явцад нэгдсэн санал дүгнэлт хэлбэрээр танилцуулдаг.

Ж. ЭРДЭНЭЧИМЭГ /Монголын эмэгтэйчүүдийн холбоо/

Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явцад иргэд, олон нийтийг идэвхтэй оролцуулах нь парламентаас батлан гаргаж байгаа хууль тогтоомжууд иргэдийн эрх ашигт нийцсэн, нийгэмд шударга ёсыг тогтоосон зөв зүйтэй хууль болоход гол үр дүн нь оршдог гэж бид боддог. Хэрвээ энэхүү үйл явцад иргэд, иргэний нийгмээ бага оролцуулаад, оролцуулсан ч тэдний санал дүгнэлтийг үл ойшоон, улмаар буруу хууль эрх зүйн орчин бүрдүүлсэн парламенттай хэрхэн яаж хариуцлага тооцдог вэ? Ийм жишээ эдгээр орнуудад байна уу? Асуултаа тодотгохын тулд би өнөөдөр манай нийгмийн амьдралд ид тулгамдаад байгаа нэг жишээг хэлье. Энэ нь юу вэ гэвэл хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааны талаархи хууль, эрх зүйн орчныг манай парламент бүрдүүлсэн. Үүний дүнд өнөөдөр хэдэн арван хоршоо дампуураад, 15 хүн амиа хорлоод, 20 гаруй хүн солиороод, 100 гаруй гэр бүл салаад, 40- өөд өрх айл орох оронгүй болоод иргэд өмч хөрөнгөөрөө, эрүүл мэндээрээ, сэтгэл санаагаараа хохирсон нийгмийн эмгэнэл явагдаж байна. Гэтэл тухайн үед тэр хуулийн төслийг хэлэлцэх явцад иргэд, иргэний нийгмийн төлөөлөгчид бид саналаа хэлж байсан. Хадгаламж зээлийн хоршоод зөвхөн гишүүдээ үйлчлэх тухай, хөндлөнгийн болон дотоодын хяналтын тухай хууль боловсруулах ажлын хэсэгт яригдаж байсан боловч яг Парламентын түвшинд эдгээр санал ороогүй, тэр битгий хэл эдийн засаг, хууль эрх зүйн талаас ямарч чадамжгүй Санхүүгийн хороо гэсэн байгууллагад хариуцуулсан. Энэ бүхэн болохгүй байна гэдэг нь харагдаад нотлогдоод байхад ч хадгаламж зээлийн хоршоод үйл ажиллагаагаа явуулсаар байсан бөгөөд дээр нь ямар эх үүсвэрээс гарсан нь мэдэгдэхгүй олон тэрбум төгрөг хадгаламж зээлийн хоршоодоор дамжин өндөр хэмжээний хүү авч үндсэндээ эдгээр хоршоод дампуурсан байгаа. Тэгвэл ийм хууль гаргасан парламент өнөөдөр ямар хариуцлага хүлээх ёстой вэ? Энэ талаар бусад оронд ямар туршлага, жишээ, механизм, тогтолцоо байна вэ?

МИКАЛ СТИЧКА

Манайд бас ийм зүйл болсон. ТББ-ууд энэ хуулийн ард хэн байна вэ гэдгийг шалгуулахаар шүүхэд хандсан. Түүнд оролцсон бөгөөд холбоотой хүмүүсийн нэрсийн жагсаалтыг гаргаж тэднийг дараагийн сонгуульд нэр дэвшүүлэхээс татгалзахыг уриалсан.

Ж.НАРАНТУЯА /УИХ-ын Тамгын Газар/

Баярлалаа. Энэ хэсгийн хуралдаанаа дүгнэж хэлэхэд аль ч улсад, манайд ч гэсэн иргэдийн оролцоог хангана гэсэн бодлого тууштай байдаг юм байна. Түүнийг зохицуулах гэж хүчин чармайлт гаргадаг, энэ нь зарим улс оронд багагүй амжилтад хүрсэн жишээтэй байна. Манайд ямар байгааг бид өөрсдөө сайн мэдэж байгаа. Цаашид хуулиа амьдралд хэрэгжүүлдэг болох, хуулийг боловсронгуй болгохын төлөө ажиллах ёстой юм байна. Энэ бол бидний эрхэм зорилго байх нь ээ. Ингээд хуралдааныхаа “ТББ-дын оролцооны зохицуулалт” гэсэн дараагийн хэсэгт оръё.

ХУРАЛДААН 2 - ТББ-ЫН ОРОЛЦООНЫ ЗОХИЦУУЛАЛТ

ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ, ХЭЛЭЛЦЭХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ТББ-ЫН ОРОЛЦОО

*Ж. БАЯРЦЭЦЭГ
/Нээлттэй Нийгэм Форумын менежер/*

Монголын ТББ-ууд

Монгол улсын ТББ-уудын товч статистик тоо баримт дурдахыг хүсч байна. Монгол улсын хувьд ТББ-ууд Монголын нийгмийн нэлээн идэвхтэй хэсэг болж хөгжсөн нийгмийн салбар бөгөөд олон иргэдийг хамруулж чадсан. 2007 оны статистикаар ХЗДХЯ-нд бүртгэлтэй ТББ-ууд 6000 гаруй байгаа бөгөөд сүүлийн үед байгуулагдан нэмэгдэж байгаа ТББ-уудын тоо нэлээн өсч байна. Жилд дунджаар 800-900 ТББ бүртгэгдэж байгаа бөгөөд үүнийг хувааж үзвэл сард 50-100, 7 хоногт 12-25 ТББ шинээр төрж байна гэсэн үг юм. ТББ-уудын үйл ажиллагааны гол чиглэлүүд нь спорт чөлөөт цаг, нийгмийн тодорхой мэргэжлийн салбар байгаа нь Ардчиллын боловсрол төвтэй хамтран явуулсан судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Оролцоо яагаад чухал вэ?

Бид ардчилсан нийгэмд амьдарч байгаагийн хувьд оролцоотой байх нь зайлшгүй гэдэг нь тодорхой. Ялангуяа бодлогын үйл явц нь ил тод байх ёстой. Ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа тэр бүх бүлгийг оролцуулж тухайн асуудал дээр зөвшилцөж гэмээ нь ил тод байна гэж хэлж болох бөгөөд аль болох нийгэмд байгаа сонирхлын бүлгүүдийг хамруулж оролцуулснаар ил тод байх нөхцөл бүрддэг байна.

Бодлогын үйл явц дахь ТББ-ын оролцоо

Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явцад иргэд оролцох, өөрсдийн санаа бодлоо илэрхийлэх эрхтэй. Түүнчлэн өөрсдийн ашиг сонирхлыг төлөөлсөн бүлгүүдээр дамжуулж саналаа илэрхийлэх нь цаг хугацаа, зохион байгуулалт талаасаа илүү үр дүнтэй байна. Нөгөө талаас Монголын ТББ-ууд ерээд оноос хойш нийгмийн эмзэг асуудлаар маш их туршлага, ур чадварыг хуримтлуулсан байдаг. Энэ нь магадгүй

төрд байдаггүй юм уу, дутагдалтай асуудал гэдэг утгаараа тэр туршлагыг тухайн гаргаж байгаа шийдвэрт тусгаж оруулснаар сайн бодлого гарах үндсэн нөхцөл болдог. Жишээлбэл, Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулинд ТББ-ын туршлага, ур чадвар маш их хэрэг болсон.

Энэхүү илтгэл нь хоёр үндсэн хэсэгтэй:

1. Эрх зүйн орчин – ТББ-уудын оролцох ямар сувгууд байна, түүнийг хуулиудад юу гэж заасан байна вэ?
2. Бодит байдал ямар байна вэ?

ТББ-ын оролцооны эрх зүйн орчин

Зөвхөн ТББ-уудын бус ер нь оролцоог зохицуулж байдаг дөрвөн хууль байдаг юм байна:

1. ХУУЛЬ, УИХ-ЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ хууль
2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ хууль /2006 онд шинэчилж найруулсан/
3. 1997 онд батлагдсан бидний гол баримталдаг хууль- ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ хууль
4. АВИЛГЫН ЭСРЭГ ХУУЛЬ 2006

Хууль УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд яг ТББ-ын оролцооны талаар тодорхой механизм сувгийн тухай заагаагүй байна. Энд гол хоёр заалт байна.

9.9. Хуулийн төсөл боловсруулах явцад холбогдох мэргэжлийн байгууллага, шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага болон бусад байгууллага, иргэдээс санал авч төсөл боловсруулахад харгалзан үзэж болно.

18.3 зүйл “Хууль санаачлагч хуулийн төсөлд холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага, иргэний саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгана”

Өөрөөр хэлбэл байгаа хоёр заалт нь ТББ-уудад эрх, боломж олгосон заалт биш байна.

Шууд бус заалтууд

- 18.4 Хууль санаачлагч хуулийн төсөлд санал авахдаа санал авахаар нэр зааж хүргүүлэх, эсхүл уулзалт, ярилцлага зохион байгуулж болно.

- 6.1.3. байгууллагын удирдлагатай нь тохиролцсоны үндсэн дээр холбогдох эрдэмтэн, мэргэжлийн хүнийг хуулийн төсөл боловсруулах ажилд татан оролцуулах;
- 6.1.5 хуулийн төсөл, түүнийг боловсруулах ажлын явцын талаар шаардлагатай гэж үзвэл олон нийтэд мэдээлэх;
- 6.1.6 иргэн, байгууллагаас ирүүлсэн хуулийн төслийн талаархи саналыг Улсын их хуралд уламжлах, Үндсэн чиглэлд тусгуулах;
- 7.1.2 холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

Референдумыг талаар энэ хуульд байгаа заалт нь:

Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухайд:

- 19.1. Шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч нь нийгмийн нэн чухал харилцааг зохицуулахаар санаачилсан хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай саналаа Улсын Их Хуралд оруулж болно.
- 19.2. Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай оруулсан саналыг Улсын Их Хурал чуулганаар хэлэлцэж, гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд төслийг ард нийтээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд хэлэлцүүлэх хүрээ болон түүнтэй холбогдон гарах зардлыг хэрхэн санхүүжүүлэхийг тодорхой заасан байна.
- 19.3.1. нийт ард түмнээр;
- 19.3.2. нийгмийн тодорхой бүлэг, ажил мэргэжлийн хүрээнд;
- 19.3.3. тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ хууль 2006 он

- 19.2.9. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар санал, дүгнэлт гаргахад туслалцаа авах, мэргэжлийн байгууллага болон олон нийтээс санал авах зорилгоор шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

Уг хуульд ТББ гэж дурдаагүй харин мэргэжлийн байгууллага гэж оруулсан байна.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ хууль 1997 он

9 дүгээр зүйл. Төрөөс төрийн бус байгууллагатай харилцах

“5. Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас гаргах шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саналыг нь үндэслэн төрийн бус байгууллагыг оролцуулж болно. “

Энд “оролцуулж болно” гэсэн нь нэг талаар оролцуулж болно гэж байгаа ч, нөгөө талаар оролцуулахгүй байсан ч болно гэж үзэхээр байна.

АВИЛГЫН ЭСРЭГ ХУУЛЬ 2006

- 5.1.1. Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль,
Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцлөөр хангах;

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

2004-2008 он

Тус мөрийн хөтөлбөрт нэн тэргүүний зорилт хэмээн хамгийн эхэнд Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх гэсэн том зорилт тавьсан байна.

Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн зорилт нь:

- Иргэддээ үйлчлэх төрийн байгууллага, албан хаагчдын хариуцлага, чадавхийг дээшлүүлж, шийдвэр гаргах бүх түвшинд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хэвшүүлэн төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргах; гэж заасан байгаа нь одоо 2008 он болж байгаа тул тодорхой ажил хийгдсэн байх гэж найдаж байна.

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГА, ИРГЭНИЙ ОРОЛЦОО

- Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах явцыг нээлттэй болгож, дээрх асуудлыг аль болох ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэдийн санаа бодолд тулгуурлаж шийддэг жишиг тогтооно.

АШСТО-уудын олон улсын V бага хурал 2003 он

- Улаанбаатарын тунхаглал “Бид иргэний нийгэм болон засгийн газар хоорондын түншлэлийг дэмжин урагшлуулах болно. Энэ зорилгоор бид орон нутгийн болон үндэсний түвшинд шийдвэр гаргах үйл явцад иргэний нийгмийг өргөнөөр татан оролцуулах үүрэг хүлээж байна.”

Энэхүү тунхагт Монгол улсын Засгийн Газар болон бусад улсын засгийн газрууд нэгдэн орсон байдаг.

Бодлогын баримт бичиг болоод эрх зүйн орчны хувьд ийм байна.

Бодит байдал

Түрүүн хэлсэнчлэн хуулийн заалтууд бүрхэг, хэрэгжүүлэх механизмууд нь тодорхойгүй, өгч болно, болохгүй, харгалзан үзвэл үндэслэлтэй гэх мэт заалтууд нь ТББ-уудад боломж олгохоосоо илүүтэй тухайн шийдвэр гаргагчдын үзэмжээр шийдэх бололцоог олгож байна гэж үзэх үндэслэлтэй.

Хууль гарснаар, хуулинд тусгагдсанаар нэгдсэн жишиг стандарт байдлаар явагдах боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл хэн нэгэн шийдвэр гаргагчийн хүсэл зоригоос хамааралгүйгээр энэ асуудал нь ямар нэгэн механизм сувгуудаар хэлэлцэж санал зөвлөгөө авч байж явагдах жишиг стандарт нөхцөл байдал бүрдэж өнөөгийн нөхцөл шиг алаг цоог байдлыг арилгах боломж бүрдэх байх.

Нээлттэй Нийгэм Форумын шугамаар бодлогын судлаач Бямбажав “Шийдвэр гаргахад ТББ-уудын оролцоо” гэсэн сэдвээр судалгаа хийсэн. Энэ судалгаагаар:

- 1992-2006 оны ажлын хэсэгт иргэд, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулсан тохиолдол 20 гаруй байсан. Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт 400 гаруй хууль байдаг. Төлөөллийн бүрэлдэхүүнийг харахад тухайн салбарын мэргэжилтэн, тухайн сэдвээр лекц уншдаг эрдэмтдийг иргэний нийгмийн төлөөлөл нэрийн доор оруулах юм уу эсвэл уламжлалт байгууллагуудыг оролцуулж төлөөллийг сонгосон байна. Жишээлбэл, Ахмадын зөвлөл, Үйлдвэрчний эвлэл гэх мэт.

- Ихэнх тохиолдолд шийдвэр гаргагчдын зөвлөлдөх, санал дүгнэлтийг нь сонсох хэрэгцээгээр бус харин сонирхогч талуудын сонирхлоор хийгддэг.

Байдлыг харахад ихэнхдээ холбогдох яамд, агентлагийн санал аваад тухайн асуудал дээр санал бодол авсан гэсэн үндэслэл бүрдүүлдэг байна.

Хийгдсэн санаачлагууд

Ерөнхийдөө оролцоог хангах гэсэн тодорхой алхмууд тал талдаа хийгдэж байна. Үүнд:

- ТББ-уудын идэвхтэй нөлөөллийн үйл ажиллагаа: Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль, Ашигт малтмалын тухай хууль..., Хүний эрх хөгжил төвөөс орон нутгийн иргэдийн оролцооны асуудлаар нэлээн зохион байгуулалттай нөлөөллийн стратеги төлөвлөгөө боловсруулан оролцож байсан.

- Байнгын хорооны нээлттэй хэлэлцүүлэг, албан сонсгол 2006 /Ашигт малтмалын тухай хууль/

- Нийгмийн бодлогын байнгын хороон дээр ТББ-тай зөвлөлдөх бүлэг - Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан тэргүүтэй бусад эмэгтэйчүүдийн ТББ-уудаас нийгмийн байнгын хорооны дарга байх үед нь Ламбаа гишүүнийг оролцуулан ажиллуулж байсан туршлага байна.

- Хэвлэл мэдээлэл – Авилгалын эсрэг хуулийг олон нийтээр хэлэлцүүлэхийн тулд хуулийн төслийг өдөр тутмын сонинд хэвлэж байсан...

- Хуулийн төслийг вэбсайтад байрлуулах

Гэхдээ эдгээр иргэдийг оролцуулсан тохиолдлууд ихэнхдээ ТББ-ууд юм уу олон улсын болон донор байгууллагуудын санаачлага байдаг байна. Ихэнх

тохиолдолд төрийн санаачлага биш байгаа учраас өөрийн бүтээгдэхүүн биш байх үндэслэлтэй.

Асуудал

- Хуулийн заалтууд бүрхэг, хэрэгжүүлэх механизм, хариуцах хүн тодорхойгүй
- Нэгдсэн зарчим стандарт байхгүй, тухайн УИХ-ын гишүүдийн хүсэл зориг, ТББ-ын санаачлага, чадавхи, стратеги, асуудлын онцлогоос хамааралтай байдаг нь нэгдсэн жишиг стандартгүй байдаг гол үндэс нь юм.
- Ихэнх санаачлагууд ТББ, олон улсын байгууллагын чармайлт, дэмжлэгээр хийгдсэн.

Оролцооны нэг гол урьдач нөхцөл нь мэдээлэл юм. Тухайн хэлэлцэж буй асуудлын талаарх мэдээлэл, хуулийн төсөл, хэлэлцэж буй явцын талаар мэдээлэл байхгүй нөхцөлд ТББ байтугай иргэд ч оролцох боломжгүй юм. Мэдээлэл олж авах суваг нь тодорхойгүй байна. Жишээлбэл: Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэлэлцүүлж байхад манай байгууллага санаа тавиад “Нээлттэй засаглал” вэб сайтыг олон удаа сайтар үзсэн боловч хуулийн төсөл, хэлэлцэж буй явц, хуваарь, засгийн газрын хуралдааны протокол гэх мэт байхгүй байсан. Хуулийн төсөл, хэлэлцэж буй асуудал, яамд, засгийн газрын түвшинд хэлэлцэж байгаа олон хувилбар болон дэлгэрэнгүй протокол, өөрчлөлт, саналууд зэргийг байнга тогтмол мэдээлж байх нь ТББ-уудад аргументаа бэлтгэх, стратегийн нөлөөллөө боловсруулахад хэрэгцээтэй байдаг. Вэбсайтын мэдээлэл хожим тавигддаг, заримдаа огт байхгүй байдаг нь оролцоог хангаж чадахгүй байгаа нэгэн том шалтгаан юм.

Оролцооны албан бус хэлбэр

Нэгэнт оролцооны албан суваг байхгүй учраас ажил хэргийн болон хувийн холбоонд тулгуурлан биечлэн уулзах, утсаар ярих, бичгээр харилцах гэх мэт сувгуудаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулахаас өөр аргагүй байдаг. Хурлын протокол, хуулийн төсөл зэрэг нь вэбсайт дээр байхгүй учраас яалтгүй өөрсдийн танил талаа ашиглахад хүрч байна. Ийнхүү ил тод байдлыг хангахгүй далд хэлбэрээр хийгдэж байгаа нь хэдийгээр бид нийтийн ашиг сонирхлыг төлөөлж ажиллаж байгаа ч нийгэмд хардалтыг төрүүлдэг. Энэ нь хэлхээ холбоо, танил сайтай аль нэгэн талд илүү давуу боломж олгож харин шийдвэр гаргагчидтай танилын холбоо хэлхээ байхгүй боловч тухайн асуудлаар нэлээн нухацтай ярьж байгаа ТББ-уудад саналаа хэлэх, аргументаа тавих, оролцох боломж бараг байхгүй гэхэд болно. Өөрөөр хэлбэл иргэний нийгмийнхэнд саналаа хэлэхийн тулд “цонх хагалах”, “гудамжинд гарах” буюу жагсаал, цуглаан, эсэргүүцлийг хэрэгслээ болгохоос өөр арга үлддэггүй.

Цаашид юу хийх вэ

Бидний зорилго бол тодорхой. Мэдээлэх, зөвлөлдөх үйл явцыг ил тод, нээлттэй болгох болон оролцоог хангах ёстой. Үүний тулд ТББ-уудын оролцоог албан ёсны болгоод тэдгээр албан сувгуудыг хуулинд маш тодорхой буюу яамдын түвшинд тухайн байгууллагын үзэмжээр бус харин хэн хариуцах, хэзээ яаж хэрэгжүүлэх, хаанаас төсөв санхүүжилт авах, хэрэгжүүлэх механизм, төсвийг оруулах зэргийг тодорхой заасан хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх нь чухал байна.

Нийтийн ашиг сонирхлыг хөндөж байгаа асуудал бүр дээр нээлттэй сонсгол, хэлэлцүүлгийг байнгын болгох шаардлагатай гэж үзэж байна.

ТББ-уудын өргөн төлөөллийг хамруулах шаардлагатай. Судалгаанаас харахад ихэнх тохиолдолд уламжлалт ТББ-ууд юм уу мэргэжлийн, салбарын болон чиглэлийн байгууллагуудыг оролцуулдаг нь өргөн төлөөллийг хамруулж чаддаггүй байна. Иймд нийгмийн маш өргөн ашиг сонирхлыг төлөөлөх үүднээс зөвхөн мэргэжлийн салбарын байгууллагыг хамруулах бус аль болох өргөн төлөөллийг оролцуулах нь зүйтэй.

Мэдээллийг нээлттэй болгох үүднээс вэбсайтаа тогтмол шинэчилж, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийг шинэ мэдээллээр хангаж байх шаардлагатай байна. Интернет бол ихэнх ТББ-уудын хувьд мэдээлэл авах гол зэвсэг нь учраас хэлэлцэж буй хуулийн төслүүдийг болон цагийн хуваарь зэргийг цаг тухайд нь УИХ-ын вэбсайт, яамдын вэб дээр тогтмол шинэчилж тавьж байх нь ТББ-уудын оролцоог хангах, мөн үйл ажиллагаагаа төлөвлөхөд хэрэгтэй. Нэгэн жишээ хэлэхэд маш зузаан хуулийн төсөл авчраад хоёр хоногийн дараа саналаа өгнө үү гэж байсан тохиолдол гарч байсан. Хуулийн төсөлд санал оруулахын тулд маш нухацтай судалгаа хийж зохион байгуулалттай саналаа өгөх нь аль аль талдаа хэрэгтэй байх болно. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

РУМЫН УЛСЫН ТББ-УУДЫН ОРОЛЦОО

КРИСТИНА РЕНЕРТ

*/Румын улсын Нээлттэй нийгэм хүрээлэнгийн
төрийн захиргааны шинэчлэлийн хөтөлбөрийн зохицуулагч/*

Зүүн Европ дахь ил тод байдал болон зөвлөлдөөнийг хэрхэн зохион байгуулж байгаа талаар эерэг зүйл ярихыг хүслээ. Тэгээд Румын улсын Мэдээллийн эрх чөлөөний хуулийн амжилтын тухай ярьж бодлоо. Та бүхэн мэдэж байгаа. 1989 оноос хойш коммунист үзэл суртал, социалист бодлогоосоо татгалзаад бид маш олон өөрчлөлтийн нүүрийг үзсэнээс хойш нэгэн том ялалтаар өөрчлөлтийн үйл явц өрнөсөн хэвээр байна гэж хэлэхэд их таатай байна. Тэрхүү том ялалт нь Румын хэдэн хоногийн өмнө буюу энэ оны 1 дүгээр сарын 1-нд Европын Холбооны гишүүнээр элссэн явдал байгаа.

2001 онд хэд хэдэн төрийн бус байгууллагын тэмцлийн үр дүнд бид төрийн захиргааны болон засгийн газрын харъяа байгууллагуудаас төрийн бус байгууллагууд болон тухайн орны иргэн бүр мэдээлэл авахыг хангасан Мэдээллийн эрх чөлөөний хуулийг баталснаас хойш Румыний бүх төрийн бус байгууллагын хамгийн өргөнөөр хэрэглэдэг хууль болсон байгаа. Сайн зүйл нь манай оронд төрийн бус байгууллага гэхээр иргэдийн эрх ашгийн тухай ярьж байна гэдгийг хүн бүр ойлгодог. Гэхдээ Нээлттэй нийгмийн хүрээлэн нь төрийн бус байгууллагад багтдаггүй юм шиг байдаг. Байнга сонин хэвлэлээр байгууллагыг маань “Ашиг сонирхлын лобби” хэмээн зандах нь олонтаа тохиолддог. Гэвч ерөнхийдөө ихэнх төрийн бус байгууллагууд мэдээллийг өгөхийг хүсээгүй төрийн захиргааны байгууллагуудын эсрэг /энд би эсрэг гэдгийг зориуд цохон тэмдэглэе/ Мэдээллийн эрх чөлөөний хуулийг ашиглаж чадсан байгаа.

Та бүхэн мэдээллээ нуусан, өгөхийг хүсээгүй төрийн захиргааны байгууллага болон албан тушаалтнуудын эсрэг энэхүү хуулийг төрийн бус байгууллагууд хэрхэн хэрэглэж чадсан, яаж ашиг шимийг нь хүртсэн талаар асуух байх. Амьдрал дээр гарсан хэдэн жишээнээс харахад маш энгийнээр чадсан гэж хариулмаар байна. Төрийн бус байгууллагууд мэдээллийг нээлттэй хүртээлтэй болгох үүргээ биелүүлээгүй хэдэн төрийн захиргааны байгууллагыг шүүхэд өгсний ачаар тэрхүү мэдээллээ хэдхэн долоо хоногийн дараа олж авч чадсан юм. Тэгэхээр хэрэв хууль хэрэгжихгүй байвал жаахан шахалт л үзүүлэхэд тэр хууль хэрэгждэгийн жишээ тод болсон.

Мэдээллийн эрх чөлөөний хуулийн заалтуудын хувьд бусад орны шинжээчдийн ярьснаас ялгаатай зүйл манай хуульд байхгүй боловч цаг хугацааны хувьд нэгэн

зүйлийг тодруулахад төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнууд олон нийтийн ашиг сонирхолд хамаарах мэдээллийг хүссэн хүсэлт авснаас хойш гуч хоногийн дотор өгөх үүрэгтэй байдаг. Мөн энэхүү заалтын үр дүнд та бүхний дурьдаж байсан интернетэд мэдээллийг байрлуулах гэх мэт олон нийтэд мэдээллийг хүртээлтэй болгох бусад чухал арга хэмжээг нэвтрүүлснээр Төлөөлөгчдийн танхим хуулийн санаачлага төслүүдээ өөрийн вэбсайт дээр нийтлэх болсон. Тиймээс төрийн бус байгууллагуудын шахалтын улмаас ил тод байдал бий болж, олон нийт, ямарваа сонирхсон иргэн Сенат болон Төлөөлөгчдийн танхимд ямар ямар хууль боловсруулах үйл явц явагдаж байгаа талаар харах боломж нээгдсэн.

Бусад илтгэгчдийн хэлсэн зүйлийг дахин давтахгүйн тулд эдгээр арга хэмжээ нь төрийн бус байгууллагууд болон иргэдтэй зөвлөлдөх, тэднийг оролцуулах үйл явцын үндэс байсан гэдгийг хэлье. Бид энэхүү хуулийг баталсан ба санаачлагатай төрийн бус байгууллагууд үүнийг хэрэглэсний үр дүнд миний хамтран зүтгэгчийн танилцуулсан 2003 оны олон нийтийн оролцоо, зөвлөлдөх үйл явцыг зохицуулсан хуулийг батласан. Үүн дээр та бүхний өмнө нь асуусан асуултуудтай холбоотойгоор нэгэн зүйлд хариулмаар санагдлаа. Төрийн бус байгууллагууд ямар арга хэлбэрээр оролцооны үйл явцад хамрагдаж ямарваа хуулийн төсөлд санал өгөх, нэмэх, өөрчлөх хүсэлтэй бол түүнийг нь хууль боловсруулах тогтоох үйл явцад яаж тусгах вэ? Үүний хариулт нь нэгэн ерөнхий нэр томъёо болох олон нийтийн бодлого боловсруулах үйл ажиллагаа юм. Энэ нь сүүлийн гурван жилд Румынд бат нэвтэрсэн арга барил болоод байгаа.

Олон нийтийн бодлого боловсруулах үйл ажиллагаа гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь төрийн бус байгууллагууд Засгийн Газрын албан тушаалтнуудын санал болгож буй бүхий л төсөлд өөрсдийн арга барил, санал бодлыг өгнө гэсэн үг. Эдгээр саналын зарим нь хуулийн төсөлд тусгалаа олж зарим нь тусгалаа олохгүй ч төрийн захиргааны байгууллагуудын санаачилсан тодорхой төслүүд, тодорхой байгууллагын чих сонорт хүрнэ гэсэн үг. Өмнөх илтгэгчид мөн дурьдсанаар хэвлэл мэдээллийн байгууллагуудын үүрэг үүнд маш чухал үүрэг гүйцэтгэнэ. Учир нь төрийн бус байгууллагууд асуудлыг шийдвэрлэх шинэлэг арга хэлбэрийг санал болгосон ч, олон нийтийн бодлого боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулсан ч хэрэв Засгийн газар, эсвэл албан тушаалтнууд тэр саналыг чинь хүлээж авахгүй бол яах ёстой вэ гэсэн асуулт гарна. Үүний хариулт маш энгийн. Бид Ил тод байдлын тухай хуулийг хэрхэн хэрэгжүүлсэн аргууд болох хэвлэл мэдээллийн байгууллагаар цацах, шахалт үзүүлэх явдал. Улс төрчид шуугианаас айдаг учир хэвлэл мэдээллээр сенсаац, шуугиан дэгдээх талаас нь бус амьдралд хэрэгжихүйц арга барилынх нь хувьд би ярьж байна.

Бид лоббиг зохицуулсан хууль тогтоомжийн талаар сонирхож байгаа бол хариулт хэлж чадахгүй нь. Энэ үйл ажиллагааны талаар эрх зүйн ямарваа нэгэн зохицуулалт одоогоор бий болоогүй учир хэн нэгнийг нууц ашиг сонирхлоо хөөн ямарваа нэгэн зүйл хийж байна хэмээн гүжирдэх боломжгүй. Гэвч бид төрийн захиргааны албан тушаалтнуудаас мэдээллийг чөлөөтэй авч болох учир төрийн бус байгууллагуудад шинэ шинэ боломж, арга зам нээгдсэн. Зөвлөлдөөн гэдэг нь үнэгүй нөөц бололцоо, харин одоо энэ механизм нь жинхэнэ ёсоор хэрэгжиж байгаа.

Ерөнхий Сайд хэд хэдэн төрийн бус байгууллагуудыг Румыний ирэх таван жилийн эдийн засаг, хууль боловсруулах стратегийг төлөвлөх үйл явцад урьсан тухай би өмнө нь дурьдаад өнгөрсөн. Энэ нь тэр болгон хэрэгждэггүй хуулийн үг үсгээс цааш дэвшсэн оролцооны үйл явцын хэрэгжилтийн хамгийн том амжилт хэмээн би боддог.

Тулгардаг бэрхшээлийн хувьд бидэнд тийм зүйл тохиолддоггүй гэж хэлэхийг би их хүсэж байгаа боловч үнэн нөхцөл байдал тийм биш нь харамсалтай. Мэдээж ямарваа түвшинд хууль хэрэгжиж байгаа хэдий ч хуулийг хөсөрдүүлэн, хэрэгжүүлэхгүй байх маш олон арга зам бий. Би нэг энгийн жишээ өгүүлье. Мэдээллийн эрх чөлөөний хуулийн нэг заалт нь төрийн⁴³ худалдан авалтын гэрээний тодорхой заалтуудыг олон нийтэд зарлахгүй байх тухай заалт байдаг. Яг одоогоор хуулийн дагуу эдгээр мэдээлэл нь нээлттэй байгаа ч төрийн худалдаа арилжааны гэрээнд нэг болон түүнээс дээш хавсралт байдгийг олон нийтэд мэдээлдэггүй. Учир нь эдгээр гэрээнээс гадна хавсралт болж орсон зүйлийг мэдээлэх үүрэггүй байдаг. Хамгийн чухал мэдээлэл гэрээ хэлэлцээрийн бичиг баримтын хавсралтад байхад төрийн бус байгууллагууд болон иргэд түүнийг мэдэх эрхгүй байдаг. Энэ талаар манай байгууллага анхааран ажиллаж байгаа юм.

43 Public гэж үг нь олон нийтийн ба төрийн гэсэн хоёр үндсэн утгаар хэрэглэгддэг. Энэхүү өгүүлбэр дэх утга нь төрийн эзэмшил нь эцсийн дүндээ ард түмний эзэмшил гэж тооцогдох тул олон нийтийн гэсэн утгаар нь уншина уу. (Орч.)

СЛОВАК УЛСЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ТББ-ЫН ОРОЛЦОО

*МИЛАН ВЕТРАК /Европын Хууль зөвлөгөө байгууллагын захирал
Трнава сургуулийн захирал/*

Парламентын хүндэт гишүүд, хатагтай ноёд, хамтран зүтгэгчид ээ. Өнөөдөр та бүхэнд Европын холбооны өөр нэгэн орны хууль боловсруулах тогтоох үйл явцдаа олон нийтийн оролцооны журмыг нэвтрүүлсэн жишээг ярих боломж олдсонд баяртай байна

Эрх зүйт төр, ардчиллын зарчмуудад тулгуурласан аливаа улс орон төрийн хэрэгт олон нийтийн оролцоог аль болох өргөн байлгах явдлыг хангах, мөн төрийн эрх мэдлийг тунгалгаар хэрэгжүүлэх тийм орчныг бий болгохын төлөө бүхий л хүчин чармайлтаа тавих ёстой⁴⁴. Ийм хүчин чармайлтыг Европын түвшинд⁴⁵ буюу олон улсын түвшинд⁴⁶ шийдвэр гаргах үйл явцад олон нийтийг оролцуулах явдлыг хуульчлан зохицуулах хэлбэрээр тэдний байр суурийг бэхжүүлэх чиг хандлага байгаатай холбон үзэж болно. Хууль тогтоох үйл явц (“leges ferre”) нь шийдвэр гаргах хэд хэдэн арга ажиллагааны нэг боловч нөгөө талаар төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх маш чухал хэлбэр юм. Иймд хууль эрхийн хэм хэмжээний төсөл гаргагчид (зохиогчид) төдийгүй иргэдийн зүгээс хууль тогтоох үйл явцад нөлөөлөх боломжийг бий болгох тийм шаардлагатай нөхцлийг тогтоож өгнө гэдэг ардчилсан аль ч засгийн газрын хувьд маш их хүч сорьсон төлөвлөгөө байх болно.

Сурталчилгаа болон хэм хэмжээний тухай хууль тогтоомж

Хууль тогтоох үйл явцын үр дүнд ерөнхийдөө заавал биелүүлэх хэм хэмжээний хууль тогтоомж батлагддаг. Хэм хэмжээний хууль тогтоомж гэдэг нь хууль эрхийн болон техникийн үүднээс бол улс төрийн хүсэл эрмэлзлийн эрх зүйн албан ёсны илэрхийлэл байдаг.

44 Хууль тогтоох үйл явцыг тунгалаг байлгах асуудлыг өргөн утгаараа бас коррупцийн эсрэг тэмцлийн нэгэн хэсэг гэж үзэж болно. Засгийн газрын 2000 оны зургадугаар сарын 21-ний тогтоолоор Коррупцийн эсрэг тэмцлийн үндэсний хөтөлбөр батлагдсан бөгөөд үүнд коррупциас урьдчилан сэргийлэх, түүний эсрэг тэмцэх олон зорилт тавьсны дотор Лобби үйл ажиллагааны тухай хууль гаргах асуудал орсон.

45 Европын Үндсэн хуулийн Гэрээний I-47 зүйл ангид олон нийт шууд бус замаар хууль санаачлан Европын Комисст өргөн барьж болох тухай заасан нь хууль тогтоох үйл явцад олон нийтийн оролцоог баталгаажуулсан хэрэг юм. Энэ талаар http://europa.eu/scadplus/constitution/index_en.htm -аас үзнэ үү.

46 Олон улсын чанартай баримт бичгүүдийн хувьд, юуны өмнө НҮБ-ын Европын эдийн засгийн комиссоос гаргасан Байгаль орчны асуудлаарх мэдээллийг нээлттэй байлгах, шийдвэр гаргах явдалд олон нийтийг оролцуулах, шүүх үйл ажиллагааг нээлттэй байлгах тухай Конвенц (Аархусын Конвенц)-ийг нэрлэх хэрэгтэй.

Улс төрийн хүсэл эрмэлзлийн эрх зүйн илэрхийлэл нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхтэй нягт холбоотой, ингэснээрээ энэ эрх мэдлийн төлөөлөгчид (сонгогдсон хүмүүс) болон сонгогчдын хоорондын, улстөрчид болон олон нийтийн хоорондын харилцаанд ч хамаатай байдаг. Энэ үүднээс төрийн төлөөлөгчдийн зүгээс хэм хэмжээний тухай шийдвэр гаргахаасаа өмнө уг төслийн талаар олон нийт санал бодлоо илэрхийлэх хөрс суурийг тавьж өгөх нь зүйд нийцнэ. Ийм хандлага нь эрх зүйн тогтолцооны хөгжил болон тогтвортой байдлын хооронд илүү сайн тэнцвэрийг олоход ихээхэн хэрэгтэй. Илүү өргөн утгаар гэвэл, хуулийн өмнө болон төрийн хэрэгт оролцох талаар олон нийт, мөн иргэн бүр эрх тэгш байх явдлыг хангах баталгаа болж чадна. Учир нь, хууль тогтоох үйл явцын хүрээнд төрийн эрх мэдлийг төлөөлөөгүй, зөвхөн иргэдийн эвлэл холбоог төлөөлсөн холбогдох янз бүрийн субъектүүдэд⁴⁷ хамаатай асуудлууд гардаг. Энэ нь олон нийтийн гэхээсээ илүү зөвхөн эдгээр субъектын таалалд нийцсэн байр суурийг хүлээн зөвшөөрөхөд санамсаргүй хүргэдэг тал бий.

Албан ёсны байр сууринаас авч үзвэл, хэм хэмжээний тухай хууль тогтоомж нь бусад баримт бичгийн нэг адил зохиогчийн тодорхой санаа бодлыг олон нийтэд хүргэж буй мэдээллийн хэрэглүүр юм. Утга агуулгаар нь авч үзвэл, хууль тогтоомжийн баримт бичиг зохиогч нь улстөрийн хүсэл эрмэлзэл, түүний албан ёсны илэрхийлэл хоёрын дунд оршиж, тиймээс ч баримт бичгийн санааг хандуулсан хүмүүсийнхээ холбогдох санал бодлыг илэрхийлэх нь маш чухал байдаг. Баримт бичгийг зохиогч уг хууль тогтоомжийн төсөл ойлгомжтой, оносон эсэх, практик амьдралд нийцсэн эсэх талаар урьдчилан, өөрөөр хэлбэл батлагдахаас нь өмнө мэдэх боломжтой байдаг бөгөөд энэ нь сайн хууль гарахад хувь нэмэр болдог.

Хууль тогтоох үйл явцад олон нийт оролцохын сайн болон муу тал

Дээр дурдсан санаануудын дагуу хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийтийн оролцох явдлын гол сайн талуудыг дор дурдсанаар базан хэлж болох юм. Үүнд:

а) хүчин төгөлдөр журам зарчим (хуульд нийцэх байдал, хууль ёсны байдал, сайн хууль боловсруулах зарчим)-д нийцсэн арга, хэлбэрээр хууль болон бусад эрх зүйн актын чанарыг сайжруулах боломж,

б) санал болгож буй хууль тогтоомжоор хөндөгдөж буй эрхээ хамгаалах боломж (эрх тэгш зарчим, эрх зүйн тодорхой байдлын зарчим),

в) нийгэм-сэтгэл зүйн талууд (хүний зан үйлийг зохицуулсан хууль гаргахад «Би оролцсон» гэх сэтгэгдэлтэй болох).

Үүний эсрэгээр, ийм оролцооны муу талыг дараахь байдлаар бас тодорхойлж болно. Үүнд:

а) өргөн олон нийтийн хувьд эрх зүй (хууль)-н мэдлэг, чадвар, мөн мэргэжлийн практик туршлага байхгүй,

⁴⁷ Жишээлбэл, нийгмийн яриа хэлцээнд оролцогчид (ажил олгогчдын төлөөлөгчид, ажилчдын төлөөлөгчид), эсвэл мэргэжлийн төрөл бүрийн байгууллагууд (Словакийн хуульчдын холбоо, Словакийн ректоруудын бага хурал зэрэг)-ыг дурдаж болох юм.

б) практик амьдрал дээр, мөн хууль тогтоох үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог тодорхойлсон байдал хязгаарлагдмал байдгаас өргөн олон нийт дотор сонирхлын бүлэг хүмүүс, лобби хийдэг байгууллагууд ноёлох,

в) хууль тогтоох үйл ажиллагаа сунжрах, удаашрах.

Хууль тогтоох журам нь хууль гаргах ажлыг зохицуулах үүрэгтэйн зэрэгцээ хууль тогтоох үйл ажиллагаан дахь холбогдох субъектүүдийн байр суурь, оролцоог мөн зохицуулдаг. Харин энэ үйл ажиллагаанд олон нийтийг оролцуулах зохицуулалтын зорилго нь дээр дурдсан сайн талуудыг аль болох өргөнөөр тусгасан, нөгөө талаар муу талуудын нөлөөг багасгасан тийм журам тогтоох явдал байх ёстой. Бүгд Найрамдах Словак Улсын хувьд, олон нийтийн зүгээс хууль тогтоох үйл явцад оролцож буй байдлыг тус тусдаа зохицуулалт бүхий парламент, засгийн газар, орон нутгийн гэсэн гурван үндсэн түвшинд хувааж болох юм.

Парламентын түвшинд

Хууль тогтоох үйл ажиллагааг Бүгд Найрамдах Словак Улсын Үндэсний Зөвлөл (цаашид Үндэсний Зөвлөл гэх)-ийн Дэг⁴⁸ -ээр зохицуулдаг бөгөөд парламентын түвшин дэх Үндэсний Зөвлөлийн Хууль тогтоох Журам⁴⁹ -д бүр тодорхой зохицуулж өгсөн байдаг. Гэхдээ эдгээр дэг журамд хууль тогтоох үйл явцад олон нийт оролцох байдлыг зааж өгөөгүй. Түүгээр ч үл барам, парламентын гишүүний санаачилсан хуулийн төслийн талаар санал бодлоо илэрхийлэх зэрэг олон нийтийн шууд оролцоог зөвшөөрсөн зүйл байхгүй. Хэдий тийм боловч, олон нийт хуулийн төслийн эцсийн хувилбарт шууд бусаар нөлөө үзүүлэх хэд хэдэн боломж бий. Үүнийг тодруулбал:

- а) Парламентын нэгдсэн хуралдаан, хороодын хуралдаанд оролцох,
- б) Парламентын тодорхой гишүүдтэй уулзах,
- в) Үндэсний Зөвлөлд өргөх бичиг мэдүүлэх⁵⁰.

Засгийн газрын түвшинд

Засгийн газрын түвшинд хууль тогтоох үйл ажиллагааг Бүгд Найрамдах Словак Улсын Засгийн газрын (цаашид Засгийн газар гэх) Хууль тогтоох Журмаар⁵¹

48 БН Словак Улсын Үндэсний Зөвлөлийн Дэгийг нэмэлт өөрчлөлт оруулснаар батлах тухай хууль №350/1996.

49 Үндэсний Зөвлөлийн 519 тоот тогтоолоор 1996.12.18-нд батлагдсан, БН Словак Улсын хуулиудын товхимолд №19/1997 дугаартай хэвлэгдсэн.

50 Өргөх бичиг мэдүүлэх явдлыг Үндэсний Зөвлөлийн Дэгийн 133, 134 дүгээр зүйлээр зохицуулсан байдаг. Дор хаяхад 100 мянган хүн гарын үсэг зурсан байвал Парламент заавал авч үзэх ёстой. Өнгөрсөн 7 жилд ердөө 3 тийм өргөх бичиг мэдүүлсэн: сүмийн сургуулийг улсын сургуультай ижил статустай болгох тухай (220 434 иргэний гарын үсэг зурж, 2000.05.09-нд өргөн барьсан; Үндэсний Зөвлөлийн 2000.06.25-ны 952 тоот тогтоолыг үзнэ үү.); ХАА-н салбарын асуудлаар гол төлөв фермерүүдийн өргөх бичиг (101 573 гарын үсэгтэй, 2003.04.08-нд өргөн барьсан; Үндэсний Зөвлөлийн 2003.04.25-ны 2773 тоот тогтоолыг үзнэ үү.); Хөдөлмөрийн хуульд ажил эрхлэгчдийн нийгмийн хамгааллыг сулруулсан нэмэлт оруулахыг эсэргүүцсэн (208 184 иргэн гарын үсэг зурж, 2003.04.20-нд өргөн барьсан; Үндэсний Зөвлөлийн 2003.06.26-ны 352 тоот тогтоолыг үзнэ үү.)

51 Засгийн газрын Хууль тогтоох журмыг 1997.04.08-нд Засгийн газрын 241 тоот тогтоолоор баталж, 1999.12.16-ны 1118 тоот, 2001.11.28-ны 1130 тоот, 2003.11.19-ний 1097 тоот, 2005.09.28-ны 736 тоот тогтоолуудаар тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан.

зохицуулдаг бөгөөд зарим талаар Засгийн газар (кабинет)-ын хуралдаанд оруулах албан бичиг боловсруулах, өргөн барих тухай Заавар⁵² (цаашид Заавар гэх)-аар зохицуулдаг. Энэ салбарт 2001 онд томоохон өөрчлөлт хийсэн нь хууль тогтоох үйл явцад олон нийтийн оролцоог анх нэвтрүүлж, энэ ажиллагааг цахим хэлбэрээр хийж болох тухай шийдвэр байсан юм.

Хууль тогтоох үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулахдаа хуулийн төсөл санаачлагч субъект өөрийн вэб сайт дээр хуулийн талаарх бүх саналаа нийтэлж, олон нийт тодорхой заасан цахим шуудан хаягаар төслийн талаар санал шүүмжлэлээ цахим хүснэгт хэлбэрээр тодорхой хугацааны дотор санаачлагчид илгээх боломжоор хангагдсан байх тухай заасан⁵³. Дээр дурдсан санал өгөх зарчим нь боловсруулсан хуулийн хэм хэмжээний объект болж буй иргэн бүрийн хувьд хууль эрхийн тодорхой, ойлгомжтой байдлыг ихээхэн сайжруулсан хэрэг юм.

Олон нийт хуулийн төслөөр санал бодлоо илэрхийлэхдээ ганц нэгээрээ юм уу хамтран ажиллаж болно. Дан ганц хүний санал бодолд хэрхэн хандах тухай тусгайлсан заалт байхгүй. Харин олон нийтийн нийтлэг саналд хандахдаа хэд хэдэн нөхцлийг хангасан байх ёстой. Олон нийтийн нийтлэг саналыг авч үзэхдээ олон тооны хувь хүн буюу хуулийн этгээд санал нэгдсэн тийм саналыг⁵⁴ тодорхойлж, тухайн саналыг гаргагчдыг төлөөлсөн бүрэн эрхт нэг төлөөлөгчийг⁵⁵ хууль тогтоох үйл ажиллагаанд оролцуулна. Хэрвээ 500-гаас дээш тооны хүн нэг ижил санал гаргасан байвал хууль санаачлагч дээр дурдсан бүрэн эрхт төлөөлөгчтэй уулзалт зохион байгуулж, саналыг төсөлд тусгах талаар зөвлөлдөнө. Зарим тохиолдолд, санал тусгах асуудлыг⁵⁶ Кабинетын⁵⁷ хурлаар ч эцэслэн шийдэх явдал гарч болно. Кабинетын хуралд оруулж байгаа хуулийн аливаа баримт бичиг нь саналуудын үнэлэлт дүгнэлт, мөн «байр суурийн (олон нийтийг оролцуулан) зөрчилгүйг нотолсон мэдэгдэл»⁵⁸ гэсэн материал заавал хавсаргасан байх ёстой.

52 Зааврыг Засгийн газрын 2001.06.13-ны 512 тоот тогтоолоор баталсан бөгөөд түүнээс хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулсан (Засгийн газрын Хууль тогтоох журмын 10-ын 8-г үзнэ үү)

53 Хууль эрхийн баримт материалын хувьд хуулийн төсөл санаачлагчийн вэб сайт дээр тухайн материалыг нийтэлснээс хойш 15 хоногийн дотор (БН Словак Улсын Засгийн газрын ажлын албаны вэб сайт дээр бүх материал угаасаа нийтлэгддэг) гэж тодорхой хугацаа заасан бөгөөд хүндэтгэх шалтгаанаар энэ хугацааг ажлын 7 хоног болтол багасгаж болно (тухайлбал, хүний эрх, үндсэн эрх чөлөөний асуудал хурцаар тавигдвал, эсвэл ЕХ-ны өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байдалд хүрэхээр байвал)

54 Санал гэдэг нь хуулийн төсөлд зүй ёсны засвар оруулахаар заасан хугацаанд өгсөн саналыг хэлнэ. Тухайн саналаар цоо шинэ заалт оруулж болох ба эсвэл байгаа заалтад нэмэлт хийх, хасах, өөрчлөх, тодруулах зэрэг сайжруулалт хийж болно. Тухайн заалтад эргэлзэж байгаагаа илэрхийлсэн тохиолдолд түүнийг засах тухай тодорхой саналаа хамт ирүүлсэн байвал түүнийг авч хэлэлцэнэ. Хуулийн төсөлд өгч буй санал нь тодорхой, ойлгомжтой байх ёстой ба хуулийн текст байх ёстой. Тодорхой журмыг Засгийн газрын Хууль тогтоох журмын 10 дугаар зүйл ангиас үзнэ үү.

55 Засгийн газрын Хууль тогтоох журмын 10-ын 6-г үзнэ үү. Тухайн заалтад төлөөллийн хэлбэр, бүрэн эрхт төлөөлөгчийн удирдамж ямар байх тухай тодорхойлоогүй. Үүнийг хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог зохицуулах ажлын нэг дутагдал гэж үзэж болох юм.

56 Хуулийн төсөл өргөн баригч этгээд 500-гаас доошгүй хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлсөн бүрэн эрхт төлөөлөгчтэй сайн дураараа уулзалт зохион байгуулж болно.

57 Иргэдийн саналыг зөвлөлдөөнөөр тодруулж, шийдэж чадаагүй бол бүрэн эрхт төлөөлөгчийг Засгийн газрын Хуулийн зөвлөлийн хуралдаан, эсвэл бүр Засгийн газрын хуралдаанд урьж оролцуулж болно. Гэхдээ тухайн санал утга агуулгын чанартай («үндсэн санал») байх, хуралдаан дээр биечлэн танилцуулах шаардлагатай тохиолдолд энэ нь боломжтой.

58 Саналуудыг үндсэн ба ердийн гэж хуваана. Санал тусгах зөвлөлдөөнөөр зөвхөн үндсэн саналыг авч хэлэлцэх ба зөвхөн ийм төрлийн саналын хувьд заавал авч хэлэлцэх, «санал болгож буй материал хуулийн төслийн талаар саналаа илэрхийлсэн бүх талуудын байр суурьтай зөрчилдөөгүйг» мэдэгдэх үүрэгтэй байдаг.

Орон нутгийн түвшинд

Орон нутгийн түвшин дэх хууль тогтоох үйл явцын үндсэн журмыг Орон нутгийн засаг захиргааны тухай хууль⁵⁹, Өөртөө засах бүс нутгуудын тухай хууль⁶⁰-иар зохицуулдаг. Орон нутгийн зарим засаг захиргаа орон нутгийн түвшинд хуулийн хэм хэмжээ тогтоох шийдвэр гаргах үйл явцыг зохицуулсан нарийвчилсан журам⁶¹ гаргасан байдаг. Харин ийм үйл явцад олон нийтийг оролцуулан, санал бодлыг нь сонсох асуудлыг 2004 оноос дээр дурдсан хуулиудаар зохицуулах болсон.

Орон нутгийн засаг захиргаанаас өөрийн өөртөө засах эрх мэдлийн хүрээнд гаргасан шийдвэрүүд, эсвэл төрийн төв засгаас олгосон эрх мэдлийн дагуу гаргасан шийдвэрийн төслөөр олон нийт саналаа илэрхийлж болно. Засгийн газрын түвшинтэй адилхнаар олон нийт ганц нэгээрээ буюу хамтран, асуудалд шууд хамаатай, утга агуулгын чанартай саналыг заасан хугацаанд⁶² багтаан гаргах боломжтой. Олон нийтийн ердийн саналын хувьд иргэдийн тодорхой тоо⁶³, тэдний бүрэн эрхт төлөөлөгч байх шаардлага үүснэ.

Орон нутгийн түвшинд хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийт оролцох асуудал зарим талаар бас ялгаатай. Олон нийтийн ердийн саналын асуудлыг орон нутгийн түвшинд зохицуулаагүй. Мөн ийм байдал хууль тогтоох үйл явцын цахим хэлбэрийн асуудал дээр оршиж байгаа. Хууль тогтоомжийн төслийг орон нутгийн парламентын хурлаас 15 хоногийн өмнө албан ёсны самбар дээр нийтлэх, бичгээр ирүүлсэн саналуудыг хурал эхлэхээс 3 хоногийн өмнө шүүн хэлэлцэх зэрэг зохицуулалтыг орон нутгийн дэд түвшний шийдвэрээр хийсэн байдаг. Орон нутгийн депутатууд орон нутгийн парламентын хуралд шууд танилцуулах зорилгоор олон нийтийн саналыг урьдчилан судлах боломж олгосон хууль эрхийн хүрээг ийнхүү тогтоож өгсөн байдаг. Дээр нь, хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийтийг төлөөлж буй бүрэн эрхт төлөөлөгч өөртөө засах бүс нутгийн хувьд олон нийтийн ердийн саналуудыг парламентын⁶⁴ хуралд шууд танилцуулах эрхтэй. Ямар ч тохиолдолд, иргэд шийдвэрийн төсөлд өгөх өөрийн саналаа танилцуулах зорилгоор өөрсдийн сонгосон депутат буюу засаг дарга (өөртөө засах бүс нутгийн тэргүүн)-тай уулзах боломжтой байдаг.

Дэмжлэг үзүүлэх механизмууд

Хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийтийг оролцуулах дээр дурдсан механизмуудаас гадна дэмжлэг үзүүлэх шинж чанартай бусад механизмыг дурдаж

59 Словакийн Үндэсний зөвлөлийн 369/1990 тоот шийдвэр (нэмэлт өөрчлөлт оруулснаар).

60 302/2001 тоот шийдвэр (нэмэлт өөрчлөлт оруулснаар)

61 Словакийн нийслэл Братислав хотын хүрээнд заавал биелүүлэх журмыг боловсруулах, батлах, хүчин төгөлдөр болгох тухай журмыг дурдаж болно. Энэ баримт бичгийг орон нутгийн парламентын тогтоол хэлбэрээр 1995.10.26-нд баталж, 174 гэсэн дугаартай нийтэлсэн.

62 Энэ хугацаа нь 10-аас доошгүй хоног байна. Гэхдээ байгалийн болон хүний үйлдлээс үүдсэн гамшиг гарсан тохиолдолд, эсвэл өмч хөрөнгө ихээр гэмтэж үрэгдэх аюул тулгарсан үед, олон нийтийн санал гаргах бүх тогтолцоог түр зогсоож болно.

63 Өөртөө засах бүс нутгийн тухай хуулийн 8-ын 8-д зааснаар бие хүн болон хуулийн этгээдийн энэ тоо 200 байна.

64 Өөртөө засах бүс нутгийн тухай хуулийн 8-ын 8-д зааснаар орон нутгийн парламентын хурал дээр саналуудыг танилцуулах хугацаа нь 10 минутаар хязгаарлагдана

болох юм. Эдгээр нь хууль тогтоох үйл явцад нөлөөлөх, төрийн захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцох бас нэг боломж олгож байна. Ийм мехамизмууд нь, юуны өмнө:

а) Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль⁶⁵-ийн дагуу мэдээлэл хүссэн шаардлага тавих,

б) онцгой чухал албан тушаалд байгаа (засгийн газрын түвшинд) төрийн албан хаагчтай уулзах хүсэлт гаргах⁶⁶

в) хуулийн төслийн тухай урьдчилсан мэдээллийг⁶⁷ заавал нийтэлж байх (засгийн газрын түвшинд).

Мэдээлэл, тодруулбал хууль эрхийн холбогдолтой санаачилга буюу иргэдийн эрх үүргийг хөндсөн шийдвэрийн тухай мэдээлэл хүссэн шаардлага тавих журам нь Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн дагуу маш энгийн бөгөөд үр дүнтэй⁶⁸ байдаг. Холбогдох субъект буюу гол төлөв төрийн захиргааны байгууллага иргэдэд хүссэн мэдээллийг өгөхөөс татгалзвал аль түвшнийх (төв болон орон нутгийн) гэдгээс үл хамааран таслан шийдвэрлэх болон шүүхийн шийдвэрээр дээрх хуулийн заалтыг хүчээр⁶⁹ мөрдүүлдэг.

Онцгой чухал алба хашиж буй албан тушаалтантай уулзах явдлыг өргөн олон нийт гэхээсээ илүү мэргэжлийн ашиг сонирхлын бүлэг гол төлөв ашигладаг. Хэдий тийм боловч, олон нийтийн ердийн санал хүсэлтийн тогтолцоог ашиглах явдал хүндэтгэх шалтгаанаар хүндрэлтэй байх үед иргэдийн шаардлага хангасан саналыг авч үзэх тохиолдолд дээрх боломж гол төлөв ач холбогдолтой байдаг.

Хууль тогтоох үйл явцад сонирхолтой бүх субъект, түүний дотор олон нийтэд хууль тогтоомжийн төслийн талаар танилцуулах зорилгоор урьдчилсан мэдээллийг бэлтгэдэг. Үүнийг Словакийн Засгийн газрын вэб сайтад Засгийн газрын Хууль тогтоох журамд заасан хэлбэр⁷⁰, хугацааны⁷¹ дотор нийтэлдэг.

65 Мэдээллийг нээлттэй байлгах, үүнтэй холбогдуулан зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан тухай (Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль) хууль (№211/2000).

66 Төрийн албаны тухай болон холбогдох зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 312/2001 тоот хуулийн 55 дугаар зүйл ангийн анхны текстийг харна уу. Харамсалтай нь, энэ хуульд 2006 онд оруулсан өөрчлөлт (№231/2006)-өөр онцгой чухал алба хашиж буй төрийн албан хаагч хууль тогтоох үйл явцад нөлөөлөх зорилгоор уулзалт хүссэн тухай протокол хөтөлж байх үүрэгтэй гэсэн заалтыг хассан байна. Энэ нь тунгалаг байх зарчимд нийцэх алхам явч биш.

67 Урьдчилсан мэдээллийн асуудлыг Засгийн газрын Хууль тогтоох журмын 8 bis зүйл анги, хавсралт 1D-ээр зохицуулсан.

68 Мэдээлэл авах хүсэлтийг бичгээр, амаар, факсаар буюу цахим шуудангаар тавьж болно. Хуулинд зааснаар хүсэлт гаргагч өөрийнхээ тухай зөвхөн ойр зуурын мэдээлэл өгөхөд хангалттай. Хүсэлт хүлээн авсан субъект 8 хоногийн дотор холбогдох мэдээллийг гаргаж өгөх ёстой. Хууль тогтоох үйл явцтай холбогдсон мэдээлэл ерөнхийдээ Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн дагуу төрийн захиргааны вэб сайт дээр нийтлэгддэг (тухайлбал, Словакийн Парламент хууль тогтоох үйл ажиллагааны явцад гарсан бүх санал болон батлагдсан хууль тогтоомжийг нийтэлдэг. Словакийн Засгийн газар мөн өөрийн баталсан хууль эрхийн актуудыг вэб сайтаа нийтлэх үүрэгтэй) учир мэдээлэл хүсэх шаардлага гардаггүй.

69 Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 19, 21 bis зүйл ангиудыг үзнэ үү (мэдээлэл өгөхөөс татгалзсан засаг захиргааны шийдвэрийг шүүхээр хянан шийдвэрлэх буюу 50 мянга хүртэл словак крон буюу 1500 орчим еврогийн торгууль ноогдуулах шийтгэл байж болно).

70 www.vlada.gov.sk –г үзнэ үү.

71 Урьдчилсан мэдээллийг А4 форматын 1-2 хуудас байхаар бэлтгэж, үндсэн 7 асуудлыг тусгана. Үүнд, хуулийн төсөл бэлтгэхэд түлхэц болсон хүчин зүйлс, батлуулахаар Кабинетэд оруулах хугацаа, батлах болсон шалтгаан, төслийн зорилго, санхүүгийн үр дагаврын тооцоо, ажил эрхлэлт, бизнес орчин, байгаль орчинд

Урьдчилсан мэдээллийн талаар санал бодлоо илэрхийлэх боломжтой бөгөөд харин энэ нь мэдээллийн чанартай учир хууль тогтоох урьдчилсан энэ шатанд саналыг тусгах зөвлөлдөөн хийнэ гэсэн асуудал байхгүй.

«De lege ferenda» зарчмыг авч үзэх нь

Хууль тогтоох үйл явцад олон нийтийг оролцуулахтай холбогдсон хууль тогтоомжийн төслийн саналыг⁷² бүр 2002 онд оруулсан боловч Засгийн газрын хуралдаан дээр дэмжлэг аваагүй юм. Төслийн шинэчилсэн найруулгыг 2003 онд дахин санал болгосон боловч хуулийн төслийн талаар санал авах явцад бас л буцаагдсан⁷³. Эцэст нь уг төслийн санааг орон нутгийн түвшинд хууль тогтоох үйл явцыг зохицуулсан хуулиудын нэмэлт⁷⁴ маягаар эрх зүйн тогтолцоонд хэсэгчлэн оруулж дөнгөсөн боловч орхигдсон хэсэг нь нээлттэй хэвээр, шаардлагатай бол ирээдүйд шинэ хууль тогтоомж маягаар гарч ирж болох юм. Хууль тогтоох үйл явцад олон нийтийг оролцуулах практик туршлагаас харахад цаашид дараахь зүйлүүдийг авч үзэх нь зүйтэй гэж дүгнэж байна. Үүнд:

а) хууль тогтоох үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцооны хууль эрхийн хүрээг тогтоох, олон нийтийн оролцоог хууль тогтоох үйл явцад мэргэжлийн үндсэн дээр, тухайлбал Лобби үйл ажиллагааны тухай хуулийн хүрээнд оролцдог ашиг сонирхлын бүлгийн (түүний дотор эрх дархтай гэгддэг бүлгүүд) оролцооноос ялгаж салгаж өгөх,

б) хууль тогтоох үйл явцад олон нийтийг оролцуулах боломж олгож буй хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд холбогдох зарим асуудлын механик зохицуулалт хийх.

Ад а/

Хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог санал бодлоо илэрхийлэх механизмаар дамжуулан хангах нь санал асуулга⁷⁵, өргөх бичиг барих эрх⁷⁶-ийн хажуугаар олон нийтийн ашиг сонирхлын чухал асуудлуудад нөлөөлөх бас нэг боломж юм. Гэхдээ практик туршлагаас харахад, өргөн олон нийтийн ашиг сонирхол нь мэргэжлийн ашиг сонирхлын бүлгийнхээс ондоо. Өргөн олон нийтийн үйл ажиллагаа нь гол төлөв орон нутгийн түвшин дэх хууль тогтоох үйл явцад нөлөөлөх, төв засаг захиргааны түвшинд бодлогын⁷⁷ тодорхой асуудлуудаар нөлөө үзүүлэхэд чиглэдэг. Харин өргөн олон нийт үндсэндээ зохион байгуулалт

үзүүлэх нөлөө, нэмэлт өөрчлөлт оруулах холбогдох хууль тогтоомжийн жагсаалт, хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн жагсаалт, хуулийг практик амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлэх тухай мэдээлэл орно.

72 UV-4514/2002 баримт бичгийг үзнэ үү.

73 0611/2003-ОВРК/2 баримт бичгийг үзнэ үү (мөн Словакийн Засгийн газрын вэб сайт дээр бий).

74 364/2004 баримт бичгийг үзнэ үү.

75 Словакийн Үндсэн хуулийн (460/1992) 93-100 дугаар зүйл ангиар санал асуулгыг зохицуулдаг. Орон нутгийн санал асуулгын гол зарчмуудыг орон нутгийн засаг захиргааны тухай хуулийн 11bis, Өөртөө засах бүс нутгийн тухай хуулийн 15 дугаар зүйл ангиар тодорхойлсон байдаг.

76 Өргөх бичиг барих (хүсэлт, шаардлага, гомдлын хэлбэрээр) эрхийг (Словакийн Үндсэн хуулийн 27 зүйлээр) баталгаажуулсан. Словакийн Парламентэд өргөх бичиг барих эрхийг Дэгийн 133, 134 дүгээр зүйлээр зохицуулдаг.

77 Бодлогын сонирхдог асуудлууд нь байгаль орчны бодлого, тээврийн бодлого, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, эсвэл шүүх, дотоод хэргийн асуудал байдаг.

байхгүй, шаардлага хангасан санал гаргах талаар мэргэжлийн болоод техник бааз суурьгүй байдаг. Тиймээс ч хууль тогтоох үйл явц дахь олон нийтийн нөлөө нь олон нийтийн ердийн санал бодлыг илэрхийлэх механизмыг ашиглах замаар хууль тогтоох үйл явцад шууд оролцох гэхээсээ илүү депутатуудтай болон төрийн албаны хүмүүстэй уулзах үеэр тус тусын санал бодлоо гаргах замаар гол төлөв илэрдэг.

Энэ туршлагаас үзэхэд, лобби хийх хуулийн зохицуулалтыг хууль тогтоох үйл ажиллагаанд дахь олон нийтийн оролцоог хуулиар зохицуулахаас ялгаж салгах бодит үндэслэл байгаа юм. Ерөнхийдээ, өргөн олон нийтийн оролцоо нь хуулийн зохицуулалтын үүднээс зөв, учир шалтгаантай гэж нотлохын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай байна. Юу гэсэн үг вэ гэвэл, ялангуяа төв засгийн түвшинд адил тэгш нөхцлөөр хангагдсан эсэх асуудал амин чухал болоод байгаа. Тиймээс хууль тогтоох үйл явц дахь олон нийтийн оролцооны үр дүн, зорилгын талаар дахин авч үзэн, үнэлэлт дүгнэлт өгөх хэрэгтэй. Өргөн олон нийтийг парламентын түвшин дэх хууль тогтоох үйл ажиллагаанд оролцуулах хүчин чармайлт нь цэвэр үр дүн, зорилгын хувьд Парламентад өргөх бичиг барих механизмтэй давхардаад байгаа юм. Засгийн газрын түвшин дэх хувь хүн, хуулийн этгээдийн эрх, үүргийг хуулийн үйлчлэлгүй дотоодын норматив актаар зохицуулна гэдэг Үндсэн хуулийн үзэл санааны үүднээс авч үзвэл эргэлзээтэй⁷⁸ ч гэсэн ямар ч нөхцөлд хуулийн ойлгомжтой, тодорхой байх зарчимд нийцэхгүй байна. Тиймээс засгийн газрын түвшин дэх хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийтийг оролцуулах ажлыг хэдийгээр одоо Словакт улс төрийн хүсэл эрмэлзэл байхгүй байгаа ч гэсэн заавал биелүүлэх хууль эрхийн актаар зохицуулах нь зүйтэй. Төв засгийн түвшин дэх хууль тогтоох үйл явц дахь өргөн олон нийтийн оролцоог зохицуулах хууль эрх зүйн акт байхгүй тохиолдолд хувь хүн болон бүлэг хүмүүс хууль тогтоох үйл явцад мэргэжлийн үүднээс нөлөөлөх ажил эрхэлсэн субъектэд хандах боломж бий. Энэ нь Словакт лобби үйл ажиллагааг чанартай хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатайг хэлж байгаа юм. Ийм зохицуулалт одоогоор байхгүй байна.

Лобби үйл ажиллагааг зохицуулах ямар ч концепц байсан Европын холбооны түвшинд⁷⁹ тогтсон практиктай адилхан бүртгүүлэх үүргийг заасан ерөнхий хүрээг багтаасан байх ёстой. Бүртгүүлэх үүргийн зорилго нь нөлөө үзүүлэх объект болон субъектын хувьд, хууль тогтоох үйл явцад шууд оролцох сонирхолгүй, харин бүртгэлтэй байгууллага, ашиг сонирхлын бүлгээс үзүүлж буй мэргэжлийн үйлчилгээг авах хүсэлтэй өргөн олон нийтийн хувьд үйл ажиллагаа нь тунгалаг байхад оршино. Бүртгүүлэх үүрэг хүлээснээр хууль тогтоох явцад санал онолоо илэрхийлэхэд нөлөөтэй. Энэ нь хуулийн төсөл өргөн баригч бүртгэлтэй бүх этгээдэд төслөө хүргүүлснээр төрийн байгууллагаас гадна байгаа

78 Зөвхөн хуулийн үндсэн дээр, түүний хамрах хүрээний дотор л үүрэг хариуцлага ноогдуулах ёстой. Энэ нь Словакийн Үндсэн хуулийн 7-гийн 4-т заасан олон улсын гэрээ, Словакийн Үндсэн хуулийн 13-ын дагуу Үндсэн хуулийн 120-ын 2-ыг хэрэгжүүлэх үүднээс Засгийн газраас баталсан журамд тулгуурлан хэрэгжих ёстой.

79 Хууль тогтоох үйл явцад нөлөө үзүүлэх асуудлыг Европын Холбоонд олон жилийн өмнө албан ёсоор шийдвэрлэсэн бөгөөд Европын Парламентын Дэгийн 9 дүгээр зүйлээр зохицуулдаг. Лоббист нь Европарламентын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх системд бүртгүүлсний дараа Парламентын байранд орж ажиллах, хуралдаанд оролцох, парламентын гишүүдтэй уулзах хэд хэдэн эрх, давуу байдал олж авдаг. Дэгийн тухай www.europarl.europa.eu/parliament/ -аас тодорхой үзнэ үү.

эрх ашиг нь хөндөгдсөн этгээдийн зүгээс гарч болох саад тотгор, буруу ташаа ойлголтыг гарилгахад хүргэх ёстой. Бүртгүүлэх үүрэг нь хууль тогтоох үйл явцад нөлөөлөх гэсэн хурал, уулзалтын тэмдэглэл хөтөлж байх тухай парламентын гишүүд, онцгой ач холбогдол бүхий төрийн албан тушаалд ажиллагсдын үүрэгтэй нягт холбоотой. Хууль боловсруулалт аль түвшинд байгаа тухай болон хуулийн төслийн⁸⁰ талаар бүх субъектээс гаргасан мэдэгдэл, байр суурийн талаар тодорхой мэдээллээр олон нийтийг хангах систем нь хууль эрхийн нийт тогтолцооны жигд ажиллагааны чухал нэг угтвар нөхцөл мөн. Хууль тогтоох ажилд нөлөөлөх (лобби хийх) явдлыг зохицуулах эрх зүйн хүрээ нь дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэхээс гадна олон нийтийн амьдралын энэ салбарт сүүлийн хоёр жилд бий болж байгаа нийгмийн шинэ харилцааг ч зохицуулах чадамжтай.

Ад б)

Техникийн шинж чанартай зарим асуудлын хувьд, юуны өмнө олон нийтийн ердийн санал дүгнэлтийг хууль тогтоох үйл явцад нөлөөлөхүйц гэж тооцоход шаардагдах хүмүүсийн тооны асуудал, мөн засгийн газрын түвшинд хууль тогтоомжийн асуудлаар олон нийтэд мэдээлэл өгөх байгууллагуудын үйл ажиллагаа давхардсантай холбоотой асуудлыг дурдахыг хүсч байна.

Хууль тогтоох үйл явц дахь олон нийтийн оролцооны тухай буцаагдсан хуулийн төслийг тухайн орон нутгийн хүн амын хамгийн идэвхтэй 10% санаачилсан гэсэн тооцоо бий. Үүнээс үзвэл, 3000 дээш хүн амтай засаг захиргааны нэгжийн хувьд 300 орчим хувь хүн, хуулийн этгээд энэ бүлэгт хамаарагдаж байна. Хэдий тийм боловч, Орон нутгийн засаг захиргааны тухай хуулинд хүний тоог хязгаарлаагүй бөгөөд харин Өөртөө засах бүс нутгийн тухай хууль⁸¹ болон Кабинетэд оруулж буй хуулийн бус баримт бичгүүдийг зохицуулсан зааварт хүний тоог тогтоож өгсөн.

Анхандаа тийм «кворум» тоог хуулийн баримт бичгийн хувьд тогтоохоор санал болгож байсан боловч баримт бичгийн чухлыг харгалзан энэ тоог 500 болгон нэмэгдүүлсэн. Бид энэ тоог ард нийтийн асуудлаар ашиг сонирхлоо илэрхийлэхэд олон нийт ашигладаг байгууллагуудын тооцоотой харьцуулан, математикийн аргаар нэг тоо гаргаж авч болох боловч энэ нь санал асуулга - өргөх бичиг барих - ердийн санал гаргах гэсэн гурвалжин доторх иргэдийн тэгш эрхийн зарчмыг ноцтой зөрчих хэрэг гарна.

Лобби үйл ажиллагааны хуулийн зохицуулалтыг хууль тогтоох үйл явц дахь олон нийтийн оролцооны хуулийн зохицуулалтаас ялгаж салгах тохиолдолд хүний тооны асуудлыг ерөнхийд нь үгүй болгох хэрэгтэй. Гэхдээ, хуулийн төсөл санаачлагч олон нийтээс журмын дагуу гаргасан саналыг хувь хүн болон хуулийн этгээдийн ашиг сонирхол шууд хөндөгдсөн тохиолдолд авч үзэх үүрэг хүлээх ёстой. Түүний зэрэгцээ олон нийтийн саналыг тусгах эсэх асуудлаар зөвлөлдөөн

80 Хуулийг ёсчлох, нэг мөр болгох мэдээллийн систем (ISLAP) нь Засгийн газрын 2002.07.03-ны 732 тоот тогтоолоор ийм үүрэг гүйцэтгэдэг. Засгийн газрын 2005.04.27-ны 309 тоот тогтоолын дагуу 2006 оны 11 дүгээр сард БН Словак Улсад «Хууль тогтоох үйл явцыг дагаж байх Нэгдсэн мэдээллийн систем бий болгох практик боломж, ажлын эхлэлийн анализ» гэсэн баримт бичгийг хууль тогтоох байгууллагад өргөн барьсан.

81 Хязгаарыг 300 хүнээр тогтоох анхны санал явсаар 200 хүн болж тогтсон.

хийдэг практикийг халж, харин саналуудад үнэлэлт дүгнэлт өгдөг явдлыг авч үлдэх хэрэгтэй. Олон нийтийн саналыг хүлээн авах боломжгүйгээ засгийн газар болон парламентын гишүүд (үндэсний болон орон нутгийн) үндэслэлтэйгээр тайлбарлаж, эрх барих байгууллагын хуралдаан дээр шууд танилцуулах боломжтой байх ёстой⁸².

Урьдчилсан мэдээлэл болон хууль эрхийн эрмэлзэл⁸³-ийн хувьд, засгийн газрын түвшинд боловсруулж байгаа хуулийн төслийн талаар ард олонд мэдээлэх үүрэг нь давхардсан механизмууд юм. Хуулиудыг нэг мөр болгох аргачлал нь Хууль эрхийн актыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг бас бүрдүүлдэг. Энэ нь дээр дурдсан хоёр механизмтай ойролцоо үүрэгтэй. Засгийн газрын Хууль тогтоох журам нь урьдчилсан мэдээлэл, хууль эрхийн эрмэлзлийн хоорондыг харилцааг салбар гэдэг утгаар⁸⁴ зохицуулдаг боловч хойшид хууль тогтоох журамд өөрчлөлт оруулж, засгийн газар болон парламент, орон нутгийн түвшинд ашигладаг нэг л хууль эрхийн механизм байхаар зохицуулах нь зүйтэй.

82 Үндэсний санал асуулгыг 350 мянгаас дээш хүн гарын үсэг зурсан тохиолдолд, орон нутгийн санал асуулгыг эрх бүхий сонгогчдын 30% гарын үсэг зурсан үед зохион байгуулах. Хэрэв 100 мянган хүн гарын үсэг зурсан байвал Үндэсний зөвлөл өргөх бичгийн асуудлаар ярилцлага явуулах үүрэгтэй. Бид урьд тогтсон 10% гэсэн үзүүлэлтийг хэрэглэвэл үндэсний хэмжээнд одоогийн 500, 300 хүн гэсэн тоо биш, харин 500 мянга, 300 мянга гэсэн тоо гарна.

83 Хууль эрхийн эрмэлзэл нь Засгийн газрын Хууль тогтоох журмын 8 дугаар зүйлээр зохицуулагддаг. Ийм эрмэлзэл, урьдчилсан мэдээлэл хоёрын хоорондын үндсэн ялгаа нь гэвэл урьдчилсан мэдээлэл нь хуулийн төсөл бүрээр (хууль эрхийн эрмэлзэл гарч байгаагаас бусад) гардаг бол эрмэлзэл нь хуулийн төсөл эдийн засгийн болоод санхүүгийн ихээхэн үр дагавартай тохиолдолд, эсвэл Засгийн газраас тийнхүү шийдсэн үед гардаг.

84 Засгийн газрын Хууль тогтоох журмын 8bis-ын 6-г үзнэ үү.

АСУУЛТ -ХАРИУЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Х.ОЮУНЦЭЦЭГ /Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо/

Манайд хуулийн төслийг боловсруулахад зөвхөн төрийн байгууллага, холбогдох яам, агентлагийн саналыг аваад эрдэмтэд, мэргэжилтнүүд болон ТББ-ыг оролцуулдаггүй. Тэгэхээр Засгийн газрын түвшинд хэрхэн яаж оролцох юм бэ? Энэ механизмыг хуульчлах хэрэгтэй. Дараа нь парламентад өргөн барьсан хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хэрхэн яаж оролцох вэ гэсэн асуудал байгаа юм. Засгийн газрын өргөн барьсан хуулийн төсөлд иргэд, иргэний нийгмийн санал ямар байгаа юм бэ гэдгийг заавал парламентад мэдэгдэж, сонсч байдаг тийм зохицуулалт хэрэгтэй байна. Манайд улс төрийн ийм соёл, хэм хэмжээ байхгүй байгаа учраас оролцооны энэ асуудлыг зайлшгүй журамлах, зохицуулах хэрэгтэй санагддаг. Тэгээд парламентад иргэд, ТББ-уудын гаргасан саналыг хүлээж аваагүй бол яагаад аваагүй вэ гэдэг талаар ярьдаг тийм зохицуулалт бусад газарт байна уу?

ПОЛЬШИЙН ТӨЛӨӨЛӨГЧ

ТББ-ын саналыг аваагүй тохиолдолд түүнийг хэлэлцдэг хууль байхгүй. Харин яамдад хийсэн зөвлөлгөөнөөс тайлан гаргадаг. Энэ нь нэлээн ерөнхийдүү байдаг. Хуулийн төслийг заавал нийтлэх ёстой байдаг.

Ч.ОТГОНБАЯР /Хөдөөгийн Эмэгтэйчүүдийн Хөгжлийг дэмжих сан/

Семинараас гарах баримт бичигт тусгах хоёр чиглэлийн санал хэлье. *Нэгдүгээрт*, үндэсний хэмжээнд болон орон нутгийн хэмжээнд бодлого боловсруулж баталдаг тэр байгууллагад ТББ-уудыг чөлөөтэй оролцуулах, хэлэлцүүлэх үйл явцыг илүү ил тод, нээлттэй болгох механизмыг суулгаж өгөх шаардлагатай. Практикаас харж байхад тухайн Байнгын хорооны дарга, ИТХ-ын дарга хэн байна гэдгээс хамаараад хэлэлцэж байгаа асуудалд иргэд, ТББ-уудыг оролцуулах асуудал шийдэгддэг байдалтай байгаа. Тиймээс үүнийг хэн нэгэн хүний үзэмжээр бус, харин хуульчлан зохицуулах ёстой. Нөгөө талаар парламентыг чадваржуулах, ялангуяа Байнгын хорооны аппаратыг чадварлаг хуульчдаар бэхжүүлэх асуудалд анхаарах хэрэгтэй. Хоёрдугаарт, парламентын мэдээлэл, судалгааны төв зайлшгүй шаардлагатай юм. Энэ бол хамгийн чухал зүйл. Скандиновын парламентын судалгааны төвийн туршлагаас харахад гадны хууль тогтоомжийг судлах, хууль хэрэгжих нөхцөл, боломжийн талаарх үнэлэлт дүгнэлт гаргахаас гадна хууль санаачлан боловсруулах явцад иргэд, ТББ-уудаас ямар саналууд гарч байсан бэ, тэр нь хэрхэн шийдвэрлэгдэх боломжтой эсэх талаар хүртэл парламентын гишүүдэд мэдээлэх

үүрэг хүлээдэг. Тиймээс парламентын мэдээлэл, судалгааны төвийн асуудал бол төрийн чадавхитай холбоотой асуудал гэж үзэхэд нэг их буруудахгүй байгаа.

ГАНБААТАР /Үндэсний “Соёмбо” хөдөлгөөн/

Хоёрхон санал хэлье. Манай төрд лобби хийх нөхцөл нь байхгүй юм даа. Учир нь улс төрийн намууд бие биенээ барьцаалчихсан байдалтай байгаа. Танайх тэгвэл манайх ингэнэ гээд. Тэгэхээр ийм арчаагүй төрийг цэвэрлэе гэвэл энэ хүмүүст найдахаасаа илүү ард иргэдэд найдах шаардлага гарна. Энэ барьцаалагдсан байдал цаашаа явахаараа олигархи буюу улс төр, бизнесийн хамтарсан бүлэглэлийн эрх мэдэлд захирагдах ёсонд хүрдэг. Тэгвэл өнөөдөр монгол орныг ийм бүлэглэлүүд захирч байгаа. Энэ нь арай цаашаа явахаараа бизнесменүүд нь улс төрчдөө шахаад бизнес-эдийн засгийн бүлэглэлүүдийн төр болдог. Энэ нь дахиад жаахан цааш явахаар бизнес дотор байдаг хулгайч нар нь бизнес, эдийн засагчдаа шахаж хулгайчдын төр болдог. Энэ нь дахиад цаашлахаар Орост юмуу Хятадад манай Ерөнхий сайдууд очиж цаазлуулдаг. Нэг ийм л байдал руу оруулахгүйн тулд өнөөдөр иргэний оролцоо гэдэг юм их чухал юм. Иргэдийн оролцоо их байх тусам тэр орны тусгаар тогтнол баталгаатай байдаг. Энэ утгаар би энэхүү семинарт ач холбогдол өгч талархаж байна. Эргээд бас ард иргэдэд нээлттэй байснаараа юм тэр бүр явахгүй. Ард иргэд гэдэг маань малчин, ажилчин, наймаачин гэх мэт хүмүүс байдаг. Тэгэхээр ард иргэдэд тэр оролцоог бий болгоход шинжээчдийн болон мэргэжлийн судалгаа шинжилгээ хийдэг тийм байгууллага хэрэгтэй. Ийм хараат бус бие даасан судалгааны байгууллага монголд ор тас байхгүй байгаа. Хуучин эрдэм шинжилгээний байгууллагууд тодорхой хийсэн юмгүй, мөнгө хөрөнгө байхгүй гээд суудаг болсон. Бусад оронд ийм байдал хэвээрээ байна уу, эсвэл өөрчлөгдсөн бол ямар болсон бэ? Парламентын гишүүд гэдэг жилдээ нэг ном унших завгүй хүмүүс байдаг. Тэгэхээр тэд нарыг мэдлэгжүүлж байдаг судалгаа шинжилгээний байгууллага хэрэгтэй байгааг олон хүн ярилаа.

ЭСТОНИЙ ТӨЛӨӨЛӨГЧ

Бодлогын болон академик судалгаа хийдэг байгууллага бол хоёр өөр юм. Бодлогын судалгаа хийдэг байгууллага нь ямар нэгэн улс төрийн хүчин, эрх ашиг, сонирхлоос хараат бус судалгааны байгууллага. Яамдын захиалгаар судалгаа хийж болно.

ЧЕХИЙН ТӨЛӨӨЛӨГЧ

Манайд бодлогын судалгааны 2-3 байгууллага байдаг. Нийгэм, улс төр, эдийн засгийн асуудлаар судалгаа хийдэг. Бодлогын сайн судалгааны байгууллагатай болоход 10 орчим жил болдог.

СЛОВАКИЙН ТӨЛӨӨЛӨГЧ

Манайх хууль, бодлогын асуудлаар судалгаа хийдэг хэд хэдэн байгууллагатай боловч саяхнаас л чанартай судалгаа гаргаж эхэлсэн. Ийм судалгааны байгууллагууд гол төлөв гадны санхүүжилтээр үүсч хөгждөг. Хүмүүсээ бэлтгэх хэрэгтэй юм.

ЛАМЖАВ /Иргэн/

Манайд ийм бодлогын судалгаа шинжилгээ хийхэд нэлээд бэрхшээлтэй. Учир нь хуулийн төслийн үзэл баримтлал нь хуулийн төслөөсөө нэлээд зөрөөтэй байдаг тохиолдол цөөнгүй байдаг. Тийм учраас оролцооны асуудал бол хуулийн төслийн үзэл баримтлалын асуудлын түвшинд бус бүр хэлэлцэж дуустал нь оролцох ёстой.

Ч.ТАМИР /МУИС-ийн багш/

Европын холбоо болон бусад гадны байгууллагаас иргэдийн оролцоог идэвхижүүлэх асуудалд хир нөлөөлж байсан бэ? Манайд донор байгууллагууд Засгийн газар, Парламент, яамдтай их ажилласан. Харин яг шийдвэр гаргахад шууд нөлөөлдөг улс төрийн намуудтай ер ажиллаагүй орхисон. Тиймээс намууд нь хуучнаараа байдаг. Зарим талаас хараад байхад бодлогын судалгааны байгууллага улс төрийн намыг дагаж хөгжих ёстой юм шиг харагддаг.

МИЛЕН ВЕТРАК

Гадаад орчны нөлөөг аль болох багасгах шаардлагатай. Гол нь ТББ-дын чадавхи чухал юм. ТББ-ууд өөрсдөө санаагаа борлуулж чаддаг байх ёстой. Словакт Лоббийн тухай хууль батлан гаргахад Европын шилжилтийн орнуудаас анх түрүүнд ийм хуультай орон болох гэж байна гээд Европын холбоо дэмжиж байсан.

Ж. НАРАНТУЯА /УИХ-ийн Тамгийн Газар/

Аливаа хууль санаачлах шатанд иргэдийн оролцоо чухал юм. Сонгосон гишүүндээ тийм хууль гаргах хэрэгтэй байна гэдэг саналаа хэлж байдаг. Харин хуулийн төсөл боловсруулах явцад мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн, ТББ-дын оролцоо чухал үүрэгтэй байдаг гэж хэлж болно. Гэхдээ бас иргэдийн оролцоо нээлттэй байх хэрэгтэй. Дараа нь нэгэнт боловсруулсан хуулийн төслөө хэлэлцэх явцад сайн хууль батлан гаргуулахын тулд лобби хийх асуудал бас чухал юм. Тиймээс одоо бүгдээрээ “Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь лоббийн үйл ажиллагаа” гэсэн хэсэгтээ оръё.

ХУРАЛДААН 3 - ПАРЛАМЕНТ ДАХЬ ЛОББИГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

ПАРЛАМЕНТ ДАХЬ ЛОББИГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ-СЛОВАКИЙН ЖИШЭЭ

ВИКТОРИЯ МЛИНАРЧИКОВА
/Словак улсын Нээлттэй нийгэм хүрээлэн/

Та бүхэнтэй ярилцах боломж олгосонд талархлаа илэрхийлье. Өнөөдөр илтгэл тавьж байгаа хамгийн сүүлийн хүн нь би учир та бүхнийг чилээлгүйгээр хэд хэдэн зүйлд хариу өгье гэж бодлоо.

Юуны өмнө өөрийгөө танилцуулъя. Би Словакийн Нээлттэй нийгэм сангийн хууль, төрийн удирдлагын хөтөлбөрийн захирал. Соросын сүлжээнд ажилд орохоосоо өмнө Словакийн Парламентад мэргэжлийн лоббичиноор бараг таван жил ажилласан учир өөрийн туршлага дээр үндэслэн лоббигийн үйл ажиллагааны тухай голлон ярина. Ихэнх хүмүүс лоббигийн талаар төрийн бус байгууллагуудын үүднээс ярьсан болохоор миний мэргэжлийн туршлагаас лоббигийн үйл ажиллагааг арай өөр өнцгөөс харах нь та бүхний сонирхлыг татах байх. Та бүхэн бухимдахгүй байх гэж найдаж байна. Учир нь би хувийн хэвшилд ажиллаж, нөлөөлөл, лоббигийн үйл ажиллагаагаар мэргэшсэн хүний үзэл бодол, туршлага юм гэдгийг ойлгоорой.

Словак улс дахь лоббигийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчны тухай товч ярья. Учир нь Милан та бүхэнд лоббигийн үйл ажиллагаатай холбоотой ихэнх зүйлийг танилцуулсан, үлдсэн нь Европын бусад оронтой адил байгаа. Би өөрийн Словакийн Парламент дахь ажлын туршлагаасаа хууль эрх зүйн зохицуулалт байхгүй ч лоббигийн үйл ажиллагааг хэрхэн явуулах арга хэлбэр, зөвлөмж, сурсан зүйлээсээ хуваалцана.

Хууль эрх зүйн баримт бичгийн хувьд Словак улс нь хэд хэдэн удаа лоббигийн үйл ажиллагааг зохицуулах хуулийн төслийг хэлэлцсэн ч одоог хүртэл Миланы хэлсэнчлэн лоббигийн хууль тогтоомжгүй байгаа. Хууль тогтоомжгүй хэрнээ ямар байдлаар мэргэжлийн лоббичны үйл ажиллагааг явуулдаг юм бэ гэж надаас хүмүүс асуусан. Миний өгөх хариулт нь маш энгийн. Яагаад гэвэл Словак улсын ямарваа хууль тогтоомжоор лоббигийн үйл ажиллагааг хориглоогүй бөгөөд Засгийн газар

эсвэл Парламентад лоббигийн үйл ажиллагааг явуулах нь хүлээн зөвшөөрөгдсөн албан ёсны зүйл юм.

Нэгэн зүйлийг дурьдалгүй өнгөрмөөргүй байна. Ихэнх тохиодолд лоббигийн үйл ажиллагааг авилгатай тэнцүүлж үздэгийг би хэд хэдэн удаа сонслоо. Тэгэхээр лоббигийн үйл ажиллагааны талаарх миний яриа нь авилгатай холбоогүй яриа байх болно. Лобби гэдэг нь хууль боловсруулах, тогтоох үйл явцад нөлөөлөх, хууль тогтоох боловсруулах үйл явцыг өөрчлөх үйл ажиллагаа юм. Мэдээж ашиг сонирхлоо хөөх асуудал лоббигийн хувьд байдгийг үгүйсгэхгүй ч, хамгийн чухал нь хууль боловсруулах үйл явцад нөлөөлөх арга хэлбэр гэдгийг цохон тэмдэглэе.

Лоббигийн үйл ажиллагааг ямар нэгэн хэлбэрээр зохицуулдаг хэдэн хууль байдаг. Үүний хамгийн хэрэгцээтэй чухал нь Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль. Энэ хуулийн тусламжтайгаар бид үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Институцууд болон тогтолцоонууд, үйл явцууд нээлттэй байгаа учраас лоббигийн үйл ажиллагаа боломжтой болсон. Би Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлагдахаас өмнө лоббичин болсон. Харин хууль батлагдаж, манай лоббигийн агентлаг хүлээн зөвшөөрөгдсөнөөс хойш үйл ажиллагааг явуулах нь хялбар болсон юм.

Парламентын түвшин дэх лоббигийн үйл ажиллагааны хувьд Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлагдангуут бүх үйл явцын нээлттэй ил тод байдал баталгаажсан. Хууль батлагдахаас өмнө ч Словакийн Парламент өөрийн вэбсайт болон мэдээлэл түгээх зорилготой байгуулагдсан харьяа агентлагуудаараа дамжуулан мэдээллийг нээлттэй байлгадаг байсан. Энд нарийн асуудал руу оролгүй мэдээлэл нээлттэй байсан юм. Хэрэв мэдээллийг олж чадахгүй бол хариуцсан хүмүүсээс мэдээллийг долоо хоногийн дотор олж авч болдог байсныг л хэлье.

Бусад орны илтгэгчидтэй ярьж байхад нэгэн сонирхолтой зүйл анзаарагдсан нь Словакийн Парламент жинхэнэ ёсоор нээлттэй юм байна гэдгийг ойлгосон. Лоббигийн үйл ажиллагааг эрх зүйн хүрээнд хуулиар зохицуулаагүй байгаа учир лобби хийж буй хүмүүсийг ч энгийн иргэд гэж үздэг ба лоббигийн үйл ажиллагаа явуулж буй хүмүүс Парламентын хуралдаанд сууж болдог. Парламентад ажиллаж буй ямар нэгэн хүнээс урилга хүсэхгүйгээр Парламентын веб сайт дахь урилгыг хэвлэж аваад хэн ч Парламентад очиж болдог. Маш нээлттэй. Хэрэв Байнгын хорооны хуралдаанаар үг хэлэхийг хүсвэл зөвшөөрөл хэрэгтэй болох ч энэ нь тийм хүндрэлтэй асуудал биш байдаг. Учир нь ямар нэгэн Парламентын гишүүнтэй холбоо бариад зөвшөөрлийн асуудлыг шийдэж болдог. Тухайн асуудлаараа өөрийн сонгосон Парламентын гишүүнтэй холбоо тогтоож тэдэнтэй ярилцана. Миний туршлагаас Парламентын гишүүдийн наян хувь нь хэнтэй ч уулзахаас татгалздаггүй нь тэд өөрсдийгөө мэдээллээр дутуу гэдгээ мэддэг. Хэрэв та тэдний дайсан байсан ч таны үзэл бодлыг сонсохыг хүсдэг. Парламентын гишүүд нэлээд нээлттэй байдаг ч тэдэнтэй хоёр гуравдагч этгээдүүдээр дамжуулан уулзах их ярвигтай байдаг. Вэбсайт нь ажилладаг ч гишүүдийн утасны дугаар, тэдний туслахуудын утасны дугаар байдаггүй. Жижиг зүйл мэт боловч их чухал зүйл. Тэгэхээр ямарваа асуудлаар хууль боловсруулах тогтоох үйл ажиллагаанд лобби хийхийг хүсэж буй төрийн бус байгууллага эсвэл лоббигийн агентлаг нь Парламентын гишүүдийн

мэдээллийн сантай байх шаардлага гарна, эс бөгөөс Парламентын клуб эсвэл хороодоор дамжуулна гэсэн үг. Эдгээрээр дамжуулж уулзах хүсэлтэй гишүүндээ утсаар хэлэх зүйлээ үлдээж, цахим шуудан бичсэн ч холбоо барина гэдэг нь маш хүндрэлтэй байдаг.

Тиймээс мэргэжлийн лоббигийн агентлаг бүр ажлаа гүйцэтгэхдээ хуримтлуулсан холбоо барих сантай байдаг.

- Парламентын түвшинд хэд хэдэн хэлбэрээр лоббигийн үйл ажиллагаа явуулж болдог.

- Парламентын гишүүдтэй уулзах;

- Байнгын хороодын хуралдаанд байлцах (нээлттэй журмаар Хороодын Хуралдаанд оролцож болдог ч зарим тохиолдолд хүндрэл үүсдэг. Жишээ нь, Словак улс Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хуулийг боловсруулж байсан үед Байнгын хороогоор хэлэлцэх болсон. Маш эмзэг асуудал байсан тул олон хүмүүсийг оролцуулахаас сэргийлэн жижиг өрөөнд хуралдахаар төлөвлөсөн байсан. Мэдээж олон хүн дургүйцлээ илэрхийлээд том өрөөнд бүтэн гурван өдөр хуралдсан жишээ ч бий. Эрүүл мэндийн асуудал бүх хүнд хамааралтай эмзэг асуудал шүү дээ, гэхдээ тийм эмзэг бус асуудал олон бий, тийм тохиолдолд лоббиг амжилттай хэрэгжүүлж болно. Харин улс төрийн шинж чанартай хувьчлал гэх мэт асуудал нь мэргэжлийн улс төрийн лобби шаарддаг);

- Парламентын хуралдааны үеэр үг хэлэх эрхгүйгээр ажиглагчаар байлцах (лоббигийн үйл ажиллагаа явуулж байгаа хүний хувьд энэ нь хамгийн эцсийн үр дүнгүй шат);

- Өргөх бичиг (лоббигийн үйл ажиллагаанд өргөх бичгийг хэрэглэдэггүй).

Лоббигийн үйл ажиллагаанд шууд бусаар нөлөөлдөг бусад хууль эрх зүйн баримт бичгүүд бий. Жишээ нь Үндэсний зөвлөлийн ба Засгийн газрын хууль тогтоох журам, үүнийг Милан танилцуулсан. Эдгээр журам нь лоббигийн тухай үг үсэггүй боловч лоббигийн үйл ажиллагааг явуулах үндэслэлийг олгодог. Дараагийн хууль эрх зүйн зохицуулалт нь Төрийн албаны хууль болон Эрүүгийн хууль юм. Та бүхэн авилгыг дурьдсан учир Эрүүгийн хуулийг заавал хэлэх шаардлагатай боллоо. Словакт олон нийтийн дунд нэгэн халуун хэлэлцүүлэг өрнөсөөр байгаа нь авлига ба лоббигийн ялгаа, тодорхойлолтын тухай маргаан юм. Түүхийн үүднээс үзвэл хэвлэл мэдээлэл энэхүү маргааны үндсийг тавьсан учир нь хэвлэл мэдээлэл лоббичдыг авилгачид гэж бичсээр ирсэн л дээ. Эцэстээ хэвлэл мэдээлэл сэрээд лоббигийн үйл ажиллагаа нь авилгаас өөр зүйл ч, ер нь энэ хоёр үйл ажиллагааны нарийн зааг ялгаа юу вэ гэсэн асуултыг өөрсдөдөө болон нийгэмд тавьсан. Харин лоббичид бидний хувьд авилгыг эрүүгийн гэмт хэрэг гэж үздэг байр сууриа байнга илэрхийлсээр ирсэн.

Хэвлэл мэдээллийн тухайд нэгэн зүйлийг хэлэхэд лоббигийг үйл ажиллагаа олон нийтэд хандсан байдаг учир энэ олон нийтэд хандах, олон нийтийг уриалан дуудах үйл ажиллагаа нь хэвлэл мэдээллийн тусламжтайгаар хийгддэг. Тиймээс

PR болон лоббигийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд хийдэг хүмүүс хэвлэл мэдээллийнхэнтэй маш ойр хамтарч ажилладаг.

Дараагийн үе шат нь лоббигийн үйл ажиллагааг зохицуулсан хуулийн төслийг боловсруулах, нээлттэй хэлэлцүүлэгт оруулах үе шат байсан. Хувийн хэвшлийн сектор болон төрийн бус байгууллагынхан олон санал өгсөн бөгөөд хувийн хэвшлийнхний санал давамгайлж байсан. Засгийн газар ч мөн энэ хуулийг авч үзэхдээ улс төрийн өөр өөр үзлээр харан, эцэстээ хуулийн төсөл батлагдаагүй. Энэ хууль нь батлагдахад мэргэжлийн лоббигийн үйл ажиллагаа явуулдаг хүмүүст маш хэрэгцээтэй хууль болно. Ийм эрх зүйн зохицуулалт үүсээгүй байгаагаас хойш лоббичид энгийн иргэдтэй адил арга хэрэгслийг ашиглахад хүрдэг. Энэ нь зарим тохиолдолд амжилт дагуулна, зарим тохиолдолд цаг хүч зарсан ч амжилт авчирдаггүй тул бэрхшээлтэй байдаг.

Сонирхсон хүмүүс байвал надад лоббигийн хуулийн англи хэл дээрх төсөл бий. Энэхүү төсөлд Америкийн Худалдааны Танхим болон Словакийн хувийн хэвшлээс ирүүлсэн саналыг багтаасан хувилбар нь юм. Харахад сонирхолтой байж мэдэх учир нь энэхүү хуулийг баталснаар үүсэх бэрхшээл хүндрэлүүдийн талаар тэдний бичсэн санал нь Польшийн хуулийн хэрэгжилтэд тулгуурласан байсан. Энэхүү хуулийн төслийг хэлэлцэх үед ч лоббигийн үйл ажиллагааны тодорхойлолт дээр маргаан үүссээр байсан. Миланы хэлснээр Европын бусад бүх орон лоббиг зохицуулсан эрх зүйн зохицуулалттай болсон учир бид лоббигийн хуультай болох шаардлагыг ухаарчихаад одоо үүнийгээ хэрхэн хэрэгжүүлэхээ мэдэхгүй зогссон. Их Британид лоббигийн хуулийг бидний анх бүдэрсэн чулуу болсон лоббигийн тодорхойлолт дээр санал нэгдэж чадаагүйн улмаас бас л баталж чадаагүй. Энэхүү хуулийг санаачлан батлахыг зорьж буй ямар ч орны хувьд энэ нь хүндрэлтэй байх болов уу.

Лоббигийн асуудлыг хэвлэл мэдээллээр дамжуулан олон нийтээр хэлэлцүүлэх нь маш чухал гэдгийг би дахин хэлмээр байна. Хэрэв хэвлэл мэдээллийг ашиглаж чадахгүй бол амжилтад хүрэх нь их эргэлзээтэй. Нөлөөлөл болон лобби гэж юу болох талаар нийгэмд нээлттэй хэлэлцүүлэг үүсгэхийн эхний шат болох тул бусад илтгэгчдийг сонсож байхдаа лобби гэсэн үг багтсан нэртэй төрийн бус байгууллагыг Монголд бий болгосонд би их бахархсан. Өмнөх илтгэгчид маань лобби гэж үгийг хэрэглэлгүй иргэдийн оролцоо, төрийн бус байгууллагын оролцоо гэсэн үгсийг олон удаа хэрэглэсэн. Миний бодлоор энэ болгон лобби, учир нь иргэд ганц ганцаараа хууль тогтоох боловсруулах үйл явцад оролцдоггүй, ихэнхдээ бүлэг хүмүүс байдаг. Харин бүлэг бүр, тодорхой хүсэл сонирхолтой. Сонгогч бүр байгаль орчныг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эсвэл үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалах гээд өөр өөрсдийн ашиг сонирхолтой. Миний хувьд энэ нь хариулмааргүй байгаа нээлттэй асуулт. Гэвч нөлөөлөл гэдэг нь олон нийтийн ашиг сонирхол дээр голлодог бол лобби нь хувийн ашиг сонирхол дээр голлодог. Гэвч зааг ялгаа нь бас л бүдэг. Нэг жишээ хэлье. Би лоббичноор ажиллаж байхдаа ширхэгийн худалдаа эрхэлсэн дэлгүүрийн сүлжээний нээгдэх хаагдах цагийн хуваарийн талаар лоббигийн үйл ажиллагаа явуулж байсан. Тэр үед бид судалгаа хийгээд Словак иргэдийн наян хувь нь супермаркетуудыг орой болтол ажиллаж, нямд нээлттэй байлгах хүсэлтэйгээ илэрхийлсэн байсан. Гэвч энэ асуудал хувийн ашиг сонирхлын асуудал байсан уу, олон нийтийнх байсан

уу? Бид дэлгүүрийн сүлжээг хариуцаж байсан тул хувийн ашиг сонирхлын төлөө ажиллаж байсан мэт харагдах боловч нөгөөтэйгүүр хүн амын наян хувийн ашиг сонирхлын асуудал байсан учир олон нийтийн асуудал байсан. Хувийн ба олон нийтийн гэдэг ойлголтын дундах ялгаа их бүдэг гэж би үздэг. Энэ талаар хэлэлцэж, маргалдаж болно. Зарим тохиолдолд яалт ч үгүй аль нэг ашиг сонирхол нь давамгайлсан байдаг. Хууль эрх зүйн зохицуулалт байхгүй ч Словакт явагдсаар байгаа маргаан Монголд ч хэлэлцэх ёстой асуудлын нэг юм.

МОНГОЛ ДАХЬ ЛОББИ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ц.ОЮУНБААТАР
/Консенсус төвийн захирал/

Эрхэм хатагтай, ноёд оо!

Монгол оронд албан ёсны лоббийн тогтолцоо байхгүй. Үүнийг бий болгох талаар ардчиллын 15 жилийн түүхэнд төр засгаас ямар нэг алхам хийсэнгүй. Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудад лоббийн тогтолцоо төлөвшин эрх зүйн зохицуулалт бүрэлдэж хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд эерэг нөлөө өссөөр байна.

1998 оны орчим Хууль зүйн сайд Л. Цогийн санаачилгаар Лоббийн тухай хууль боловсруулах оролдлого хийгдэж байсан. 2004-2005 онд Лоббийн хуулийн төсөл Удирдлагын академийн багш нар манай Лобби төвийн судлаачдын оролцоотой хийж байна. Нэгэнт албан ёсны лоббийн тогтолцоо байхгүйгээс үүний хоосон зайг монгол төрийн тогтворгүй, үймээнтэй цаг үед Лоббийн үйл ажиллагаа:

- улс төр, бизнес бүлэглэл /олигархи/
- аймаг, бүс нутгийн холбоо, зөвлөл /нутгийн зөвлөл/
- ашиг сонирхлын бүлэглэл /анги, сургууль, найз нөхөл, танилын холбоо/

хэрэгжүүлэх хэлбэр ресторан, баар, тусгай байранд уулзан тохирох, нэр нөлөө бүхий хүмүүсийг ашиглах, үлэмжхэн мөнгө хөрөнгө зарцуулах, хахуульдах, авилгал өгөх зэрэг. Энэ нь нэг талаас хууль тогтоох үйлчилгээгээ УИХ-ын гишүүд худалдах, нөгөө талаас тодорхой хууль батлуулах, өөрчлөх зэргээр төлбөр төлж ардчилал, шударга ёс алдагдахад хүрч байна. Монголын лобби мөнгөн дээр суурилсан арилжаа юм.

Лоббийн үйл ажиллагаа бүхэлдээ хөрөнгө мөнгөн дээр зогсож байна. Хууль тогтоох байгууллагад сонгогдох нь сонгогчдын саналыг худалдан авах томоохон компани ажил болж хувирсан бөгөөд лоббийдуулах УИХ маань авилгалын томоохон сүлжээ болсон байна. Үүнийг би биш судлаачид ч биш улс төрийн намуудын удирдлагууд олон нийт мэдэгдэж сонгуулийн дүнг хүлээн авахгүйгээ зарлаж, хахуулийн зүйлээр үзэсгэлэн музей гаргаж олон мянган хүн үзэж байв.

Монголд төрийн боловсон хүчний бодлого бүрэн алдагдав. Улс төрийн намууд бие биенээ шүүмжлэх боловч зарчмын ялгаа алга. Сонгодог лобби нь мэргэжлийн лоббист хэрэгжүүлэх бөгөөд 2003, 2005 онд 2 удаа бид лоббист бэлтгэх сургалтыг

зохион байгуулж явуулсан юм. Гол нь Улс төрийн академийн сонсогчид, парламентын экс гишүүд сургалтад хамрагдсан. Парламентын гишүүд 4,8,12 жилээр хууль боловсруулсан, асар өндөр мэдлэг туршлагатай хуульч, улс төрч, олон салбарын өргөн мэдлэгтэй байдаг. Энэ хүмүүс лоббистод ажиллах Монголд лоббизм үүсгэн байгуулж ажиллах таатай нөхцөл бүрдүүлнэ. Парламентын шинэчлэл клуб үүний эхлэл юм.

Зөв лобби нь хуулиар баталгаажсан, хяналтын олон нийтийн эрх ашгийг илэрхийлсэн байх ёстой. Хахуульд автагдах явдлыг багасгах, эрх мэдлийн байгууллагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, хууль ёсонд нийцтэй байдлыг нэмэгдүүлэх, ингэхдээ нийгэм /иргэд/ ба эрх мэдлийн харилцан үйлчлэлцэх явцыг зохион байгуулалттай, хууль ёсонд нийцтэй шинжтэй болгох ёстой.

Бидний үзэж буйгаар лоббизмын тухай хууль тогтоомж нь суурь, зохицуулагч, мөн түүнчлэн түүнийг батлан гаргаснаар эрх зүйн актууд болон хуульчилсан акт гаргах боломжтой байхуйц тийм тулгуур хууль байх ёстой. Эдгээр нь бусад хууль тогтоомжид харгалзан үзээгүй байж мэдэх бүх асуудлыг зохицуулахад зайлшгүй шаардлагатай.

Консенсус лобби төв нь 2002 онд байгуулагдсан анхны албан бус лоббийн тогтолцоо юм. Консенсус лобби төв нь нам бус, ашгийн бус, ТББ бөгөөд олон ургальч үзлийг гүнзгийрүүлж шударга ёсыг тогтоох, бүлэглэлийг зөвшилцөлд хүргэх зорилготой.

Үзэл баримтлал

Монголын төр, ард түмэн эв нэгдэл, зөвшилцлийн ачаар тусгаар тогтнож, хүчирхэг болж ирсэн түүхэн уламжлал ёсоор шударга ёсонд үндэслэсэн ардчилсан төрийн замнал ч үндэсний эвсэл, зөвшлөөр эхэлсэн билээ. Ардчилал нь байнгын хөгжил, хөдөлгөөнд оршиж төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, иргэдийн санаачилга, итгэл үнэмшил, улс төрийн соёл, ухамсараар баталгааждаг ажгуу.

Зорилго

Монголын ард түмний язгуур эрх ашгийн төлөө улс төрийн хүчнүүдийн хамтын ажиллагаа, зөвшилцөлд хүрэхэд чиглэгдсэн улс төрийн шинэ тогтолцоог бий болгоход хувь нэмэр оруулах.

- Лоббизмын эрх зүйн институц бий болгох
- Иргэдийн санаачилга, улс төрийн эрх төр засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, авилгалтай тэмцэх санаачилгыг дэмжих замаар шууд ардчиллын механизмыг дэмжих.
- Зөвшилцөлд тулгуурлан нийгэм, эдийн засгийн эрчимтэй хөгжлийг хангахад хувь нэмэр оруулах

Зарчим

- Консенсус лобби төвийн үйл ажиллагаа нь олон нийтэд нээлттэй, олон ургальч үзлийг дээдэлсэн байна.
- Үйл ажиллагаандаа ардчилсан зарчмыг удирдлага болгоно. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- Улс орныг хөгжил дэвшилд хүргэх зөвшилцөл, нэгдмэл байх зарчмыг удирдлага болгоно.

ХБИ-гэй хамтарч 30 гаруй төрийн бус байгууллагыг оролцуулан бүтэн жилийн хугацаанд ажиллаж, ХБИ-ийн нийгмийн хамгааллын тухай хуулийг боловсруулж УИХ-д өргөн бариад байна. Энэ бол ТББ-уудаас анх удаа ийм томоохон багц хуулийг бие даан боловсруулж УИХ-д өргөн барьсан үйл ажиллагаа бөгөөд 1000 гаруй иргэдээс социологийн судалгаа авч арваад орны энэ төрлийн хууль тогтоомжийг нарийвчлан судалж, 2 хэсэг, 12 бүлэг, 62 зүйлээс бүрдэх хуулийг боловсруулсан юм.

Энэ хугацаанд мөн ЭИ байгууллагатай хамтран зэвсэглэлийг хязгаарлах асуудал, цаазаар авах ялыг халах, сэтгүүлчдийг эрүүгийн хариуцлагад татах явдлыг цуцлах зэрэг томоохон лоббийн үйл ажиллагааг зохион байгуулж явууллаа.

Монгол орны байгалийн баялгийг нийт иргэдэд шударга тэгш хуваарилах, хувьцаа нэрийн данстай болгох, говийн бүс нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах, дэлхийд ховордож байгаа хоёр бөхт тэмээг өсгөх, хамгаалах зэрэг чиглэлээр лоббийн үйл ажиллагаа явуулж байгааг та бүхэнд уламжилъя.

Манай төв дээр улс төрийн нам, ТББ-ууд хурал, семинар зохион байгуулж хамтын үйл ажиллагаа идэвхтэй зохион байгуулж явуулж байна. 60 хүний суудалтай лобби хуралдааны танхим, 2500 номтой номын сангаар үйлчилдэг бөгөөд олон улсын байгууллагуудтай хамтран авилгалтай тэмцэх, хүний эрхийг хамгаалах, нийгмийн шударга ёсыг төлөвшүүлэх, ёс зүйтэй эрүүл нийгмийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр өргөн хүрээнд ажиллаж байна. Та бүхнийг манай лобби төвөөр зочлохыг урьж байна. Төрийн ордны зүүн талд 50 метрийн зайнд байрлаж байна.

АСУУЛТ -ХАРИУЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монголын хувьцаа эзэмшигчдийн холбооны дэд ерөнхийлөгч Польшид 17 жилийн дотор гурав удаа ард нийтийн санал асуулга явуулсан байна. Үүнд ямар хүчин зүйл нөлөөлсөн бол?

МАКОВСКИ

Германд 1945 оноос хойш нэг ч удаа ард нийтийн санал асуулга явуулаагүй байгаа. Тиймээс референдумыг ач холбогдлыг бас хэтрүүлж үнэлж болохгүй. Польшид хувьчлалын асуудлаар, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар хоёр удаа ард нийтийн санал асуулга явуулсан. Зайлшгүй шаардлагатай үед тухайн асуудлаар ард нийтийн санал асуулга явуулах нь ардчилалын чухал хэлбэр болдог.

Ж.НАРАНТУЯА /УИХ-ын Тамгын Газар/

Энэ хэсгийн хуралдааныг дүгнэж хэлэхэд нэгдүгээрт, манай Парламентад иргэд, ТББ-уудын оролцоо тодорхой түвшинд байна гэж хэлж болно. Цаашид оролцооны талаархи зохицуулалтыг холбогдох хуульд илүү нарийвчлан оруулах нь зүйтэй байна. Хоёрдугаарт, оролцооны талаархи одоогийн зохицуулалтын боломжийг ТББ-ууд хэр зэрэг ашиглаж чадаж байна вэ, ТББ-ууд парламентад хэрэгтэй мэдээллийг өгч чадаж байна уу гэдэгт бас анхаарлаа хандуулж ажиллах шаардлагатай байгаа. Гуравдугаарт, Парламентад бодлогын судалгааны төв зайлшгүй хэрэгтэй байгаа. Дөрөвдүгээрт, Лоббийн тухай зохицуулалтыг буй болгох нь зүйтэй гэж үзэж байна. Хуралдаанд идэвхитэй оролцсон та бүхэнд баярлалаа. Дараагийн өдрийн хуралдаанд амжилт хүсье.

**2007 ОНЫ НЭГДҮГЭЭР САРЫН 16-НЫ ХУРАЛДААН:
ХУРАЛДААН 4-“ЗАСГИЙН ГАЗРЫН ТҮВШИН ДЭХ ОРОЛЦОО”**

Хуралдаан даргалагч Нээлттэй Нийгэм Форумын менежер Ж.Баярцэцэг

Хурал даргалагч

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн хуралдааны сэдэв маань “Засгийн газрын түвшинд иргэдийн оролцоо ямар байх вэ?” гэсэн асуудал байх болно. Өчигдрийн хуралдаанд ярьснаар УИХ-д өргөн мэдүүлж байгаа хуулийн төслийн 80 гаруй хувийг Засгийн газраас, 15 орчим хувийг УИХ-ын гишүүдээс, 5 орчим хувийг Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлдэг байна. Энэ статистикаас харахад Засгийн газрын түвшинд, ялангуяа яамны түвшинд хуулийн төсөл боловсруулах үйл явцад иргэд оролцох нь ямар их ач холбогдолтой болох нь ойлгомжтой юм. Тиймээс бид энэ сэдвээр ярих гэж байна. Эхлээд “Яамны түвшинд хуулийн төсөл боловсруулахад оролцоог хангах боломж” гэсэн сэдвээр Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль зүйн газрын дарга Цолмон илтгэл тавина. Хөтөлбөрт тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Баясгалан илтгэхээр орсон боловч тэрээр Байнгын хорооны хуралд асуудал оруулж байгаа учраас амжсангүй.

**ЯАМДЫН ТҮВШИНД ХУУЛИЙН ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХАД ИРГЭД, ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГЫГ ОРОЛЦУУЛАХ НЬ**

*Ц.ЦОЛМОН /Хууль зүй, дотоод хэргийн Яамны
хууль зүйн бодлогын газрын дарга/*

Илтгэлийнхээ эхэнд Монгол улсын Үндсэн хуулиар тогтоосон хууль санаачлагчдын нэг болох Засгийн газраас баримталж буй журмын талаар товч дурдъя гэж бодож байна. Энэ үйл ажиллагааг 1997 онд анх баталж, 2001 онд шинэчлэн найруулсан Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль болон Засгийн газрын тухай хуулийн хүрээнд зохицуулж байна.

Засгийн газраас санаачлах хуулийг төлөвлөх, боловсруулах, хэлэлцэж өргөн мэдүүлэх гэсэн гурван үндсэн үе шатаас бүрддэг. Монгол улсын эрх

зүйн шинэтгэлийн хөтөлбөр, нийгэм, эдийн засгийн салбаруудын хэрэгцээ, шаардлагад тулгуурлан Монгол улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг Засгийн газар, тодруулбал хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан боловсруулж Улсын Их Хурлаар батлуулах замаар хууль санаачлах үйл ажиллагаа төлөвлөгддөг. Энэхүү төлөвлөгөө буюу үндсэн чиглэлд тусгагдах асуудлыг салбарын яамдаас саналыг нь авч ийм хууль санаачлах үндэслэл шаардлага байгаа эсэх талаар судалсны үндсэн дээр шийдвэрлэж байна.

Хууль санаачлах эрхээ хэрэгжүүлэх дараагийн үе шатны ажиллагаа нь хуулийн төсөл боловсруулах юм. Энэ ажиллагааг хууль санаачлагч нь өөрөө хуулийн төслөө боловсруулах, холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах, эсхүл иргэн, хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх гэсэн хэлбэрээр зохион байгуулахаар холбогдох хуульд заасан байгаа. Хууль боловсруулах ажил нь өргөн мэдлэгт тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд хийх зүй ёсны шаардлагатай учраас ихэвчлэн ажлын хэсэг байгуулах замаар хийгддэг. Ажлын хэсгийг янз бүрийн түвшинд байгуулдаг, яамдын тухайд ихэвчлэн тухайн асуудлыг хариуцсан Сайдын тушаалаар томилж, түүний дотор Хууль зүйн яамны төлөөллийг оролцуулах, эсхүл сайд нар хамтарсан ажлын хэсэг зохион байгуулах хэлбэрээр хийдэг.

Яамдын дэргэдэх ажлын хэсэг үзэл баримтлалыг боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлуулахаар ирүүлдэг журамтай. Үзэл баримтлалыг тус яам хянаж үзээд Үндсэн хууль болон бусад хуульд харшлахгүй бол баталж хүргүүлдэг. Баталсан үзэл баримтлалын дагуу хуулийн төслөө боловсруулж, уг төсөлд Засгийн газрын бусад гишүүдээс санал авч нэгтгэн хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлэх хүртэл боловсруулалтын нэг үе шатны ажил дуусдаг.

Тус яам Засгийн газрын түвшинд хуулийн төсөл боловсруулах явцад голлох үүргийг гүйцэтгэдэг. Юуны өмнө дээр дурдсанчлан үзэл баримтлалыг хянахаас гадна хуулийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагууд болон бусад хуульд нийцүүлэх талаар санал зөвлөгөө өгөх, эцэслэн боловсруулах шатанд хамтарч төслийг бичих зэргээр оролцдог. Бас нэг чухал үүрэг бол Засгийн газраар хэлэлцүүлсний дараа эцэслэн хянаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгох явдал байдаг.

Энэхүү Засгийн газраас хууль санаачлах үйл ажиллагаанд иргэдийн болоод төрийн бус байгууллагын оролцоо хэрхэн хангагдаж байна вэ гэдгийг авч үзье.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд тэдний оролцоог хангахад чиглэгдсэн хэд хэдэн заалтууд байна. Тухайлбал, хуулийн 8.3-т ашгийн бус байгууллага хуулийн төсөл боловсруулах ажиллагааг санхүүжүүлж болохоор, мөн хуулийн 9.9-д төсөл боловсруулах явцад холбогдох мэргэжилтэн, байгууллага, шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага болон бусад байгууллага, иргэдээс санал авч төсөл боловсруулахад харгалзан үзэж болохоор тус тус заасан.

Үүнээс илтгэгч миний судалснаар төрийн бус байгууллага хуулийн төсөл боловсруулахад гадаад улс, олон улсын байгууллагаас мэргэжилтэн урьж зөвлөгөө өгөх, гадаад оронд туршлага судлахад дэмжлэг үзүүлэх, хурал зөвлөгөөн зохион байгуулахдаа төрийн байгууллагуудыг урьж оролцуулах, хуулийн төсөл боловсруулж хууль санаачлагчид өгөх, хуулийн төсөлд санал өгөх зэрэг хэлбэрээр санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх хэлбэрээр оролцож байна.

Энэ үйл ажиллагаа зөвхөн төрийн байгууллагын санаачилгаар явагдаад байдаггүй. Яамдын ажлын хэсэг байгуулахдаа ТББ-ын төлөөллийг оролцуулахаас гадна хуулийг хэрэгжүүлэхэд оролцох байгууллагаас саналыг нь авах явдал нэлээн түгээмэл байдаг. Жишээ нь тус яамны дэргэд хуулийн төсөл боловсруулах чиглэлээр байгуулагдсан 20 ажлын хэсгийн тушаалыг судлан үзэхэд хуулийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон хуулиудыг боловсруулахад Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн чиглэлийн их, дээд сургуулийн эрдэмтэд, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн ажлын хэсэгт Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Монголын Хэвлэлийн Хүрээлэн, Монголын өдөр тутмын сонины холбооны удирдлагууд, Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн ажлын хэсэгт “Глоб интернейшнл”, “Нээлттэй Нийгэм Форум” төрийн бус байгууллагын ажилтнуудыг гэх зэргээр 10 ажлын хэсэгт төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж байгуулсан байна.

Иргэдийн тухайд хуулийн төсөл боловсруулахад оролцож байгаа үндсэн хоёр хэлбэр байна. Юуны өмнө иргэд өөрсдөө санал ирүүлэх явдал байна. Ийм журмаар ирүүлсэн саналд Төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу 20 хоногийн дотор хариу өгөх журамтай байдаг. Хуульд ирүүлж буй иргэдийн санал ихэвчлэн практикт тулгуурласан санал байдгаас гадна хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны онцлогоос хамаарч шууд аваад шийдвэрлэгддэггүйг дурдаж байна. Иргэдээс ирсэн саналуудыг ажлын хэсэг байгуулагдсан нөхцөлд ажлын хэсгээр хэлэлцүүлэх, тухайн хуульд өөрчлөлт оруулах ажил төлөвлөөгүй нөхцөлд цаашдын ажилдаа анхаарах чиглэлээр хариу өгөх зэргээр асуудлыг шийдвэрлэдэг. Өнгөрсөн онд тус яаманд иргэдээс Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Нийгмийн халамжийн тухай, Хуульчдаас сонгон шалгаруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг хуульд өөрчлөлт оруулах талаар 10 гаруй өргөдөл ирсэн. Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд оруулахаар ирүүлсэн саналыг ажлын хэсгүүд дээр хэлэлцүүлсэн.

Харилцаа, холбоо технологийн хөгжилтэй уялдаад сүүлийн үед интернетээр харилцах замаар санал санал авах явдал дэлгэрч байгаа. Засгийн газар “Нээлттэй засаг” вэб хуудастаа хуулийн төслүүдийг тавьж хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж байна. Уг хуудсыг нээж үзэхэд Ашигт малтмалын тухай, Ашгийн бус хуулийн этгээдийн тухай, Мэдээллийн эрх чөлөөний тухай, Гаалийн тухай, Гаалийн тарифын тухай зэрэг хуулийн төслийг тавьсан байгаа.

Түүнээс гадна төрийн ихэнх байгууллага өөрийн вэб хуудсуудад хуулийн төслүүдийг нийтэлж, санал авах тусгай линк байршуулсан боловч иргэд, байгууллагаас ирүүлсэн саналыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан байдлын талаар эргээд мэдээлэх

механизм байхгүй байгаа нь ажиглагдаж байна. Төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо өнөөгийн түвшинд иймэрхүү хэмжээнд хэрэгжиж байна.

Засгийн газар тодорхой зорилго, зорилтууд тавьж ажиллаж байна. Эрх зүйн шинэтгэлийн талаар хэдэн үг хэлэх хэрэгтэй гэж үзэж байна. 1992 онд Монгол Улсын үндсэн хууль батлагдснаас хойш 360 орчим хууль батлагдан хэрэгжиж байна. Үүнээс үзэхэд нийгмийн бүх салбарын харилцааг шинэ Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн өөрчлөх үйл явцын тодорхой үеийн ажил хийгдэж дууссан гэж хэлж болохоор байгаа юм. Үүнийг ганцхан дээр дурдсан тооны үзүүлэлтээр төдийгүй утга агуулга, чанарын хувьд ч өөрчлөлт хийгдсэн гэдгийг олон судлаач, эрдэмтэд тэмдэглэн хэлсэн байдаг.

Засгийн газар ч энэ байдалд дүгнэлт хийж дараагийн үе шатны зорилтоо тодорхойлох зорилгоор 1998 онд Улсын Их Хурлаар баталсан Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх ажлыг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулан хэрэгжүүлэхээр төлөвлөөд ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд хуулийн төсөл боловсруулах ажлын чанарыг сайжруулах чиглэлийг баримтална. Хуулийн үзэл баримтлал гэдэг бол хамгийн чухал баримт бичиг байдаг, одоогийн түвшинд бид хуулийн төслөө эхэлж хийчихээд дараа нь түүндээ тааруулж үзэл баримтлалаа бичих явдал гарч байгааг юуны өмнө өөрчилнө. Бас нэг яах аргагүй анхаарах асуудал бол төсөл боловсруулах ажлыг хэрэгжүүлэгч байгууллага хариуцаж байгаа нь тухайн байгууллагын хүсэл, сонирхол түлхүү орж батлагдах явдал байгаа.

Иймд үзэл баримтлалд тусдаг зарчмын асуудлууд, тодруулбал, хууль боловсруулах үндэслэл, шаардлага, хуулиар зохицуулах харилцааны хүрээ зааг, батлагдсны дараа гарах нийгэм, эдийн засгийн үр нөлөөг бүх талаас нь нарийн нухацтай судалсны дараа хууль санаачлах, хуулийн төслийг боловсруулж байх тогтолцоог бий болгох зорилт тавьж байна. Судалгаа хийх явцаас эхлээд эрх ашиг нь хөндөгдөх этгээдийн саналыг авах, иргэдийн төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх хандлагыг барина.

Үүнээс гадна хуулийн төсөл боловсруулах ажлын чанарт нөлөөлж буй хүчин зүйлүүд олон байгаа /хууль эрх зүйн орчин, төсөл боловсруулж буй төрийн албан хаагчдын чадавхи, төрийн байгууллагуудын уялдаа холбоо, чиг үүрэг гэх мэт/ тодруулж сайжруулах шаардлагатай байгаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт /2004-2008 оны/ “иргэддээ үйлчлэх төрийн байгууллага, албан хаагчдын хариуцлага, чадавхийг дээшлүүлж, шийдвэр гаргах бүх түвшинд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хэвшүүлэн төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргах” гэсэн үндсэн зорилтыг тодорхойлсон.

Энэ зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газар Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулсан. Энэ хуулийн гол агуулга нь иргэдийг мэдээллээр хангах тогтолцоог боловсронгуй болгох, нууцад хамаарахаас бусад мэдээлэл аль болох хүртээмжтэй байх нөхцлийг бүрдүүлэхэд оршиж байгаа

юм. Мөн төсөлд төрийн байгууллагууд мэдээллийн хэрэгслээр хууль, УИХ-ын шийдвэрийн төслөөс гадна хууль тогтоомж, бусад шийдвэрийн төсөлд санал өгөх журмыг нийтэд мэдээлж байх талаар тусгаж өгсөн. Ингэснээр иргэд, байгууллагаас санал өгөх, хүлээн авч шийдвэрлэх зохицуулалт тодорхой болох юм.

Ер нь эрх зүйн бодлогын хувьд бидний тавьж буй зорилт бол аливаа асуудлуудыг цогцоор нь авч үзэхэд чиглэгдэнэ. Захиргааны эрх зүйн шинэтгэлийн хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, хүнд суртлыг багасгах, шийдвэр гаргах үйл явц болоод шийдвэрийг олон нийтэд мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг сайжруулах зэрэг зорилтын хүрээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх асуудлыг анхаарах болно.

Энэ асуудлаар бид судалж эхэлж байна. Сүүлийн үед бусад улсад ч хуулийн төслийг нийтэд мэдээлэх, нийтээс санал авах хандлага дэлгэрч байгаа юм байна. Хуулийн төслийг /public legislative hearing/ нийтэд мэдээлэх, сонгох арга нэлээн түгээмэл хэрэглэгддэг байна. 2000 оны 3 дугаар сард Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн хурлаас баталсан Хууль тогтоох тухай хуульд төрөөс шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцох боломжийн талаар тусгасан байна. Тус улсад иргэдийн оролцоог хангах ажлыг 2003 оноос эхлэн Хятадын хууль зүйн төв хэрэгжүүлж байгаа гэсэн байна.

АНУ-д интернетийг ашиглаж санал авах явдал голлон дэлгэрсэн байна. Мөн түүнээс гадна конгрессийн гишүүд өөрийн санаачилсан хуулиа мужийн хууль тогтоох эрх бүхий байгууллагын вэб сайтад байршуулж санал авахаас гадна биечлэн хүлээн авч уулздаг гэсэн байна.

Мөн “notice comment” гэж нэрлэгддэг аргыг өргөн хэрэглэж байгаа юм байна. Энэ нь эхлээд хуулийн төслийг олон нийтийн хүртээл болгоод иргэдээс ирүүлсэн саналыг судалж, зохих хариу өгөх, ингэснээр иргэдийн идэвх, сонирхлыг ч төрүүлэх ач холбогдолтой байна. Украинд иргэдтэй уулзалт зохион байгуулж санал бодлыг хүлээн авч тусгах арга хэмжээ авдаг гэсэн байна.

Хуулийн төсөл боловсруулах ажилд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд олон улсын чиг хандлага, туршлага, цаашилбал тэдгээрийг хангах арга механизмын судлах асуудал яах аргагүй чухал гэдгийг тэмдэглэхийн зэрэгцээ олон улсын байгууллага, гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид оролцсон энэ хоёр өдрийн семинар ач холбогдлоо өгнө гэж үзэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

“ЧЕХ УЛСЫН ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО”

МИКАЛ ШТИЧКА

*/Чех улс дахь Транспэрэнси интэрнейшнл байгууллагын
авилгатай тэмцэх асуудлаар хуулийн зөвлөгөө өгөх төвийн тэргүүн*

Оршил

Ноёд, хатагтай нараа,

Танай сайхан оронд зочилж, Монгол улсын Их Хурал болон Нээлттэй Нийгэм Форумас хамтран зохион байгуулж буй энэхүү семинарт оролцох бололцоо олгосонд ихэд талархаж буйгаа хэлмээр байна.

Хууль тогтоох үйл явц өөр өөр загвартай байдгаас шалтгаалан түүнд оролцох иргэний нийгмийн үүрэг оролцоо⁸⁵ өөр өөр байдгийг харуулахад энэхүү мэдээллийн зорилго оршино. Хууль тогтоох үйл явцад ИНБ-уудыг нэгтгэн оролцуулах чиглэлээр авч буй арга хэмжээ нь тухайн улс орны хууль тогтоох үйл явцын мөн чанарыг тусгасан байх учиртай.

Энэхүү мэдээллийн эхний хэсэгт хууль тогтоох үйл явцад иргэд ямар арга замаар оролцдог талаар мэдээлэл хийх болно. Дараагийн хэсэгт нь хууль тогтоох үйл явцын хоёр үндсэн загварын талаар товч мэдээлэх бөгөөд гурав дахь хэсэгт нь хууль тогтоох үйл явцад иргэдийг оролцуулах талаар Бүгд Найрамдах Чех Улсын парламентын одоогийн үйл ажиллагаанд тогтсон зарим нэгэн жишээг дурьдах болно. Төгсгөлд нь танай улсын парламентын үйл ажиллагаанд ч ашигтай байж болох хэд хэдэн зөвлөмжид та бүхний анхаарлыг хандуулах юм.

Иргэдийн оролцооны хэв загвар

Ерөнхийдөө иргэд хууль тогтоох явцад улс төрийн намууд эсвэл иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан оролцдог. Улс төрийн намуудын хувьд ардчилсан сонгуулийн үр дүнд хууль тогтоох байгууллагын эрхийг авахыг эрмэлздэг бол ИНБ-ууд нь эрх баригчдад нөлөөлөх арга замыг хайж байдаг.⁸⁶

⁸⁵ Цаашид ИНБ-ууд гэх

⁸⁶ Иргэдийн оролцооны энэхүү хоёр төрөл нь харилцан тэнцвэртэй байх нь чухал. Хэт туйлшрал (намчирхсан төр эсвэл байгууллагажсан төр) нь улс орны ардчилалд сөрөг нөлөөтэй тул ийм байдлаас зайлсхийж байх нь зохистой.

Хууль тогтоох үйл явцад иргэд оролцоходоо⁸⁷ бүхий л үйл явцад оролцох учиртай. Өөрөөр хэлбэл хуулийн төслийг боловсруулахаас (Засгийн газрын төвшинд) эхлээд хуулийг батлахад (парламентын төвшинд) ч мөн адил. Хууль тогтоох үйл явц дахь ИНБ-уудын үүрэг оролцоо нь идэвхитэй бодлого боловсруулагч эсвэл талууд тоглоомын дүрмийг баримталж байгаа эсэхийг ажиглаж хянах байдлаар хэрэгжинэ.

Энэхүү мэдээлэлдээ би хууль тогтоох үйл явцын ямар хэсэгт ИНБ-ууд үйл ажиллагаагаа төвлөрүүлэх вэ? ИНБ-уудын үүрэг оролцоо ямар бүрэлдэхүүн хэсэгтэй байх вэ? гэдэг хоёр асуултад хариулахыг зорих болно.

Эдгээр асуултад хариулахын тулд тухайн хууль тогтоох тогтолцооны мөн чанарыг судлах шаардлагатай.

Хууль тогтоох үйл явцын хоёр загвар

Парламентаг ёсны хувьд хоорондоо чанарын ялгаа бүхий хууль тогтоох үйл явцын хоёр макро загвар бий. Энэ нь гүйцэтгэх засаглал давамгайлсан эсвэл парламент давамгайлсан загварууд юм. Эдгээр загвараас шалтгаалан хууль тогтоомжууд тогтвортой байдал болон хүчин төгөлдөр чанар хэмээх хоёр хувьсагчаар тодорхойлогдоно.

Гүйцэтгэх засаглал давамгайлсан хууль тогтоох үйл явцын загвар

Гүйцэтгэх засаглал давамгайлсан хууль тогтоох үйл явцын загвар нь сонгуулийн мажоритар тогтолцооны үр дүнд бий болсон хоёр намын тогтолцоотой улс орнуудад ихэвчлэн хэрэглэгддэг. Ийм тогтолцооны хувьд парламент дахь намууд харьцангуй дуулгавартай байх ба парламентын нэг гишүүний тохиролцоо хийх эрх хэмжээ сул байдаг.

Хууль тогтоох энэхүү загварын дагуу батлагдсан хууль тогтоомжууд нэлээд тогтвортой байдгаараа онцлог. Өөрөөр хэлбэл нөгөө загвартай харьцуулахад энэ тохиолдолд харьцангуй цөөн тооны хууль тогтоомж батлагддаг бөгөөд зөвхөн улс төрийн чухал хэрэгцээ бий болсон үед л үйлчилж буй хууль тогтоомжийг өөрчлөн шинэчлэх юм уу шинэ хууль баталдаг байна. Энэхүү загварыг мөрддөг улс орнуудын хувьд парламент нь гүйцэтгэх засаглал буюу де факто (бодит байдал дээр) хууль тогтоогчийн боловсруулсан хууль тогтоомжийн төслийг хүлээн авах эсвэл түүнээс татгалзах үүрэг бүхий санал өгөх машины үүргийг л гүйцэтгэдэг байна.

Харин нөгөө талаас иргэдийн оролцоодоогуур байдгаас шалтгаалж хууль тогтоох энэхүү загварын хүрээнд батлагдсан хууль тогтоомжийг хүчин төгөлдөр чанар султай гэж шүүмжилдэг. Учир нь засгийн газрын технократууд хууль тогтоомжийг боловсруулахын зэрэгцээ парламентад олонхийг бүрдүүлж эрх барьж буй засгийн газар түүнийг нь онцын засваргүйгээр батлуулан мөрдүүлдэг. Хууль тогтоох үйл явцын онолын энэхүү загварын тод жишээгээр Их Британийг дурьдаж болох юм.

87 Энэхүү мэдээлэлд хууль тогтоох явц дахь иргэдийн оролцоо гэж дурьдагдаж буйг ИНБ-уудын оролцоо хэмээн ойлгоно уу.

Энэхүү загварт байвал зохих нөхцөл бол улс төржөөгүй, мэргэшсэн төрийн алба. Харамсалтай нь дээрх нөхцөл хуучин коммунист орнуудын хувьд үндсэндээ байхгүй. Тийм ч учраас ихэнх хуучин коммунист байсан ардчилсан улс орнуудад хууль тогтоох хоёр дахь загвар хэрэглэгддэг.

Парламент давамгайлсан хууль тогтоох үйл явцын загвар

Парламент давамгайлсан хууль тогтоох загвар нь сонгуулийн пропорциональ тогтолцооны үр дүнд бий болсон олон намын тогтолцоонд ихэвчлэн хэрэглэгддэг. Парламент дахь улс төрийн намууд нь хүлцэнгүй ноомой биш (түүнчлэн парламентын гишүүн тус бүрийн тохиролцоо хийх эрх хэмжээ нь ихэвчлэн өндөр байдаг).

Хууль тогтоох энэ загварын хүрээнд батлагдсан хууль тогтоомжууд нь харьцангуй тогтвор (бас чанар) муутай гэж тооцогддог. Улс төрийн намууд тэр ч байтугай бие даасан гишүүд хоорондын харилцан тохиролцсон асуудлаас шалтгаалан хууль тогтоомжууд ойр ойрхон өөрчлөгдөхөд хүрдэг. Гүйцэтгэх засаглалын боловсруулсан хуулийн төслийг парламент бүрмөсөн өөрчилж ч болдог. Учир нь засгийн газар парламентад байнгын олонхийг (тэр ч бүү хэл цөөнхийг ч) бүрдүүлдэггүй. Тиймээс жинхэнэ хууль тогтоогч нь парламент өөрөө байдаг.

Нөгөө талаас энэхүү загварын хүрээнд батлагдсан хууль тогтоомжийг илүү хүчин төгөлдөр чанартай хэмээн үзэх нь бий. Учир нь иргэд өөрийн сонгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан харьцангуй шууд байдлаар хууль тогтоомжид нөлөөлж чаддаг.

Францын дөрөвдүгээр бүгд найрамдах улс болон Бүгд найрамдах Чех улс зэрэг нь тус онолын загварын төлөөлөгчид юм.

Хүснэгт 1. Хууль тогтоох үйл явцын загварууд, тэдгээрийн онцлог шинжүүд

	Гүйцэтгэх засаглал давамгайлсан хууль тогтоох үйл явц	Парламент давамгайлсан хууль тогтоох үйл явц
Хууль тогтоомжийн тогтвортой байдал	Хүчтэй	Сул
Хууль тогтоомжийн хүчин төгөлдөр чанар	Сул	Хүчтэй

Дээрх загваруудад ИНБ-ууд хэрхэн оролцдог вэ?

Мэдээжийн хэрэг дээр өгүүлсэн хоёр тогтолцооны аль сайн чанаруудыг нэгтгэх замаар тогтвортой мөн хүчин төгөлдөр чанар сайтай хууль тогтоомжууд баталдаг хууль тогтоох үйл явцыг бий болгочихвол бол үнэхээр сайн байхсан. Үүний тулд гүйцэтгэх засаглал давамгайлсан загварын хүчин төгөлдөр чанарын дутагдлыг нөхөх, парламент давамгайлсан загварын хүрээнд бий болсон хууль

тогтоомжуудын тогтвортой байдлыг сайжруулах шаардлагатай болно. Энэхүү зорилгод хүрэхэд ИНБ-ууд дараахь үүрэг оролцоотой байх хэрэгтэй:

- Гүйцэтгэх засаглал давамгайлсан тогтолцоотой бол хууль тогтоох үйл явцад эхнээс нь ИНБ-уудыг оролцуулах талаар засгийн газарт шахалт үзүүлэх⁸⁸;
- Парламент давамгайлсан тогтолцоотой бол цөөн тооны сонирхлын бүлгүүд өөрсдийн ашиг сонирхлын төлөө хууль тогтоох үйл явцыг урвуулан ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих⁸⁹

Хүснэгт 2. Хууль тогтоох үйл явц дахь ИНБ-уудын үүрэг оролцоо

	Гүйцэтгэх засаглал давамгайлсан хууль тогтоох үйл явц	Парламент давамгайлсан хууль тогтоох үйл явц
“Бодлого боловсруулагч” ИНБ-ууд	+++	+
“Хяналт тавьдаг” ИНБ-ууд	+	+++

Энэ нь ТББ-ууд бодлого боловсруулах, хяналт тавих үүргийг зэрэг гүйцэтгэх чадваргүй гэсэн үг биш юм. Харин тухайн хууль тогтоох үйл явцынхаа онцлогт тохирсон үүрэг оролцоотой байх нь хууль тогтоох үйл явцад оруулах ТББ-уудын хувь нэмрийг илүү ач холбогдолтой болгоно.

Мэдээллийн дараагийн хэсэгт хууль тогтоох үйл явцад ИНБ-ууд ямар арга замаар оролцож болох талаар Чех (мөн Словак) улсын жишээн дээр тулгуурлан өгүүлнэ.

Гүйцэтгэх засаглал давамгайлсан хууль тогтоох үйл явцын хүчин төгөлдөр чанарыг сайжруулахад чиглэгдсэн зарим арга замууд

- Засгийн газраас эрхзүйн акт гаргах тухай дүрэмд зааснаар захиргааны байгууллага (ихэнх тохиолдолд яамд) боловсруулсан хуулийн шинэ төслөө зөвхөн бусад яамдад бус мөн нэр дурьдсан ИНБ-уудад (үйлдвэрчний эвлэл, худалдааны танхим, хэрэглэгчдийн нийгэмлэг, их дээд сургуулиуд, бодлогын төвүүд зэрэг) санал авах зорилгоор давхар илгээж байх үүрэгтэй (5 дугаар зүйлийн 1/f, g-д заасны дагуу дээр нэр дурьдсан байгууллагуудад заавал илгээх, 5 дугаар зүйлийн 3-т заасны дагуу шаардлагатай гэж үзсэн этгээд бүрт санал авахаар илгээх үүрэгтэй).

- Хууль тогтоох үйл явцын эхний шатанд олон нийтийг оролцуулах (Словак). Засгийн газраас дараахь зүйлийг нийтэлдэг байх:

- Шинэ хуулийн тухай дараахь асуудлуудыг багтаасан урьдчилсан мэдээлэл:

88 Эсрэг тохиолдолд өөрөөр хэлбэл гүйцэтгэх засаглал давамгайлсан хууль тогтоох загвартай бол ИНБ-ууд хяналт тавьж ажиллах нь хууль тогтоомжийн хүчин төгөлдөр чанарыг сайжруулахад хангалттай нөлөөлж чадахгүй. Учир нь энэ асуудал аль хэдийнэ хууль тогтоох үйл явцын эхний шатанд шийдвэрлэгдсэн байдаг.

89 Дахин хэлэхэд парламент давамгайлсан хууль тогтоох үйл явцад ИНБ-ууд хууль тогтоох үйл явцад хэт анхаарсанаар хууль тогтоомжуудын тогтвортой байдлыг дээшлүүлэхэд ахиц гаргаж чадахгүй. Яагаад гэвэл парламентын танхимд хууль тогтоох явцад оролцсоноороо ИНБ-ууд жаахан ялалтын төлөө (эрхзүйн системийн тогтвортой байдлыг хөндсөн) их хохирол амсах болно.

- Хуулийг хэн санаачилсан болох;
- Шинэ хуулийн үндэслэл;
- Хуулийн санхүүгийн өртөг болон бусад үр дагаврын тухай тооцоо;
- Шинэ хуулийг баталсанаар өөрчлөгдөх бусад хууль тогтоомжууд;
- Шинэ хуулийг дагалдаж гарах дүрэм журмуудын жагсаалт;
- Шинэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой практик арга хэмжээ.
- Шинэ хуулийн төсөл.

Тогтоосон хугацаанд багтааж хүссэн этгээд бүр саналаа өгөх эрхтэй бөгөөд холбогдох захиргааны байгууллага эдгээр саналыг хүлээн авч шийдвэрлэх үүрэгтэй. Хэрэв 300 хүн адилхан санал гаргасан боловч түүнийг нь захиргааны байгууллага хуульд тусгахаас татгалзсан бол үүнийг шийдвэрлэх тусгай журам бий.

Парламент давамгайлсан хууль тогтоох үйл явцын ил тод байдлыг сайжруулах зарим арга замууд

- **Парламентын гишүүдийн хууль санаачлах эрхэд хязгаарлалт тогтоох.** Чех улсад парламентын аль нэг гишүүн дангаараа хууль санаачлах эрхтэй (Үндсэн хууль, 41 дүгээр зүйл, 2 дугаар хэсэг). Энэхүү эрх нь Чехийн парламентаас маш олон тооны хууль, нэмэлт өөрчлөлтүүдийг гаргах шалтгаан болдог.

- **Парламентын нэгдсэн болон хороодын хуралдааныг олон нийтэд мэдээлэх.** Парламентын хуралдааны дэгийн тухай хуульд өөрөөр заагаагүй, эсвэл хороо өөрөөр шийдээгүй (Парламентын дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйл) бол хороодын хуралдаан нь олон нийтэд нээлттэй байна. Түүнээс гадна төлөөлөгчдийн танхим болон сенатын хуралдааныг телевизээр нэвтрүүлдэг (гэхдээ шөнийн цагаар).

- **Лоббиг зохицуулах.** Төлөөлөгчдийн танхим (парламент)-ын өмнөх ерөнхийлөгч лобби хийгчдийн танхимд нэвтрэх боломжийг зохицуулах оролдлогыг 2005 онд хийсэн. Тэрээр лобби хийгчдэд тодорхой давуу эрх эдлүүлэх замаар бүртгэх ажлыг санаачилсан юм. Энэхүү санаачлагын дагуу гишүүд зөвхөн бүртгэлтэй лоббичидтой л танхимд уулзалт хийх ёстой. Гэхдээ тус санаачлага батлагдаагүй.

- **Мэдээлэл олж авах.** Хуралдааны тэмдэглэлүүд, саналын үр дүн (гишүүн тус бүрээр олж үзэх боломжтой), бүх хуулийн эх бичвэрүүдийг харьцангуй хялбар байдлаар олж үзэх боломжтойгоор интернэт дээр байршуулсан байдаг. (www.psp.cz, www.senat.cz).

Дүгнэлт

Гүйцэтгэх засаглал эсвэл парламент давамгайлсан хууль тогтоох үйл явц ялгаатай байдгаас шалтгаалж ИНБ-уудын үүрэг оролцоо өөр өөр байдаг талаар энэхүү мэдээллээр харуулахыг оролдлоо.

Гүйцэтгэх засаглал давамгайлсан хууль тогтоох үйл явцын хувьд ИНБ-ууд бодлого боловсруулагчийн үүрэг гүйцэтгэхэд анхаарах шаардлагатай бөгөөд ийм боломж олгохыг төрийн байгууллагуудаас шаарддаг байх ёстой. Чех улсын жишээтэй адилаар сонгож авсан байгууллагуудад хуулийн төслийг санал авахаар илгээх үүргийг төрийн байгууллагад хүлээлгэх замаар эсвэл Словак улсын адил хуулийн төслийн талаар бүхий л хүмүүс, хуулийн этгээдийн саналыг цуглуулах аргаар бодлого боловсруулагчийн энэхүү үүргийг хэрэгжүүлж болох юм.

Парламент давамгайлсан хууль тогтоох үйл явцын хувьд ИНБ-ууд нь гишүүд танхимын дотор ч, гадаа ч дүрэм, журмаа баримталж буй эсэхэд хяналт тавих үүргийг гүйцэтгэж байх учиртай. Парламентын хурлыг олон нийтэд мэдээлэх, чухал мэдээллийг (гишүүдийн санал өгсөн байдлын тухай зэрэг) олж авах боломжийг бүрдүүлэх гэх мэт нь хууль тогтоох үйл явцыг олон нийтийн зүгээс хянах талаар ахиц дэвшил гаргахад чухал ач холбогдолтой. Эдгээр арга хэмжээний зэрэгцээ гишүүдийн хууль санаачлах эрхийг хязгаарлах, лоббиг зохицуулах зэрэг хязгаарлалт шаардлагатай байдаг байна.

Эцэст нь хууль тогтоох үйл явцад идэвхитэй үүрэг оролцоотой байхын тулд ИНБ-ууд хангалттай хэмжээний нөөц бололцоо, чадавхитай байх хэрэгтэй. Тийм учраас бодлого боловсруулах, хяналт тавих аль ч үүргийг гүйцэтгэлээ гэсэн хууль тогтоох үйл явцад оролцох сонирхолтой ИНБ-уудад зориулсан тусгай тэтгэлэгт хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай.

АСУУЛТ-ХАРИУЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Г. ПҮРЭВБААТАР /Эдийн засагч, доктор/

Их чухал асуудлаар хуралдаж байна. Би өнгөрсөн онд батлан гаргасан зургаа, долоон хуулийг судалж үзлээ. Дэндүү хөөрхийлэлтэй байна. Татварын багц хууль гэхэд гурван тэрбум төгрөг хүртэл 10 хувь, түүнээс дээш 25 хувь гэсэн хоёрхон шатлалтай байна. Тэр хоорондын зайд гадаадын хөрөнгө оруулалтыг л дэмжсэн, үндэсний хөрөнгө оруулалтыг дэмжээгүй байх жишээтэй. Өндөр цалинтай хүнийг дэмжсэн, бага, дунд цалинтай хүнийг дэмжээгүй. Бодлогын хувьд бараг улс орны хөгжлийн эсрэг шахуу болсон байна. Ашигт малтмалын тухай хууль байна. Үндсэн хуульд зааснаар газар, түүний баялаг ард түмний өмч байх ёстой. Гэтэл хууль батлахаараа ерөөсөө 34 хувийг төр эзэмшинэ гээд өмчөө шилжүүлсэн байгаа. Гадаадын хөрөнгө оруулалтыг илт дэмжсэн, тэдэнд захирагдсан хууль болсон байна. Боловсролын тухай хуульд мөн ялгаагүй бизнесийг дэмжсэн бодлоготой, боловсролын тогтолцоог өөрчлөх, засахад өөрчлөлт оруулаагүй. Манай дээд боловсролын салбар гэхэд л тэр чигээрээ бизнес болсон шүү дээ. 116 их, дээд сургуульд 154 мянган суралцагчтай, сурсан юм байхгүй, улс орны хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй, сургалтын чанар муу, дунд, бага орлоготой өрхийг ядууруулсан ийм гажиг тогтолцоо үүсчихээд байхад үүнийг засч залруулах талаар хуульд огт тусгагдаагүй. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд ч мөн ялгаагүй байдал ийм хэвээр байгаа. Шинжлэх ухааныг зах зээлийн харилцааны үндсэн эргэлт, өөрчлөлтөд шилжүүлээгүй учир ямар ч хэрэггүй хууль болсон. Өөрөөр хэлбэл, эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, лаборатори зэрэг нь компаний жишгээр ашигтай ажиллах зарчмаар байгуулагдан ажиллах ёстой байтал энэ тогтолцоог хийж өгөөгүй.

Эмч, багш, эрдэм шинжилгээний ажилтан гурав бол төрийн албан хаагч биш юм. Зөвхөн тэдгээрийн тарифт цалин, эрдмийн зэрэг цолны нэмэгдлийг Засгийн газар тогтооно. Тиймээс манайд хамгийн хоцрогдсон гурван салбар байдаг нь боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд юм. Энэ гурван салбарыг зах зээлийн харилцааны үндсэн эргэлтэд шилжүүлэх шаардлагатай. Ийнхүү батлан гаргаж байгаа хуулийн чанар муу байгаа нь хууль боловсруулагчдын чадвар, мэдлэг хүрэлцэхгүй байгаатай шууд холбоотой. Ялангуяа яам, агентлагийн түвшинд хууль боловсруулагчдын мэдлэг, чадвар тун тааруу байна. Тухайн салбарын мэргэжлийн хүмүүсийг оролцуулдаггүй, хуулийн төсөл боловсруулсан болоод бушуухан Засгийн газарт оруулдаг. Засгийн газар нь хам хум хэлэлцсэн болоод Их хуралдаа өргөн мэдүүлдэг. Их хурлын гишүүд нь олигтой хэлэлцдэггүй. Бас чадвар, мэргэжил нь хүрдэггүй. Хүнээс асуудаггүй, мэргэжлийн болоод бусад

хүнийг сонсдоггүй. Зүй ёс нь Засгийн газарт хуулийн төсөл ороод ирэхэд тухайн мэргэжлийн хүмүүсээр групп гаргаад санал дүгнэлтийг нь гаргуулах ёстой. Дараа нь УИХ хүлээж аваад Байнгын хороогоор хэлэлцэхийн өмнө хөндлөнгийн хүмүүсээр дүгнэлт гаргуулаад түүнийгээ Байнгын хорооны хуралдаанд сонсох, хэлэлцэх ёстой.

Дээрхи дутагдлыг засч залруулахын тулд Ерөнхийлөгчийн дэргэд иргэний нийгмийн зөвлөл байгуулах ёстой. Энэ зөвлөл нь УИХ-д нэр дэвшигчдийг урьдчилан хэлэлцэж саналаа гаргадаг, шалгаруулдаг байх. Тэгвэл сонгууль ч амархан, зардал чирэгдэл ч багатай болно. Үүний үр дүнд сайн бүтэцтэй, сайн парламент гарч ирнэ. Нөгөө нэг асуудал бол хууль боловсруулахад оролцох иргэний нийгмийн тодорхой бүтэц бий болгож түүнийгээ батлуулах хэрэгтэй. Тэгэхгүй бол хүн бүр оролцоод нэмэргүй.

УНДРАЛ /Ардчилалын Боловсрол төв/

Хэдэн асуулт асууя. Нэгдүгээрт, Засгийн газрын түвшинд хууль боловсруулах үйл явцад иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах, иргэний нийгмийн зөвлөл байгуулах эрх зүйн зохицуулалт байдаг уу? Байдаггүй бол бий болгох талаар юу хийж болох вэ? Хоёрдугаарт, хуульд редакцийн засвар хийх эрх Хууль зүйн яаманд байдаггүй гэж та илтгэлдээ хэлсэн. Энэ эрх хаана, ямар байгууллагад байдаг вэ? Гуравдугаарт, Ашгийн төлөө бус байгууллагын хуулийн төсөл ямар байдалтай байна вэ?

Д. ЛАМЖАВ /Иргэн/

Хуулийн редакцийн найруулгыг эцсийн найруулгын дараа нь уу, эсвэл өмнө нь хийх нь зүйтэй гэж бодож байгаа юм уу?

Ц. ЦОЛМОН /ХЗДХЯ/

Засгийн газрын дэргэд иргэний нийгмийн зөвлөл байгуулах талаар хуульд байхгүй боловч шийдэж болохгүй асуудал биш. Засгийн газрын тухай хуульд нэг заалт байдаг. Засгийн газар төрийн тодорхой үүргийг ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно гэсэн заалт юм. Хуулийн редакци хийх асуудал бол санаачлагч субъектуудын түвшинд эцсийн найруулгыг хийхэд оролцох явдал шаардлагатай байгаа нь практикаас ажиглагдаж байгаа юм. Энэ талаар Хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хэлэлцэх журмын тухай хуульд заасан заалт байдаггүй. Ашгийн төлөө бус байгууллагын тухай хуулийн төслийг Засгийн газраар хэлэлцээд түр хойшлогдсон байгаа. Учир нь бүртгэлийн тогтолцоотой холбоотой нэгдсэн үзэл баримтлалд нийцүүлэх шаардлага гарсан байх.

Д. АЛТАЙ /МСАЭХ/

Аливаа хуулийн төсөлд эрх зүй, эдийн засаг, нийгмийн экспертиз хийдэг дэлхийн жишиг байдаг. Хууль хэрэгжих үндэслэлийг ч авч үздэг. Үүнийг хийдэггүйгээс бидний нэрлэдэг “хуулийн цоорхой” гардаг байх. Хоёрдугаарт хуулийн бүртгэл, кодификацийг хаана хийдэг вэ? Энэ бүртгэл бас иргэний нийгэмд ил тод байх ёстой байх.

Ц. ЦОЛМОН /ХЗДХЯ/

Бид Хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг баримталдаг. Энэ хуульд нийцүүлэн гаргасан сайдын тушаалаар баталсан хоёр аргачлал байдаг. Эдгээр аргачлалын дагуу хуулийн төслийн үзэл баримтлал болоод төсөл боловсруулах аргын талаар заасан зүйлийг баримтлан ажилладаг. Энд хуулийн төсөлд эрх зүй, эдийн засаг, нийгмийн экспертиз хийлгэх тухай заагаагүй. Гэхдээ бид тухайн хууль хэрэгжих үндэслэлийг заавал авч үздэг. Ингэхдээ мэргэжлийн байгууллага, эрдэмтдийн санал дүгнэлтийг гаргуулах замаар авч үзэх бололцоотой гэж үзэж байна.

Ж. НАРАНТУЯА /УИХ-ын Тамгын Газар/

Хуулийг системчлэх, кодлах, ангилах асуудлыг мэргэжлийн талаас үндсэнд нь ХЗДХЯ хариуцдаг. 2004 онд кодификацийн нэгдсэн ангилагч батлан гаргаад түүний дагуу хуулийг ангилах, системчлэх, нийтэд хүргэх ажлыг хийдэг. Одоо Хууль зүйн үндэсний төв хариуцан хийж байгаа. УИХ бол батлан гаргасан хууль, тогтоолын мэдээллийн анхдагч бүртгэлийг хийдэг. Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын шугамаар гарч байгаа захирамж, тушаал, шийдвэрийн бүртгэлийг энэ төв рүү явуулаад тэнд нэгдсэн бүртгэл, ангилал хийгддэг. Ингээд энэ мэдээллийг төрийн байгууллага, ТББ-ууд аль аль нь авч ашиглах боломжтой юм. Хуулийн ангилал, системчлэлийг сайн хийх асуудлыг хаана хаанаа хүлээн зөвшөөрч байгаа. Нэг тайлбар хэлэхэд 1992-2006 онд манай парламент нийтдээ 360 гаруй хууль батлан гаргасан. Маш их ачаалалтай ажилласан гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл хууль батлах үйл явц хугацааны хувьд зарим талаар тун бага байснаас тэр үед хуулийн төсөл хэлэлцэх үе шатанд иргэний нийгмийн төлөөллийг тэр бүр оролцуулаад байх боломж байхгүй байсан гэдгийг хэлэх хэрэгтэй юм. Харин энэ 2007 оноос эхлээд гол гол хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр ихэвчлэн ажиллах учраас бид ТББ-уудтай үр бүтээлтэй хамтран ажиллах бололцоотой болно.

Д. ЛАМЖАВ /Иргэн/

Манайд гадны тусламжаар ТББ-ын оролцоотойгоор нэг төсөл хэрэгжүүлэх тохиолдол нэлээд гардаг. Ингэхэд тухайн байгууллагад урьд нь алба хашиж байсан хүмүүс ТББ байгуулаад уг төслийг хэрэгжүүлдэг явдал түгээмэл байдаг. Үүнд сайн тал байгаа гэдгийг би үгүйсгэхгүй. Харин энд зарчмын нэг алдаа байгаа нь юу вэ гэхээр бидний ярьж байгаа оролцоог тухайн эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа төрийн байгууллагын зүгээс сонгож авдаг тийм арга барил байх ёсгүй юм. Тиймээс миний өчигдрөөс хойш яриад байгаа нэг зүйл бол хууль тогтоох үйл явцыг боловсронгуй болгоход тодорхой процедур буюу дэг хэрэгтэй. Одоогийн хууль тогтоож байгаа үйл явц бүхэлдээ болохгүй байна. Хоёрдугаарт, интернетээр хууль уншаад энэ хуульд нэмэлт, өөрчлөлтийг нь оруулсан юм болов уу, үгүй юм болов уу гээд эргэлзэх явдал байдаг. Тэрнийг мэдэх арга нь маш хүнд. Бүх хуулийг уншихаас нааш мэдэхгүй. Тиймээс хуулийн толгой дээр нэг хүснэгт хийчихээд хэдийд баталсан, хэдийд ёсчилсон, нэмэлт, өөрчлөлт орсон огноонуудыг дэс дараалан оруулсан байх, тэгээд тэр огноо дээр дарахад нэмэлт, өөрчлөлт нь гарч байдаг интернетийн өргөн боломжийг ашиглах ёстой байхгүй юу. УИХ-аас гаргаж байгаа

хуулийн эмхтгэл нь /Төрийн мэдээлэл/ өчнөөн зузаан хирнээ ард талд дугаар нь байхгүй байх жишээтэй.

Х. ОЮУНЦЭЦЭГ /Хуульч эмэгтэйчүүдийн холбоо/

ОХУ-ын парламентын дэргэд Общественная палата гэсэн бүтэц байгуулсан байгаа. Энэ нь иргэдтэй холбоотой асуудлыг авч хэлэлцдэг эхний шатны бүтэц юм уу гэж боддог. Бусад оронд ийм бүтэц байгаа болов уу?

МИЛАН ВИТРАК

Манайд Засгийн газрын дэргэд ТББ-ын зөвлөл байгуулсан ч тодорхой үр дүнтэй юм болоогүй. Иймд одоо хийх гэж хичээж байгаа зүйл бол гол нь илүү үр нөлөөтэй тийм бүтцийг сонгож олох явдал юм. Хороо болохоор үр дүнтэй бус, институт буюу тодорхой бүтэцтэй болохоор уусаад байдаг талтай.

ХУРАЛДААН 5 - МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХУУЛИЙН ОРОЛЦООНЫ ЗОХИЦУУЛАЛТ

Ж. БАЯРЦЭЦЭГ /ННФ-ын менежер/

Одоо бид “Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн оролцооны зохицуулалтын тухай” ярилцана. Мэдээлэлгүй бол оролцоогүй, мэдээлэлтэй байж иргэд оролцох эрхээ эдэлж чадна. Тийм учраас иргэдийн мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулсан Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль бол оролцоог зохицуулахад маш чухал үүрэг гүйцэтгэдэг юм байна. Үүнийг ч бусад орны туршлага батлан харуулдаг. Ялангуяа энэ байдал Словакийн жишээн дээр тод харагдаж байна. 19 дүгээр зүйл байгууллага гэж хэвлэлийн эрх чөлөөний талаар ажилладаг олон улсын байгууллага байдаг. Энэ байгууллагаас гаргасан Мэдээллийн эрх чөлөөний талаархи загвар хууль гэж бий. Үүнд хоёр гол зарчим байдаг юм байна. Нэгдүгээрт нь хэвлэн нийтлэх үүрэг, нөгөөдөх нь оролцоог хангах үүрэг гэсэн ийм хоёр зарчим заавал ийм хуульд тусгагдсан байх ёстой байна. Тэгэхээр мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь иргэд мэдээлэл олж авах тэр харилцааг зохицуулахаас гадна нөгөө талаас, төр нь иргэддээ тогтмол мэдээллээ түгээж байх, оролцоог хангаж байх харилцааг зохицуулдаг байх ёстой. Тиймээс энэ зохицуулалтын талаар өнөөдөр бид ярих болно.

За ингээд “Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар оролцоог зохицуулах нь” гэсэн сэдвээр УИХ-ын гишүүн Сүхбаатарын Батболд танилцуулга хийнэ. Гишүүн маань энэ хуулийн төслийг санаачлагч юм. Таныг индэрт урьж байна.

МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИАР ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ НЬ

СҮ.БАТБОЛД

*/УИХ-ын гишүүн, “Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль”-ийн
төслийн санаачлагч/*

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая!

Илтгэлээ эхлэхээсээ өмнө хууль тогтоох үйл ажиллагаанд шаардагдаж байгаа, тулгамдсан асуудлыг олж сонгон энэ семинарыг Улсын Их Хурлын Тамгын

газартай хамтран зохион байгуулж буй Нээлттэй Нийгэм Форумын хамт олонд талархлаа илэрхийлье!

Миний илтгэл “Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар иргэдийн оролцоог зохицуулах нь” гэсэн сэдэвтэй байгаа.

Мэдээллийн эрх чөлөөний тухай гэж нэрлэгдсэн хууль байхгүй байгаа болохоор энэ талаар тодорхой ярих боломжгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Сү.Батболд, Э.Бат-Үүл, С.Оюун нарын хамтаар бид Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төслийг санаачилж байгаа.

Тэгэхээр Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар иргэдийн оролцоог зохицуулах асуудлыг санаачилж буй хуулийн төсөлтэйгээ уялдуулан ярих гэж байна. Энэ сэдвийг надад өгсөн нь ч үүнтэй холбоотой болов уу гэж ойлгож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д Монгол улсын иргэн нь төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй гэж заасан байдаг.

Энэ эрх нь иргэдийн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх зэрэг бусад эрхийн салшгүй нэг хэсэг болж байдаг.

Түүнчлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Мэдээллийг улсын хил заагаар үл хязгаарлан боломжтой бүх л арга хэрэгслээр эрж хайх, хүлээн авах, түгээх” эрхтэйг тунхаглан заасан байдаг билээ.

Ийнхүү хүн мэдээллийг хайх, авах салшгүй эрх Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын Пакт зэрэг олон улсын гэрээнд тусгагдаж мэдээллийн эрх чөлөөний талаар баримтлах эрх зүйн үндэс тавигдсан хэдий ч иргэдэд энэ эрхийг нь сурталчлах, бүрэн эдлүүлэх байдал хангалтгүй байна. Эрхээ эдлэхдээ хэрхэн эдлэх, хэнд, яаж хандаж, ямар мэдээллийг авах талаар хуулиар тусгайлан зохицуулаагүй байгаа.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн алба ил тод байх зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгодог хэдий ч иргэний аливаа хуулиар хориглоогүй мэдээлэл авах хүсэлтэд төрийн албан хаагч хойрго хандаж түүнд үйлчлэх үүргээ тэр бүр биелүүлдэггүй. Энэ нь нэг талаар Төрийн алба нээлттэй ил тод байх, ард түмэндээ үйлчлэх зарчмыг ихэнх төрийн байгууллага, албан хаагчид нь бүрэн ухамсарладаггүйгээс шалтгаалдаг боловч гол шалтгаан нь иргэдэд мэдээлэл өгөх үүргийг түүнд хууль тогтоомжоор тусгайлан хүлээлгээгүй байдагтай холбоотой байдаг.

Иймд иргэд хуулиар хориглоогүй бодит мэдээллийг авах эрх чөлөөний тухай процессын хэм хэмжээ бүхий хуулийг батлан гаргах шаардлагатай байна.

Дээр дурдсан шаардлагын үүднээс Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төслийг санаачилж байгаа юм.

Өмнө нэр дурдсан Улсын Их Хурлын гишүүд бид энэ хуулийн төслийг санаачлахдаа ХЗДХЯ зэрэг бусад энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай санал солилцож, хамтарч ажилласан болно.

Хуулийн төсөл нь 4 бүлэг, 20 зүйлтэй. Хуулийн төслөөр дараахь үндсэн асуудлыг зохицуулж байгаа.

1. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд Улсын Их Хурал, түүнд ажлаа тайлагнадаг байгууллага, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүх, прокурорын байгууллага, Засгийн газар, яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хуульд заасны дагуу гэрээний үндсэн дээр улсын буюу орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлдэг байгууллага, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэндийн болон тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн салбарын тодорхой үйлчилгээг хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу нийтэд үзүүлж буй хуулийн этгээдээс мэдээлэл авах;

2. Хуулиар нууцлахаар тогтоосноос бусад мэдээлэл нээлттэй байх бөгөөд байгууллага өөрийн нууцын жагсаалтын талаар нийтэд нээлттэй мэдээлэх;

3. Иргэн мэдээлэл авахаар хүсэлт гаргах, түүнийг мэдээлэл өгөх асуудал хариуцсан албан тушаалтан хүлээн авч бүртгэх, хариу өгөх;

4. Хүсэлт гаргагч иргэн нь төрийн байгууллагаас мэдээлэл авах хэлбэрээ өөрөө чөлөөтэй сонгох, мэдээлэл авах болсон шаардлага, үндэслэлээ тайлбарлахгүй байх, мэдээлэл авах эрхийг нь зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтны талаар гомдол гаргах эрхтэй байх.

5. Төрийн байгууллагаас нийтэд мэдээлж байх мэдээллийн төрөл үүнд: хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Засгийн газар, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, Засгийн газрын агентлагийн нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэр, Улсын Их Хурлын хуралдааны дэг, журам, Засгийн газар, түүний гишүүд, Засаг даргын дэргэдэх зөвлөл, хорооны ажиллах журам зэрэг мэдээллийг төрийн байгууллага хэвлэн нийтлэх, эсхүл өөр хэлбэрээр нийтэд түгээх үүрэгтэй байх ;

6. Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, гомдол гаргах журам болон иргэд мэдээлэл авсныхаа төлөө зөвхөн уг мэдээллийг хувилах, олшруулах зэрэгт гарсан зардалтай тэнцэх үйлчилгээний төлбөр төлж байх зэрэг асуудлыг Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөлд тусгасан болно.

Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хууль батлагдснаар иргэдийн үнэн зөв мэдээлэл олж авах боломж нэмэгдэж, иргэд мэдээлэл хайх, хүлээн авах хууль зүйн баталгаа бий болж, мэдээлэл нээлттэй болсноор иргэдийн нийгмийн амьдралд оролцох оролцоо нэмэгдэж, төрийн үйл ажиллагаанд тавих хяналт сайжирна гэж бодож байна.

Хуулийн төслийн талаар Та бүхэнд товч танилцууллаа.

Одоо хуулийн төсөлтэй холбогдуулан иргэдийн оролцооны талаар товч дурдъя.

Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоо ямар байгаа, нийгэмд хэр идэвхитэй байр суурьтай байгааг нь түүний хэр мэдээлэлтэй оролцож байгаагаар хэмждэг.

Төрийн үйл хэрэгт мэдээлэлтэй оролцож, шийдвэр гаргах үйл ажиллагаанд мэдээлэлтэй хяналт тавих эрхийг хэрэгжүүлэхэд төр засаг, иргэн аль аль нь хариуцлагатай, эрх, үүргээ ухамсарлаж хандах ёстой.

Тиймээс мэдээллийн эрх чөлөөний талаархи эрх зүйн орчинг бүрдүүлэхээс дутуугүй ач холбогдолтой байх зүйл бол төрийн албанд иргэд хуулиар хориглоогүй мэдээллийг авах, мэдэх эрх чөлөөтэй гэдэг сэтгэлгээг төлөвшүүлэх асуудал юм.

Төрийн байгууллагын мэдээлэл нээлттэй байх тусмаа иргэдээс санал, шүүмжлэл ихээр ирж, түүнийг нь зохистой ашиглаж бодитой хэрэгжих шийдвэр гарах үндэслэл болдог байна.

Нөгөөтэйгүүр үндэсний аюулгүй байдал, хувь хүний нууцыг хүндэтгэж, мэдээллийн эрх чөлөөнд тавих хязгаарлалтыг нарийсган тодруулах, иргэн хүн ийнхүү хуулиар тогтоосон хязгаарлалтыг давахгүйгээр эрхээ эдлэх ёстойгоо ухамсартайгаар хандах нь зүйтэй.

Одоогийн байдлаар холбогдох хууль тогтоомжийн дагуу хууль, УИХ-ын бусад шийдвэр, Засгийн тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт “Төрийн мэдээлэл” эмхтгэлд нийтлэгдэж байгаа.

Гэхдээ энэ нь иргэд мэдээлэл авахад хангалттай эх сурвалж биш юмаа. Энд ялангуяа төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудаас гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актуудыг заавал хэвлэн нийтлэх хэрэгтэй. Түүнчлэн хуулийн төсөлд тусгасан хуулийн төсөл, хуралдааны дэг зэрэг асуудлыг мэдээллийн бусад хэрэгслийг ашиглан нийтэд нээлттэй байлгах шаардлагатай байгаа.

Нээлттэй, ил тод байх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим юм. Энэ бол ардчилсан, эрх зүйт төрийн үндсэн шинж мөн. Монгол Улсын Үндсэн хуульд “Ардчилсан ёсны зарчим ... төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим” болохыг тунхагласан байдаг.

Энэ нь Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааны чухал зарчим болж байдаг юм. Тухайлбал Улсын Их Хурлын 2002 оны 22 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөндөө “Улсын Их Хурал нь ардчилсан зарчимд тулгуурлан үйл ажиллагааныхаа ил тод, нээлттэй байдлыг бүх талаар хангах” асуудлыг үйл ажиллагааны зорилт болгон дэвшүүлсэн байдаг.

Дүгнэлт

Иргэд хууль тогтоох үйл ажиллагаанд идэвхитэй, үр дүнтэй оролцохын тулд мэдээлэлтэй байх шаардлага зүй ёсоор гарч ирнэ. Тэгэхээр “Мэдээллийн

эрх чөлөөний хууль тогтоомж нь хууль тогтоох үйл ажиллагаан дахь иргэдийн оролцооны асуудлыг хэрхэн зохицуулах вэ?” гэдэг асуудалтай холбогдож байна.

Дээр дурдсанчлан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, хуралдааны дэгийг хэвлэн нийтлэх болон бусад хэлбэрээр нийтэд түгээх үүрэгтэй байхаар хуулийн төсөлд тусгаж байгаа.

Оролцооны асуудал нь шийдвэр гаргах болон тэрнээс өмнөх шатанд яригдах учраас энд хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй танилцах боломж, хууль, тогтоолын төслийг хэзээ Байнгын хорооны болон чуулганы хуралдаанаар хэлэлцэх, хууль, тогтоолын төслийн ажлын хэсэгт хэн оролцож байгаа, өөрийн саналаа хэнээр уламжлуулан төсөлд оруулах боломжтой байх зэрэг асуудлаар сонирхогч этгээд мэдээлэлтэй байх боломжийг бүрдүүлэх ёстой.

Өнөөгийн байдлаар дээр дурдсан мэдээллүүдийг УИХ-ын вэб сайтад байрлуулах байдлаар нийтэд түгээж байгаа. Гэхдээ энд ийм мэдээлэл байна гэдгийг иргэд тэр бүр мэдэхгүй нөгөө талаар ялангуяа хөдөө орон нутагт интернетэд холбогдон тэр мэдээллийг олж авах боломж бараг үгүйтэй адил байна.

Гэтэл эдгээр асуудлыг байнга хэвлээд тараагаад байх боломжгүй учраас энд манай хэвлэл, мэдээллийн байгууллагууд идэвхтэй оролцож, иргэдэд дутагдаж буй тэр мэдээллийг үнэн зөв, шуурхай хүргэн өөрсдийн нийгэмд гүйцэтгэх үүргээ анхаарч ажиллах шаардлагатай байна.

Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөлд заасны дагуу Монгол Улсын иргэн хүн бүр дээр дурдсан аль ч асуудлаар мэдээлэл авахаар хандаж болох бөгөөд мэдээлэл авах болсон шаардлага, үндэслэлээ тайлбарлахгүйгээр уг мэдээллээ албан ёсоор, түргэн шуурхай гаргуулан авах эрхтэй бөгөөд уг хүссэн мэдээлэл буюу баримт бичгийг цаасан болон электрон /цахим/ хэлбэрээр хуулбарлан авах, мэдээлэлтэй холбоотой баримт бичиг, биет зүйлтэй танилцах, нийтийн болон электрон шуудангаар хүлээн авч болохоор хуульчилсан байна.

Нөгөө талаас хөдөө орон нутгийн иргэд маань энэ эрхээ тэр бүр бүрэн гүйцэд эдлэж чадахгүй байх талтай. Учир нь орон нутгийн иргэд тэр бүр тухайн төрийн байгууллагаас хүссэн мэдээллээ авахаар биечлэн ирээд байж чадахгүй бөгөөд энэ нөхцөлд мэдээллийн тэнцвэртэй байдлыг хадгалах талаар анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа!

СЛОВАК УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ОРОЛЦООНЫ ЗОХИЦУУЛАЛТ

ВИКТОРИЯ МЛИНАРЧИКОВА

/Словакийн Нээлттэй нийгэм хүрээлэнгийн ажилтан/

МИЛАН ВЕТРАК

*/Европын Хууль зөвлөгөө байгууллагын захирал,
Трнава сургуулийн багш/*

*Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, түүгээр олон нийтийн оролцоог
зохицуулах нь*

Энэхүү илтгэлийг хоёр хэсэгт хувааж та бүхэнд танилцуулна. Эхний хэсэгт нь би Словак улсын Мэдээллийн эрх чөлөөний тухай Хууль болон түүний дагуу төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, кампанит үйл ажиллагааны тухай ярина. Дараа нь Милан та бүхэнд энэхүү хуулийн техникийн зохицуулалтын асуудлыг танилцуулна.

Юуны өмнө та бүхэнд Словак улсад Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хэрхэн бий болж батлагдсан талаар тайлбарлая. Мэдээллийн эрх чөлөөг хангах зохицуулалтын хувьд энэ нь маш хүчтэй хууль болж чадсан учир бид хуулиараа бахархдаг. Анх 2000 онд батлагдсанаасаа хойш нэг удаа засварт орсон ч одоо хүртэл хүчтэй хэвээр байгаа.

Төрийн бус байгууллагууд болон кампанит үйл ажиллагааны талаар ярихдаа энэхүү хуулийг боловсруулах үндэслэл, ямар асуудлыг шийдвэрлэхээр батласнаас нь эхлэх ёстой. Яагаад Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль байх хэрэгтэй талаар би нурших шаардлагагүй болов уу, учир нь бид бүгд яагаад ийм эрх зүйн зохицуулалт хэрэгтэй гэдэг дээр санал нэгдэнэ. Цаашлаад Словак Улс дахь хууль тогтоох боловсруулах үйл явц дахь иргэдийн үүсгэл санаачлага, үзүүлэн дээр байхгүй ч хуулийн хэрэгжилт, хуулийн хэрэгжилтийн хяналтын талаар төрийн бус байгууллагуудын хийсэн үйл ажиллагааны талаар та бүхэнд танилцуулна.

Ямар үндэслэлээр мэдээллийн эрх чөлөөний тухай эрх зүйн зохицуулалт шаардлагатай болсон нь мэдээж бид бүхний мэдэж байгаагаар ардчиллыг хөгжүүлэх, ардчиллын бүхий л үйл ажиллагааны угтвар нөхцлийг хангах явдалтай холбоотой. Словак улсад мэдээллийг хүргэх нь маш хялбар бус үйл явц байсан ба мэдээллийн эрх чөлөө хангагдвал төрийн захиргаан дахь ил тод байдлыг хөхүүлэн авлигыг багасгах, авлигатай тэмцэх арга зам болно гэдэгт бид итгэж байсан. Тухайн үеийн нөхцөл байдлыг энд дурьдах нь чухал. Мэдээллийн эрх чөлөөний

тухай хуулийг боловсруулан бэлтгэх үед Словакийн иргэний нийгэм санхүүжилт сайтай, маш хүчтэй, зоригтой, зохион байгуулалт сайтай байсан. Энэ их чухал, учир нь Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг боловсруулах, бэлтгэх кампанит үйл ажиллагаа нь Словакийн түүхнээ эхнээсээ дуустал явагдаж чадсан хамгийн амжилттай том кампанит ажил байсан юм. Өөр ийм кампанит үйл ажиллагаа дахин явагдаагүй. Ийм үйл ажиллагаа дахин явуулъя ч гэсэн нөөц бололцоо байхгүй. Тухайн цагаас хойш маш олон ардчиллын бэхжилтийн үйл ажиллагаа явагдаж, Засгийн Газар гэж том дайсан байсан институц маань өөрчлөгдөн нээлттэй, ил тод болсноос хойш иргэний нийгэм урьдынхтайгаа адил хүчтэй нэгдмэл биш болсон. Дахин тийм санаачлага үүсэх эсэхийг би хэлж мэдэхгүй ч, үүснэ хэмээн найдаж байна.

1999 онд “Сайн хуулийн төлөө иргэдийн санаачлага” нэртэй зуун мянга гаруй иргэдийг төлөөлсөн зуун хорин байгууллагын эвсэл байгуулагдснаар кампанит үйл ажиллагаа эхэлсэн. Тийм их тоо биш юм шиг сонсогдож байвч Словакийн хувьд энэ бол маш их тоо байсан. Энэ нь иргэний нийгэм тэр үед хэр нэгдмэл байсныг харуулдаг. Иргэний нийгэм Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулинд багтаахыг шаардсан есөн зарчмыг боловсруулснаар кампанит ажил эхэлсэн байгаа. Эдгээр зарчмыг өөрсдөө бие дааж боловсруулаагүй ч тэдгээр нь бусад орны жишиг, жишээнд үндэслэсэн байсан. мэдээллийн эрх чөлөөний төлөө ажиллаж буй хүн бүрт ойлгомжтой учир нэг бүрчлэн есөн зарчмыг тайлбарлах хэрэггүй байх.

1. Мэдээллийг дээд зэргээр нээлттэй байлгах зарчим (Өөрөөр хэлбэл, “Нууцын ангилалд багтаагүй бүх мэдээлэл олон нийтэд нээлттэй байна”).
2. Бүх шатны төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн засаг захиргааны байгууллагаас гадна төрийн төсвөөс санхүүждэг бүх этгээд мэдээллийг нээлттэй байлгах.
3. Олон нийтэд хаалттай мэдээллийн ангилал нь ойлгомжтой байх, эдгээрийг хангах хуулийн заалтын тайлбарыг хязгаарлах.
4. Цаг хугацааны хязгаарлалтыг үндэслэлтэй тогтоон, шалтгаан үндэслэлгүй үл сунгах.
5. Мэдээллийг нээлттэй эсвэл хаалттай байлгах шийд гарснаас хойш иргэд тэр шийдийг даван заалдах, тэр шийдийн талаар гомдол гаргах шуурхай, үр дүн бүхий арга хэрэгслүүдийг бий болгох.
6. Хууль зөрчсөн этгээдүүдэд зохих шийтгэл оноох тогтолцоог бүрдүүлэх.
7. Мэдээллийг нээлттэй болгох нь иргэдэд тустай байгаад зогсохгүй, байнга гардаг асуултуудад мэдээлэл өгөх үйл явцыг илүү үр дүнтэй болгоно.
8. Мэдээлэл авахад тухайн мэдээллийг гаргахтай холбогдсон зөвхөн шууд зардлыг тусгасан төлбөртэй байлгах.
9. Шинэ хууль нь илүү үр дүн бүхий байх тул шинэ хуулиар одоогийн хүчин төгөлдөр 171/1998-р Байгаль орчны асуудлаарх мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хүчингүй болгох.

Кампанит үйл ажиллагааг эхлэхээс өмнө судалгаагаар сайн хийж Засгийн газар эсвэл Парламентад санал болгох хуулийн төслийн хувилбараа бэлтгэх ёстой. Үүнийг цохон тэмдэглэж байгаа нь ийм кампанит ажил Словакт ганц удаа явагдсан ба иргэний нийгмийн салбар бэлтгэл сайтай оролцсноор л амжилт олсон.

Тухайн үед Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн гурван төсөл боловсруулагдсанаас нэг нь Засгийн газрын, нөгөө хоёр нь Парламентын хоёр гишүүний боловсруулсан хувилбар байсан. Иргэний нийгмийн эвсэл нь энэ гурван хувилбарыг нэгтгэн нэг хувилбар болгоод Засгийн газар, Парламентын гишүүдтэй зөвшилцөлд хүрэхийг оролдсон боловч амжилтад хүрээгүй тул өөрсдийн хувилбарыг боловсруулахаар шийдсэн. Түүний дараа Парламент болон төрийн бус байгууллагуудын хэлэлцээрт оролцож байсан Парламентын нэг гишүүн төрийн бус байгууллагуудын боловсруулсан хувилбарыг Парламентад танилцуулсан байгаа. Эцэстээ Парламентад Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн нэг л төсөл үлдсэн нь иргэний нийгмээс боловсруулсан хувилбар байсан. Энэ бол бидний анхны амжилттай алхам байсан. Тэр хувилбар Парламентын хэлэлцүүлэгт ороход хуулийн төслийг лоббидон, хяналт тавьж байсан иргэний нийгмийн хороо нь Парламентын хороодын хуралдаан бүрт оролцсон. Иргэний нийгмийнхэн ямарваа нэг асуудлаар зуун тавин Парламентын гишүүдийн бүгдтэй уулзаж ярилцсан нь мөн л Словакийн лоббигийн түүхэнд анх удаа болсон үйл явдал. Парламентаар батлагдаад тухайн хуулийн эсрэг байсан Ерөнхийлөгчид очсон. Гэвч иргэний нийгэм болон хэвлэл мэдээлэл энэ асуудлаар маш идэвхитэй байсан учир Ерөнхийлөгч ч хориг тавьж чадалгүй хуулийг хүлээн зөвшөөрсөн байгаа.

Энэхүү үйл явцад Парламентын Ордны өмнө жагсаал хийх, гудамж олон нийтийн газраар зурагт хуудас байрлуулах гэх мэт кампанит үйл ажиллагааны бусад туслах арга хэлбэрүүдийг ашигласан байгаа. Кампанит үйл ажиллагааны хамгийн чухал хэрэгсэл нь энэ асуудлаар эхнээсээ иргэний нийгэмтэй хамтарч ажилласан хэвлэл мэдээллийнхэн байсан. Ер нь ямар ч кампанит үйл ажиллагаанд хэвлэл мэдээлэл зайлшгүй чухал байдаг. Энэхүү хэрэгслийг ашиглаж чадахгүй бол кампанит үйл ажиллагааны үр дүн гарахгүй ч байх магадлалтай.

Миний өмнө илтгэл тавьсан Засгийн газрын төлөөлөгчийн хэлсэнчлэн Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилтэд иргэний нийгмийн үүрэг маш их байсан. Энэхүү хуулийг хэрхэн ашиглах, хэрэгжүүлэх талаар хуулийн хэрэгжилтээр үйл ажиллагаагаа явуулж байсан хэд хэдэн төрийн бус байгууллага бүх шатны, ялангуяа орон нутгийн засаг захиргааны түвшин дэх төрийн албан хаагчдад сургалт явуулж байсан. Төрийн албан хаагчид ямарваа хууль батлагдсныг мэдлээ ч түүнийг хэрхэн ашиглах, хэрэгжүүлэхийг тэр бүр мэддэггүй. Хууль батлагдан гарснаас хойш иргэдийг энэхүү хуулийг хэрэглэх талаар мэдлэг олгох кампанит ажлыг хоёр гурван жилийн турш өрнүүлсэн.

Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг нэг удаа засварлаж энэ талаар мэдээлэл гарахад иргэний нийгэм маш цочирдсон. Парламентад очсон хууль бүр олон асуудалтай тулгардаг. Гэвч хийгдсэн засвар нь хуулийн хүчийг сулруулаагүй ч хуулийг боловсруулах үед байгуулагдсан иргэний нийгмийн эвсэл тарсан байсан. Гэсэн хэдий ч иргэний нийгэм хуулийн хэрэгжилтийг хянасан хэвээр

байлаа. Нээлттэй Үийгмийн Хүрээлэн ч мэргэжилтнүүд хуульчдаараа энэхүү хуулийн хэрэгжилтийн хяналтад оролцсоор байгаа. Словак улсын Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хувьд үүссэн бэрхшээл нь төвийн бус, орон нутгийн захиргааны түвшинд хуулийг засварлах, өөрчлөх санаачлагууд гарсан. Төвлөрлийг сааруулах үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн эрх мэдэл орон нутгийн засаг захиргаанд очсон бөгөөд энэ түвшинд хуулийг хөсөрдүүлэх, үл хэрэгжүүлэх явдлууд гарсан. Одоо хуулийн зохицуулалтыг хязгаарлахыг эрмэлзэж буй этгээдүүд ч энэ л түвшинд байгаа тул хуулийн хэрэгжилтийн хяналт дээр Нээлттэй нийгмийн хүрээлэн үйл ажиллагаа явуулсаар байна. Бидний хэрэгжүүлдэг мониторингийн нэг төсөл нь “Өрсөлдөөн” нэртэй. Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль бий тухай хүмүүст сануулсан үйл ажиллагаа явуулдаг, энэ үйл ажиллагаагаа хэвлэл мэдээллээр өргөнөөр сурталчилдаг төсөл.

Дээр дурьдсан бүх шатны үйл ажиллагаанаас харахад хууль батлагдлаа ч хуулийг хэрэгжүүлэхийн төлөө байнга хяналт тавигдах ёстой гэдэг нь тодорхой болж байна. Нээлттэй нийгмийн хүрээлэн нь “Анхан шатнаас сэрэмжлүүлэх тогтолцоо” төслийг хэрэгжүүлж эхэлсэн юм. Энэ нь хуулиудын хэрэгжилтийг урьдчилсан байдлаар дүгнэх үйл ажиллагааг явуулдаг төсөл бөгөөд зөвхөн Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар зогсохгүй бусад хуулиудыг хянадаг тогтолцоо юм. Төрийн бус байгууллагууд Парламентад хэлэлцэж буй ямарваа нэгэн хууль журмыг өөрчлөхийг хүсдэг ч дэндүү оройтсон байдаг. Тиймээс мониторингийн үйл ажиллагаа Засгийн газар эсвэл өөр хэн нэгэн түүний талаар бодохоос өмнө эхэлдгийг санаад сайн бэлтгэлтэй байж урьдчилсан байдлаар хуулийн төслүүдэд хяналт хийх хэрэгтэй гэж би зөвлөмөөр байна.

II

Баярлалаа. Викториагийн илтгэл дээр нэгэн жижиг тодруулга хийе. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд нэг том, хоёр жижиг засвар хийгдсэн. Сүүлийн үед зарим хот тосгодын захирагч нарын өрнүүлж байгаа хуулийн үйлчлэлийг хязгаарлахын зорьсон үйл ажиллагааны хувьд Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн дагуу хот тосгоны захирагч энэхүү албан тушаалын хажуугаар Парламентын гишүүн байхыг хориглосон зүйл байдаггүйгээс олон хот тосгодын захирагч нар Парламентын гишүүд байдаг. Тэд орон нутгийн түвшинд санхүүгийн эрх мэдлээ хэрхэн ашиглаж буй, Европын Холбооны санхүүжилтийг хэрхэж буй талаар ил тод байдлыг хүсэхгүй байгаа учир Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг засварлах, ил тод байх зарчмыг нь хязгаарлах томоохон нөлөөллийг зохион байгуулсаар байгаа.

Энд хэд хэдэн баримтыг дурдъя гэж бодлоо. Хэрэв та чухал хүмүүсийг таньдаг танил тал ихтэй хүн бол Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль ямар ч хэрэггүй. Мөн хэрэв та тагнуулын албанд ажилладаг бол Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль бүр ч хэрэггүй. Мэдээллийг хүртэх, олох асуудал дээр хоёр чухал хүчин зүйл байдаг. Энэ нь цаг ба мөнгө. Словак улсад яамдаас жилдээ дунджаар есөн зуун мэдээлэл хүссэн өргөдөл гаргадаг тоотой хэдэн хүн бий. Тэд өдөртөө дунджаар гурван хүсэлт гаргадаг гэсэн үг. Өөр нэгэн бүлэг хүмүүс нь цаг зав муутай, ихээхэн мөнгөтэй бизнесменүүд юм. Тэд мэдээллийг цагт нь авахын тулд мөнгө

төлөх чадвартай хүмүүс байдаг. Тэгэхээр Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиа батлахдаа иймэрхүү зүйлсийг анхааралдаа авна биз ээ.

Харин одоо та бид шиг мэдээлэл авахыг хүссэн энгийн хүмүүсийн тухай ярилцъя. Словакийн Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн дагуу бид ямар байгууллага, хуулийн этгээдээс мэдээлэл хүсэж болох вэ? Эдгээрт төв болон орон нутаг, хот тосгодын захиргаа, хувь хүн болон хуулийн этгээдийн эрх үүргийг тогтоох эрх мэдэл бүхий этгээдүүд, төр болон орон нутгийн засаг захиргаагаар байгуулагдсан хуулийн этгээдүүд багтана. Хэрэв та орон нутаг, хотын захиргааны төсөв, Европын холбооны санхүүжилтээс нэг ширхэг евро, Словак кроун захиран зарцуулах эрх мэдэлтэй бол мэдээллийг өгөх үүргийг заавал хүлээсэн этгээд мөн.

Мэдээллийг хоёр төрөлд хувааж болно. Нэгд, заавал нээлттэй байх мэдээлэл. Тэр нь дээр дурьдсан байгууллага этгээдүүд өөрсдийн веб сайт дээр заавал нээлттэй байх мэдээллийг цаг тухайд нь байрлуулна гэсэн үг. Хоёрт, хүсэлтийн дагуу нээлттэй болох мэдээлэл. Заавал нээлттэй байх мэдээллийг хэрхэн хангадаг вэ? Хувийн болон төрийн албан хаагчид, тосгодыг оролцуулахгүйгээр зайлшгүй хууль даган мөрдөх дээр дурьдсан хуулийн этгээд, төрийн захиргааны байгууллага бүр өөрийн вэбсайтыг бий болгох ёстой. Вэбсайт бүр “И” гэсэн товчтой байх бөгөөд тэр товчийг дарснаар мэдээллийг хүсэх үйл явцад юу юу шаардагдахыг тайлбарлах мэдээлэл гарч ирнэ. Вэбсайт дээр заавал байх мэдээлэл нь хэзээ, хаана, ямар хэлбэрээр мэдээллийг хүсэж болох тухай тайлбар байна. Та бүхэнд би өчигдрийнхөө илтгэлд Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хууль боловсруулах тогтоох үйл явц дахь иргэдийн оролцоог зохицуулах үйл ажиллагааны туслах механизм хэмээн тооцож болох тухай танилцуулж тайлбарласан байгаа. Жишээ нь, Засгийн газраас Парламентад өргөн барьсан бүх хууль, эрх зүйн зохицуулалтын баримт бичгийн төслийг, мөн өөрийн боловсруулж буй хуулийн төслүүдийг Парламент вебсайт дээрээ байрлуулна. Засгийн Газар ч мөн өөрийн баталсан журам дүрмийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрынхаа вэбсайт дээрээ байрлуулна. Яамд өөрсдийн Парламентад институт хоорондын санал хураахаар хууль боловсруулах, тогтоох үйл явцад өргөн барьсан хууль, эрх зүйн зохицуулалтын баримт бичгийн төслийг яамныхаа вэбсайт дээр байрлуулна. Орон нутгийн түвшинд хувь хүмүүс болон хуулийн этгээдүүдийн эрх үүргийг тодорхойлон зохицуулсан бүх хууль, дүрэм журмыг хэвлэн нийтлэх үүрэг бий. Ямарваа саадгүйгээр мэдээлэл олж авна гэдэг нь хууль боловсруулах, тогтоох үйл явц дахь олон нийтийн оролцоог ханган зохицуулсан маш чухал туслах механизм юм.

Мэдээллийг нээлттэй болгоход тодорхой хязгаарлалтууд бий. Эдгээрийг хуулиар зохицуулна. Жишээ нь, нууцын ангилалд багтсан мэдээллийг олон нийтэд мэдээлэхгүй. Мөн банкны нууц хэмээн тодорхойлогдох мэдээлэл, татварын нууц, хувийн мэдээллийг хамгаалах нууц, арилжааны нууц зэргийг олон нийтэд нээлттэй болгохгүй. Хамгийн сүүлийн зүйл болох арилжааны нууц нь сонирхол тагдаг. Словакт ямарваа нэг чухал гэрээ хэлэлцээр хийгдэхэд гэрээт хоёр тал гэрээний олон заалт зүйлийг “Арилжааны нууц” хэмээн гэрээндээ тодорхойлдог. Тиймээс ч Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулинд арилжааны нууц гэж юу болох тухай тодорхойлолт, үүнд үл хамаарах зүйлүүдийг тусгасан байдаг. Жишээ нь, хүний эрүүл мэнд, соёлын өв, байгаль орчны бохирдол, улсын төсвийн захиран зарцуулалт болон төрийн зээл тусламжтай холбоотой асуудлуудыг арилжааны

нууцад үл хамаарах асуудлууд хэмээн тодорхойлсон. Хэдэн жилийн өмнө Словакийн Засгийн Газар Германы цахилгаан холбооны нэгэн том компанитай гэрээ байгуулсан бөгөөд энэхүү гэрээнийхээ маш олон зүйлийг арилжааны нууц хэмээн олон нийтэд мэдээлээгүйгээс их том дуулиан үүссэн. Хүмүүс энэ гэрээнд төрийн өмч байсан Словакийн цахилгаан холбооны компанийн хяналтын багцын үнэ байгаа учир Засгийн Газар гэрээг нийтэд дэлгэхийг хүсэхгүй байна гэсэн сэжиг авсан. Тухайн цахилгаан холбооны компани төрийн өмч, өөрөөр хэлбэл ард түмний өмч байсан тул мөнгө нь ч ард түмнийх байсан. Иргэд өөрсдийнх нь санхүүг захиран зарцуулсан хэлбэрийг мэдэх эрхтэй тул иргэд ба төрийн бус байгууллагынхан тэрхүү гэрээний нууцыг нээлттэй болгохын төлөө маш их шахалт үзүүлсэн. Эцсийн дүндээ шүүхийн шийдвэр гарч байж мэдээлэл нээлттэй болсон.

Мэдээллийг нээлттэй болгох хүсэлтийн дагуу юу хийж болох талаар ярья. Иргэд хүсэлтээ хариу ямар хэлбэрээр авахыг хүссэн тэр хэлбэрээр буюу амаар, бичгээр, цахим шуудангаар, факсаар тавьж болно. Мэдээлэл авахыг хүссэн өргөдөл хүсэлтэд нэр, хаяг, хэнд хандсан, яг ямар мэдээлэл авахыг хүссэн тухай мэдээлэл багтсан байх ёстой.

Хүсэлт, өргөдөл гаргахад ямар бэрхшээл асуудал үүсэж болох вэ? Магадгүй та хүсэлтээ бүрэн тавиагүй байх магадлалтай. Тийм тохиолдолд хүсэлт өргөдлөө гүйцээхэд танд долоо хоног байна. Эсвэл та буруу захиргааны байгууллагад хандсан байх магадлалтай. Тийм тохиолдолд таны анх хандан хүсэлт тавьсан төрийн захиргааны байгууллага, этгээд таны хүсэлт өргөдлийг зохих газар луу тав хоногийн дотор шилжүүлэх, шилжүүлсэн талаар танд мэдэгдэх үүрэгтэй.

Мэдээллийг өгөх үүрэг хүлээсэн төрийн захиргааны байгууллага нь хүсэлт хүлээж авснаасаа хойш найм хоногийн дотор танд мэдээллийг өгөх ёстой. Дөрөв таван жилийн өмнө надад тохиолдсон нэгэн туршлагаас хуваалцъя. Би төрийн төв захиргааны яамд, Засгийн газрын хэрэг эрхлэх газар гэх мэт арван таван байгууллагад хууль боловсруулах, тогтоох үйл явц дахь олон нийтийн оролцооны талаар буюу хэдэн хуулийн төсөлд олон нийтийн оролцоо орсон тухай мэдээлэл, хууль тогтоох журамд багтаагүй байсан нэг мэдээлэл болох олон нийтийн бүрэн эрхт төлөөлөгчид ямар шалгуур тавьдаг талаар тодруулах мэдээлэл хүссэн өргөдлөө явуулсан хэрэг. Тэгээд тогтсон найм хоногоо хүлээлээ. Тэр хугацаанд арван таван байгууллагаас найман байгууллага нь хариу өгсөн, бусад нь мэдээллээ өгөөгүй. Мэдээлэл ирээгүй тохиолдолд мэдээллийг нээлттэй болгохоос татгалзсан хариу өгөх хугацаа нь гурав хоног байдаг. Харин түүний дараа Мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасан арга хэмжээний талаар бодох шаардлагатай болно.

Мэдээллээ олж авч чадаагүй тохиолдолд Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулинд ямар арга хэмжээг тусгасан байдаг вэ? Нэгдүгээр шатны арга хэмжээ нь давж заалдах. Төрийн захиргааны байгууллагын хариу өгөөгүй, эсвэл татгалзсан хариу өгсөн талаар та давж заалдаж болно. Хоёрдугаар шатны арга хэмжээ нь шүүхэд дуудах. Энэхүү хоёр дахь шатны арга хэмжээг төрийн байгууллагаас мэдээлэл өгөхөөс татгалзсан сөрөг хариу өгсөн тохиолдолд хэрэглэх учир анхан шатны арга хэмжээгээр ашиглаж үл болно. Шүүхэд хандсан тохиолдолд мэдээллээр таныг хангаагүй, эсвэл дутуу мэдээллээр таныг хангаж хууль зөрчсөн

байгууллагад шийтгэл хүлээлгэх арга хэмжээг шаардаж болно. Татгалзсан хариу авснаас хойш танд тухайн байгууллагатай давж заалдах, эсрэг арга хэмжээ авах эсэх тухайг шийдэх арван тав хоногийн хугацаа бий. Миний тохиолдолд хариу өгөөгүй долоон яамны давж заалдах дээд шат нь тухайн яамны Сайд өөрөө байсан. Сайд ийм давж заалдсан гомдол хүлээн аваад тухайн асуудлаар хариу өгөх эсэх шийдвэрийг гаргах шинжээчдээс бүрдсэн хороо байгуулах ёстой. Зарим тохиолдолд сайд нь ч хариулахгүй тохиолдол бий. Би долоон байгууллагаас зургаан эерэг хариу ирсэн ч Засгийн газрын хэрэг эрхлэх газар намайг давж заалдан гомдол үүсгэхэд ч хариу өгөөгүй. Давж заалдахад шийдвэр гаргах хугацаа нь арван тав хоног байдаг. Сөрөг хариу өгөх тохиолдолд хариуг хүргэх хоёр хоногийн хугацаа байдаг, эдгээрээ хүлээсэн. Үүний дараа шүүхэд хандах үйл ажиллагаа эхлэнэ шүү дээ. Засгийн газрын хэрэг эрхлэх газар мэдээлэл өгөхгүй байсан тул холбогдох шатны шүүх нь Словак улсын Дээд шүүх байсан тул би тийш нь мэдэх эрхээ эдлэх талаар хэрэг үүсгэсэн. Анхан шатанд даван заалдаад сөрөг хариу авснаас хойш шүүхэд гомдол гаргах хүсэлтэй бол хоёр сарын дотор гаргана. Дээд шүүх хэргийг миний талд шийдэн Засгийн газрын хэрэг эрхлэх газар ялагдаж, мэдээллийг надад өгөх шийдвэр сонссон. Энэ бол энгийн мэдээлэл хүссэн өргөдөл байсан ч яагаад тэрхүү мэдээллийг надад өгөхгүй байсныг нь би ойлгоогүй.

Словак улсад мэдэх эрх хуулиар хангагдсан, мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд төрийн байгууллагуудыг шахаж энэхүү эрхийг хэрэгжүүлж болдгийг энэ жишээнээс та бүхэн харж байгаа биз ээ. Гэхдээ мэдэх эрхтэй эн тэнцүү чухал асуудал нь шүүх хэргийг шийддэг цаг хугацаа байгаа. Магад танд хэрэгтэй байсан мэдээллээ та хоёр гурван жилийн дараа хүлээж авбал тэр мэдээлэл танд хэрэггүй болсон байх биз. Өөр нэг чухал хүчин зүйл бол санхүү юм. Шүүхэд хандана гэдэг хэрэг бүртгэлийн төлбөр, өмгөөлөгчийн хөлс гэх мэт их зардалтай байдаг. Иргэний хуулийн дагуу хэрэг үүсгэн бүртгүүлэхэд зуун евро байдаг. Өөрөө хуульч эсвэл Хуулийн сургууль төгсөөгүй бол өмгөөлөгчийн хөлс гэж төлбөр гарна. Өөр нэгэн жишээ хэлэхэд би наян хот тосгодоос дээрхтэй адил мэдээллийг хүссэнээс дөч нь л надад хариу өгсөн. Надад тэр мэдээлэл хэрэгтэй учир би дөчин хот тосгоны эсрэг шүүхэд хандахаар шийдлээ гэж төсөөлье. Надад маш их чөлөөт цаг, маш их мөнгө шаардлагатай болно. Дөчин хэрэг үүсгэхийн тулд надад доод тал нь дөрвөн мянган евро хэрэгтэй болно, харин ийм их мөнгө энгийн хүмүүст арай ахадсан даваа.

Энгийн арга хэмжээгээ бүгдийг нь барсны дараа та мэдэх эрхээ хамгаалуулахаар Словакийн үндсэн хуулийн шүүх болон Страсбург дахь Европын хүний эрхийн шүүхэд хандаж болно. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд шүүхэд хандах, давж заалдах үйл ажиллагаанд тодорхой цаг хугацаа заасан байдаг. Захиргааны шийдвэр гарснаас хойш хоёр сарын дотор бүсийн, Дээд шүүх, Үндсэн хуулийн шүүхэд хандаж болох бөгөөд Европын хүний эрхийн шүүхэд захиргааны шийдвэр гарснаас хойш зургаан сарын дотор хандаж болно.

Хэрэв та худал эсвэл дутуу мэдээлэл авсан гэдгээ шүүхээр баталж чадвал тухайн төрийн захиргааны байгууллагыг хууль зөрчсөнийх нь төлөө танд нэг мянга таван зуун орчим евротой тэнцэх торгуулиар шийтгэхийг шаардаж болох ба энэхүү хуулийн дагуу мэдээлэл авч чадаагүй хүмүүс шүүхэд хандвал ихэнхдээ энэхүү мөнгийг нэхэмжилдэг.

АСУУЛТ-ХАРИУЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Д.ЛАМЖАВ /Иргэн/

Сая тараагдсан хуулийн төсөл нэлээн сонирхол татаж байна. Энэ мэдээллийн эрх чөлөөний тухай асуудал бол Үндсэн хуулийн 16-гийн 17-д байгаа. Гэхдээ энэ нь жаахан дутагдалтай заалт байдаг юм. Жишээлбэл, нууцын тухай хориглоод л мэдээлэл түгээх гэдэг нь орхигдсон байгаа. Гэхдээ Үндсэн хуулийн 10 дугаар зүйлээр энэ дутагдал засагддаг. Улс төрийн эрхийн тухай болон иргэний эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйл бол энэ заалтаас давж үйлчлэх ёстой. Тэгээд хууль санаачлагчдын ярьснаар мэдээлэл түгээх тухай энэ заалтыг тэр чигт нь мартсан байна. Тэгээд энэ их зовлонтой л доо. Мэдээлэл авах асуудал бол ганцхан төрийн байгууллагаар хязгаарлагддаг биш, өөр эх сурвалжаас авах эрхтэй. Иймд хууль ерөөсөө буруу хийгдсэн байна. Хуулийн төслийн гарчиг нь зөв бичгийн алдаатай, бас агуулгын алдаатай байна. “Төрийн байгууллагаас мэдээлэл авах эрхийн тухай хууль” гэж байвал арай дээр байхсан. Одоо жишээлбэл 6 дугаар зүйлд “Мэдээлэл хайх, авах эрх чөлөөг хангахад дараахи үндсэн зарчим үйлчилнэ” гээд л их айтгар болсон байна. Мэдээлэл нь албан ёсны байх гэнэ. Уг нь иргэд албан ёсны бус эх сурвалжаас хүртэл мэдээлэл авах эрхтэй байхгүй юу. Мэдээлэл нь гуравдагч этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй байх гэнэ. Энэ хорвоод чинь дандаа л хөндөж хөдөлж байгаа шүү дээ. Одоо ийм сайхан бие биедээ огт хүрдэггүй зарчим гэж огт байхгүй. Тэгэхээр болгоомжтой хандах хэрэгтэй байна. Энэ талаар дараа дараагийн хэлэлцүүлэгт сайн яригдах ёстой байх. Би нэг кейс хэлье. Саяхан хэдхэн хоногийн өмнө УИХ дээр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцсэн. Тэгээд УИХ-ын гишүүн Цэцийн даргыг загнаж байна. “Хэрвээ дахиад ингэх юм бол чамайг ер нь албан тушаалаас чинь халах эрх бидэнд байгаа шүү” гэж. Ингэж загнах шалтгаанаа юу гэж тайлбарласан гэхээр хуульд нийцээгүй Засгийн газрын шийдвэрийг Засгийн газар өөрөө эсвэл УИХ хүчингүй болгож болно гэсэн заалт УИХ-ын хуульд, Үндсэн хуульд ч байгаа юм байна. Үндсэн хуульд Цэц бас хүчингүй болгож болох тухай өөр нэг заалт байгаа юм. Тэгэхээр тэрнийг ганцхан шугамаар орж ирэх юм шиг ойлгож байгаа байхгүй юу. Тийм сэтгэхүйгээр хандах юм бол одоо бид нар гагцхүү төрийн байгууллагаас мэдээлэл авдаг, дандаа албан ёсны байдаг байх нь. 19 дүгээр зүйлд чинь уран сайхны аргаар, хил хязгаар хамаагүй гэхчилэн заасан байгаа шүү дээ. Нууцад хамаарах асуудлаар ч гэсэн хүмүүс мэдээлэл авах эрхтэй байхгүй юу. Тэгэхээр энэ их том гажуу байнаа. Үүнийг хэлэх гэсэн юм.

УНДРАЛ /Ардчилалын Боловсрол төв/

Би буруу ойлгосон байж магадгүй. Илтгэлтэй нь холбогдуулж Сү.Батболд гишүүнд нэг асуулт тавимаар байна. Бид нарын өчигдөр, өнөөдөр хэлэлцэж байгаа семинар маань хууль боловсруулах үйл явц дахь иргэний болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо гэж байгаа тиймээ. Тэгэхээр миний болон бусад төрийн бус байгууллагуудын мэдэхээр Глоб интернейшнл ТББ маань Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулаад Хууль зүй, дотоод хэргийн яаманд өгсөн байгаа гэж сонссон. Тэгээд ч бас нэлээд олон удаа хууль тогтоогчид, Засгийн газрын байгууллагууд, ТББ-уудыг оролцуулж уг хуулийн төслийг хэлэлцүүлж байсан. Харин өнөөдөр би их гайхаж байна. Батболд гишүүн хэлэхдээ энэ хуулийн төслийг Мөнх-Оргил, Оюун, Бат-Үүл гишүүн бид санаачилсан гэж хэлсэн. Тэгэхээр энэ нь нэг төсөл юм уу эсвэл хоёр өөр төсөл болж байна уу?

Та бүхэн ийм хуулийн төсөл санаачлаад явж байгаа нь сайшаалтай. Тэгээд хэрвээ энэ төсөл хэлэлцэгдэх гэж байгаа юм бол хэзээ хэлэлцэх юм бэ? Энэ хаврын чуулганаар хэлэлцэгдэх гэж байгаа юм уу. Тэгээд энэ санааг хаанаас авсан юм бэ? Түрүүнд Баярцэцэгийн яриад байдаг ownership буюу эзэн нь хэн юм бэ? Хуулбарлачихсан юм биш биз дээ.

СҮ. БАТБОЛД /УИХ-ын гишүүн/

Хуульд ямар нэгэн эзэн гэж байдаггүй гэдгийг та бүхэн маань сайн мэдэж байгаа байх л даа. Иймд саяын асуулттай холбогдуулаад хэлэхэд УИХ-ын гишүүд өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг санаачлаад өргөн барьж байгаа. Ийм хуулийн төслийг Засгийн газраас өргөн барих асуудал нээлттэй шүү дээ. Тэгэхээр бид яг өөрсдөө өргөн барьж байгаа хуулийн төслийн хүрээнд энэ мэдээллээ та бүхэнтэй хуваалцаж байна. Энэ хуулийн төслийг ойрын үед энэ хүрээндээ ярьж та бүхнээс болон бусад иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс санал авахын зэрэгцээ цаашдаа бусад гишүүдээс, хуулийн төслийн талаар ярих эрх нээлттэй байж байгаа. Нөгөө талаасаа бол бид энэ төслийг өнөө маргаашгүй шийдэхээр төлөвлөж байгаа зүйл байхгүй. Хаврын чуулганаар энэ хуулийн төслийг хэлэлцүүлэх бодолтой байгаа. Глоб интернейшнл ТББ-ын хувьд хуулийн төсөл боловсруулаад Хууль зүй, дотоод хэргийн яаманд өгсөн бол Засгийн газар дээр хэлэлцэгдэж Засгийн газраас тодорхой чиглэл авсан эсвэл хүлээж аваагүй юм бол тодруулж хэлэх байхаа гэж бодож байна. Нарантуяа дарга үүн дээр бас жаахан тодруулаад хэлчих үү?

Ж. НАРАНТУЯА /УИХ-ын Тамгын Газар/

Хууль зүйн яамныхан, Дуламсүрэн та нар бас үүн дээр мэдээлэх юм бол тодруулаад хэлнэ биз дээ. Зүгээр энд хэлэхэд Мэдээллийг авах эрх чөлөөний тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүд санаачлахаар хуулийн төслөө эхний хувилбараар боловсруулаад байгаагаа танилцуулсан. Энэ бол одоогоор зөвхөн боловсруулалтын шатанд явагдаж байгаа юмаа. Уг хуулийн төсөлд гишүүд өөрсдийнхөө үзэл баримтлалаа оруулсан. Энэхүү үзэл баримтлалаа гаргахдаа гол суурь нь болж өгсөн зүйл бол манай Нээлттэй Нийгэм Форум, бас Глоб интернейшнл ТББ, та нөхдийн гаргаж байсан санаа юм. Тэр санаан дээр тулгуурласан байхаа. Тэгээд Засгийн газраас боловсруулсан төслийн хувь заяа би сонсохдоо буцаагдсан байгаа гэсэн.

Ямар нэгэн дутуу боловсруулагдсан гэдэг утгаараа ч юм уу. Юу ч гэсэн гишүүд үүнд анхаарч энэ асуудлыг яаравчлах, ач холбогдол өгөх хэрэгтэй юм байна гээд өөрсдийн төслөө боловсруулаад явж байгаа.

Д. САРАНЧИМЭГ /Хууль зүйн яамны хууль зүйн бодлого боловсруулах газрын орлогч дарга/

Тэгэхээр энд нэг тайлбар хэлье гэж бодож байна. Засгийн газар ч бай, УИХ ч бай ерөнхийдөө өөр өөрсдийн эрхийнхээ хүрээнд энэ хуулийн төслийг санаачилж байна. Хууль зүйн яам бол Засгийн газраас Мэдээллийн эрх чөлөөний тухай гэсэн нэрээр хуулийн төсөл санаачлаад Засгийн газраар хэлэлцүүлсэн. Засгийн газар тодорхой үүрэг өгөөд одоо бид нар тэр хуулийн төсөл дээр ажиллаж байгаа. Эдгээр хуулийн төслүүд угаасаа зохицуулах харилцаа маань ойролцоо болохоор ерөнхийдөө адилхан, нэг л юмыг зохицуулах гээд байгаа учраас энэ хуулийн төсөл дотор байгаа агуулга, заалт адилхан байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Яагаад гэвэл энэ чинь нэг л харилцааг зохицуулах гээд байгаа шүү дээ. Ийм л тайлбар хэлмээр байна. Өөрөөр хэлбэл хууль санаачлагчид өөр өөрсдийнхөө эрхийн хүрээнд хуулийн төсөл санаачлах эрхээ хэрэгжүүлж байгаа хэрэг юм.

Ц. ОЮУНБААТАР /Консенсус төв/

За баярлалаа. Асуулт санал хоёроо нэгтгээд хэлье. Мэдээлэл авах эрх чөлөөний тухай хуулийн төсөл орж ирж байгаа юм бол энэ хоёр өдрийн семинар үр дүн гарах ганц асуудал энэ юмуу даа гэж ойлгож байна. Өчигдөр лоббийн тухай баахан ярилаа. ТББ-ын хууль боловсруулахад оролцох оролцооны тухай баахан ярилаа. Иргэдийн хууль боловсруулахад оролцох оролцооны талаар ярилаа. Энэ талаархи хууль эрх зүйн зохицуулалт монголд байхгүй. Үүнийг барьж аваад явах гэж байгаа УИХ-ын гишүүд магад нэг ч алга. Харин энэ мэдээлэл авах эрх чөлөөний тухай хэлбэржсэн төсөл ороод ирж байгаа бол маш сайшаалтай зүйл. Зүгээр түрүүчийн парламентын үед бол Глоб интернейшнл ТББ нэлээд том үйл ажиллагаа явуулаад бас семинар юм зохион байгуулаад гайгүй тийм үзэл баримтлалтай хуулийн төсөл явж байсан. Чухам яасныг мэдэхгүй. Хэн санаачлах нь хамаагүй, хэн оруулж ирэх нь хамаагүй ийм хууль маш их хэрэгцээтэй байгаа. Монголд өнөөдөр иргэний нийгэм хүчтэй хөгжсөн мөртлөө яг төрд нөлөөлөх, хууль боловсруулах, батлахад нөлөөлөх тийм нөлөөлөл байхгүй. Семинар хийдгээс л бусдаар бол. Бид өчигдөр хэлсэн.

Олон арав, зуун семинар болдог. Үр дүн нь хаана байдаг билээ. Эндээс юутай гарах, юутай үлдэх вэ ямар ажлын хэсэгтэй үлдэх вэ гэдэг асуудлаар Нарантуяа дарга хаалтын ажиллагаан дээр базаж нэгтгээд санал бодлоо хэлэх байх. Эсвэл энэ семинарыг нээсэн Лүндээ дарга орж ирж дүгнэх юм болов уу мэдэхгүй байна. Ямар ч гэсэн мэдээлэл ямар нэг хэмжээгээр хаалттай, цуурхал, гүтгэлэг, сонин дуулиан дээр манай мэдээлэл явж байгаа. Цаана нь захиалагч нар байгаа. Энэ тухай асуудлаар би сая УИХ-ын 76 гишүүнд захидал бичээд өгчихсөн байж байгаа. Сэтгүүлчдийг эрүүгийн хариуцлагад татахыг больёо, харин иргэний хуулийн журмаар шийдье. Энэ бол хэвлэлийн эрх чөлөөтэй шууд холбогдож байгаа асуудал. Тэгэхээр үүн дээр нэлээд анхаарч боловсруулалт хийх шаардлагатай байх. Магадгүй үүнийг дагаад олон

хуульд зохих өөрчлөлт оруулах шаардлага гарна. Улсын нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, хувийн нууцын тухай хуулиуд гэх мэт.

Тэгээд өнөөдрийн энэ хууль гарсан ч гэсэн тунхаглалын шинжтэй хууль болоод тэр хуулиудаас болоод үйлчилж чадахгүй. Наад зах нь хариуцлагын асуудал гэж инээдэмтэй юм энэ дотор явж байгаа шүү дээ. Албан тушаалтныг 15-30 мянган төгрөгөөр торгоно ч гэдэг юм уу, байгууллагыг нь тэд ч гэдэг юм уу. Хүний эрхийн комисст гомдлоо гаргана гэх шиг. Хүний эрхийн комисс яах вэ гэдэг талаар эрх зүйн зохицуулалт нь байхгүй, Дээд шатны албан тушаалтанд гомдлоо гаргана гэдэг үндсэндээ манай нөгөө сүлжээгээр бүтсэн төрийн байгууллага доод шатныхаа албан тушаалтны гаргасан шийдвэрийг хамгаалах, бөөрөнхийлөх тийм тогтолцоо манайд байдаг. Хамгийн гол нь Монголд мэдээлэл нь чөлөөтэй, нээлттэй байдалтай ийм тогтолцоо шаардлагатай байна. Энэ чиглэлээр хүчээ нэгтгэж хууль санаачилж байгаа хүмүүс баг болоод ажиллах хэрэгтэй байгаа юм. Тэр Глоб байгууллага нь ч алга, сэтгүүлчид нь бүр алга. Гарахаар нь гомдол гаргаад байдаг шүү дээ.

Өчигдөр нэг ТББ-уудын оролцооны асуудал дээр ТББ-ууд бол санаагаа худалддаг гэж ярьж байсан. Тийм учраас сая Нарантуяа даргын хэлснээр хэн санаа гаргасан нь хуулийг өмчлөхгүй гэж бодож байна. Монголд ТББ-ууд олон. Чиглэл чиглэлээрээ үйл ажиллагаа явуулдаг боловч үр дүн гардаггүй, болохоо байхаар ордноо тойрч цонх хагалдаг тухай өчигдөр баахан ярьсан шүү дээ. Энэ биш юм аа. Уг нь ТББ-ууд нь томоохон концерциум хэлбэрээр зохион байгуулагдаж төрд нөлөөлөх нөлөөллөөр, хууль боловсруулахад нөлөөлөх нөлөөллөөр тодорхой эрч хүчтэй ажиллах ийм шаардлага байгаа юм. Үүнийг ч бас бид нар урьд нь боддог, ярьдаг байсан. Энэ хуулийн төслийг маш сайн боловсруулж нэгдсэн ийм хууль гаргаж авах нь монголын нийгмийг эрүүл болгох, эрүүлжих тэр улс төржсөн, бизнесжсэн төрийн тогтолцооноос зүгээр нээлттэй, ил тод, цомхон олон нийтийн хараа хяналтад байдаг тийм төрийн тогтолцоо руу явахад маш чухал алхам болох зүйл юм. Баярлалаа.

Р. БУРМАА /Сонгогчдын Боловсрол Төв/

Хуулийн төслөөр нэлээн өргөн хэлэлцүүлэг явуулах байх гэж найдаж байна. Тэрнээс биш саяны төсөв хэлэлцэж байгаа шиг Байнгын хороо нь хуралдаад маргааш өглөө нь чуулганаар баталдаг шиг тийм байдлаар явагдахгүй байх гэж бодож байна. Хоёрдугаарт Төрийн байгууллагаас мэдээлэл авах асуудал дээр илүү анхаарал төвлөрсөн хууль байх байхаа гэдэгт Ламжав багшийн тэр саналыг дэмжиж байна. Гуравдугаарт, бид өчигдөржингөө л яриад манай илтгэл тавьсан хүмүүс хэлээд л байсан дахиад энэ хуулийн төсөл дотор явж байна даа. Шаардлагатай бол, үндэслэлтэй бол гээд нэг ийм тодорхойгүй шалтгаанууд энд дахиад л байж байгаа юм. Жишээ нь, төрийн байгууллагын хэвлэн нийтлэх үүрэг дээрээ жагсаалт гаргаж байснаа “тухайн байгууллагын шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл” гэж байгаа юм. Тэгэхээр хамгийн гол нь энэ хууль чинь өөрөө мэдээллийг нийтэд ил тод болгох гээд байгаа юм бол тэр юм чинь л хэн нэгэн хүн өөрийн үзэмжээр шаардлагатай бол гэж үзэж тодорхойлохгүйгээр байхын тулд энэ хууль гарах байх гэж би бодож байна. Гэтэл дахиад л нөгөө бусад хуульд байдаг гацаа, дэгээ нь хэвээрээ байх юм. Тухайн байгууллага аягүй бол нөгөө өөрийнхөө

нууцын тухай мэдээллээ хүртэл нууц гээд, нэрс нь хүртэл нууц байдаг шүү дээ. Тэр чинь нөгөө нэг хэлбэрээрээ дахиад л ороод ирэх нь байна шүү дээ. Байгууллага өөрөө л үүнийгээ тодорхойлох юм бол... гэх мэтчлэн энд эргэж харахаар, ярихаар зүйл олон байна. Олон улсын шинжээчид ирсэн байгаа. Нээлттэй нийгэм форумд хүсэлт тавихад энэ семинарт оролцож байгаа гадаадын шинжээчдийг энэ хуулийн төсөл дээр зөвлөмж өгч ажиллуулах талаар санаачилга туслалцаа гаргаж өгвөл их хэрэгтэй байх болов уу. Баярлалаа.

СҮ. БАТБОЛД /УИХ-ын гишүүн/

Бидний хэсэг гишүүдийн санаачлан боловсруулсан хуулийн төслийн талаар та бүгдэд товчхон мэдээлэл өглөө. Та бүхний, Ламжав гуай, Оюунбаатар гишүүн, бусад хүмүүсийн саналыг бид бас сонсч холбогдох нөхдүүддээ уламжилж хуваалцана. Ер нь зарчмын хувьд анхаарууштай нэлээд хэдэн санал гарсныг сайшааж хүлээж авч байна. Энэ хуулийн төсөл маань дөнгөж боловсруулалтын шатанд байгаа гэдгийг Нарантуяа дарга хэлсэн. Тэгээд бид та бүхэнд танилцуулж санал авч байгаа юм. Хавар хэлэлцүүлэхээр төлөвлөж байгаа. Энэ хууль маань нийгэмд үйлчлэх энэ агуулгаараа бүхий л талаас нь оролцоог хангаж өгөх шаардлагатай гэж үзэж байна. Шаардлагатай бол гэдэг үгийг шүүмжилж байгааг хүлээж авч байна. Бид нээлттэй хэлэлцүүлэг юм уу, нээлттэй сонсгол хийж болох юм байна гэдгийг бодолцон цаашдаа хэлэлцүүлэг хийх, ямар хэмжээнд хийх вэ гэдгийг бас бодох ёстой. Үүнд манай УИХ-ын Тамгын газраас анхаарч цаашдаа ямар чиглэлээр тодорхой үр дүнтэй болгох, вэ гэдэгт туслах, эцсийн дүндээ нийгмийн хариуцлага, нийгмийн үр дүнгээ өгөөсэй гэсэн энэ санал дээр бид нэгдэж байгаа учраас энэ талаасаа бүрэн нээлттэй, хамтарч ажиллана гэж бодож байна. Ямар ч гэсэн цаашдаа нэлээд хэдэн ярилцлага зохион явуулах шаардлагатай юм байна. Баярлалаа.

Ж.НАРАНТУЯА /УИХ-ын Тамгын Газар/

УИХ-ын Тамгын газар, Нээлттэй Нийгэм Форумгаас зохион байгуулж байгаа энэхүү олон улсын семинарт хүрэлцэн ирж өөрсдийнхөө практик туршлагаасаа ярьж өгсөн гадны шинжээчдэд юуны өмнө баярлалаа гэж хэлмээр байна. Түүнчлэн манай яамны түвшинд, УИХ-ын гишүүд, ТББ-ууд өөрсдийнхөө санал бодлоо илэрхийлж өөрсдийн хувь нэмрээ оруулсан та бүхэнд бас баярлалаа. Эцэст нь дүгнэж хэлэхэд бид энэхүү семинарын үйл ажиллагаанд оролцсон та бүхний хэлсэн үгийг парламентынхаа болон Нээлттэй Нийгэм Форумын вэб хуудаст байрлуулах болно. Цаашид бид Нээлттэй Нийгэм Форумтай хамтран хийх гэж байгаа гурван чиглэлийн үйл ажиллагаа байгаа юм. Энийгээ бас та бүхэнд танилцуулъя гэж бодож байна. Нэгдүгээрт, оролцооны талаархи эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Энэ нь иргэний нийгэм, ТББ-уудын оролцоог зохицуулсан энэ эрх зүйн актуудыг боловсронгуй болгоно гэсэн үг. Эхний төслийг гарсны дараа бид нар энэ семинарт оролцсон хүмүүстэй эргээд санал солилцох, онлайн хэлэлцүүлэг ч юмуу тийм хэлбэрээр та бүхний саналыг авнаа. Хоёрдугаарт, үйл ажиллагаандаа энэхүү семинарын үр дүнг тусгах ажиллагаа явуулна. Үйл ажиллагаа гэдэг маань нэгдүгээрт, Байнгын хороодын түвшинд УИХ-аар хэлэлцэх гэж байгаа хуулиудын төслөөр нээлттэй хэлэлцүүлэг, нээлттэй сонсгол зохион байгуулна гэж бодож байгаа. Эхний ээлжинд эдгээр гишүүдийн санаачлах хуулийн төслөөр хэлэлцүүлэг

хийгээд дараа нь бас Байнгын хорооны түвшинд бусад байнгын хорооны гишүүдэд мэдээлэл өгөх зорилгоор нээлттэй сонголттой зохион байгуулна гэж төлөвлөж байна. Ингээд Нээлттэй нийгэм форумын зүгээс бас шаардлагатай мэдээллээр хангах, ялангуяа хөтөлбөр болоод Европын орнуудын ТББ-дын оролцоо, энэ асуудлыг зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалтын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах, энэ чиглэлээр бодлогын шинжилгээ хийхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Гуравдугаарт, энэ өдрүүдэд яригдсан зүйлийн талаар Нээлттэй Нийгэм Форум, Тамгын газар хамтраад сонинд үр дүнгийн талаар ийм юм яригдлаа, ийм шийдэлд хүрлээ гэсэн зөвлөмж юм уу нэг мэдээлэл гаргана. Ийм гурван юм хийхээр төлөвлөж байна. За ингээд та бүхэнд баярлалаа. Энэ бол бидний хамтын ажиллагааны нэгэн шинэ эхлэл гэж бодож байна. Баярлалаа.